



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



"ИРГЭДИЙН ОРЛОЦОО"
ТӨСӨЛ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

/Судалгааны тайлан/

Улаанбаатар хот

2022 он

ГАРЧИГ

Өмнөтгөл

Үнэлгээний зорилго

Үнэлгээ хийхэд баримтлах зарчим, арга зүй

Нэг.Төлөвлөх үе шат

- 1.1.Үнэлгээ хийх шалтгаан;
- 1.2.Үнэлгээний хүрээг тогтоох нь;
- 1.3.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох;
- 1.5.Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- 1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

Хоёр.Хэрэгжүүлэх үе шат

Гурав.Үнэлэх үе шат

3.1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үзэл баримтлалтай холбоотой үнэлгээ;

3.1.1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслүүдийг боловсруулж байсан үйл явцын талаар

3.2.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэрэгжсэн байдал;

3.2.1.Улс төрийн нөхцөл байдал

3.2.2.Эдийн засгийн нөхцөл байдал

3.2.3.Нийгэм-соёлын нөхцөл байдал

3.2.4.Сэтгүүлчийн аюулгүй байдал, бие даасан байдлын хэрэгжилт

Дөрөв.Олон улсын сайн туршлагууд

Дүгнэлт

Зөвлөмж

НОМ ЗҮЙ

Судалгааны баг:

Багийн ахлагч:

Л.Галбаатар – Олон улсын эрх зүйч, хуульч

Глоб интернэшнл төв болон Монголын Хуульчдын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн; Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хуульч

Багийн гишүүд:

Н.Зулзаяа - Олон улсын сэтгүүлч

Глоб интернэшнл төвийн Мэдээлэл харилцааны ажилтан

Л.Жаргалмаа - Сэтгүүлч, эрх зүйч

“Засаглалд залуу сэтгүүлчдийн оролцоо хөтөлбөр”-ийн төгсөгчдийн холбооны гишүүн; Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын сэтгүүлч

З.Энхбаяр - Сэтгүүлч

“Засаглалд залуу сэтгүүлчдийн оролцоо хөтөлбөр”-ийн төгсөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн; “Стар” телевизийн Мэдээний албаны дарга

Энэ судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар гүйцэтгэв.

1. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 14 дүгээр зүйлийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.”, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.” гэж, 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж тус тус заасны дагуу Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын эерэг, сөрөг талуудыг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлэхэд оршино.

Чөлөөт, цензургүй, хориг саадгүй хэвлэл ба хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэл нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах, бусад эрх чөлөөг эдлэхэд нийгмийн салшгүй хэсэг болдог.¹ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966.12.16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 1-т “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”, 2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”, 3-т “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж заасан.² Энэхүү пактад Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан.³ Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэл нийтлэх эрх чөлөөтэй, 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй болохыг тус тус баталгаажуулсан.⁴

Эдгээр зохицуулалтаар хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болохыг баталгаажуулсан. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр тайлбарт “Мэдээлэл хайх, хүлээн авах ба үзэл санааны бүхий л хэлбэрийг хил хязгааргүйгээр хуваалцах эрхэд улс төрийн мэтгэлцээн, хүний хувийн болон төрийн үйл хэргийн асуудлаарх тайлбар, ухуулга, хүний эрхийн талаарх хэлэлцүүлэг, сэтгүүл зүй, соёл, уран сайхны илэрхийлэл, номлол, шашны мэтгэлцээн багтана. Үүнд арилжааны зар сурталчилгааг хамруулж болно” гэж тусгасан. Энэ нь хэвлэл мэдээллийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлын зарчмыг хангах буюу хэвлэл мэдээлэл нь төрийн шууд ба шууд бус цагдан хяналтаас ангид байх, редакцийн хараат бус байдал хангагдсан байхад чиглэх ёстойг илэрхийлж байна.⁵ Үүнээс үндэслэн хэвлэл мэдээллийн олон талт байдал, бие даасан зохицуулагч, хараат бус байдлын үзэл санаа, агуулгыг тодорхойлж байна.

Мэдээлэлтэй байх эрхийг хангахтай холбоотойгоор төрөөс хэвлэл мэдээллийн олон талт байдлыг дэмжих үүрэгтэй. Хэрэв нэг буюу цөөн тооны хүмүүс, компаниуд хэвлэл мэдээллийн салбарт давамгайлбал тэдний хувьд хэвлэл мэдээллээр дамжуулсан маш их нөлөөтэй болж мэдээллийн цар хүрээ, түүний тээж буй үзэл санааг хязгаарлана. Хэвлэл мэдээллийн олон талт байдал нь нийгэм дэх олон янзын үзэл бодол, тодорхой хандлагыг нийгэмд сонсож, хэлэлцэх боломжийг олгодог. Мөн цөөнхийн санаа бодол, дуу хоолой ба тэдний хүрээлэлд хамаарах мэдээллийг тэдний хэлээр хүлээн авах явдлыг хамгаалдаг. Төрөл бүрийн хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжихийн тулд засгийн газар

¹ Монгол Улсын Их Хурал 2015 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

зөвхөн хэвлэл мэдээллийн олон талт байдлыг дэмжихэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн дэглэмийг хэрэгжүүлнэ. Тухайлбал, хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулахын тулд зөвшөөрөл авах ёсгүй. Бизнес эрхлэхэд шаардагдах албан ёсны бүртгэлийн шаардлага нь захиргааны зорилгоор тохиромжтой байж болох ч эрх мэдэлтнүүд ийм бүртгэлийг дур зоргоор хязгаарлах эрхгүй байх ёстой. Тухайн улсад олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгсэл байж болох тул тэдгээрийн тоог хязгаарлах нь ямар ч зорилгогүй бөгөөд хэвлэл мэдээллийн олон талт байдлыг алдагдуулдаг. Харин өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн хувьд зөвшөөрөл олж авах шаардлагатай. Уламжлалт өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл нь хязгаарлагдмал тооны радио давтамжийн хандалтад тулгуурладаг. Улс орнууд олон янзын дуу хоолойг өргөн нэвтрүүлэгт хамруулж, давтамжийг шударгаар хуваарилах ёстой. Үүнийг тусгай зөвшөөрлийн тодорхой, ойлгомжтой журам боломжтой болгодог бөгөөд өргөн нэвтрүүлгийн нэг, хоёр үйлчилгээ эрхлэгчдийг монополь байхаас сэргийлдэг.

Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл болон бусад аливаа хэвлэл мэдээллийн зохицуулалтыг бие даасан зохицуулах байгууллага хариуцах ёстой. Бие даасан зохицуулах байгууллагыг улс төрийн шууд нөлөөллөөс хамгаалагдсан үйл явцын дагуу томилогдсон гишүүд бүхий Зөвлөл удирдах нь илүү тохиромжтой. Энэхүү байгууллага нь яам, засгийн газрын эрх бүхий байгууллагын харьяанд байж болохгүй. Мөн тус байгууллагын санхүүжилт тогтвортой, зөвлөлийн гишүүдийг дур мэдэн чөлөөлөхөөс хамгаалагдах ёстой. Өргөн нэвтрүүлгийн зохицуулагчийн нэн тэргүүний үүрэг хариуцлага нь тусгай зөвшөөрөл олгох явдал юм. Гэхдээ зарим контентыг зохицуулах нь хууль ёсны байна. Тухайлбал, өргөн нэвтрүүлгийг тодорхой цагт үзэх, сонсох хүүхдийг хамгаалах зохицуулалт байж болно. Энэ төрлийн зохицуулалт нь маш эмзэг асуудал тул хатуу шалгуур үзүүлэлтийг нарийн чанд мөрдөж, бие даасан байгууллага хариуцах ёстой. Хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн хувьд хэвлэлийн ёс зүйн дүрэм, зарчим боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн өөрийгөө зохицуулах байгууллага хариуцах нь илүү зохистой юм.

Хэвлэл мэдээллийн хараат бус байдал гэдэгт төрийн өмчит аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг засгийн газрын хяналтад байлгах ёсгүй гэсэн шаардлага багтана. Засгийн газрын хяналт бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтийн эрх ашигт үйлчлэх редакцийн хараат бус байдал байхгүй бөгөөд үүний оронд эрх барьж байгаа засгийн газрын ашиг сонирхолд үйлчлэх болно. Гэхдээ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрөөс дэмжиж болно. “Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэгдэх хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төрийн өмчит, төрийн дэмжлэгтэй боловч нийтийн ашиг сонирхолд үйлчлэх үүрэгтэй, улс төрийн шууд нөлөөллөөс хамгаалагдсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд багтана. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ардчилалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир нь олон нийтийн ашиг сонирхлын үүднээс тэд олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн боловч арилжааны ашиг сонирхолд төдийлөн хамрагдаагүй асуудлын талаар мэдээлэхэд төвлөрч чаддаг.

¹ UN Human Rights Committee (HRC), General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression, 12 September 2011, CCPR/C/GC/34, available at: <https://www.refworld.org/docid/4ed34b562.html>

² International Covenant on Civil and Political Rights. Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2200A (XXI) of 16 December 1966 entry into force 23 March 1976, in accordance with Article 49. <https://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CCPR.aspx>

³ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт <https://old.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

⁴ Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он, №1


⁵ Centre for Law and Democracy. Background Paper: Freedom of Expression and International Law. November 2021 www.law-democracy.org

1.1. Үнэлгээ хийхэд баримтлах зарчим, арга зүй

Иймд энэхүү судалгаагаар Улсын Их Хурлаас 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд саад болж буй хүчин зүйлсийг “Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагаас тогтмол эрхлэн гаргадаг “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд хэрэглэж буй 80 гаруй асуултын дагуу тодорхойлж, тэдгээр асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн олон улсын хэм хэмжээ, зөвлөмжийг авч үзэж, гаднын зарим улсын сайн туршлагыг тодорхойлж, үүний үндсэн дээр Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг хангахад чиглэсэн бодлогын хувилбар /Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын загвар төсөл, түүний дагалдах хууль тогтоомжийн загвар төсөл/ боловсруулахыг зорив.

“Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллага 2002 оноос эхлэн жил бүр 180 улсын хэвлэлийн эрх чөлөөний индексийг дүгнэж, байр эзлүүлдэг. Энэхүү индексээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөний нөхцөл байдлыг түүний олон талт байдал, хэвлэл мэдээллийн хараат бус байдал, хууль тогтоомжийн зохицуулалтын чанар, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг үнэлэх замаар тодорхойлдог. Гэхдээ энэ индекс нь тухайн улс орон, бүс нутаг бүрийн сэтгүүл зүйн чанарын үзүүлэлт биш юм.⁶ Энэхүү “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн оноо 5 түвшинтэй. Үүнд: 0-15 оноо маш сайн; 15.01-25 оноо сэтгэл хангалуун нөхцөл байдал; 25.01-35 оноо асуудалтай нөхцөл байдал; 35.01-55 оноо хүнд нөхцөл байдал; 55.01-100 оноо маш ноцтой нөхцөл байдлыг тус тус илэрхийлэн. Дээрх индексийн тайлангаар Монгол Улсын хувьд сүүлийн 10 жилийн байдлаар ямар үнэлгээтэй байсан бэ гэдгийг дараах графикт харуулж байна. Эндээс харахад, 2012 онд “хүнд нөхцөл байдал”-тай, 2013-2021 онд “асуудалтай нөхцөл байдалтай” гэж дүгнэгджээ.⁷

График 1. "Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс" дэх Монгол Улсын үзүүлэлт, 2012-2021



Ингэж хангалтгүй дүгнэгдэж буй цаад шалтгаан нөхцөлийг “Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагын хувьд дараах байдлаар ангилдаг.

- улс төрийн нөхцөл байдал,
- эдийн засгийн нөхцөл байдал,
- эрх зүйн зохицуулалт,
- нийгэм-соёлын нөхцөл байдал,
- сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл.

Иймд энэхүү судалгаанд хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд саад болж буй хүчин зүйлсийг дээрх таван нөхцөлөөр тодорхойлж, тайлбарлав.

Энэхүү судалгаанд сайн туршлагыг нь судлах гадаадын улсуудыг сонгохдоо “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд “маш сайн” ба “сэтгэл хангалуун нөхцөл байдал”-тай гэж дүгнүүлсэн төдийгүй эрх зүйн зохицуулалтын хувьд Монгол Улсад жишиг болох нөхцөлийг харгалзав. Энэ хүрээнд хэвлэлийн эрх чөлөөний хувьд “маш сайн” үзүүлэлт бүхий Норвеги, “сэтгэл хангалуун” үзүүлэлт бүхий Австрали, ИБУИНХУ, БНСУ, АНУ-ын туршлагыг судлав.

Нэг.Төлөвлөх үе шат

1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалтгаан нь хуулийн зохицуулалт нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэгжилтийн байдал эерэг үр дүн үүсгэж байгаа эсэх, Монгол Улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө бүрэн хангагдсан эсэх, уг эрх чөлөө зөрчигдсөн бол түүний шалтгаан нөхцөлийг тогтоох замаар хуулийг шинэчлэн найруулах эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг илрүүлэх явдал юм.

1.2.Үнэлгээний хүрээг тогтоох нь

1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь 4 зүйлтэй бөгөөд үнэлгээг бүхэлд нь буюу хуулийн нийт зүйлд хийх юм.

1.2.Шалгуур үзүүлэлтийг тогтоох

Өмнөх үе шатанд үнэлгээ хийхээр сонгосон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн нийт зүйл, хэсгийн хэрэгжилтийн байдлыг тогтооход туслах, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж, тогтоож чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзуулан сонгов.

1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цугуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаанд үндэслэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээг хийх болно.

Харьцуулах үзүүлэлтээ байх ёстой болон байгаа гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож бусад улсын жишгийг байх ёстой түвшин гэж үзэж үнэлнэ.

1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн

алхмууд нь томъёолсон шалгуур үзүүлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Төлөвлөлтийн үе шатанд хийгдсэн өмнөх алхам /үнэлгээний шалтгаан, хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг тогтоох, шалгуур үзүүлэлтийг томъёолох/-уудаа ямар тохиодолд тоон, ямар тохиолдолд чанарын мэдээллийг ямар аргаар цуглуулахаа энэ үе шатанд сонгоно.

Ихэвчлэн бодит тоон мэдээлэл дээр ажиллах болно.

Хоёр.Хэрэгжүүлэх үе шат

Энэ үе шатанд холбогдох мэдээллийн цуглуулав.

⁶ Reporters Without Borders. The World Press Freedom Index <https://rsf.org/en/world-press-freedom-index>

⁷ Reporters Without Borders. Mongolia <https://rsf.org/en/mongolia>;

World Press Freedom Index 2011/2012 <https://rsf.org/en/world-press-freedom-index-20112012>

Гурав.Үнэлэх үе шат

3.1.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үзэл баримтлал буюу түүний хэрэгжилт

Улсын Их Хурлаас 1998.08.28-ны өдөр баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 1998.01.20-ны өдрийн, чуулганы 1998.08.28-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс тус хуулийг хэлэлцсэн байдлыг тодруулан авч үзье.

Байнгын хорооны хуралдаанд хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүн Э.Бат-Үүл, Н.Энхбаяр, С.Төмөр, С.Баярцогт, Ж.Гомбожав, Ц.Нямдорж, П.Жасрай, Х.Дашзэвэг, М.Чимэдцэрэн нар санал хэлжээ. Тус хуралдаан дээр Ерөнхийлөгч Н.Багабанди, Улсын Их Хурлын гишүүн Т.Ганди болон Э.Бат-Үүл нарын өргөн барьсан гурван төслийн алийг хэлэлцэх, үлдсэн хоёр төслийг хэрхэх талаар төвлөрч хэлэлцжээ. Тухайн үед цөөнхийн бүлгийн дарга Н.Энхбаярын хувьд гишүүн Э.Бат-Үүлийн төсөл нь зарчмын суурь асуудлыг хөндсөн, суурь хууль болох ёстой, үлдсэн хоёр хуулийн төслийн хувьд процедурын буюу нарийвчилсан зохицуулалт бүхий тусдаа хууль болох ёстой талаар санал хэлж, үүнийг байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшөөрсөн байна. Ингэхдээ хуулийн төслийн эхний гурван зүйлийг бүхэлд нь дэмжиж, 4 дүгээр зүйлийн эхний заалтыг үлдээж, эхний зүйлүүдтэй зөрчилдсөн гэх “Төрийн байгууллага албан ёсны мэдээгээ өөрийн албаны эмхтгэл болон хэвлэлийн албаны албан ёсны төлөөлөгчөөр дамжуулан мэдээлнэ. Албан ёсны мэдээ баримтыг бүрэн эхээр нь нийтэлнэ. Төрийн албан ёсны мэдээний тайлбарыг мэдээлэлтэй хамтад нь нийтэлнэ.” гэх үлдсэн гурван заалтыг хасах, хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолын төслийг яаралтай оруулж ирж, хэлэлцэхээр болсон байна.⁸

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Д.Баттулга хуулийн төслийн талаарх Байнгын хорооны дүгнэлтийг өмнө нь хэлэлцсэн тухай тайлбарлажээ. Төслийн 4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх заалтыг хасах саналынхаа үндэслэлийг гишүүн Н.Энхбаяр, Э.Бат-Үүл, Р.Гончигдорж, Т.Ганди, Т.Очирхүү, Ж.Бямбадорж нар тайлбарлажээ. Хуулийн төслийн талаар гишүүн Д.Цогбадрах, Б.Дэлгэрмаа, Н.Энхбаяр, Т.Ганди, Т.Очирхүү, Р.Сандалхан, Бат-Эрдэнийн Батбаяр, Р.Нарангэрэл, Ж.Бямбадорж, Ц.Шаравдорж, Э.Бат-Үүл, С.Зориг, Ц.Нямдорж, Д.Баттулга нар санал хэлжээ.⁹ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцсэний дараа нэгдсэн хуралдаанаар хуулийн төсөлтэй хамт хэлэлцэж, хууль, тогтоол хоёрыг нэгэн зэрэг эхний хэлэлцүүлгээр нь батлахаар болжээ. Ингээд хууль батлах дээр санал хураахад 53 гишүүн оролцож, бүгд зөвшөөрчээ. Мөн тогтоол батлах дээр санал хураахад 53 гишүүний 48 нь зөвшөөрсөн байна.

Ийнхүү Улсын Их Хурлаас 1998.08.28-ны өдөр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталж, 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино”, 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.”, 3 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй. Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд

⁸ Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдааны протокол. 1998.01.20, дугаар 16

⁹ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны протокол. 1998.08.28, дугаар 32

хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.”, 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” гэж зохицуулсан.¹⁰ Мөн Улсын Их Хурлын 1998.08.28-ны өдрийн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоолоор:

1. “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонин, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, яам, агентлаг, түүнтэй адилтгах байгууллагын дэргэдэх радио, телевиз, сонин, сэтгүүлийг 1999 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс татан буулгах;
2. Хууль, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар болон хуулиар олгогдсон эрх бүхий байгууллагын нийтээр дагаж мөрдөх шийдвэрийг гагцхүү “Төрийн мэдээлэл” эмхтгэлд албан ёсоор хэвлэн нийтэлж байхаар тогтоох;
3. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэрийг 5 жилийн хугацаанд дахин ашиглахгүй байхаар тогтоох;
4. Радио, телевизийн хэрэг эрхлэх газар, МОНЦАМЭ агентлагийг Засгийн газрын тохируулагч агентлагийн хувьд татан буулгаж, Үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон өөрчлөн зохион байгуулах;
5. Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх радио, телевизийг энэ тогтоолын 4 дэх хэсэгт заасан Үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагын харьяанд ажиллуулахаар өөрчлөн зохион байгуулах;
6. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль, энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан зарим хууль тогтоомжид орох өөрчлөлт, энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэвлэл, мэдээллийн хэрэгслийн өмчийн талаар гаргах шийдвэр, 4 дэх хэсэгт заасан байгууллагын удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийн төслүүдийг боловсруулж, 1998.10.15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгахаар тус тус тогтсон байна.

Мөн 1999.01.22-ны өдөр “Татан буугдсан Ардын эрх, Засгийн газрын мэдээ сонины өмчийг хувьчлах тухай” хуулийн 1 дүгээр зүйлд “Татан буугдсан ‘Ардын эрх’, ‘Засгийн газрын мэдээ’ сонины тус бүрийн өмчлөлд байсан хөрөнгийн үндсэн дээр шинээр хувьцаат компаниуд үүсгэн байгуулж тэдгээрийн хувьцааг худалдах замаар хувьчилж, тус бүрийн хувьцааны дөчин хувийг ‘Ардын эрх’, ‘Засгийн газрын мэдээ’ сонинд ажиллаж байсан ажиллагсдад нь давуу эрхээр буюу хувьцааны доод үнээр, үлдэж байгаа хувьцааг хязгаартай буюу сонин, хэвлэл эрхлэн гаргадаг хуулийн этгээд, иргэдэд дуудлага худалдаагаар худалдах замаар хувьчлах”-аар заажээ.¹¹ Энэ хуультай холбоотойгоор Улсын Их Хурлын 1999.01.22-ны өдрийн “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолоор

- Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмчийг 1999 оны 4 дүгээр сарын 1-ний дотор хувьчлахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгаж,
- “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмч хөрөнгийн байдлыг 1998.12.31-ний байдлаар тогтоон шалгаж дүнг 1999.04.10-ны дотор танилцуулахыг Төрийн хянан шалгах хороонд даалгажээ.

Дээрх хууль, тогтоол хэрхэн хэрэгжсэний жишээг энд авч үзье. Улсын Их Хурлын тогтоолд дурдсан “Ардын эрх” сонины нэрийг хэрэглэхийг хориглосон таван жилийн хугацаа 2004 онд дууссан бөгөөд 2004 оны 12 дугаар сарын 01-нээс тус сонин дахин гарч эхэлсэн байна. Тухайн үед өдөр тутмын “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Засгийн газрын мэдээ”,

¹⁰ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 1998 он, №10

¹¹ Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмчийг хувьчлах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 1999 он, №5

“Монголын мэдээ”, “Монголын үнэн” гэсэн өдөр тутмын сонингууд гарч байсан бөгөөд “Ардын эрх” зургаа дахь өдөр тутмын сонин болон гарч эхэлжээ.¹² Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр хэвлэл мэдээллийн салбар дахь төрийн шууд оролцоо бараг тэглэж, төрийн оролцоо, санхүүжилттэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй өрсөлдөж чаддаггүй байсан хувийн хэвшлийн чөлөөт хэвлэлүүд үйл ажиллагаагаа идэвхжүүлэх өргөн боломж нээгдсэнээр чөлөөт хэвлэлийн тогтолцоо чанарын шинэ түвшинд гарсан гэж сэтгүүл зүйн судлаачид дүгнэжээ.¹³

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид 2004 онд “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө” өгүүлэлдээ “1998 онд ‘Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай’ бяцхан боловч суурь чанарын хууль гарсан нь чухал алхам болсон билээ. Түүнд эргэн харж тодруулах зүйл бий ч гэсэн, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад цагдан хяналт тогтоохыг, тийм хяналт тавих байгууллага байгуулахыг, мөн тийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхийг, төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг тус тус хориглож, хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрийн нийтлэлийнхээ төлөө хариуцлага хүлээж байхыг тогтоосноороо, олон түмний хэвлэл мэдээллийн хэрэгслийг төр өмчлөхөөс татгалзсанаараа шинэ үзэл санаа нэвтрүүлж байна. Ялангуяа ‘Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно’ гэсэн заалт энэ талын эрх зүйн хэм хэмжээнүүдийг бүхэлд нь эргэн харж дүйцүүлэн шинэтгэхийг шаардаж байгаа юм. ... давуу тал нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хийгээд хэвлэл мэдээллийн бүлэг эрх чөлөөг үндсэн ба тулгуур хуулиар лавтай баталгаажуулж, цагдан хяналтыг халж, олон түмний хэвлэл мэдээллийн хэрэгслийг төр өмчлөхийг хориглон зогсоосон явдал юм. Сул тал нь гэвэл хуулийн биелэлт тааруу, суурь хуулиас өмнө ба дараа нь гарсан хуулиудад илүү хязгаарлалт, хориглолт, бас хийдэл байгаа явдал мөн гэх үндэс байна.” гэж онцолсон бөгөөд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх хийгээд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомжийн үзэл баримтлалыг алдагдуулж буй хууль тогтоомжийг:

- Урьдын адил үүрэгдэх, захиргаадах хандлага хараахан арилж гүйцээгүй байна.
- Хориглосон зарим заалт эргэлзээ төрүүлэхээр байна.
- Үндэслэл муутай хязгаарлалт цөөнгүй үзэгдэнэ.
- Олон түмний хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн эрх зүйн статусын талаар хуулийн хийдэл байна гэж 4 хэсэгт хуваан дүгнэжээ.¹⁴

Эндээс харахад, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хувьд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд бүрэн нийцсэн хэдий ч түүний үзэл баримтлал, зохицуулалтыг бусад хууль тогтоомжид баталгаажуулах, дэлгэрүүлэх явдал хангалтгүй байна.

¹² Д.Нарантуяа. Редакцийн зурвас (сэтгүүлч, редактор, редакцийн тухай; нийтлэлүүд). Улаанбаатар. 2021 он. 10-11 дэх тал

¹³ Б.Галаарид. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил. Улаанбаатар. 2018 он. 95 дахь тал

¹⁴ Б.Чимид. “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө”. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл (Хоёрдугаар дэвтэр). Улаанбаатар. 2004 он.

Б.Чимид сан. Үндсэн хуулийн үзэл баримтлал (хоёр дахь хэвлэл). Улаанбаатар. 2017 он. 205-215 дахь тал

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барьсан, хэлэлцсэн үйл явц

Өмнөх 1.2-т дурдсан нөхцөл байдалтай холбоотойгоор 2011 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тусдаа боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан бөгөөд хэлэлцүүлгийн явцад эдгээр төслийг нэгтгэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьсан төслийг голлохоор шийдвэрлэжээ.¹⁵ Энэ хуулийн төсөл хоёр парламент дамжсан бөгөөд 2013.01.24-ний өдөр хууль санаачлагч төслөө өөрөө татаж авсан байна.¹⁶

Тус хуулийн төслийг татсаны дараа сэтгүүлчийн асуултад Улсын Их Хурал дахь ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг “Хэлэлцүүлгийн явцад Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг батлагдана гэдэгт би итгэл үнэмшилтэй байсан. АН-ын бүлгийн хувьд ч дэмжиж байсан. Мөн иргэдийн зүгээс, сэтгүүлчдийн зүгээс дэмжлэг авч байсан ч эргүүлэн татахаас аргагүй болсон нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, хэвлэлийн эрх чөлөө эздийн гарт байгаагийн нэг илэрхийлэл гэж бодож байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эсрэг гол зогсч байгаа хүмүүс нь хэвлэлийн эзэд юм байна. Магадгүй ингэж хэллээ гээд маргаашаас надад маш их дарамт ирэх байх. Энэ хүмүүс олон жил өөрсдийнхөө дур зоргоор хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашигласан. Тэд хууль батлуулахыг эсэргүүцэж байна. Намрын чуулганаар хэлэлцэж байгаа хуулиудын хамгийн бэрхшээлтэй хууль нь энэ. Ерөнхийлөгч өөрөө сэтгүүлч мэргэжилтэй хүн учраас хэвлэлийн эрх чөлөөний төлөө бат зогсч байсан. Асуудлыг олон талаас нь авч үзэж, хуулийг батлуулах талаар ажилласан. Хуулийг татаж байгаа нь тодорхой шалтгаантай байгаа байх” гэж хариулж байжээ.¹⁷

Дээрх үйл явдлаас хойш буюу 2014 онд Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг зарим гишүүдийн хамт Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай шинэ хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэж буй тухайгаа мэдэгдсэн. Тэрээр “Миний хувьд өмнө нь багагүй хугацаанд ажилласан төслөө дахин сайжруулах гэж нэлээд ажиллалаа. Уншиж судаллаа. Дотоод гадаадын нэлээд хүмүүсээс санаа оноог нь ч сонслоо. Өөрийнхөө хэмжээнд шинэ төслийг бичиж дуусч байна. Одоо хамт өргөн барих хүсэлтээ илэрхийлж байсан гишүүдээ өгч хэлэлцүүлэх, санаа оноог нь тусгах ажил хийгдэнэ. Гишүүд уншиж судлаад, санал солилцсоны дараа хамт өргөн барих эсэхээ шийдэж таарна. Тэгэхээр яг одоо хэн хэн байхыг эцэслэн хэлэхэд арай эрт байна. Ямар ч гэсэн сэтгүүлчдийн зүгээс өргөн барих гишүүд сонирхлын зөрчилгүй байх ёстой гэж хэлж байгааг ойлгож, хүндэлж байгаа. ... Хаврын чуулганы хугацаанд амжиж өргөн бариад намрын чуулганаар хэлэлцүүлнэ гэсэн чигтэй байна. Хуулийн төслийг Ерөнхийлөгч өргөн барихаас өмнө, мөн УИХ-ын чуулганаар хэлэлцэх үед хэвлэл мэдээллийн салбарын олон хүмүүстэй хамтарч ажиллаж санаа оноог нь сонссон, хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг явсан. Зөвхөн энэ хуулийн төсөл дээр гэлтгүй ер нь сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл тойрсон асуудлаар би хувьдаа бүтэн жилийн турш байнгын мэдээлэлтэй байж олон удаагийн уулзалт ярилцлагуудад оролцлоо. Тухайлбал төслийн тодорхой асуудлаар Сэтгүүлчдийн эвлэл, зарим холбоод, бас “Глоб интернэйшнл”, Хэвлэлийн хүрээлэн зэрэг төрийн бус байгууллагууд ямар байр суурьтай байгааг ерөнхийдөө мэдэж байгаа. Бичгээр авсан

¹⁵ Хууль зүйн яамны 2013 оны үйл ажиллагааны товч тайланд Хууль зүйн сайдын тушаалаар нийт 29 ажлын хэсэг байгуулагдан холбогдох хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна гэж дурдсан байх бөгөөд үүнд “Хэвлэл мэдээллийн багц хуулийн төсөл” багтсан байна. 2014.04.01 <https://mojha.gov.mn/newmojha/?p=1522>

¹⁶ Б.Галаарид. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил. Улаанбаатар. 2018 он. 164 дэх тал <https://www.yumpu.com/en/document/read/61174886/->

¹⁷ “Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг эргүүлэн татлаа”. 2013.01.25 <https://gogo.mn/r/117578>

“М.Батчимэг: Хэвлэлийнх гэдэг хэний эрх чөлөө болохыг ярих цаг болжээ”. “Зууны мэдээ” сонин. 2013.01.29 <https://www.zms.mn/a/1073>

саналууд ч их байна. Өнөөдрийг хүртэл маш олон хүний хөдөлмөр, сэтгэл, дэмжлэг энэ хуулийн төсөлд шингэсэн. Тиймээс энэ удаа өмнө хийгдсэн бүх ажлууд дээр суурилоод төслийн шинэ хувилбарыг гаргаж ирэхэд харьцангуй хялбар байлаа. Шинэ төслийг өргөн барих гишүүдээр хэлэлцэгдэж бэлэн болмогц интернетэд тавьж нээлттэй санал авна гэж бодож байгаа. Бас зарим уулзалт, хэлэлцүүлэг ч хийх бодолтой байна.” гэжээ.¹⁸ Мөн “Нэгдмэл ойлголтод хүрсэн цагт Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль батлагдах хөрс суурь тавигдана” гэж онцолж байжээ.¹⁹

Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг нарын 7 гишүүн 2014.07.07-нд өргөн барьсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон холбогдох бусад 2 хуулийн төслийг Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулсан ч хэлэлцэлгүй хойшлуулж байгаад 2016 оны сонгуулиар бүрдсэн шинэ Улсын Их Хурлаас “хууль санаачлагч нь өөрчлөгдсөн, төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын санал, дүгнэлтийг авах шаардлагатай” гэж үзэж хууль санаачлагчдад нь буцаасан байна.²⁰ Энэ нөхцөл байдлыг сэтгүүлч, доктор Б.Галаарид “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэ төсөл ийнхүү хэдэн парламент дамжин хэлэлцэгдэхгүй байгаа нь Монголд хараат бус, чөлөөт хэвлэлийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх сонирхол хууль тогтоогчид, улс төрийн намууд, мөн хэвлэл мэдээллийн салбарын зарим хөрөнгө оруулагчдад байхгүй байгааг нотлон харуулж байна” гэж дүгнэжээ.²¹

Хүснэгт 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг өргөн барьсан, хэлэлцсэнтэй холбоотой тойм, 2003-2021

Огноо	Үйл явдал
<i>Монгол Улсын Ерөнхийлөгч</i>	
2009.09.10	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 105 дугаар зарлигийн хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009-2013 оны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.2-т “иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах шинэтгэлийн бодлого явуулна” гэж заасан.
2011.11.16	Монгол Улсын Ерөнхийлөгчөөс “Хуульчийн эрх зүйн байдлын тухай” болон “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төсөл санаачилсныг УИХ-ын дарга Д.Дэмбэрэлд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Д.Баттулга өргөн барьсан. ²²
2013.01.24	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлж байсан Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөө татан авсан.
2013.08.29	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 142 дугаар зарлигийн хавсралт “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013-2017 онд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.5.2-т “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулж, боловсронгуй болгоно” гэж заасан.
2017.12.28	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны “97 дугаар зарлигийн хавсралт “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017-2021 онд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.6-д “Иргэний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх эрх, хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг хамгаалж, “Дөрөв дэх засаглал”-ын үүднээс дэмжин, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл, санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлнэ” гэж заасан.
<i>Улсын Их Хурал</i>	

¹⁸ “М.Батчимэг: Мэргэжлийн сэтгүүлзүй л үлдэнэ”. 2014.05.28

<https://www.arslan.mn/politics/parliament/3624.shtml>

¹⁹ М.Батчимэг. “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар редакцийн хараат бус байдлыг хангах нь” илтгэл. Хэвлэлийн хүрээлэн. “Чөлөөт сэтгүүл зүйн эрх зүйн орчин” хэвлэл мэдээллийн удирдах ажилтны үндэсний хоёрдугаар чуулганы илтгэлийн эмхэтгэл. Улаанбаатар. 2013.10.04. 27 дахь тал

²⁰ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 44 дүгээр тогтоолын хавсралт “Хууль санаачлагчид нь буцаах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”

²¹ Б.Галаарид. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил. Улаанбаатар. 2018 он. 166 дахь тал

²² “Ерөнхийлөгч шинээр хоёр төсөл санаачилж УИХ-ын даргад өргөн барилаа”. 2011.11.16

<https://vip76.mn/content/11824>

2003.10.24	Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.5.4-т “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно” гэж заасан.
2009.05.14	Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 107-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулан хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох” зорилгоор Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг шинээр боловсруулах, тус төслийг Засгийн газар санаачлах, 2010 онд өргөн барихаар тусгасан.
2010.07.15	Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3-т “..., чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшилийг дэмжиж”, 3.3.4.3-т “Хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана.”, 3.6.1.4-т “...Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. ...”, 3.6.4.5-д “Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж заасан.
2012.09.18	Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т “хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшил, орлогыг ил тод болгож, хэвлэлийн байгууллагуудын бие даасан байдлыг дээшлүүлж, иргэний хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах” гэж тусгасан.
2012.09.18	Улсын Их Хурлын 2012 оны “Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 36 дугаар тогтоолын 10-т “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл” гэж заасан.
2014.07.07	Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг нарын 7 гишүүн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон холбогдох бусад 2 хуулийн төслийг өргөн барьсан.
2015.02.13	Улсын Их Хурлын 2015 оны “Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” 38 дугаар тогтоолын 24-т “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” гэж заасан.
2016.09.09	Улсын Их Хурлын 2016 оны 44 дүгээр тогтоолын хавсралт “Хууль санаачлагчид нь буцаах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”-ын 59-т Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг нарын 7 гишүүний 2014.07.07-нд өргөн барьсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон холбогдох бусад 2 хуулийн төсөл орсон.
2016.09.09	Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3.8-д “Хэвлэлийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчинг сайжруулж, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн баталгааг хангана” гэж тусгасан. ²³
2020.05.13	Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.5.9-д “Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ” гэж заасан.
2020.08.28	Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.6.4-т “Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр хөгжүүлнэ”, 4.4.11-т “Монгол Улсын Үндсэн хуульд заасан ... мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна” гэж тусгасан.
2021.01.22	Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 83-т “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгчийг ил тод болгох, сэтгүүлчийн эх сурвалжийн нууцлалыг хамгаалах эрхийг баталгаажуулах, редакцийн хараат бус байдлыг

²³ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.12.19-ний өдрийн А/233 тоот тушаалаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулжээ. Тус ажлын хэсэг 2019.02.21-ний өдөр хуралджээ. <https://mojha.gov.mn/newmojha/?p=1919>

	нэмэгдүүлэх, мэдээллийн хэрэгслийн бие даасан, олон ургалч байдлыг дэмжсэн бодлоготой болох, түүний хүрээнд хэвлэл мэдээллийн бие даасан байдлыг хангах, ёс зүйтэй сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн өөрөө удирдах ёсны зарчмыг дэмжих хүрээнд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” зорилгоор Засгийн газар санаачлан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг өргөн мэдүүлэхээр тусгасан.
<u>Засгийн газар</u>	
2012.11.03	Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 316-д 2013-2014 онд “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төслийг боловсруулна” гэж заасан.
2016.10.26	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2018-2020 онд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах”, энэ ажлыг ХЗДХЯ хариуцан хэрэгжүүлэх, ингэхдээ 2018 онд “Хуулийн төслийг боловсруулах бэлтгэл ажлыг хангах, холбогдох тооцоо, судалгаа хийх”, 2019 онд “Хуулийн төсөл боловсруулах”, 2020 онд “Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх”-ээр тусгасан.
2017.04.12	Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2017-2019 онд “Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг шинэчлэн боловсруулж, эрх зүйн орчинг сайжруулах” гэж тусгасан.
2020.12.09	Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2020-2024 онд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж тусгасан бөгөөд энэ ажлыг ХЗДХЯ хариуцан хэрэгжүүлэх, ингэхдээ 2022 онд “Хуулийн төслийн судалгааг хийлгэсэн байна”, 2023 онд “Хуулийн төслийг боловсруулсан байна”, 2024 онд “Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулсан байна” гэж заажээ.
2021.12.31	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны “Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө батлах тухай” 91 дүгээр тушаалаар “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-г баталсан. 2021-2023 онд хэрэгжүүлэх тус төлөвлөгөөнд “Хэвлэлийн эрх чөлөөг хангах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн орчныг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл, түүний үзэл санаанд нийцүүлэх” талаар тусгасан. ²⁴

Эндээс харахад, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барих, хэлэлцэн батлах бодлого хэвээр үргэлжилж байна.²⁵ Энэ хүрээнд боловсруулсан, хэлэлцүүлсэн хуулийн төслүүдэд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид, хөндлөнгийн судлаачид дүн шинжилгээ хийж, тодорхой зөвлөмжийг тухай бүр өгчээ.

Хүснэгт 2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийн талаарх шүүмжийн тойм

Хуулийн төсөл	Шүүмж, зөвлөмж
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 11 дүгээр сард өргөн барьсан төсөл	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 онд өргөн барьсан төсөлд Улсын Их Хурлын ажлын хэсгээс зохих өөрчлөлт оруулсан 2013.01.15-ны өдрийн хувилбарт Канадад төвтэй “Хууль ба ардчилал төв”-өөс 2014 оны 4 дүгээр сард дүн шинжилгээ хийж ирүүлсэн байна. ²⁶ Энэхүү дүн шинжилгээгээр Хэвлэл мэдээллийн зөвлөл; ёс зүйн дүрэм зөрчсөнтэй холбоотой гомдлыг

²⁴ “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө IV”. 2021.12.31 <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2021-2023/>

²⁵ Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар 2020-2021 оны ажлын тайландаа “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэжээ. Х.Нямбаатар. “Эрх зүйн шинэтгэл II” ажлын тайлан — 2020-2021. <https://online.fliphtml5.com/actjo/xxwy/#p=1> 109 дэх тал

²⁶ Centre for Law and Democracy. “Mongolia: Note on the Law on Freedom of the Media”. April 2014. <http://www.law-democracy.org/>

	хүлээн авах, шийдвэрлэх асуудал; бусад асуудлаар дэлгэрэнгүй зөвлөмж өгсөн байна.
Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг нарын 2014 оны 7 дугаар сард өргөн барьсан төсөл	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгчөөс 2015 оны 2 дугаар сард тус төсөлд дүн шинжилгээ хийж ирүүлсэн байна. ²⁷ Энэхүү дүн шинжилгээгээр хэвлэл мэдээллийн байгууллага; сэтгүүлч зэрэг нэр томъёоны тодорхойлолт, сэтгүүлчийн эх сурвалжаа хамгаалах эрх, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээг тодорхой болгох, тус зөвлөлийн санхүүжилтийн асуудлаар дэлгэрэнгүй зөвлөмж өгсөн байна.
Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.12.19-ний өдрийн А/233 тушаалаар байгуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийн 2020 оны 2 дугаар сард танилцуулсан төсөл ²⁸	Глоб интернэшнл төвөөс тус төслийн талаар 2020 оны 3 дугаар сард “Ажлын хэсгийн боловсруулсан хуулийн төслийн одоогийн хувилбар нь дэвшилтэт зарим зүйл агуулсан боловч нарийвчилсан зохицуулалт үгүй, мөн олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудтай зөрчилдөж буй бөгөөд ойлголтын зөрүүтэй асуудлууд байна” гэж шүүмжилжээ. ²⁹ Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2020 оны 3 дугаар сард “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан ‘Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт’ гэсэн бүлэг дэх заалтууд нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын мөн чанарыг үгүйсгэсэн, ‘өөрийн зохицуулалт’ нэрээр Монголын бүхий л хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төрийн хяналтад оруулж, сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйн асуудлыг төрийн оролцоотой шийдэх гэсэн оролдлогыг илэрхийлсэн, олон улсын тавцанд ардчилсан Монгол Улсын нэр хүндийг сэвтээсэн, хэвлэлийн эрх чөлөөний индексийг бууруулсан үйлдэл болно гэж үзэж байна” гэж шүүмжилжээ. ³⁰ Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл 2020 оны 2 дугаар сард “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагыг байгуулахдаа Засгийн газраас анхных нь хурлыг зохион байгуулах, төлөөлөгчдийг нь сонгох асуудлыг Засгийн газрын харьяа яам зохион байгуулна гэсэн заалт бүхий дагаж мөрдөх журмын тухай хуулийг Хууль зүйн яамны Ажлын хэсгээс санаачилсан байна. Энэ асуудлыг бид ярилцаад дээрх саналыг бүгдийг нь хасах хэрэгтэй гэдэг дээр санал нэгдсэн” гэжээ. ³¹ Тус эвслээс 2020.12.17-нд зохион байгуулсан хэвлэл мэдээллийн эвслэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн хуралдаанаар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах чиглэлээр Үндэсний түр зөвлөл байгуулж, дөрвөн дэд ажлын хэсгийг байгуулжээ. ³²

²⁷ Organization for Security and Co-operation in Europe (OSCE). The Representative on Freedom of the Media. “Law of Mongolia on Freedom of Media”. Reviewed by Eve Salomon, Director of Salomon Whittle Ltd. February 2015. <https://www.osce.org/files/f/documents/4/e/165056.pdf>

²⁸ Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Эстони, ОХУ, БНСУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, онцлог эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны зохион байгуулалт зэргийг судалсан байна. Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулж ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн байх бөгөөд ажлын хэсгийн хурлыг 2019.02.21, 2019.10.10, 2019.10.16-ны өдрүүдэд нийт 3 удаа хуралдуулсан. Түүнчлэн 2019.10.18-ны өдөр Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс зохион байгуулсан хэлэлцүүлэгт хуулийн төслийн талаар танилцуулга хийж, 2019.10.30-ны өдөр Сэтгүүлчдийн ёс зүйн форумд оролцож, тус хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлагын талаар хэлэлцүүлсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны үйл ажиллагааны тайлан. <https://mojha.gov.mn/newmojha/?p=3631>

²⁹ Глоб Интернэшнл төв 2021.02.01-ний өдрийн мэдэгдэл <https://www.gic.mn/post/r/1565>; Глоб Интернэшнл төв Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулах Ажлын хэсгээс чөлөөлөгдөх саналаа Хууль Зүй, Дотоод Хэргийн сайд Ц.Нямдоржид 2020.02.19-ний өдөр хүргүүлжээ. <https://www.gic.mn/post/r/1496>;

³⁰ Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл “Хэвлэл мэдээлэлд төрийн хяналтыг нэмэгдүүлэх гэж байгааг ХМЗ эсэргүүцэж байна”. 2020.03.03 <https://www.mediacouncil.mn/a/154>

³¹ “Х.Мандахбаяр: Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд сэтгүүлч бүрийн санал хэрэгтэй”. 2020.02.21 <https://cmj.mn/7d>

2020.12.17-ны өдөр Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын хэвлэлийн хүрээлэн, Монголын телевизүүдийн холбоо, Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо, Монголын сайтын холбоо, Монголын үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбоо, Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо, Монголын гэрэл зурагчдын холбоо, Хангарди Улаанбаатарын сэтгүүлчдийн холбоо, Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клуб, Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн Эв нэгдэл төв зэрэг 21 эвлэл, холбоо нэгдэж Хэвлэлийн эрх чөлөөний төлөө Үндэсний түр зөвлөлийг байгуулжээ. Тус түр зөвлөл хэвлэл мэдээллийн салбарынхан өөрсдөө хуулийн төслөө боловсруулан санал болгох нь зүйтэй гэж үзсэн байна.

³² “Хэвлэлийн эрх чөлөөний төлөө үндэсний түр зөвлөл байгуулагдлаа”. 2020.12.18 <https://equur.mn/163925/>

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах хууль тогтоомжийн төслүүдэд олон улсын байгууллага, шинжээчдээс өгсөн зөвлөмжийг энд дэлгэрүүлж үзье.

Хууль ба Ардчилал төвийн 2014 оны зөвлөмж

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 онд өргөн барьсан төсөлд Улсын Их Хурлын ажлын хэсгээс зохих өөрчлөлт оруулсан 2013.01.15-ны өдрийн хувилбарт Канадад төвтэй “Хууль ба ардчилал төв”-өөс 2014 оны 4 дүгээр сард өгсөн зөвлөмж:

1/ Хэвлэлийн зөвлөлийн зохицуулалтын талаар:

- Хэвлэлийн зөвлөлийг байгуулах мэргэжлийн холбоодын төлөөлөгчдийн хуралд хэн оролцохыг хуулиар тодорхой зааж өгөх ёстой бөгөөд хурлын гишүүдийн дунд хэвлэн нийтлэгчдийг байлцуулах эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй.
- Хэвлэлийн зөвлөлийг байгуулах мэргэжлийн холбоодын төлөөлөгчдийн хурлаас зөвлөлийн гишүүдийг томилох нь урт хугацаандаа үр дүнтэй байх уу, эсвэл үүнийг хийх илүү хөнгөн, төвөг багатай аргыг хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй.
- Хэвлэлийн зөвлөлийн гишүүдийн тоог тогтоох, хэн нэр дэвших боломжтойг зааж өгөх зэрэг хүмүүсийг томилох үйл явцтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хуульд нарийвчлан тусгах ёстой.
- Хэвлэлийн зөвлөлийг байгуулах мэргэжлийн холбоодын төлөөлөгчдийн хурал нь Зөвлөлийн дотоод хэрэгт үүрэг гүйцэтгэх ёсгүй. Хуралтай холбоотой гэх мэт гол дүрмүүд нь хуульд заасан байх ёстой бөгөөд зөвлөл нь бусад дотоод дүрмийг хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байх хэрэгтэй.
- Бие даасан хараат бус байдлыг хамгаалах үүднээс Хэвлэлийн зөвлөлийг олон нийтийн санхүүжилтээр хангахад анхаарах хэрэгтэй.

2/ Ёс зүйн дүрэм зөрчсөн талаарх гомдол хүлээн авах, шийдвэрлэх талаар:

- Гомдол гаргах дотоод тогтолцоог бүрдүүлж, “Хэвлэл мэдээллийн байгууллага гомдлыг хянан шийдвэрлэх” 14 дүгээр зүйлийг хасах талаар анхаарах хэрэгтэй.
- Хэвлэлийн Зөвлөлийг байгуулах мэргэжлийн холбоодын төлөөлөгчдийн хурлаас сэтгүүлчийн ёс зүйн нийтлэг дүрэм батлах 15.5.1 болон Хэвлэлийн зөвлөл хэвлэл мэдээллийн салбарт мөрдөх нийтлэг ёс зүйн дүрэм, хэм хэмжээ тогтоох 16.1.1 дэх заалтын зөрүүг шийдвэрлэх хэрэгтэй.
- Ёс зүйн нийтлэг дүрмийг Хэвлэлийн зөвлөлийг байгуулах мэргэжлийн холбоодын төлөөлөгчдийн хурал эсвэл өөр бусад байгууллага батлах уу гэдгийг анхаарч үзэх хэрэгтэй.
- Гомдол гаргагчийг ёс зүйн нийтлэг дүрмийг хэрэгжүүлэх тогтолцоогоор болон шүүхээр нэгэн зэрэг гомдол гаргах арга хэмжээ авахыг хуулиар хориглох хэрэгтэй.
- Хэвлэлийн зөвлөлөөс авах боломжтой арга хэмжээний хүрээ, хариу өгөх эрх болон зөвлөлөөс гаргасан мэдэгдлийг хэрэгжүүлэх үүргийг хамруулан анхааран үзэх хэрэгтэй.
- Дүрэм зөрчсөн нь тогтоогдсон эсэхээс үл хамааран Хэвлэлийн зөвлөл нь шүүхэд хэвлэл мэдээллийн байгууллагыг төлөөлөх үүрэг хүлээх ёсгүй.

3/ Бусад асуудлын талаар:

- 3.1.1-т заасан хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон 3.1.2-т заасан хэвлэл мэдээллийн байгууллагын тодорхойлолтын аль нь хэрэгтэй эсэхийг харгалзан үзэх ёстой. Аль ч тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж хууль ёсны дагуу бүртгүүлсэн байгууллагуудаар хязгаарлагдах ёсгүй.
- Үндсэн хуульд бусад хууль тогтоомж нийцэх ёстой талаар нэгэнт зохицуулсан тул 5.1 дэх заалтыг хуулиас хасах хэрэгтэй.

- “Улсын Их Хурал, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага хууль тогтоомж, эрх зүйн акт, түүнтэй холбоотой лавлагаа, мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор эмхтгэл, товхимол, цахим хуудас гаргах” гэсэн 6.1.1 дүгээр заалтыг хуулиас хасах эсвэл Засгийн газрын буюу төрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл түгээх боломжийг хязгаарлахгүйн тулд ихээхэн өргөжүүлэх хэрэгтэй.
- “Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод байлгах зорилгоор шууд нэвтрүүлэг явуулах төлөвизийн сувагтай байж болно” гэсэн 6.1.2 болон “Засгийн газар Монгол Улсын тухай мэдээллийг дэлхий дахинд түгээх, сурталчлах үйл ажиллагаа эрхэлдэг мэдээллийн хэрэгсэлтэй байж болно. Үүнтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулна” гэсэн 6.1.3 дугаар заалтыг хуулиас хасах эсвэл олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл түгээхэд Монголын Үндэсний Өргөн нэвтрүүлэгч буюу МҮОНРТ-ийн үүргийг хүлээн зөвшөөрөх асуудалд өөрөөр хандах хэрэгтэй.
- “Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчийн зүгээс сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд улс төрийн цензур тавих, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно. Сэтгүүлчийн мэргэжлийн хараат бус байдлыг хангах асуудлыг хэвлэл мэдээллийн байгууллагын дүрэм, журам, сэтгүүлчтэй байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд тусгана” гэх 8.1 болон “Хэвлэл мэдээллийн байгууллага нь үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчтэй сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах гэрээ байгуулж, байгууллагын дотоод дүрэм, журамд тусгах үүрэг хүлээнэ” гэх 8.2 дахь заалт дээр дурдсан дүрмийг ядаж л редакц, сэтгүүл зүй болон хараат бус байдлын асуудлаар ил тод байдлыг бий болгоход анхаарч үзэх чиглэлээр солих хэрэгтэй.
- “Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч дараах тохиолдолд олж авсан мэдээллийнхээ эх сурвалжийг илчлэхгүй байх үүрэгтэй” гэсэн 9.1 дүгээр заалт, “мэдээллийн эх сурвалжийг нууцлах” тодорхойлолт бүхий 3.1.3 заалтыг хэн нэгний хувийн нууц эх сурвалжийг задруулахгүй байх эрхтэй гэсэн заалтаар солиход анхаарч үзэх хэрэгтэй. “Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь энэ хуулийн 9.1-д заасан үндэслэлээр нэрээ нууцлахыг хүссэн мэдээлэгчид холбогдох мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн 9.2 дахь заалт нь “мэдээллийн эх сурвалжийг задруулах нь бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил, албан тушаалын байдал, орлогод хохирол учруулж болзошгүй бол” гэсэн 9.1.2 дахь заалттай давхардсан тул хасах хэрэгтэй.
- Тохиромжтой тохиолдолд эх сурвалжийн хамгаалалтыг цуцлах боломжийг шүүхэд олгох талаар харгалзан үзэх хэрэгтэй.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүжүүлэгч, эзэмшигчийг ил тод болгохгүй байх нь хууль бус байх асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй.
- Аль хэдийн хууль тогтоомжоор хориглосон зүйлийг давхардуулж оруулахгүйн тулд хуулийн төслөөс “Хэвлэл мэдээллийн байгууллага нь Үндсэн хуульт байгууламжийг хууль бусаар өөрчлөх, хүчирхийлэл, садар самуун болон бусад гэмт хэргийг сурталчлах, олон нийтийг уриалах, оюуны өмчийн эрхийг зөрчих, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг задруулах, хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг нотлох баримтгүйгээр, санаатайгаар гутаах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн 12.1, “Хэвлэл мэдээллийн байгууллага нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг санаатайгаар гутаан доромжилсон болон бусад хууль бус мэдээллийг сэтгэгдэл болон бусад хэлбэрээр дамжуулан нийтлэх, нэвтрүүлэх боломжийг гуравдагч этгээдэд олгохыг хориглоно” гэсэн 12.2 болон “Иргэн алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл шүүхэд хандахдаа Иргэний хуулийн 21.2-т зааснаар нотлох үүргийг өөрөө хүлээнэ” гэсэн 13.3 дугаар заалтыг хасах хэрэгтэй.
- 12.3, 12.4-т тусгагдсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээний хөтөлбөрт төлбөртэй, захиалгатай мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг оруулахыг хориглоно.”, “Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч аливаа этгээдийг тодорхой мэдээлэл, нийтэлж, нэвтрүүлэхээр дарамтлах, шахалт үзүүлэх, нийтэлсэн болон нийтлээгүйн төлөө төлбөр, шан харамж авах, авах оролдлого хийхийг хориглоно” гэсэн асуудлыг хуульд шууд тусгахаас илүү дүрмээр зохицуулах талаар анхаарах нь зүйтэй.

- Хуулийн 13.4, 13.5 дахь заалтыг буюу “Төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан өөрт холбогдох сөрөг мэдээллийг тайлбарлах үүрэг хүлээнэ”, “Тайлбар хийсэн асуудлаар нэмэлт баримт, нотолгоогүйгээр дахин мэдээлэл түгээвэл гомдлоо энэ хуулийн 13.2, 14.1, 14.2-т зааснаар шийдвэрлүүлж болно” гэсэн тодорхойгүй зохицуулалтыг хасах асуудлыг анхаарч үзэх хэрэгтэй.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын 2015 оны зөвлөмж

Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг нарын 2014 оны 7 дугаар сард өргөн барьсан төсөлд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгчөөс 2015 оны 2 дугаар сард өгсөн зөвлөмж:

Тусгайлсан зөвлөмж:

- Хуульд “хэвлэл мэдээллийн байгууллага”-уудад олгох эрх, хамгаалалтыг тодорхойлжээ. Харьяаллын талаар тодорхой заагаагүй тул тус хууль нь зөвхөн Монгол Улсын өмчит хэвлэл мэдээллийн байгууллагууд, эсвэл Монгол Улсад үйл ажиллагаа явуулж, хүлээн авч байгаа аль нэг хэвлэл мэдээллийн байгууллагад үйлчлэх эсэх нь тодорхойгүй байна. Тус хуульд интернэтээр түгээгдэх нийтлэлүүдийг хамрахаар заасан тул энэ тодорхойлолт орхигдуулж болохгүй чухал зүйл юм. Тиймээс хуульд зөвхөн Монгол Улсад үүсгэн байгуулагдсан (эсвэл бүртгэлтэй) хэвлэл мэдээллийн байгууллага, тэдгээрт хувь нэмрээ оруулж буй сэтгүүлчид хамаарах эсэхийг тодорхой болгох ёстой.
- Хууль нь ажил олгогч, гэрээт байгууллагын статусаас үл хамааран бүх хэвлэл мэдээллийн байгууллагуудад хамааралтай эсэхийг тодорхой болгох хэрэгтэй. “Сэтгүүлч” гэдэг тодорхойлолтод хэвлэл мэдээллийн байгууллагатай хөдөлмөрийн гэрээний харилцаатай эсэхээс үл хамааран сэтгүүл зүйн чиг үүргийг гүйцэтгэж буй хэн бүхнийг хамруулах ёстой. Сэтгүүл зүйн эх сурвалжийн хамгаалалт, Хэвлэл мэдээллийн зөвлөл дэх оролцоотой холбоотой заалтууд нь гэрээт ажилтан эсэхээс үл хамааран бүгдэд хүртээмжтэй байх.

Зөвлөмжийг илүү нарийвчлан задлан шинжилж дор оруулсан болно.

- “Хэвлэл мэдээллийн байгууллага” гэдэг тодорхойлолтыг зөвхөн редакц нь редакцын шийдвэр гаргадаг хэвлэл мэдээллийн хэрэгслд хамаатай гэдгийг тодорхой болгох үүднээс өөрчлөлт оруулах ёстой.
- “Сэтгүүлч” гэдэг тодорхойлолтод хэвлэл мэдээллийн байгууллагатай ямар нэгэн гэрээгээр ажилладаг эсэхээс үл хамааран сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлж буй хэн бүхнийг хамруулах ёстой.
- 4.2-т “Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээ, мэдээллийг хайх, хүлээн авах, хадгалах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх зэрэг сэтгүүл зүйн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хараат бусаар, чөлөөтэй эрхэлнэ” гэсний “хуулийн хүрээнд хараат бусаар, чөлөөтэй” гэсэн сүүлийн үгийг хасч өөрчлөх хэрэгтэй. Хэдийгээр заалтын бусад хэсэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага хоорондын гэрээ болон бусад харилцаанаас үл хамааран гэж заасан байгаа ч үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор хуулийн тодорхойлолтын хэсэгт оруулах нь ашигтай байх болно.
- Эх сурвалжийг хамгаалах эрх нь ардчилсан нийгэмд сэтгүүл зүйн хэвийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Олон улсын шилдэг туршлагыг хэрэгжүүлэхийн тулд эх сурвалжийг хамгаалах эрхийг түдгэлзүүлэх үндэслэлүүд нь хүнд гэмт хэрэг эсвэл гэм буруутай этгээдийг өмгөөлөхөд хязгаарлагдмал байх хэрэгтэй. Гэмт хэргийн мөрдөн байцаалт, өмч хөрөнгийн хамгаалалт нь маш доогуур түвшний үндэслэл бөгөөд энэ нь сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг шаардахад ашиглагдаж болохгүй.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлд бүс нутгийн төлөөлөлтэй байхыг тусгах ба сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас дор хаяж нэг төлөөллийг бүс нутгаас оролцуулахыг зөвлөж байна. Учир нь голдуу нүүдэлчин хүн амтай, өргөн уудам газар нутагт ажиллаж буй сэтгүүлчдийн асуудал нь Улаанбаатар хотод ажилладаг сэтгүүлчдээс эрс ялгаатай. Ялангуяа энэ нь мэдээ цуглуулахад ашиг сонирхлын зөрчил үүсэхтэй холбоотой.

- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гишүүдийг тогтмол сэлгэж, хэвлэл мэдээллийн байгууллага болон олон нийтийн дунд ёс зүйн дүрмийн талаарх түвшинг тогтмол байлгахын тулд анхаарах ёстой.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гишүүнээр асуудлыг бүхэлд нь шийдүүлж үлдээхээс илүү ардчилсан хариуцлагыг нэмэгдүүлэх нь зүйтэй. Хэвлэл мэдээллийн зөвлөл нь ёс зүйн дүрэм (эсвэл түүнд оруулсан өөрчлөлт), өөрийн үйл ажиллагааны дүрэм, жилийн төсвөө батлахын өмнө гишүүдтэй зөвшилцөх үүрэгтэй. Энэхүү хэлэлцүүлгийг Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Хэвлэл мэдээллийн эздийн холбоо болон Хэвлэл мэдээллийн зөвлөлд сайн дураараа бүртгүүлсэн аливаа хүн, байгууллага (жишээ нь эвлэлд харьяалагддаггүй иргэний сэтгүүлчдийг харгалзан үзэх)-ыг хамруулан хийх хэрэгтэй. Томоохон хэмжээний уулзалт зохион байгуулахад зарцуулах зардал, цаг хугацаа үрэхээс зайлсхийж бичгээр зөвлөлдөх боломжтой байх ёстой.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагуудад хариуцлага тооцно гэж үзэж байгаа ч үүнийг тодорхой болгох хэрэгтэй.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс ирүүлсэн санал хүсэлтийг төрийн аль байгууллага хариуцаж, хууль тогтоомжийн өөрчлөлтөд анхаарч ажиллахыг үүрэг болговол тохиромжтой.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн санхүүжилтийн 60 хувийг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас бүрдүүлэн, гишүүдтэйгээ зөвшилцсөний үндсэн дээр Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс шийдвэрлэнэ гэж нэмж тусгаснаар Хэвлэл мэдээллийн зөвлөлийн санхүүжилтийг тодотгож болно. Хэвлэл мэдээллийн зөвлөлд гадаадын төрийн бус байгууллагуудын хандив тусламжийг зарцуулж болох бөгөөд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас орж ирэх санхүүжилтийг бууруулахад хувь тэнцүүлэн зарцуулна.
- Хориг арга хэмжээний тухай заалтууд зарим тохиолдолд үр дүнгүй, зарим тохиолдолд тодорхой бус байж болох тул сайтар нягтлан үзэх шаардлагатай.
- Засгийн газар өөрөө хууль зөрчсөн нь ноцтой зүйл байх ёстой. Албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулахаас гадна холбогдох газрын даргыг албан тушаалаас нь огцруулах шийтгэл оногдуулахыг зөвлөж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын хэсгээс 2021 оны 3 дугаар сард 80 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны дунд хийсэн судалгааны дүнгээс харахад, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын 83.8% нь үзсэн байна. Энэхүү хууль тогтоомжийг сайжруулснаар “иргэний мэдээлэл авах эрх хангагдана” гэж 48.8%, “чөлөөт хэвлэл хөгжих орчин, нөхцөл сайжирна” гэж 46.3%, “сэтгүүлчийн ёс зүй сайжирна” гэж 42.7% үзсэн бол 41.5% нь “сэтгүүлчийн мэргэжлийн эрхийг хангана” гэсэн хүлээлттэй байгаагаа онцолжээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд эх сурвалжаа нууцлах эрхийг хангах, сэтгүүлчийн бие даасан, аюулгүй байдлыг хангах, хууль хүчний байгууллагад дуудагдаж, айлган сүрдүүлэгт өртөх явдлыг халах, төрийн байгууллагын нээлттэй байдлыг бий болгох, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг заах зэрэг асуудлыг тусгах нь чухал гэж судалгаанд оролцогчид үзжээ.³³

Энэ нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, батлах талаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны дунд нэгэнт хүлээлт бий болсон бөгөөд гагцхүү өмнө боловсруулсан, хэлэлцүүлсэн хуулийн төслүүдэд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид, хөндлөнгийн судлаачдын хийсэн дүн шинжилгээ, тодорхой зөвлөмжийг зайлшгүй анхаарч, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг цогц хууль тогтоомжоор баталгаажуулах нь чухал болохыг харуулж байна.

³³ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”. Улаанбаатар. 2021.05.03. 15 дахь тал
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2021.01.13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/01 дүгээр тушаалаар байгуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөө, мэдэх эрхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын санал боловсруулах Ажлын хэсэг

2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Өмнөх хэсэгт дурдсанаар, Улсын Их Хурлаас 1998.08.28-ны өдөр баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль дангаараа хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангахад дутагдалтай байна. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий алба зохион байгуулалтын хувьд бэхжээгүй бөгөөд хүний нөөц тогтворгүй байгаа нь дээрх байдал бий болох нэг шалтгаан болж байна.³⁴ Мөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах нарийвчилсан зохицуулалт үгүй, холбогдох хууль тогтоомж олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмуудтай зөрчилдөж байна. Зөвхөн үүгээр хязгаарлагдахгүйгээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд саад буй болж хүчин зүйлс буюу нөхцөл байдал илүү өргөн хүрээтэй байх бөгөөд түүнийг дараах таван хэсэгт хуваан энд дэлгэрэнгүй авч үзье.

- Улс төрийн нөхцөл байдал;
- Эдийн засгийн нөхцөл байдал;
- Эрх зүйн зохицуулалт;
- Нийгэм-соёлын нөхцөл байдал;
- Сэтгүүлчдийн аюулгүй байдал.

Ингэхдээ “Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагаас тогтмол эрхлэн гаргадаг “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийг тодорхойлоход хэрэглэж буй 80 гаруй асуултад хариулж дээрх таван нөхцөл байдлыг дүгнэв.

2.1. Улс төрийн нөхцөл байдал

Энэ хэсэгт улс төрийн нөхцөл байдлыг судалгааны асуулт бүрийн хүрээнд дүгнэв.

2.1.1. Төр засгийн зүгээс түүний үйл ажиллагааг дэмжин сайшаадаг, эсхүл шүүмжилдэг болон олон нийтийн хэвлэл мэдээллийн редакцийн агуулгад нөлөөлдөг эсэх

Улсын Их Хурлаас 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “...Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэж, 3.2-т “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” гэж тус тус заасан. Гэвч редакцийн агуулгад төрөөс нөлөөлөх буюу түүнийг өөрчлөх боломж олгосон хууль тогтоомж хэд хэд байна.

Тухайлбал, Улсын Их Хурлаас 2019.06.06-нд баталсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 32 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг”-ийг тодорхойлсон бөгөөд 32.1-т “Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, сурвалжлага хийх, нэвтрүүлэг бэлтгэхдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно”, 32.2-т “Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлнэ”, 32.4-т “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл, нийтлэлийн агуулга, хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирох, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, өөрийн эрх, ашиг сонирхлыг хууль

³⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан. Улаанбаатар. 2017. 65 дахь тал

ёсны аргаар хамгаалах арга замыг тодорхой тусгаж хэрэгжүүлнэ.”, 32.6-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглоно.”, 32.8-д “Хэвлэл, мэдээллийн байгууллага гэмт хэргийн шинжтэй, илт хууль бус нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгааны тухай асуудлыг цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.”, 32.3-т “Энэ хуулийн 32.2-т заасан хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”, 32.5-д “Энэ хуулийн 32.4-т заасан агуулга бүхий нийтлэл, мэдээллийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж, нийтэлж байгаа нийт мэдээлэлд эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж тус тус заасан.³⁵

Дээрх зүйл, хэсэгт заасан гэмт хэрэг, зөрчил гэдэг нь өргөн хүрээг хамарч байна. Улсын Их Хурлаас 2015.12.03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-д зааснаар нийт 20 бүлгийн 213 зүйлийн гэмт хэрэг бий.³⁶ Улсын Их Хурлаас 2017.05.11-ний өдөр баталсан Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд зааснаар нийт 13 бүлгийн 214 зүйлийн зөрчил бий.³⁷ Энэ нь нийт хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд нийт 427 төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх, нийтлэхэд агуулгын хяналт тавих нөхцөл болж байна. Одоогоор “хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журам” болон “гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийтлэл, мэдээллийн эзлэх хувь, заавал нэвтрүүлбэл зохих нийтлэл, мэдээллийн доод хэмжээ”-г батлаагүй ч тэрхүү журам, хэм хэмжээ нь төрөөс мэдээллийн агуулгад нөлөөлөх байдлаар хэрэгжих үр дагавартай байна.

Дээр дурдсанаас гадна,

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.13-т “олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх” гэж,³⁸
- “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 14.1-т “Хэвлэл мэдээллийн байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын онцгой комисс болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн сэрэмжлүүлэг, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлнэ” гэж, 14.2-т “Цар тахлын талаарх цаг үеийн болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой үнэн, бодит мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ” гэж,³⁹ Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Түр хороо байгуулах тухай” 29 дүгээр тогтоолын 4-т “мэдээ,

³⁵ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2019 он, №42

³⁶ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2016 он, №7

³⁷ Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2017 он, №24

³⁸ Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2017 он, №7

³⁹ Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2020 он, №17

мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх” гэж,⁴⁰

- Цагдаагийн албаны тухай 59.1.2-т “Шуурхай мэдээлэл нийтэд түгээх шаардлага гарсан тохиолдолд өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглах” гэж,⁴¹
- Онц байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4-т онц байдал зарласан бол “олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох” арга хэмжээ тогтоож болно гэж тус тус заасан бөгөөд энэ нь урьдчилсан цензур тавих нөхцөлийг бүрдүүлж байна.⁴²

Мөн Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1.3-т “хуулиар түгээхээр тусгайлан заасан сэрэмжлүүлгийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг харгалзалгүйгээр холбогдох шийдвэрт заасан давтамжаар үнэ төлбөргүйгээр түгээгээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

2008 онд нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд дөрөв хоногийн хугацаатай онц байдал тогтоох үед Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээс (МҮОНТ) бусад бүх радио, телевизийн үйл ажиллагааг зогсоосон. Түүгээр ч зогсохгүй цагдаагийн байгууллагаас сэтгүүлчдийг сурвалжлага хийхийг хориглож, видео хальсуудыг хураасан. Арилжааны телевизийн сэтгүүлчдийг Төрийн ордонд орохыг хориглож, Засгийн газар болон Улсын Их Хурлын хуралдааныг сурвалжлах эрхийг нь хааж байсан.⁴³

Нийслэлийн засаг даргын цахим хуудаст 2020.11.22-ны өдөр гарсан мэдээлэлд “Хэвлэл мэдээллийн байгууллагуудын автомашинд зөвшөөрөл олгох журам”-ын талаар дурдсан байх бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагын автомашинуудад Улаанбаатар хот доторх замын хөдөлгөөнд оролцох QR код бүхий зөвшөөрөл олгох бөгөөд QR код бүхий зөвшөөрөл авах автомашины тоог тогтоохдоо телевиз 10 хүртэлх автомашин, өдөр тутмын сонин 1-3 хүртэлх автомашин, мэдээллийн сайт 1-3 хүртэлх автомашин, ФМ, радио 1-3 хүртэлх автомашин байхаар тусгажээ. Гэвч энэ журмыг аль байгууллага, хэзээний ямар шийдвэрээр баталсан болох, ямар хууль тогтоомжийг үндэслэсэн болох талаарх мэдээлэл байхгүй. Үүнээс гадна, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөл, хэлбэрээр ялгавартайгаар зөвшөөрөл олгосон үндэслэлийн талаар дурдаагүй байна.⁴⁴

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн талаар НҮБ-ын Хүний эрхийн хорооны 102-р чуулганаар баталсан тайлбарын 44-т “Сэтгүүл зүй бол мэргэжлийн, бүтэн цагаар ажиллаж буй сурвалжлагч, шинжээч, мөн блогчид, хэвлэл болон интернэт, өөр бусад хэрэгслээр өөрөө хэвлэн нийтлэл эрхлэгчдийг хамарсан өргөн хүрээтэй, олон тооны тоглогчдын дунд хуваагддаг үйл ажиллагаа бөгөөд улсын бүртгэлийн ерөнхий тогтолцоо, сэтгүүлчдийг лиценжүүлэх нь Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт үл нийцнэ. Хязгаарлагдмал итгэмжлэх үнэмлэх олгох нь тодорхой газар, үйл явдалд нэвтрэх давуу эрх олгож байгаагаар зөвшөөрөгдөнө. Ийм зохион байгуулалт нь 19 дүгээр зүйл, Пактын бусад зүйл заалтад нийцсэн, үл ялгаварлах зарчим, бодит шалгуурт

⁴⁰ Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Түр хороо байгуулах тухай” 29 дүгээр тогтоол

⁴¹ Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2017 он, №8

⁴² Онц байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 1996 он, №2

⁴³ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ.

2016 он. 44 дэх тал <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245364>

⁴⁴ Хэвлэл мэдээллийн байгууллагуудын автомашинд зөвшөөрөл олгох журам. 2020.11.22

<http://ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=52033>

үндэслэгдэх бөгөөд сэтгүүл зүй бол өргөн хүрээтэй, олон тооны тоглогчдын дунд хуваагддаг үйл ажиллагаа болохыг анхааралдаа авах ёстой” гэж, 45-д “... сэтгүүлч, хүний эрхийн зөрчлийг мөрдөгчдөд тухайн Гишүүн улс дотроо (зөрчилд нэрвэгдсэн газар нутаг, байгалийн гамшиг гарсан, хүний эрхийг гутаан доромжилсон гэх мэт газар) хөдлөн явах эрхийг хязгаарлах нь Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт ерөнхийдөө үл нийцнэ.” гэснийг дээрх журмын зохицуулалт хангахгүй байна.⁴⁵ НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас 2020.05.13-ны өдөр гаргасан “Ковид-19 удирдамж”-д зааснаар Ковид-19-тэй холбоотойгоор онцгой байдлын үеийн эрх хэмжээгээ гагцхүү нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэхээс бус хүний эрхийн хамгаалагчид эсвэл сэтгүүлчдийн ажил, үйл хэргийг няцаах, хүчингүй болгох эсвэл тэднийг чимээгүй болгоход ашиглах ёсгүй юм.⁴⁶

2.1.2. Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох үйл явц ил тод эсэх

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2019.12.12-ны өдөр баталж, 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйлчилж байна.⁴⁷ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын бүртгэлд бүртгүүлж, зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх хүчин төгөлдөр байна.⁴⁸

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.1-т зааснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ. Мөн хуулийн 4.1.2-т зааснаар “өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ” гэж энэ хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5-д заасан үйлчилгээ буюу дараах үйлчилгээг ойлгоно:

- радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ /радио давтамж ашиглан сүлжээ байгуулж, хэрэглэгч хүлээн авах төхөөрөмж ашиглан радио, телевизийн үйлчилгээг тодорхой хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авах боломжоор хангах үйлчилгээ/;
- олон суваг дамжуулах үйлчилгээ /утаастай, утасгүй, хиймэл дагуулын сүлжээгээр радио, телевизийн олон сувгийг хэрэглэгчид гэрээний үндсэн дээр дамжуулан хүргэх/;
- радио, телевизийн үйлчилгээ /өөрийн редакцад хөтөлбөр бэлтгэн харилцаа холбооны сүлжээнд холбогдож, олон нийтэд түгээх үйлчилгээ/.
 - а.олон нийтийн радио, телевиз;
 - б.арилжааны радио, телевиз;
 - в.өргөн нэвтрүүлгийн радио, телевиз;
 - г.төлбөртэй радио, телевиз.

Хуулийн 7.2-т зааснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно. Мөн хуулийн 7.4-т Харилцаа холбооны зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгохдоо баримтлах зарчмыг заасан.


Зураг 1. Харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авч шийдвэрлэх дараалал

⁴⁵ UN Human Rights Committee (HRC), General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression, 12 September 2011, CCPR/C/GC/34, available at: <https://www.refworld.org/docid/4ed34b562.html>

⁴⁶ The Office of the High Commissioner for Human Rights. COVID-19 Guidance. 13 May 2020 <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/COVID19Guidance.aspx>

⁴⁷ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2020 он №06

⁴⁸ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2020 он №06



(Зургийн эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо)

Мөн хуулийн 30.1.7.6-д Харилцаа холбооны зохицуулах хороо өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам батлахаар заасан. Үүний дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020.09.22-ны өдрийн 64 тоот тогтоолын хавсралтаар “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам” баталсан. Энэхүү журам нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 4904 дугаарт бүртгэгдсэн.⁴⁹ Энэ журмаар төлбөртэй радио, телевизийн үйлчилгээнээс бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг зохицуулж байна. Харин Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021.01.29-ний өдрийн 02 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-аар арилжааны радио, телевизийн үйлчилгээ; өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ; төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулж байна.⁵⁰ Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021.05.14-ний 34 дүгээр тогтоолын хавсралт “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын дагуу өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчид Улаанбаатар хотод 18, орон нутагт 62 байна.⁵¹ Эдгээр 18 үйлчилгээ эрхлэгчийн хувьд Монгол Улсыг хамарч үйл ажиллагаа явуулж байгаа бол 62 үйлчилгээ эрхлэгчийн хувьд тухайн аймгийн нутаг дэвсгэрт хамарч үйл ажиллагаа явуулж байна. Харин радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч Улаанбаатар хотод 37, орон нутагт 27 байна.⁵²

Дээрх тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгалт хийх хүсэлтийг Харилцаа холбооны зохицуулах хорооны <https://license.crc.gov.mn> цахим хуудсанд цахим гарын үсгээр хүлээн

⁴⁹ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020.09.22-ны өдрийн 64 тоот тогтоолын хавсралт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам” <https://crc.gov.mn/k/35M>

⁵⁰ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021.01.29-ний өдрийн 02 тоот тогтоолын хавсралт “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” <https://crc.gov.mn/k/376>

⁵¹ Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчид <https://www.crc.gov.mn/k/U/5H>

⁵² Радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид <https://www.crc.gov.mn/k/V/5I>

авч байна. 2020 оноос хойш өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл шинээр аваагүй байна.⁵³

2.1.3. Өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын удирдлагууд, олон нийтийн өргөн нэвтрүүлгийн удирдлагууд улс төрийн эрх мэдэлтнүүднээс хараат бус эсэх

2.1.3.1. Харилцаа холбооны зохицуулах хороо

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлд Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх, үүргийг тусгасан. Улсын Их Хурлаас 2001.10.18-ны өдөр баталсан Харилцаа холбооны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 8.2-т “Зохицуулах хороо нь дарга, орон тооны бус 6 гишүүнээс бүрдэнэ.”, 8.3-т “Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно.” гэж заасан.⁵⁴ Энэ нь өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын удирдлага буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хувьд Ерөнхий сайд буюу улс төрийн эрх мэдэлтнээс хараат байх эрсдэлийг бүрдүүлсэн зохицуулалт юм. Тухайлбал, Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүнээр Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020.03.03-ны өдрийн 29 дүгээр захирамжаар Ерөнхий сайдын зөвлөх А.Үйлстөгөлдөрийг 2024.03.02-ны өдөр хүртэл 4 жилийн хугацаагаар, 2020.08.19-ний өдрийн 31 дүгээр захирамжаар Ерөнхий сайдын хэвлэлийн төлөөлөгч Ө.Золбаярыг 6 жилийн хугацаагаар томилсон. Мөн тус хорооны гишүүн Э.Энхтуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны газрын дарга бөгөөд хорооны 6 гишүүний 3 нь Засгийн газраас шууд хамааралтай төрийн албан хаагч байна.⁵⁵

2012 онд Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээнд “Өргөн нэвтрүүлгийг хараат бус байгууллага зохицуулдаг. Уг байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх нөхцөлийг хуулиар бүрдүүлсэн. Тус байгууллагын удирдах зөвлөлийг ил тодоор иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулан бүрдүүлдэг бөгөөд уг зөвлөлд аль нэг улс төрийн намын нөлөөлөл давамгайлдаггүй” гэх шалгуурыг үнэлэхдээ боломжит 5 онооноос 1.6 оноо өгсөн байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн томилгоонд иргэний нийгмийн оролцоо байдаггүй.⁵⁶

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн ээлжит дүгнэлт, хэлэлцүүлгээс 2015 онд Монгол Улсад “Харилцаа, холбооны зохицуулах хорооны хараат бус байдлыг хангах” талаар 108.131 тоот зөвлөмж өгсөн.⁵⁷ Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралт “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-нд “Харилцаа холбооны зохицуулах хорооны бие даасан байдлыг хангах зорилгоор Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, хорооны гишүүдийн томилгоог Засгийн газраас хараат бус болгох” гэж тусгасан.⁵⁸ Харилцаа холбооны тухай хуульд Монгол Улсын Их хурлаас 2015.12.04, 2017.01.26, 2019.05.30-ны өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Гэвч, Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхийг нэмэгдүүлсэн хэдий ч тус хорооны хараат бус байдлыг хангах талаар зохицуулаагүй орхисон.

⁵³ Тусгай зөвшөөрөлтэй телевиз, радио, сувгийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн 2020 оны мэдээлэл. 2021.02.25 <https://www.crc.gov.mn/k/4x>

⁵⁴ Харилцаа холбооны тухай хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2001 он, №43

⁵⁵ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны товч тайлан. 2021.04.15 <https://www.crc.gov.mn/k/37Y>

⁵⁶ Фридрих-Эбэртийн сан. “Азийн хэвлэл мэдээллийн барометр – Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”. Улаанбаатар. 2012 он. 47 дахь тал

⁵⁷ A/HRC/30/6/Add.1

http://lib.ohchr.org/HRBodies/UPR/Documents/Session22/MN/UPR22_Mongolia_list_of_recommendations.doc

⁵⁸ Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралт “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”

Иймд Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийг сонгох буюу томилоход хэвлэмэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон өргөн нэвтрүүлгийн чиглэлийн холбоод, мэргэжилтнүүдийн оролцоог заавал хангах, Ерөнхий сайд томилох бус, Улсын Их Хурлаас холбогдох зохицуулалтын дагуу зөвхөн батламжлах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

2.1.3.2. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл

Улсын Их Хурлаас 2005.01.27-ны өдөр баталж, 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 20.1-т зааснаар Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага нь олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл байна.⁵⁹ Тус хуулийн 21 дүгээр зүйлд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох нөхцөлийн талаар заасан. Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй байна. Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.

Дор дурдсан байгууллага, албан тушаалтан Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ:

- Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн;
- Монгол Улсын Их Хурал 7 хүн;
- Монгол Улсын Засгийн газар 4 хүн.

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бөгөөд нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно. “Азийн хэвлэл мэдээллийн барометр — Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”-нд дурдсанаар, анхны Үндэсний зөвлөлийн 15 гишүүнийг сонгох сонгуулийг төрийн бус байгууллагууд маш сайн зохион байгуулсан. Энэ үеэр төрийн бус байгууллагууд хэд хэд удаа зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, Үндэсний зөвлөлд нэр дэвшүүлэх журмаа тохиролцоод, тохирсон журмынхаа дагуу салбар тус бүрээс хүнээ дэвшүүлсэн бөгөөд Улсын Их Хурлаас тэдгээрийн 60 хувийг хүлээн зөвшөөрч албан ёсоор томилсон. Үүнээс хойш томилгоо улс төрийн шийдлээр явагддаг болсон. 2012 оны 9 дүгээр сард Үндэсний зөвлөлийн 7 гишүүний томилгоог хийхэд ч иргэний нийгмийн ямар нэг уулзалт, зөвлөлгөөн болоогүй бөгөөд Үндэсний зөвлөлийн бүх гишүүн улс төрийн ямар нэгэн хамааралтай, томилгоо нь өөрөө цэвэр улс төрийн шийдвэр болдог гэх хардлага түгээмэл байна. Үндэсний Зөвлөлийн гишүүд хэний ч өмнө хариуцлага хүлээхгүй байна. Олон нийтийн өмнө тайлангаа тавих байдлаар хариуцлага хүлээх нь ёс төдий хэрэгждэг. Үндэсний Зөвлөлийн гишүүдтэй хариуцлагын асуудал ярьж, эгүүлэн татах эрх бүхий этгээд нь хуулийн дагуу Хяналтын зөвлөл боловч энэхүү Зөвлөлд Үндэсний Зөвлөлийн гишүүд багтдаг гол асуудал оршиж байна. Бодит байдалд Үндэсний зөвлөлийн гишүүнд сонирхлын зөрчилтэй, дээрх хуулийн дагуу томилж болохгүй хүмүүсийг төрийн бус

⁵⁹ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2005 он, №8

байгууллагын халхавчин дор томилдог. Жишээлбэл Улс төрийн боловсролын академийн нэрээр Үндэсний зөвлөлд орж ирсэн гишүүн нь Ардчилсан Намын олны танил төлөөлөл болохыг олон хүн мэдэж буй. Үндэсний зөвлөлийн өөр нэгэн гишүүн тухайн үедээ арилжааны телевизийн зөвлөхөөр ажиллаж, өөрөөр хэлбэл ашиг сонирхлын зөрчилтэй байсан зэрэг дутагдал гарсан байна.⁶⁰

Хүснэгт 3. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн одоогийн гишүүдийн нэрс

Овог, нэр	Томилогдсон огноо	Чөлөөлөгдөх хугацаа	Шийдвэр
Д.Жавзандорж	2022.01.14	2028.01.14	УИХ-ын 2022.01.14-ний өдрийн 02 дугаар тогтоол
Н.Онон	2022.01.14	2028.01.14	
Д.Оюун-Эрдэнэ	2021.01.07	2027.01.07	УИХ-ын 2021.01.08-ны өдрийн 01 дүгээр тогтоол
Ж.Цэсэн	2021.01.01	2027.01.01	УИХ-ын 2020.12.10-ны өдрийн 43 дугаар тогтоол
Г.Отгонбаяр	2021.01.01	2027.01.01	
Д.Цоодол	2021.01.01	2027.01.01	
М.Наранбаатар	2021.01.01	2027.01.01	
Б.Ганболд	2021.01.01	2027.01.01	
С.Алтанцэцэг	2019.04.19	2025.04.19	УИХ-ын 2019.04.19-ний өдрийн 30 дугаар тогтоол
Д.Батсүх	2019.04.19	2025.04.19	
В.Бат-Эрдэнэ	2019.04.19	2025.04.19	
Н.Жанцан	2019.04.19	2025.04.19	
Д.Өлзийбаатар	2019.04.19	2025.04.19	
Х.Чилаажав	2016.12.01	2022.12.01	УИХ-ын 2016.12.01-ний өдрийн 74 дүгээр тогтоол

Гэвч дээрх байдал үргэлжилсээр байна. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн нь түүнийг санал болгосон Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас хамааралтай буюу ашиг сонирхлын зөрчилтэй байх тохиолдол гарсаар байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Галаарид, Ж.Соёл-Эрдэнэ нарын бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэгт заасны дагуу түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилуулахаар Д.Жавзандорж, Н.Онон нарыг нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх жүжигчин Н.Ононг МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлсэн нь “өнгөрсөн хугацаанд өөрийнх нь талд хүчин зүтгэж ирснийх нь төлөө шагнал” гэж зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дүгнэжээ.⁶¹

⁶⁰ Фридрих-Эбэртийн сан. “Азийн хэвлэл мэдээллийн барометр – Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”. Улаанбаатар. 2012 он. 49, 50 дахь тал

⁶¹ Ergelt.mn сайтын 2022.01.13-ны өдрийн “Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ангийн анд МУГЖ Н.Онон МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд тэнцэх үү” гэх гарчигтай нийтлэлд “У.Хүрэлсүх, Н.Онон хоёрын хэн хэн нь Хэнтийн гаралтай, нэг нутгийнх. Дээрээс нь тэр хоёр 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрх зүйн ангид хамт суралцаж явсан, нэг ангийн андууд. Цаашлаад МУГЖ Н.Онон 2000 оны УИХ-ын сонгуулиас эхлээд У.Хүрэлсүхийн сурталчилгааны багт ажиллаж, Хэнтийн сонгогчидтой “тулж” ажиллаж ирсэн. Түүгээр зогсохгүй МУГЖ Н.Ононтой “Икс Түц” ХХК буюу хошин урлагийн “Икс Түц” продакшныг хамтран эзэмшдэг МУГЖ И.Одончимэг өнгөрсөн сонгуулиар МАН-ын талд, дамаа У.Хүрэлсүхийн талд ажилласан гэж шуугьж байсан. Тэр байтугай “И.Одончимэг “тролл”-уудаа загнаж буй групп чат нь задарлаа” гэх мэдээлэл ч зурагтайгаа цацагдаж дуулиан тарьж байв.” гэжээ. <https://ergelt.mn/news/44/single/17123>

Eguur.mn сайтын 2022.01.15-ны өдрийн “Хөшигний ард: У.Хүрэлсүхийн найз Н.Онон Үндэсний зөвлөлд очих нь А.Бүрэнбаатарыг унагах фракцад таалагдахгүй” гэх гарчигтай нийтлэлд “У.Хүрэлсүхийн дэмжлэгээр “илгээгдэж” буй Н.Ононгийн чадамжгүй байдлыг шүүмжлэх нь ч ач холбогдолгүй сэдэв гэлтэй. Утгаа Н.Ононгийн хариуцлагагүй, итгэл үнэмшилгүйгээр байнгын хорооны хуралдаанд оролцож, “Үндэсний зөвлөлд юу болдгийг мэдэхгүй. Ойлголтгүй байгаа” гэж суух нь асар буруу, тавиул шинжтэй үйлдэл юм. Гэхдээ энэ газар зөв зарчмаараа урагшилж, нар үзэх эсэх нь л чухал асуудал.” гэжээ. <https://eguur.mn/286506/>

Мөн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 31.6-д зааснаар түүний Ерөнхий захирал олон нийтийн радио, телевизийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; нэвтрүүлгийн хөтөлбөрийг тогтоох; олон нийтийн радио, телевизийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах зэрэг бүрэн эрхтэй. Гэвч 2020.12.21-ний өдөр Олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирлаар томилогдож, 2021.01.19-ний өдөр чөлөөлөгдсөн Н.Дэмбэрэлийн хувьд “Хүүхдийн төлөө фонд нэрээр мөнгө босгох гэж эфирийг цаг эвдэн олон цаг шууд дамжуулсан”, “Соёлын сайд асан С.Чулууныг хамгаалах ажлыг олон нийтийн телевизээр нэвтрүүлсэн”, “программ зөрчиж, 600 студид Ерөнхийлөгч Х.Баттулгатай ярилцлага хийсэн. Энэ үеэрээ хувийн студийн техник хэрэгсэл, уран бүтээлчдийг оролцуулсан” зэргээр улс төрийн эрх мэдэлтнүүдээс хараат байдлаар ажилласан байна. Мөн МҮОНРТ-ийн ерөнхий захирлын сонгон шалгаруулалтад нэр дэвшигч 15 хүний 13 нь улс төрчдөөс хамааралтай буюу тэдний дэмжлэгтэй талаар зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дүгнэжээ.⁶² 2020.12.07-ны өдөр Нээлттэй Нийгэм Форум, Глоб интернэшнл төвтэй хамтран зохион байгуулсан “Олон нийтийн радио телевизийн тухай хууль”-ийн хэлэлцүүлэгт “МҮОНРТ-ийн Ерөнхий захирал ‘Цагийн хүрд’ мэдээний дарааллыг байнга шаардаж авах, нэвтрүүлгийн зочин хэн байхыг ч шийддэг. Мөн олон ургалч үзэл бодлыг хүндэтгэх үүрэгтэй ч нэг шашинд хэт давуу цаг олгох, мэдээний хөтөлбөр дундуур зар сурталчилгаа явуулах зэргээр нийтлэл нэвтрүүлгийн бодлого, редакцийн хараат бус байдал алдагдаж байна” гэж онцолжээ.⁶³

2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороогоор бүрэн эрх нь дуусгавар болсон Үндэсний зөвлөлийн гишүүний орон тоон дээр нэр дэвшсэн хүмүүсийг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах үйл явц нэр төдий явагдаж, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21.4-т заасан “...иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон иргэнийг томилно” гэсэн заалтыг үл хайхарсан, нэр дэвшсэн хүмүүсийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийтлэг зарчмыг үл баримтлан, үг хэлэх, тайлбар санал хэлэх боломжгүй, олон нийтэд тухайн хүмүүсийг бүрэн танилцуулаагүй, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хатуу хөл хорио тогтоосон үед яаравчлан хэлэлцсэн нь хараат бус, олон ургалч, ил тод ажиллах зарчим бүхий МҮОНРТ-ийн удирдах дээд байгууллагын томилгоонд хайнга хандсан, хариуцлагагүй үйл явдал болсон гэж Хүний эрхийн Форум үзэж, эсэргүүцлээ илэрхийлсэн. Хамт олны эсэргүүцэл гараад багагүй хугацаа өнгөрч байхад асуудлыг үл хайхарсан дээрх шийдвэр нь тэмцлийн хэлбэрийг хурцатгаж жагсаал, цуглаан хийх, хүч хэрэглэхээр сүрдүүлсэн нөхцөл байдал үүсгэсэн. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүдийг томилохдоо иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосны дагуу ил тод, нээлттэй хэлэлцэж, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу томилгооны сонсгол зохион байгуулах замаар томилох шаардлагатай. Салбарын хуулийн зохицуулалт хангалтгүй байгаагаас үүдэн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг Хууль тогтоомжийн тухай хуулийг баримтлан, иргэдийн оролцоог хангах замаар шинэчлэн найруулж, батлах нэн шаардлагатай байна.⁶⁴

Нийтлэлч, эдийн засагч Д.Жаргалсайханы хөтлөн явуулдаг “Дефакто” нэвтрүүлэг Монголын Үндэсний Олон нийтийн телевизээр долоо хоног бүр цацагддаг байв. Гэтэл Үндсэн хуулийн Цэцийн дарга асан Ж.Амарсанааг урьж ярилцлага авснаас болоод түүний нэвтрүүлгийг МҮОНТ-ээр цаашид дахин гаргах боломжгүй гэдгээ телевизийн удирдлагууд мэдэгджээ. Энэ талаар Д.Жаргалсайхан “Ямар нэг шалтгаан байхгүй. Үндэсний телевизийн дарга Ц.Мөнхтөр над руу утастаад нэвтрүүлгийг чинь цаашид гаргах ямар ч боломжгүй гэдгээ

⁶² News.mn. “МҮОНРТ-ийн ерөнхий захиралд улстөрчид хэн, хэнийг сойв?”. 2021.03.05 <https://news.mn/r/2407616/>

⁶³ Нээлттэй нийгэм форум. “Олон нийтийн радио телевизийн тухай хуульд өгөх санал, шүүмж”. “Хуулийн шүүмж” №31. 2021 https://forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1193&menu_id=3&resmenu_id=3

⁶⁴ Глоб интернэшнл төв. Хэвлэлийн эрх чөлөөний тайлан — 2020. Улаанбаатар. 2021 он. 42 дахь тал

мэдэгдсэн. Өөрөөр хэлбэл, МҮОНТ-тэй хийсэн гэрээ цуцлагдсан болохыг дуулгасан.” Гэрээгээ цуцлах болсон шалтгаанаа телевизийн удирдлагууд уг нэвтрүүлгийг бодлоготой уялдаагүй, тэнцвэртэй үзэл бодол гаргаагүй хэмээн тайлбарлажээ.⁶⁵

Эндээс үзэхэд, өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын удирдлагууд болон олон нийтийн өргөн нэвтрүүлгийн удирдлагууд улс төрийн эрх мэдэлтнүүднээс ихээхэн хараат байдалтай байна.

2.1.4. Төрийн албан тушаалтнууд болон бусад улс төрчид хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр үйлдэл үзүүлдэг эсэх

2.1.4.1. Улсын Их Хурлын гишүүдийн санаачилга

Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр бодлогын баримт бичиг хангалттай гаргасан болохыг харуулж байна. Харин хууль тогтоомжийг өөрчлөх, сайжруулах чиглэлээр бодит үйлдэл хийж буй эсэх нь анхаарал татаж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.3.2-т “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ”, 3.3.4.3-т “хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана”, 3.6.4.5-д “Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.⁶⁶

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.8-д “иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх”, 4.1.8.1-т “хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах”, 4.1.8.2-т “эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох”, 4.1.8.3-т “хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх”, 4.1.8.4-т “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах”, 4.1.8.5-д “сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй зөрчсөн асуудлыг хэлэлцэх, холбогдох хариуцлага тооцох чиглэлээр ажиллах Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах” гэж тус тус заасан.⁶⁷

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.5.9-д “Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ” гэж заасан.⁶⁸ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны

⁶⁵ Глоб интернэшнл төв. Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2016. Улаанбаатар. 2017 он. 17 дахь тал

⁶⁶ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”

⁶⁷ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”

⁶⁸ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”

хөтөлбөр"-ийн 4.4.11-т "Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна" гэж заасан.⁶⁹ Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд 2022-2024 онд "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ" гэж заасан.⁷⁰

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 2022.01.10-ны өдөр өгсөн мэдээлэлдээ "Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээрт зааснаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүнийг 100 мянган төгрөгөөр торгоно гэж заасан. 2019.06.06-ны өдөр баталсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 31.1.1-т иргэн "бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх" үүрэгтэй гэж заасан. Эдгээр заалтын үр дүнгээр зөвхөн цагдаа болон тагнуул Зөрчлийн хэрэг нээж, өөрсдөө торгоод явах заалтыг бий болгож, хууль үйлчилснээс хойш 600 орчим хүнийг торгосон байна. Иргэд өөрсдийнхөө эрх нь зөрчигдөж буй талаар үзэл бодлоо зайлшгүй илэрхийлж байх ёстой гэх зарчмын байр суурьнаас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31.1.1 дэх заалтыг авч хаях хуулийн төслийг өргөн барьсан. Бусдын нэр хүндэд халдлаа гэх асуудлыг иргэний болон Эрүүгийн хуулиар шийдэх бүрэн боломжтой" гэжээ.⁷¹

Хууль тогтоогчид, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарын төлөөллүүдийг оролцуулсан "Үндсэн хууль ба хэвлэн нийтлэх эрх чөлөө-30 жил" сэдэвт хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын Тамгын газар, Хэвлэлийн хүрээлэн хамтран 2022.01.12-ны өдөр зохион байгуулжээ. Тус хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хэлсэн үгэндээ хэвлэл мэдээллийн салбар чөлөөт тогтолцоонд дасан зохицох үе шатаа туулан, техник, технологийн шинэ нөхцөл байдал, хэрэглэгчдийн шинэ үетэй нүүр тулан учирч, уламжлалт сэтгэлгээ өөрчлөгдөн, нийгмийн харилцаа хөгжихийн хэрээр хууль тогтоомжоо ч шинэчлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна гээд Улсын Их Хурлаас сэтгүүлчидтэйгээ хамтран тодорхой арга хэмжээ зохион байгуулах болно гэжээ. Мөн хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын арга механизмуудыг хэвшүүлж, маргаан гарсан тохиолдолд сэтгүүлч болон бусад талыг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлдэг, иргэний няцаах эрхийг хангадаг зэрэг шинэ тогтолцоо бүрдүүлэх нь чухал талаар тэмдэглэж, тус хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр оролцож, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн барьсан талаараа танилцуулаад тус хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлаар ирэх долоо хоногт шийдвэрлэх учир цаг үеийн энэ асуудалд анхаарал хандуулаасай гэсэн үүднээс хэвлэлийнхэнд мэдээлэл өгч буйг дурдлаа. Хуулийн төсөлд төрийн байгууллагууд, улс төрд нөлөө бүхий этгээд төрийн албан тушаалтны хувиар Эрүүгийн хуулийн гүтгэх гэсэн зүйл ангиар цагдаад гомдол гаргахгүй гэсэн тайлбар бүхий зохицуулалт тусгасан гэжээ.⁷²

⁶⁹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"

⁷⁰ Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"

⁷¹ Б.Пүрэвдорж: Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг хаасан заалтыг өөрчилнө.

<https://ubn.mn/p/23043>

⁷² "Үндсэн хууль ба хэвлэн нийтлэх эрх чөлөө-30 жил" сэдэвт хэлэлцүүлэг болов. 2022.01.12

<http://parliament.mn/n/xс3yn>

2022 оны 1 дүгээр сарын эхний долоо хоногт Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар сэтгүүлчидтэй уулзсан уулзалт дээр “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль ямар ч санхүүг хууль. Тэгэхээр хэрэгжих боломжгүй” гэж мэдэгджээ. Энэ талаар “Өдрийн сонин”-д “Хэдийгээр албан бус уулзалт хэдий ч Монголын хэдэн арван сэтгүүлчийг өмнөө суулгаж байгаад ийн мэдэгдсэн нь хэтэрхий том доромжлол байлаа. Хууль баталдаг хамгийн том институцийн дарга нь ингэж мэдэгдэнэ гэдэг Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т ‘Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн’ гэснийг зөрчсөн гэж үзэж болохоор байгаа юм” дүгнэжээ.⁷³

2.1.4.2. Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам

Улсын Их Хурлаас 2007.10.11-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2010.12.30-ны өдөр нэмсэн, 2011.01.20-ны өдөр өөрчлөн найруулсан 53¹ дүгээр зүйл /Улсын Их Хурлын үйл ажиллагааг мэдээлэх журам/-ийн 53¹.2-т “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг хэвлэл мэдээллийн байгууллагаас ирүүлсэн саналыг нь харгалзан Улсын Их Хурлын Тамгын газар хэвлэл мэдээллийн ажилтанд нэр зааж олгоно. Хэвлэл мэдээллийн байгууллага нь саналаа ирүүлэхдээ тухайн ажилтны ажлын ур чадвар, мэргэшсэн байдлыг нь харгалзсан байвал зохино”, 53¹.3-т “Энэ хуулийн 53¹.2-т заасан сурвалжлах эрхтэй хэвлэл, мэдээллийн ажилтан нь Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд заасан журмыг баримтлан үйл ажиллагаа явуулна” гэж заасан.⁷⁴

Улсын Их Хурлаас 2020.05.13-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 122.2-т “Чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлахтай холбогдсон журмыг Улсын Их Хурлын дарга батална” гэж заасан.⁷⁵ Дээрх зохицуулалттай холбоотойгоор Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэхтэй холбоотой 5 удаа журам батлан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журмуудын тойм

Огноо	Шийдвэр / Журмын нэр	Онцлог
2008	УИХ-ын даргын 2008.05.30-ны өдрийн 62 дугаар захирамж “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам”	Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг хэвлэл мэдээллийн байгууллагаас ирүүлсэн саналыг нь харгалзан Улсын Их Хурлын Тамгын газар хэвлэл мэдээллийн ажилтанд нэр зааж олгоно. Хэвлэл мэдээллийн байгууллага нь саналаа ирүүлэхдээ тухайн ажилтны ажлын ур чадвар, мэргэшсэн байдлыг нь харгалзсан байвал зохино.
2013	УИХ-ын даргын 2013.09.18-ны өдрийн 165 дугаар захирамж ⁷⁶ “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам”	Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс нь Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах эрхийн үнэмлэхийг хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтанд нэр зааж олгоно. Тус үнэмлэхийг өдөр тутмын сонинд 3, өргөн нэвтрүүлгийн телевизэд 4, кабелийн телевизэд 2, өргөн нэвтрүүлгийн радиод 2, FM радиод 1, редакци бүхий, өдөр тутам 5000-аас доошгүй хандалттай /энэ хандалт нь давхардаагүй/ цахим сайтад 2, бусад сонин, сэтгүүл, гэрэл зургийн агентлагт тус бүр 1 хүнд
2014	УИХ-ын даргын 2014.09.22-ны өдрийн 145 дугаар захирамж ⁷⁷	

⁷³ “Өдрийн сонин”. “Төр Хэвлэлийн эрх чөлөөний хуулийг нулимлаа”. 2022.01.11 №007 (6880)

⁷⁴ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

“Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2011 он, №3, №5

⁷⁵ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2020 он, №22

⁷⁶ - УИХ сурвалжлах, мэдээлэх журам баталжээ. 2013.09.20 <https://news.mn/r/643462/>

- УИХ-ын үйл ажиллагааг сурвалжлах журамд орсон өөрчлөлт сэтгүүлчдийг бухимдууллаа. 2014.09.25 <https://www.ulstor.mn/post/2604.html>

⁷⁷ Парламентын үйл ажиллагааг сурвалжилдаг сэтгүүлчидтэй уулзлаа. 2019.10.22 <https://www.sonin.mn/news/politics-economy/106083>

	“Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам”	олгоно. Хэвлэл, мэдээллийн байгууллага нь Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах эрхийн үнэмлэх авах саналаа Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэст тухайн ажилтны ажлын үр чадвар, мэргэшсэн байдлыг нь харгалзан дээрх тооны хязгаарт багтааж ирүүлнэ. Энэ журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд тухайн сурвалжлагчид анхааруулах, Улсын ИХ Хурлын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг тодорхой хугацаагаар, эсхүл бүрмөсөн хасах арга хэмжээ авна.
2020	УИХ-ын даргын 2020.04.02-ны өдрийн 46 дугаар захирамж ⁷⁸ “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх түр журам”	Улсын Их Хурлын Тамгын газар хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын хугацаанд сэтгүүлчид ажиллах түр цэгийг Төрийн ордны 2 дугаар давхарт байгуулсан. Холбогдох албан тушаалтнууд хэвлэл мэдээлэлд мэдээлэл, ярилцлага өгөхдөө зөвхөн энэ цэгийг ашиглахаар зохицуулжээ. ⁷⁹ Мөн зайлшгүй шаардлагаар сэтгүүлчдийг заасан цэгээс бусад байршилд нэвтрүүлэх тохиолдолд үйл явдлын цаг хугацаа, оролцох сэтгүүлчдийн тоог урьдчилан товлож зохион байгуулах, хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын үед хэвлэл мэдээллийн ажилтнуудыг Төрийн ордонд ажиллах боломжийг хангах арга хэмжээг Тамгын газар авч хэрэгжүүлэхээр тусгажээ. ⁸⁰
2021	УИХ-ын даргын 2021.09.30-ны өдрийн захирамж “Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам”	Үнэмлэх авахыг хүссэн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид тавигдах шаардлага: -ажилтан нь улс төрийн болон парламентын сэтгүүлчийн мэдлэг, үр чадвар эзэмшсэн, энэ чиглэлийн 3-аас доошгүй жилийн туршлагатай байх; -хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн ажлын байр, албан ёсны редакцтай, хэвлэн мэдээлэх чиглэлээр 3-аас доошгүй жил тасралтгүй, тогтмол үйл ажиллагаа эрхэлсэн байх. Хэвлэл мэдээллийн байгууллага нь дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ: хүсэлт гаргасан албан бичиг /ажилтны овог, нэр, гүйцэтгэх үүргийг хавсаргана/; байгууллагын гэрчилгээний хуулбар; хаягийн лавлагаа, татвар, даатгал төлсөн баримт; ажилтны мэргэшсэн байдал, үр чадварын товч тодорхойлолт

2014 онд баталсан “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам”-ын зохицуулалтыг сэтгүүлчид эсэргүүцэж байжээ. 2020 онд баталсан “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх түр журам”-тай холбоотойгоор 2021 оны 9 дүгээр сард сэтгүүлчид нэгдэн “Парламентын сэтгүүлчдийн Түр хороо” байгуулан, мэдээлэл дамжуулах эрхээ хамгаалж, холбогдох хүмүүст шаардлага хүргүүлжээ. “Парламентын сэтгүүлчдийн Түр хороо”-ноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хандан тэдний боловсруулж буй гэх “Төрийн ордноос мэдээ, мэдээлэл бэлтгэх журам”-д мэдээлэл олж авах боломжоор хангахтай холбоотой заалтуудыг тусгуулахаар шаардав.⁸¹ Харин Засгийн газрын Хэвлэл мэдээлэлтэй

⁷⁸ УИХ-ын хаврын чуулган ирэх Даваа гарагт нээлтээ хийнэ. 2020.04.03 <https://ikon.mn/n/1ud6>

⁷⁹ Монгол Улсын Их хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх түр журам баталжээ. 2020.04.06 <https://www1.medeer.mn/p/147036>

⁸⁰ УИХ-ын хаврын ээлжит чуулганыг цахимаар явуулахтай холбогдуулан сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. 2020.04.03 <https://news.mn/r/2282732/>

⁸¹ Сэтгүүлчид дараах байр суурьтай байжээ:

- UBN сайтын эрхлэгч Г.Лхагвадорж: “Бид эхэндээ цар тахлын нөхцөл байдлыг ойлгоод Төрийн ордноос тогтоосон дүрэм, журмын хүрээнд ажиллаж ирсэн. Гэтэл одоо дэлхий нийт цар тахалтай зэрэгцэн амьдраад эхэлсэн. Мөн манай улсад бүх үйл ажиллагаа нээчихээд байхад Төрийн ордонд сэтгүүлчдийн ажиллах эрхийг нээхгүй байгаа нь сэтгүүлчид, хэвлэл мэдээллийг хэрэгсэл зөвхөн дамжуулах хэрэгсэл л болж хувирлаа.”

- NTV телевизийн сэтгүүлч Ч.Лодойсамбуу: “УИХ-ын гишүүд дарга биш ээ. Дөрвөн жилд нэг удаа ажилд орёе гээд мөрийн хөтөлбөрөө бариад ирдэг. Иргэд өөрсдөө ажилд авдаг. Ажилд авсан хүмүүс нь ажлаа хийж байна уу гэдгийг мэдэх эрхтэй. Хоёр жил үүнийг мэдүүлэхгүй явлаа. Одоо бүх зүйл нээлттэй болсон учраас сэтгүүлчдийг ч чөлөөтэй ажиллуулмаар байна. Цар тахал нэрээр өөрсдөө хүсвэл гарч ирээд ярьдаг болсон. Ярилцлага өгөх, эсэх нь тухайн хүний эрх. Гэхдээ гишүүд хувь хүн биш. Олон мянган хүний санал авч гарч ирсэн учраас олон нийтийн анхаарал хандуулж байгаа, хүсч байгаа мэдээллийг өгөх үүрэгтэй.”

харилцах газрын дарга Т.Ганзул, Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн дарга С.Батбаатар нар сэтгүүлчдийн шаардлагыг хүлээн авч Төрийн ордноос мэдээ, мэдээлэл бэлтгэх түр журамд өөрчлөлт оруулах хамтарсан ажлын хэсэг байгуулна гэж хэлсэн байна.⁸²

Эндээс харахад, Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журмаар тодорхой заасан цэгт мэдээлэл авахыг шаардах зэргээр сэтгүүлчдийн Төрийн ордон дахь хөдөлгөөнийг хязгаарлаж байжээ. Мөн Төрийн ордонд ажиллах сэтгүүлчийн тоог өдөр тутмын сонин, өргөн нэвтрүүлгийн телевиз, кабелийн телевиз, өргөн нэвтрүүлгийн радио, богино долгионы радио, редакц бүхий цахим сайт зэргийг шалгуур болгон тогтоож байжээ. Харин төрийн ордонд ажиллах сэтгүүлчийг тухайн хэвлэл мэдээллийн байгууллага өөрөө тухайн сэтгүүлчийн ажлын ур чадвар, мэргэшсэн байдлыг нь харгалзан сонгох нөхцөлтэй байсан бол 2021 оны журмаар “Үнэмлэх авахыг хүссэн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь улс төрийн болон парламентын сэтгүүлчийн мэдлэг, ур чадвар эзэмшсэн, энэ чиглэлийн 3-аас доошгүй жилийн туршлагатай байх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн ажлын байр, албан ёсны редакциятай, хэвлэн мэдээлэх чиглэлээр 3-аас доошгүй жил тасралтгүй, тогтмол үйл ажиллагаа эрхэлсэн байх” гэж шаардлагыг Улсын Их Хурал өөрөө тогтоож, төрийн ордонд ажиллах сэтгүүлчийг “сонгон шалгаруулах”, түүнд “тусгай зөвшөөрөл олгох” байдлаар зохицуулсан байна.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр тайлбарт “Хязгаарлагдмал итгэмжлэх үнэмлэх олгох нь тодорхой газар, үйл явдалд нэвтрэх давуу эрх олгож байгаагаар зөвшөөрөгдөнө. Сэтгүүлчийг тухайн Гишүүн улс дотроо хөдлөн явах эрхийг хязгаарлах, сэтгүүлчдийг лицензжүүлэх нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт ерөнхийдөө үл нийцнэ” гэжээ.⁸³ Иймд Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журмаар дамжуулан сэтгүүлчийн хөдөлгөөнийг хязгаарлах, сурвалжлага, мэдээлэл бэлтгэх сэтгүүлчдийг төрийн байгууллага өөрөө шилж сонгох, тухайн редакц өөрөө сэтгүүлчээ сонгож ажиллуулах нөхцөлийг хязгаарласан, улмаар мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа улс төрийн эрх мэдэлтнүүднээс хараат байдалтай болгоход чиглэсэн зохицуулалтыг хүчингүй болгох шаардлагатай байна.

2.1.5. Олон хэрэглэгчтэй мэдээний хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу олон нийтийн радио, телевиз, хувийн хэвшлийн радио, телевиз, сонин хэвлэлээр төр засгийн талаар хараат бусаар мэдээлж сурвалжилдаг эсэх

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдал ямар байгааг иргэд хэрхэн үнэлснийг энд авч үзье. Энэхүү Үндэсний статистикийн хорооны “Ардчилсан засаглал” судалгаанд хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээг 0-100 ононд шилжүүлэн тооцсон байх бөгөөд оноо их байх нь иргэдийн зүгээс хэвлэл

- Zarig.mn сайтын ерөнхий эрхлэгч Н.Өнөрцэцэг: “Өнөөдөр парламентын сэтгүүлчид нэгдээд УИХ-ын тамгын газар, Ерөнхийлөгчийн тамгын газар, ЗГХЭГ-т шаардлага хүргүүлж байгаа. Төрийн ордноос мэдээ, мэдээлэл бэлтгэх журмыг эргэн харах хүсэлт тавьж байна. Биднийг ажиллах нөхцөлөөр хангахгүй хоёр жил боллоо. Ордонд ажиллах сэтгүүлчид ариун цэврийн өрөө ороход хүртэл хамгаалалтын ажилтан дагаж явдаг. Сөрөг хүчин нь тараад явчихсан, эрх баригч нам хэт олонх байгаа энэ үед хэвлэл л сөрөг хүчний үүргийг гүйцэтгэнэ. Гэтэл сэтгүүлчдийн нүд чихийг хааж, ажиллах нөхцөл боломжийг хязгаарлаж байна. Бид дарга нарын захиалсан дууг дуулдаг утсан хүүхэлдэй биш. Төрийн ордонд бид чөлөөтэй нэвтэрч гишүүд, сайд нараас асуулт асуумаар байна. Иргэдийн мэдэх эрхийг хангамаар байна.”


- TV5 телевизийн сэтгүүлч Ч.Доржбат: “Сэтгүүлчид мэдэх эрхээ олж авахаар тэмцэж байгаад манай редакц дэмжиж оролцож байна. Ганцхан УИХ ч хаалттай болсон юм биш. Яамд, агентлагууд ч хаалттай болсон. Сэтгүүлч очоод мэдээлэл авъя гэхээр оруулахгүй, гадаа үүдэнд нь дуудаж уулздаг болсон. Төрийн бүх шатанд ийм болсон. УИХ-ын Тамгын газарт гол учир бий гэж бодож байна. Маш их хаалттай байдаг.”

⁸² “Цар тахлаас сэргийлэх нэрийн дор дарагдсан мэдээлэх эрхийг сэргээхийг шаардав.” 2021.09.29


<https://ikon.mn/n/2c76>

⁸³ UN Human Rights Committee (HRC), General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression, 12 September 2011, CCPR/C/GC/34, available at: <https://www.refworld.org/docid/4ed34b562.html>

мэдээллийн хэрэгсэл нь улс төр, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг, оноо бага байх нь хараат байна гэсэн санал өгснийг илэрхийлнэ.⁸⁴



Эндээс харахад, иргэдийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төрийн болон эдийн засаг, санхүүгээс ихээхэн хараат гэж үнэлж байна. Тодруулбал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд 2009-2020 он буюу 12 жилийн дунджаар улс төрөөс хараат бус байдал 22.5%-тай, эдийн засаг, санхүүгээс хараат бус байдал 21.3%-тай байна гэж иргэд үнэлж байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд улс төр ба эдийн засаг, санхүүгийн байдал шууд хамааралтай болохыг харуулж байна. Үүнийг нарийвчлан, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөл тус бүрээр авч үзье.⁸⁵




Хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төрийн болон эдийн засаг, санхүүгээс хараат байх нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх үнэлгээнд нэгэн адил нөлөөлж буйг дараах графикаас харж болохоор байна.⁸⁶ Эндээс харахад, олон хэрэглэгчтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл төр засгийн талаар хараат бусаар мэдээлж сурвалжилдаг байдал хангалтгүй байна.

⁸⁴ Үндэсний статистикийн хороо. “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2009-2017 оны үр дүн. Улаанбаатар. 2018 он. 4 дэх тал https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=AZ_survey_2009-2017.pdf&ln=Mn
 Үндэсний статистикийн хороо. “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2017-2020 оны үр дүн. Улаанбаатар. 2021 он. 4 дэх тал

⁸⁵ Үндэсний статистикийн хороо. “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2009-2017 оны үр дүн. Улаанбаатар. 2018 он. 4-7 дахь тал https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=AZ_survey_2009-2017.pdf&ln=Mn
 Үндэсний статистикийн хороо. “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2011, 2012; 2013, 2014; 2014, 2015; 2016-2018; 2017-2020 оны үр дүн.

⁸⁶ Үндэсний статистикийн хороо. “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2009-2017 оны үр дүн. Улаанбаатар. 2018 он. 7 дахь тал https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=AZ_survey_2009-2017.pdf&ln=Mn



Харин 18-40 насны 2494 иргэнийг түүврийн аргаар хамруулан 2020.05.14-2020.06.15-ны өдрүүдэд Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Асуулга судалгааны төвийг төлөөлөн Хараат бус судалгааны хүрээлэнгээс хийсэн “Залуучуудын санал бодлын судалгаа”-нд “Манай улсад хэвлэл мэдээллийн байгууллагууд аливаа асуудлыг хараат бусаар эрх чөлөөтэй хэвлэн нийтэлдэг үү?” гэх асуултад 17% нь маш чөлөөтэй, 51% нь зарим талаараа эрх чөлөөтэй, 21% нь зарим талаараа эрх чөлөөгүй, 6% нь огт эрх чөлөөгүй, 5% нь мэдэхгүй гэж хариулжээ.⁸⁷

Монголын Үндэсний олон нийтийн телевизийн 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Нээлттэй хором” нэвтрүүлэг “Үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө” сэдэвтэй байсан бөгөөд тухайн нэвтрүүлэгт цагдаагийн болон төрийн байгууллагын зүй бус үйл ажиллагааны талаар ил тод, нээлттэй хэлэлцсэнтэй холбоотойгоор тус нэвтрүүлгийг тус телевизийн фэйсбүүк хуудаснаас устгасан байна. Энэ нь 2012 оны 6 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “Хүмүүсийн оффлайн орчин дахь эрхүүд, тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх эрх онлайн орчинд нэгэн адил хамгаалагдах ёстой” гэж заасныг зөрчиж цахим орчинд мэдээлэл авах эрхийг зөрчсөн байна. Энэ явдал нь “Олон нийтийн радио телевизийн тухай” хуулийн 4.1-т “Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална” гэснийг мөн зөрчсөн байна.

“Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль” буюу “Цар тахлын түр хууль”-ийн үйлчлэх хугацааг 3 дахь удаа сунгах эсэх талаарх олон нийтийн хэлэлцүүлэг идэвхтэй өрнөж буй үед буюу 2021.12.27-ны өдөр Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт “АН: Цар тахлын хуулийн зарим заалт улсын төсвийг хяналтгүй зарцуулах эрсдэлтэй” гэсэн гарчиг бүхий мэдээг 20 секунд, “Баянгол дүүргийн МАН-ын хорооноос ахмадууддаа хүндэтгэл үзүүллээ” гэсэн гарчиг бүхий мэдээг 60 секунд тус тус нэвтрүүлжээ. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 4.1-т зааснаар олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа олон ургальч үзлийг эрхэмлэх, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална. Мөн хуулийн 8.2.2-т зааснаар олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх үүрэгтэй. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн талаарх НҮБ-ын Хүний эрхийн хорооны 34 дүгээр тайлбарт “Гишүүн улсууд нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хараат бус

⁸⁷ Хараат бус судалгааны хүрээлэн. “Залуучуудын санал бодлын судалгаа”. 2020.06.15. 42 дахь тал https://www.iri.org/sites/default/files/mongolia_ned_youth_poll_2020_-_public_deck_mongolian_final.pdf

байдлыг хангавал зохино. Үүнтэй холбогдуулан Гишүүн орон түүний хараат бус байдал, редакцийн эрх чөлөөг баталгаажуулах ёстой” гэж заасан. 2021.12.27-ны өдөр МҮОНТ-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт эрх баригч нам болон сөрөг хүчний мэдээллийг хэт тэнцвэргүй буюу эрх баригч намд хэт илүү цаг олгосон нь Олон нийтийн радио, телевизийн тухай хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ буюу Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг ноцтой зөрчсөн явдал юм. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлөөс түүний редакцийн хараат бус байдлыг хангахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай бөгөөд олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангаж буй эсэхэд иргэд хяналт тавьж байх нь улам чухал болж байна.

2.1.6. Сонгуулийн үеэр өргөн нэвтрүүлгийн хэрэгслээр ярих цагийг адил тэгш хуваарилдаг эсэх


Глоб Интернэшнл төв 2005.05.22-нд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийг хийхэд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлсэн 4 дүгээр сарын 4-ний өдрөөс 22-ны өдрийн хооронд Монголын Үндэсний Телевизээр нэр дэвшигчийн үйл ажиллагаа болон тэдгээрийн талаарх байр суурийг харуулсан мэдээллийн цаг МАХН-аас нэр дэвшигч, тухайн үеийн Улсын Их Хурлын дарга Н.Энхбаярын хувьд 55% буюу үлдсэн 3 нэр дэвшигчээс их байжээ. Нэр дэвшигчид өөрийн үзэл бодлыг сонгогчдод хүргэж эфирт шууд гарсан цагийн ихэнх нь нэр дэвшигч Н.Энхбаярт оногдож байжээ.⁸⁸

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.3-т “Олон нийтийн радио, телевиз нь нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг олгох саналаа Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхдээ нам, эвслээс нэр дэвшигчдэд намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, бие даан нэр дэвшигчийн тухайд Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн дарааллыг баримтлан ижил нөхцөл, тэнцүү хугацаа ногдохоор тооцно”, 46.4-т “Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзсэний үндсэн дээр сонгуулийн сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө батална”, 46.20-д “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмыг Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран энэ хуульд нийцүүлэн батална” гэж тус тус заасан. Үүний дагуу Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2020 оны 18/22 дугаар хамтарсан тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам” баталсан байна.


“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн байгууллага болох Глоб Интернэшнл төв Монгол Улсын Их Хурлын 2020 сонгуулийн телевизийн сурталчилгааны мониторингийг хийсэн бөгөөд Монголын үндэсний олон нийтийн телевизийн хувьд сонгуулийн сурталчилгааны сонгуульд нэр дэвшсэн 18 субъектийг бүгдийг нь хамруулан мэдээлсэн боловч нам тус бүрт оноосон цаг нь ялгаатай байв. Хуульд заасан сурталчилгааны хугацаанд тус телевиз 149 цаг 8 минут 43 секундийг намуудад зарцуулснаас цаг хуваарилсан байдлыг шинжилбэл, эрх баригч Монгол ардын намын талаарх мэдээлэл хамгийн их гарсан (19%) байна. Харин сөрөг хүчин Ардчилсан намд 14 хувьтай тэнцэх цаг оногдов. “Та бидний эвсэл”-д 12, “Шинэ эвсэл”-д 11, “Зөв хүн электорат эвсэл”-д 9 хувь тус тус оногдсон бол бие даагчдад нийт 15 хувтай тэнцэх цаг ногдуулав. Ийнхүү буурсаар Зон олны нам болон “Сахигтун! Үндсэн хуулийн 19 эвсэл”-д зарцуулсан

⁸⁸ Глоб интернэшнл төв. “2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн хоёрдахь шатны дүн”. 2005.05.09. 1, 2 дахь тал


цаг нь адил тэнцүү 5 хувь байсан бол Монголын ногоон нам, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намд оногдсон цаг нь тус бүр 2 хувь, Гэр хороолол хөгжлийн нам, Хөгжлийн хөтөлбөр намд оногдсон цаг нь адилхан 1 хувь болов. Ард түмний нам, Эх орончдын нэгдсэн нам, Их эв нам, Ард түмнээ хайрлая нам, Дэлхийн монголчууд намд хамгийн бага цаг оногдсон буюу сонгуультай холбоотой нийт мэдээллийн 1 хувьд ч хүрсэнгүй.⁸⁹



Монголын үндэсний олон нийтийн телевизийн мэдээний хөтөлбөрт эрх баригч МАН хамгийн их хугацаа эзэлсэн (53%) бол үүний дараа АН (27%) удаалав. Эвслүүдээс хамгийн их цагийг ТБЭ-д оноосон нь 7 хувь болсон ба ЗХЭЭ-д 4, ШЭ-д 3 хувьтай тэнцэх цагийг тус тус оноожээ.




Монголын үндэсний олон нийтийн телевизийн сонгуультай холбоотой мэдээллийн 3 хувь (04:33:43 секунд) нь далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл байв. Үүний 68 хувь (03:06:34 секунд) нь цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр цацагджээ. Монголын үндэсний олон нийтийн телевизийн далд сурталчилгааны шинжийг агуулсан нийт мэдээллийн дийлэнх буюу 71 хувийг эрх баригч МАН дангаараа эзэлсэн байна. Харин АН-д үүнээс 3.7 дахин бага буюу 19 хувьтай тэнцэх цаг оногдов. Бусад намын хувьд ТБЭ, ШЭ-ийн талаар адил 3 хувь байсан бол ЗХЭЭ-ийн талаарх мэдээлэл 1 хувь байна. Бие даан нэр дэвшигчдийн талаарх далд шинжийг агуулсан мэдээлэл бүхэлдээ 3 хувь болж байна.



⁸⁹ Глоб интернэшнл төв. "УИХ-ын 2020 оны сонгуулийн үеэр телевизийн сурталчилгаанд хийсэн мониторингийн дүгнэлт". 2021.04.12 <https://www.gic.mn/post/r/1588>

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 41.3-т “Олон нийтийн радио, телевиз нь нэр дэвшигчдэд сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг олгох саналаа Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлэхдээ намаас нэр дэвшигчдэд намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг, эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон намын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллыг баримтлан ижил нөхцөл, тэнцүү хугацаа ногдохоор тооцно.”, 41.4-т “Харилцаа холбооны зохицуулах хороо олон нийтийн радио, телевизээс ирүүлсэн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цагийн талаарх саналыг хянан үзсэний үндсэн дээр сонгуулийн сурталчилгаа эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө батална.”, 41.20-д “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмыг Харилцаа холбооны зохицуулах хорооны саналыг үндэслэн энэ хуульд нийцүүлэн Сонгуулийн ерөнхий хороо батална” гэж тус тус заасан. Үүний дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос 2021.03.11-ний өдрийн 32 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам” баталсан.

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн байгууллага Глоб Интернэшнл төв Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн сурталчилгаанд телевизийн мониторинг хийсэн байна.⁹⁰ 2021 оны 5 дугаар сарын 24-27 буюу албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхэлсэн 4 хоногийн хугацаанд Монголын үндэсний олон нийтийн телевизийн сонгуультай холбоотой мэдээллийн хамгийн их цагийг Монгол ардын намаас нэр дэвшигч У.Хүрэлсүх эзэлж буй 37%-д хүрсэн бол бусад нэр дэвшигчдэд ойролцоо цаг оноосон буюу Ардчилсан намаас нэр дэвшигч С.Эрдэнэд 32%, Зөв Хүн Электорат эвслээс нэр дэвшигч Д.Энхбатад 31%-тай тэнцэх цаг оноожээ. 2021 оны 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Монголын үндэсний олон нийтийн телевизийн сонгуультай холбоотой мэдээллийн хамгийн их цагийг Монгол ардын намаас нэр дэвшигч У.Хүрэлсүх эзэлж 47%-д хүрсэн бол Ардчилсан намаас нэр дэвшигч С.Эрдэнэд 28%-тай тэнцэх цаг оногдов. Харин Зөв Хүн Электорат эвслээс нэр дэвшигч Д.Энхбатад оноосон цаг 25% хүрсэн.⁹¹



2.1.7. Сонгуулийн бус үеэр төр засгийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг хүчинд цаг олголгүйгээр; сэтгүүлчдийг асуулт асуулгахгүйгээр ярих цаг олгохыг албаддаг эсэх

⁹⁰ Глоб интернэшнл төв. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд сурталчилгааны телевизийн мониторингийн I үеийн үр дүн”. 2021.05.31 <https://www.gic.mn/post/r/1604>

⁹¹ Глоб интернэшнл төв. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн сурталчилгааны телевизийн мониторингийн II үеийн дүн” 2021.06.04 <https://www.gic.mn/post/r/1606>

Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу олон нийтийн телевизээр сөрөг хүчинд цаг олгоогүй, сэтгүүлчдийг нэр дэвшигчдээс асуулт асуулгаагүй тохиолдол гарсан. Тодруулбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41.17-д “Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нийт нэр дэвшигч оролцсон байна.”, Сонгуулийн ерөнхий хорооноос 2021.03.11-ний өдрийн 32 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам”-ын 3.15-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.17-д заасны дагуу улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр нэвтрүүлэхдээ нийт нэр дэвшигчийг бүрэн оролцуулах, оролцогчдод ижил асуулт тавих, хариултын хугацаа тогтоох зэрэг мэтгэлцээний тогтсон дэгтэй байх ба оролцсон нэр дэвшигчдийн нэрийг намын харьяаллын хамт тодорхой илэрхийлсэн байна” гэж тус тус заасан.

Монголын үндэсний олон нийтийн телевизээс 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Ерөнхийлөгчийн сонгуулийн мэтгэлцээн зохион байгуулахаар төлөвлөж, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021.05.14-ний 32 тоот тогтоолын хавсралтаар баталсан хуваарь, цагт өөрчлөлт оруулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021.06.03-ны өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралтаар Монголын үндэсний олон нийтийн радио, телевизээр төлбөргүй нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, 2021.06.07-ны өдрийн хуваарь, цагт холбогдох өөрчлөлтийг оруулж хүргүүлсэн.⁹²

Гэвч Монголын үндэсний олон нийтийн телевизээс дээрх мэтгэлцээн зохион байгуулах боломжгүй болсон тухай олон нийтэд мэдээлсний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар радио, телевизээр ямар ч мэтгэлцээн болоогүй. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал А.Бүрэнбаатар 2021.06.07-ны өдрийн мэдэгдэлдээ “Манай телевиз нэр дэвшигчдэд тэгш боломж олгох үүднээс хүч зарж өнгөрсөн хугацаанд бэлтгэлээ сайн хангасан. ‘Зөв хүн электорат’ эвслээс нэр дэвшигч Д.Энхбатыг халдвар хамгааллын дэглэмийг сахиулаад студид авчирч болох эсэх, мөн гурван нэр дэвшигчийг эмнэлэгт байлгаж мэтгэлцүүлэх хувилбар яригдсан. Эсхүл Д.Энхбат нэр дэвшигчийг эмнэлгээс, нөгөө хоёрыг нь студид байхаар тооцож үзсэн. Ингээд эмнэлгийн тусгай өрөөнд явуулын станцаар мэтгэлцээн зохион байгуулах хүсэлтийг Улсын хоёрдугаар төв эмнэлэгт албан бичгээр илгээсэн. Тус эмнэлгээс Улсын онцгой комисс, Засгийн газар, Эрүүл мэндийн сайдын тушаал, шийдвэрийн хүрээнд халдварын улаан бүс рүү хүн оруулах, гаргах боломжгүй гэсэн тайлбарыг өнөөдөр өгсөн” гэжээ.⁹³

Сэтгүүлч Д.Жаргалсайхан “Clubhouse” нийгмийн сүлжээнд мэтгэлцээн зохион байгуулахыг эрмэлзсэнээр нэр дэвшигч Д.Энхбат, С.Эрдэнэ нар “Clubhouse/Zoom/Facebook” нийгмийн сүлжээнд шууд дамжуулалтаар хэлэлцүүлэг өрнүүлсэн бол нэр дэвшигч У.Хүрэлсүх оролцоогүй байна.⁹⁴ Мэтгэлцээн болоогүй нөхцөл байдлыг хуульч Б.Мягмардорж “Д.Энхбат нэр дэвшигчийн хувьд хэдийгээр ковид-19-ийн халдвар авсан ч биеийн байдал хэвийн, ярьж, мэтгэлцэх боломжтой байсан, боломжтой хэвээрээ ч байгаа. Тийм учраас, Д.Энхбат нэр дэвшигчээс болж мэтгэлцээн болоогүй гэж үзэх үндэслэлгүй, боломжгүй юм. Харин

⁹² Харилцаа холбооны зохицуулах хороо. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн тайлан”. Улаанбаатар. 2021 он. 17 дахь тал

⁹³ “Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн мэтгэлцээнийг цуцаллаа” 2021.06.07

<https://www.montsame.mn/en/read/266198>

⁹⁴ Julian Dierkes, Marissa Smith, and Shannon Tiezzi. Khurelsukh Cruises to Victory in Mongolian Presidential Race. June 10, 2021 <https://thediplomat.com/2021/06/khurelsukh-cruises-to-victory-in-mongolian-presidential-race/>

мэтгэлцээнийг хариуцан зохион байгуулах үүрэгтэй төрийн байгууллага, эрх баригчдын үйл ажиллагаанаас шууд шалтгаалсан алдаа байна” гэж дүгнэжээ.⁹⁵

Харин сонгуулийн бус үеэр төр засгийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг хүчинд цаг олголгүйгээр буюу сэтгүүлчдийг асуулт асуулгахгүйгээр ярих цаг олгохыг албадах тохиолдол гараагүй байна.

2.1.8. Төр засгийн зүгээс олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сэтгүүлчид, хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн сэтгүүлчид, тэдгээрийн удирдлагууд, өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын удирдлагуудыг ажлаас нь хялбар чөлөөлөх боломжтой эсэх

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн сэтгүүлчид, хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн сэтгүүлчид, тэдгээрийн удирдлагуудыг томилох, чөлөөлөх харилцааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг. Улсын Их Хурлаас 1999.05.14-ний өдөр баталсан, 2022.01.01-ний өдөр хүртэл үйлчилсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.15, 23.2.1, 24.1-т зааснаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн удирдлагатай хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулах ба хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно.⁹⁶ Мөн хуулийн 37 дугаар зүйлд хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох 8 үндэслэлийг заасан.

Мөн хуулийн 128 дугаар зүйлд зааснаар ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдлыг шүүхээр хянан шийдвэрлэнэ. Улсын Их Хурлаас 2021.07.02-ны өдөр баталсан, 2022.01.01-ний өдрөөс үйлчилж буй Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дээрх хөдөлмөрийн гэрээтэй холбоотой харилцааг хэвээр хадгалсан.⁹⁷

Фридрих-Эбертийн сангийн захиалгаар Монголын Хэвлэлийн Хүрээлэн 19 аймаг, Улаанбаатар хотын 260 хэвлэл мэдээллийн хэрэгслийн 1100 сэтгүүлчдээс тэдний хөдөлмөрийн нөхцөл, байдлын талаар судалгаа авахад, бодит байдал дээр хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын 92 хувь нь хөдөлмөрийн гэрээтэй, 7 хувь нь хөдөлмөрийн гэрээгүй, 1 хувь хөдөлмөрийн гэрээтэй эсэхээ хэлж мэдэхгүй ажил хөдөлмөр эрхэлж байна.⁹⁸ Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын хоёр хүн тутмын нэг нь 1-3 жил, гурван хүн тутмын нэг нь 6 сараас 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүд 30 хүртэлх насандаа, мөн 41-ээс дээш насанд хөдөлмөрийн гэрээтэй ажиллах нь илүү түгээмэл бол 26 — 35 насны ангилалд хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж буй эрэгтэйчүүдийн тоо давамгайл байна. Ажилладаг салбараар нь харвал радиод ажиллагсад хөдөлмөрийн гэрээтэй ажиллах нь илүү түгээмэл, сонин сэтгүүлд ажиллагсдын дунд гэрээгүй хүн олон байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын 40 хувь хугацаагүй гэрээтэй ажилладаг. Хугацаагүй гэрээтэй ажиллагсдын 60 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Хөдөлмөрийн гэрээгүй ажиллагсдын 66 хувь нь эмэгтэйчүүд, 57 хувь нь 21-35 насныхан байгаа бол 45 хувь нь сэтгүүлч, 15 хувь нь зураглаач, техникийн ажилтан байлаа. Газар зүйн байршлын хувьд 3 хүн тутмын 2 нь нийслэлд ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээгүй ажиллагсдын талаас илүү хувь нь телевизэд ажилладаг. Үндсэн ажилтнуудын ихэнх нь (95%) хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж байгаа бол гэрээгүй ажиллагсдын тал нь (45%) сэтгүүлч, уран бүтээлчид байв. Мөн хөдөлмөрийн гэрээгүй ажиллагсдын дийлэнх нь (68%) тухайн байгууллагадаа 3 хүртэлх жил

⁹⁵ Б.Мягмардорж. Сонгуулийн мэтгэлцээн болоогүйн “жинхэнэ шалтгаан” юу вэ? 2021.06.09 <https://gogo.mn/r/24o0q>

⁹⁶ Хөдөлмөрийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1999 он, №25

⁹⁷ Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2021 он, №31

⁹⁸ Хэвлэлийн хүрээлэн, ХБНГУ-ын Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. “Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан”. Улаанбаатар. 2019.09. 29-32 дахь тал <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/15695.pdf>

ажилласан 21-30 насныхан байна. Түүнчлэн гэрээгүй хүмүүсийн гуравны нэг нь тухайн салбарт 10-аас дээш ажилласан туршлагатай хүмүүс буй нь анхаарал татаж байна.

Харин олон нийтийн өргөн нэвтрүүлгийн удирдлагуудыг томилох, чөлөөлөхтэй холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар, өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын удирдлагууд буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх харилцааг Харилцаа холбооны тухай хуулиар тус тус зохицуулж байна. Олон нийтийн радио, телевизийн тухай 21.2-т зааснаар Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байх ба 26.1-т зааснаар Үндэсний зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараах 5 үндэслэлээр Хяналтын зөвлөл зөвлөмж гарган, уг гишүүнийг сонгосон байгууллагад мэдэгдэж, Улсын Их Хурал эгүүлэн татна:

- эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлж өгөхийг хүссэн өргөдлийг Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн гаргасан;
- гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;
- энэ хуулийн 21.3-т заасныг зөрчсөн буюу төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч, улс төрийн намын удирдах албан тушаалтан, бусад радио, телевизэд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход нь оролцдог этгээд, бусад радио, телевизэд хөрөнгө оруулалт хийсэн этгээд, эсхүл олон нийтийн радио, телевизийн санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж болох этгээд болох нь сонгогдсоных нь дараа илэрсэн;
- энэ хуулийн 21.3-т заасан ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;
- Үндэсний зөвлөлийн хуралдаанд 6 сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй.

Хүснэгт 5. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүдийн ажилласан хугацаа

№	Овог нэр	Томилогдсон огноо	Чөлөөлөгдсөн огноо	Хугацаа
1	Ганхүүгийн Пүрэвбат	2005.10.13	2008.12.31	3 жил 2 сар
2	Готовын Цэрэнпүрэв	2005.10.13	2012.09.18	6 жил 11 сар
3	Жүрмэдийн Занаа	2005.10.13	2008.12.31	3 жил 2 сар
4	Лувсангийн Болд	2005.10.13	2012.09.18	6 жил 11 сар
5	Лувсансамбуугийн Төмөрбаатар	2005.10.13	2012.09.18	6 жил 11 сар
6	Лувсансүрэнгийн Дамдинсүрэн	2005.10.13	2008.12.31	3 жил 2 сар
7	Мархаахүүгийн Буянбадрах	2005.10.13	2012.09.18	6 жил 11 сар
8	Найдансүрэнгийн Золжаргал	2005.10.13	2008.12.31	3 жил 2 сар
9	Нямжавын Содномдорж	2005.10.13	2012.09.18	6 жил 11 сар
10	Ойдовын Эрдэнэ-Өлзий	2005.10.13	2012.09.18	6 жил 11 сар
11	Очирхуягийн Мөнгөнтуул	2005.10.13	2012.09.18	6 жил 11 сар
12	Раднаагийн Бурмаа	2005.10.13	2008.12.31	3 жил 2 сар
13	Раднаагийн Хадбаатар	2005.10.13	2008.12.31	3 жил 2 сар
14	Хайдавын Чилаажав	2005.10.13 /2016.12.01/	2012.09.18	6 жил 11 сар
15	Цэдэндоржийн Дашдондов	2005.10.13	2008.12.31	3 жил 2 сар
16	Баасанжавын Ганболд	2008.12.31	2015.01.01	6 жил
17	Дамбын Гантөмөр	2008.12.31	2015.01.01	6 жил
18	Сүрэнгийн Цэрэндорж	2008.12.31	2015.01.01	6 жил
19	Цэрэнпилийн Гомбосүрэн	2008.12.31	2015.01.01	6 жил
20	Цэрэнчимэдийн Зоригтбаатар	2008.12.31	2015.01.01	6 жил
21	Чойжилжавын Дамбажав	2008.12.31	2015.01.01	6 жил
22	Норовын Алтансүх	2009.01.15	Мэдээлэл байхгүй	
23	Дамбын Ганбат	2009.07.02	2015.12.25	6 жил 5 сар
24	Алений Арман	2012.09.18	2019.04.19	6 жил 7 сар
25	Бямбажавын Цэнддоо	2012.09.18	2015.12.25	3 жил 3 сар
26	Догмидын Сосорбарам	2012.09.18	2015.12.25	3 жил 3 сар
27	Аюушийн Мөнхбат	2012.09.18	2016.12.01	4 жил 2 сар
28	Дамбийгийн Гоошоохүү	2012.09.18	2019.04.19	6 жил 7 сар
29	Лувсангийн Пүрэвдорж	2012.09.18	2019.04.19	6 жил 7 сар

30	Содномпилийн Мягмар	2012.09.18	2019.04.19	6 жил 7 сар
31	Шагдарын Батцэцэг	2013.02.08	2015.01.01	1 жил 10 сар
32	Баастын Золбаяр	2015.01.01	2021.01.01	6 жил
33	Балдангийн Энхмандах	2015.01.01	2021.01.01	6 жил
34	Батжаргалын Батбаяр	2015.01.01	2021.01.01	6 жил
35	Довдонгийн Цэндсүрэн	2015.01.01	2021.01.01	6 жил
36	Дэндэвийн Нямсамбуу	2015.01.01	2021.01.01	6 жил
37	Дэшигрэнцэний Оюун-Эрдэнэ	2015.01.01 /2021.01.07/	2021.01.01	6 жил
38	Зургаанжингийн Энхболд	2015.01.01	2021.01.01	6 жил
39	Бадам-Очирын Галаарид	2015.12.25	2022.01.14	6 жил
40	Жарантайн Соёл-Эрдэнэ	2015.12.25	2022.01.14	6 жил
41	Содномдоржийн Санасэр	2015.12.25	2019.04.19	3 жил 3 сар

Эндээс харахад, Улсын Их Хурлаас томилсон Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүдийн дийлэнх нь хуульд заасан хугацаанд ажилласан байх бөгөөд түүнээс бага хугацаанд ажилласан гишүүдийн хувьд тус зөвлөлийн гишүүнээр ажиллахад харшлах ажил, албан тушаалд томилогдсон байна. Харин С.Санасэрийн хувьд Үндэсний зөвлөлийн хуралд 6 сараас дээш хугацаанд биечлэн оролцоогүй тул хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 8.3-т зааснаар Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох бөгөөд 8.4-т зааснаар Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Зохицуулах хорооны гишүүдийн анхны томилгоог 2, 4, 6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилно. Гэвч 2008 оноос хойш бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө чөлөөлөгдөх явдал түгээмэл байх бөгөөд 6 жилийн хугацаанд ажилласан гишүүн байхгүй.⁹⁹ Энэ нь тус хорооны дарга гишүүнийг томилох эсэх асуудал зөвхөн Ерөнхий сайдтай хамааралтай байгаатай холбоотой байж болохоор байна.

Хүснэгт 6. Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн ажилласан хугацаа

№	Овог нэр	Ажилласан хугацаа	Хугацаа
1	Ирвузын Норовжав	2002-2006	4 жил
2	Чойдоржийн Лхагвасүрэн	2002-2006	4 жил
3	Намсрайжавын Лувсанжав	2002-2006	4 жил
4	Гомбын Басанжав	2002-2004	2 жил
5	Жанцангийн Бадарч	2002-2004	2 жил
6	Осорхүүгийн Баттогтох	2002-2005	3 жил
7	Лувсанцэрэнгийн Банзрагч	2005-2006	1 жил
8	Гомбын Төмөрсүх	2004-2009	5 жил
9	Жалавсүрэн Бат-Эрдэнэ	2004-2006, 2008-2012	2, 4 жил
10	Базаррагчаагийн Сарантунгалаг	2005-2009	4 жил
11	Ганбаатарын Ганболд	2006-2009	3 жил
12	Өлзийхутагийн Одгэрэл	2006-2009	3 жил
13	Жиймэнгийн Сансар	2006-2012	4 жил
14	Жанчивын Уранчимэг	2009-2012	3 жил
15	Буяндэлгэрийн Мөнхбат	2008-2016	4 жил
16	Аюушийн Мөнхбат	2009-2012	3 жил
17	Норинпэлийн Эрдэнэхүү	2009-2012	3 жил
18	Мэлсчогийн Мэнд-Очир	2009-2012	3 жил
19	Наранцогтын Баатархуяг	2009-2012	3 жил
20	Бавуужавын Мягмарнаран	2012-2014	2 жил
21	Давгадоржийн Энхцог	2012-2014	2 жил
22	Норовын Баттогтох	2014-2016	2 жил
23	Рэнцэндоржийн Отгонтулга	2014-2016	2 жил

⁹⁹ Харилцаа холбооны зохицуулах хорооны үе үеийн гишүүд. <https://crc.gov.mn/k/4h/2F>

24	Дэлэгдоржийн Амгаланбаатар	2012-2016	4 жил
25	Цагаан-Өвгөний Жадамбаа	2012-2016	4 жил
26	Чойндон Даваажамц	2012-2017	5 жил
27	Цогтбаатар Нямдорж	2016-2018	2 жил
28	Пүрэв Сэргэлэн	2018-2018	1 жил

2.1.9. Төр засгийн зүгээс тодорхой хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тэдний улс төрийн байр суурь (редакцийн таатай агуулга), улс төрчид ба хэвлэл мэдээллийн эзэмшигчдийн ойр дотно байдлын төлөө давуу байдал (хэвлэлийн хуралд орох, ярилцлага хийхийг зөвшөөрөх гэх мэт) олгодог эсэх

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын хувьд сэтгүүлчдийн олон талт төлөөлөлтэй уулзаж, тэдний асуултад хариулдаг жишиг тогтсон байна. Гэхдээ уулзалтад оролцох сэтгүүлчдийн тоо нь танхимын багтаамж, цагийн хуваарьтай холбоотойгоор хязгаарлагдах тохиолдол байна. Ерөнхий сайдын хувьд ихэвчлэн “Засгийн газрын 100 хоног”-той холбоотойгоор сэтгүүлчдэд мэдээлэл өгч, асуултад хариулж байна. Харин Ерөнхий сайд Н.Алтанхуягийн хувьд 2012.08.09-2014.11.14-ний хугацаанд ажиллахдаа долоо хоног бүр “Ерөнхий сайдын 30 минут” нээлттэй уулзалтаар сэтгүүлчидтэй уулзаж үйл ажиллагаагаа танилцуулж, тэдний асуултад хариулж байжээ.

Хүснэгт 7. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар сэтгүүлчдэд тусгайлан мэдээлэл өгч байсан үйл явдлын тойм

Овог, нэр	Огноо	Сэдэв / Сэтгүүлчдийн оролцоо
<i>Монгол Улсын Ерөнхийлөгч</i>		
Н.Энхбаяр	2007.12.12	Ерөнхийлөгч Н.Энхбаяр “Ерөнхийлөгч ба 100 сэтгүүлч” уулзалтаар улстөрийн намуудын санхүүжилт, Монгол Улсын гадаад харилцаа сэдвээр мэдээлэл өгч, 10 гаруй сэтгүүлчийн асуултаар уулзалт өндөрлөсөн ¹⁰⁰
Ц.Элбэгдорж	2017.05.03	Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Орхон аймагт төвийн бүсийн аймгийн сэтгүүлчидтэй уулзсан. Уулзалтын үеэр сэтгүүлчид “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 49:51 хувь, төрийн албан хаагчдын ёс зүй, авилга, хээл хахууль, шударга ёс, эдийн засгийн нөхцөл байдлын талаар асуужээ ¹⁰¹
Х.Баттулга	2017.09.20	Ерөнхийлөгч Х.Баттулга цаг үеийн зарим асуудлаар сэтгүүлчидтэй уулзаж, тэдний асуултад хариулжээ ¹⁰²
	2018.06.13	Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын уулзалтыг сурвалжилсан сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулж, ярилцлага өгчээ ¹⁰³
<i>Улсын Их Хурлын дарга</i>		
Д.Дэмбэрэл	2008.11.19	УИХ-ын дарга Д.Дэмбэрэл Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн 3 дугаар их хурлаас шинээр сонгогдсон тус эвлэлийн удирдлагуудыг хүлээн авч уулзаж сэтгүүлчид бол нийгэмд хууль тогтоогчдын адил чухал үүрэг гүйцэтгэдгийг онцолжээ ¹⁰⁴
З.Энхболд	2016.04.22	Монгол Улсын Их Хурал Ази, Европын дээд түвшний 11 дүгээр чуулга уулзалт /АСЕМ/-ын хүрээнд Ази-Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Энэхүү уулзалтын үр дүнгийн талаар УИХ-ын дарга З.Энхболд сэтгүүлчдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгчээ ¹⁰⁵

¹⁰⁰ “Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр сэтгүүлчидтэй уулзлаа”. 2007.12.12 <https://gogo.mn/r/qkvv>

¹⁰¹ Өдрийн сонин. “Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж орон нутгийн сэтгүүлчидтэй уулзлаа”. 2017.05.03 <https://tinyurl.com/59kx9jtc>

¹⁰² “Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн асуултад хариуллаа”. 2017.09.20 <https://president.mn/1648/>

¹⁰³ “Ерөнхийлөгч Х.Баттулга ШХАБ-ын уулзалтыг сурвалжилсан сэтгүүлчидтэй уулзав”. 2018.06.13 <https://www.montsame.mn/cn/read/92698>

¹⁰⁴ “УИХ-ын дарга сэтгүүлчдийн байгууллагын удирдлагуудтай уулзлаа”. 2008.11.19 <https://gogo.mn/r/mx5oq>

¹⁰⁵ “УИХ-ын дарга З.Энхболд сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ”. 2016.04.22 <https://www.mass.mn/n/45972>

М.Энхболд	2018.12.20	УИХ-ын дарга М.Энхболд сэтгүүлчидтэй уулзаж, МАН-ын Бага хурлын үеэр болон сүүлийн үед өөртэй нь холбогдуулан ярьж байгаа асуудлаар мэдээлэл, тайлбар хийжээ ¹⁰⁶
Г.Занданшатар	2019.06.17	УИХ-ын дарга Г.Занданшатар цаг үеийн асуудлаар МҮОНТ-ийн студид 11 сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹⁰⁷
<i>Ерөнхий сайд</i>		
С.Баяр	2008.11.30	Шинэ Засгийн газрын зорилго, сэтгүүлчид, сэтгүүлчдийн байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлын талаар Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн шинэ удирдлагуудтай уулзаж санал бодлоо илэрхийлжээ ¹⁰⁸
Н.Алтанхуяг	2013.05.23	“Ерөнхий сайдын 30 минут” буюу Ерөнхий сайдын нээлттэй уулзалт: Долоо хоног бүр сэтгүүлчидтэй уулзаж ярилцдаг 2 дахь уулзалтаар Засгийн газрын өнгөрсөн долоо хоногт хэрэгжүүлж буй ажлыг танилцуулж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгчээ ¹⁰⁹
	2013.08.02	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалт болж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹¹⁰
	2019.08.29	Ерөнхий сайд Арвайхээр хотод ажиллах үеэрээ “Ерөнхий сайдын 30 минут” уулзалтаа зохион байгуулжээ. Түүнийг дагалдаж явсан Улаанбаатар хотын 30 орчим сэтгүүлч, зураглаачид болон Өвөрхангай аймгийн хэвлэл мэдээллийнхэнд хандаж Баянхонгор, Өвөрхангай аймагт ажиллах хугацаандаа анхаарах, шийдвэрлэх асуудал, Засгийн газраас 2013 онд зорилт болгон хэрэгжүүлж буй ажлын талаар товч мэдээлэл өгчээ ¹¹¹
	2013.10.31	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалт болж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹¹²
	2013.11.07	“Ерөнхий сайдын 30 минут” буюу Ерөнхий сайдын нээлттэй уулзалтад Эрүүл мэндийн сайдын хамт оролцож сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹¹³
	2013.11.14	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалт болж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹¹⁴
	2013.11.21	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалт болж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹¹⁵
	2013.11.29	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалт болж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹¹⁶
	2013.12.13	“Ерөнхий сайдын 30 минут” буюу Ерөнхий сайдын нээлттэй уулзалт: Засгийн газрын үйл ажиллагааг танилцуулж, сэтгүүлчдийн асуултад хариулсан ¹¹⁷
	2013.12.19	Ерөнхий сайд Боловсрол, шинжлэх ухааны яамны сайд Л.Гантөмөрийн хамт оролцож, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹¹⁸
	2014.01.03	Сэтгүүлчидтэй уулзаж, тэдний асуултад хариулжээ ¹¹⁹
	2014.01.23	Сэтгүүлчидтэй уулзаж, тэдний асуултад хариулжээ ¹²⁰
	2014.02.06	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалтад Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнийн хамт оролцож сэтгүүлчдийн асуултад хариулсан ¹²¹

¹⁰⁶ “УИХ-ын дарга М.Энхболд хэвлэлийнхэнд мэдээлэл хийлээ”. 2018.12.20 <http://www.parliament.mn/n/mbmo>

¹⁰⁷ “УИХ-ын дарга Г.Занданшатар цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн асуултад хариулж байна”. 2019.06.17 <https://www.youtube.com/watch?v=ohlCs1vZkSc>

¹⁰⁸ “Ерөнхий сайд сэтгүүлчдийг дэмжихээ илэрхийлэв”. 2008.11.20 <https://gogo.mn/r/36o1g>

¹⁰⁹ “Ерөнхий сайд сэтгүүлчидтэй уулзлаа”. 2013.05.23 <https://news.mn/r/632732/>

¹¹⁰ “Ерөнхий сайдын 30 минут”. 2013.08.02 <https://www.youtube.com/watch?v=oB8S3LQIF3M>

¹¹¹ “Ерөнхий сайд “30 минут” уулзалтаа Өвөрхангайд хийлээ”. 2013.08.29 <http://www.uvurkhangai.mn/95/item/387>

¹¹² “Ерөнхий сайдын 30 минут”. 2013.10.31

¹¹³ “Ерөнхий сайдын 30 минут” 2013.11.07 https://www.youtube.com/watch?v=8PmNp3sn_U0

¹¹⁴ “Ерөнхий Сайдын 30 минут”. 2013.11.14 <https://www.youtube.com/watch?v=DuTiUkk4UuE>

¹¹⁵ “Ерөнхий сайдын 30 минут” 2013.11.21 <https://www.youtube.com/watch?v=-xBbqGgfzrg>

¹¹⁶ “Ерөнхий сайдын 30 минут” 2013.11.29 <https://www.youtube.com/watch?v=JnKbmeQuJNQ>

¹¹⁷ “Ерөнхий сайдын 30 минут”. 2013.12.13 <https://www.youtube.com/watch?v=nJq0lxjyis>

¹¹⁸ “Ерөнхий сайдын 30 минут”. 2013.12.19 <https://www.youtube.com/watch?v=YuicVBk5eA8>

¹¹⁹ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.01.03 <https://www.youtube.com/watch?v=VKorR5eyp2o>

¹²⁰ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.01.23 <https://www.youtube.com/watch?v=Npl6KI2wiGg>

¹²¹ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.02.06 <https://www.youtube.com/watch?v=F8H22R3JdZk>

	2014.02.13	Ерөнхий сайд газар тариалангийн бодлогыг шинэчлэх, экспортлох нүүрсний хэмжээг нэмэгдүүлэх, утаатай тэмцэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргах гэсэн гурван асуудалд өнгөрч буй долоо хоногт төвлөрч ажилласан талаар танилцуулж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹²²
	2014.02.20	Үйлдвэржилтийг дэмжих төсөл, Монголын эдийн засгийн форум зохион байгуулах, ТЕГ-ын барилгыг дуудлагаар худалдах, “Самурай” бондын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгчээ ¹²³
	2014.02.27	Ерөнхий сайдтай хамт Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал оролцож, валютын ханшийн хэлбэлзэл, мөнгөний бодлого, Монгол Улсын эдийн засгийн байдлын талаар мэдээлэл хийж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹²⁴
	2014.03.06	Пүрэв гариг бүрийн “Ерөнхий сайдын 30 минут” ээлжит уулзалтаар сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹²⁵
	2014.03.20	“Ерөнхий сайдын 30 минут” буюу Ерөнхий сайдын нээлттэй уулзалтад Засгийн газрын үйл ажиллагааг танилцуулж, сэтгүүлчдийн асуултад хариулсан ¹²⁶
	2014.03.27	Пүрэв гариг бүрт сэтгүүлчидтэй уулзаж, тэдний асуултад хариулдаг “Ерөнхий сайдын 30 минут” уулзалт Ерөнхий сайдын өрөөнд болж, Ерөнхий сайд өнгөрсөн сард хийсэн, ирэх сард төлөвлөсөн ажлаа сэтгүүлчдэд танилцуулжээ ¹²⁷
	2014.04.03	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалтынхаа үеэр аймгийн удирдлагуудтай холбогдож, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹²⁸
	2014.04.17	Сэтгүүлчидтэй уулзаж, тэдний асуултад хариулдаг “Ерөнхий сайдын 30 минут” уулзалтын эхэнд Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар товч мэдээлэл хийжээ ¹²⁹
	2014.04.24	Ерөнхий сайд “Эдийн засгаа эрчимжүүлэх нийт 100 хоног” төлөвлөгөөний төслөө танилцуулж, сэтгүүлчдийн асуултад хариулжээ ¹³⁰
	2014.05.29	“Ерөнхий сайдын 30 минут” уулзалтаар эдийн засгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгчээ ¹³¹
	2014.07.03	Долоо хоногийн пүрэв гараг бүрийн 12:30 цагт сэтгүүлчидтэй хийдэг “Ерөнхий сайдын 30 минут” уулзалтаар олны анхаарлын төвд байгаа зарим асуудлаар тайлбар өгчээ ¹³²
Ж.Эрдэнэбат	2016.10.27	Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат болон ЗГХЭГ-ын дарга, Засгийн газрын гишүүд Төрийн ордонд сэтгүүлчидтэй уулзжээ. Засгийн газрын 100 хоног тохиож байгаа учраас 100 хоногийн хугацаанд ямар ажлууд хийсэн талаараа мэдээлэл өгчээ. Мөн яамдууд 100 хоногийн хугацаанд хийсэн ажлаа тус, тусдаа тайлагнажээ. Энэ үеэр сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулжээ ¹³³
Л.Оюун-Эрдэнэ	2021.05.10	Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Засгийн газар байгуулагдаад 100 дахь хоног нь болж байна. Энэ үеэр 37 сэтгүүлчтэй ярилцжээ. Мөн талбай дээр “Нэг намын дарангуйлал үүслээ” хэмээн өлсгөлөн зарлаад буй АН-ын бүлгийн гишүүдийн талаар байр сууриа илэрхийлжээ ¹³⁴

¹²² “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.02.13 <https://www.youtube.com/watch?v=08luaijS2Y0>

¹²³ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.02.20 https://www.youtube.com/watch?v=6WmtWh6pa_Y

¹²⁴ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.02.27 <https://www.youtube.com/watch?v=Hwhz80z2g94>

¹²⁵ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.03.06 <https://www.youtube.com/watch?v=MeaAHiW2UJA>

¹²⁶ “Ерөнхий сайдын 30 минут” 2014.03.20 <https://www.youtube.com/watch?v=-Z-jitm6HxA>

¹²⁷ “Ерөнхий сайд сэтгүүлчидтэй уулзлаа”. 2014.03.27 <https://www.youtube.com/watch?v=NVcP55TwUzI>

¹²⁸ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.04.03 <https://www.youtube.com/watch?v=vkWyDbq0VLQ>

¹²⁹ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.04.17 <https://www.youtube.com/watch?v=zzNx-28CK-s>

¹³⁰ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.04.24 <https://www.youtube.com/watch?v=UYmaSiGaMVk>

¹³¹ “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.05.29 <https://www.youtube.com/watch?v=lrbxl9xFUkc>

¹³² “Ерөнхий сайдын 30 минут”. 2014.07.03 <https://www.youtube.com/watch?v=kSJwOVK34Iq>

¹³³ “Ерөнхий сайд сэтгүүлчидтэй уулзаж байна”. 2016.10.27 <https://tinyurl.com/3putdsxw>

¹³⁴ “Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ сэтгүүлчдэд “байцаагдав”. 2021.05.10 <https://eguur.mn/205672/>

2.1.10. Төрийн эрх мэдэлтнүүд эсвэл улс төрийн гол тоглогчдын зүгээс хуурамч мэдээлэл буюу үзэл суртлын томоохон хэмжээний хөдөлгөөн зохион байгуулдаг, дэмждэг эсэх

Англи хэл дээр нийтлэг байдлаар “fake news” гэх ойлголтыг монгол хэлнээ худал/хуурамч мэдээлэл гэж орчуулж хэрэглэх болсон. Энэхүү ойлголтын цаана “dis-information”, “mis-information”, “mal-information” гэх гурван ойлголт бий.¹³⁵

- “Dis-information” буюу худал мэдээлэл гэдэг нь хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага, улс оронд хохирол учруулах зорилгоор санаатайгаар бий болгосон худал мэдээлэл юм. Ялангуяа Засгийн газар, улс төрийн намаас өрсөлдөгч хүчин, хэвлэл мэдээллийг төөрөгдүүлэх зорилгоор гаргасан суртал ухуулга үүнд хамаарна.
- “Mis-information” буюу буруу, ташаа мэдээлэл гэдэг нь хохирол учруулах санаа зорилго агуулаагүй худал мэдээлэл юм. Тодруулбал, хуурах, төөрөгдүүлэх зорилготой мэдээлэл үүнд хамаарна.
- “Mal-information” буюу хуурамч мэдээлэл гэдэг нь бодит үйл явдалд тулгуурласан бөгөөд хувь хүн, байгууллага, улс оронд хохирол учруулах зорилгоор ашигладаг мэдээлэл юм.

Тодруулбал, хэр худал, ноцтой үр дагавартай эсэхээр нь худал мэдээллийг дээр дурдсан гурван төрөлд ангилж байна. Үүнийг дараах зураглалаас тодорхой харж болно. Эндээс харахад, худал мэдээлэл нь зөвхөн буруу, ташаа мэдээлэл түгээхээр хязгаарлагдахгүй бөгөөд нийгмийн бүх оролцогчдод хохирол учруулах үр дагавартай байна. Энэ нь ихэвчлэн цахим орчин дахь тархи угаалт хэлбэрээр илэрч байна.

Зураг 2. Худал, ташаа, хуурамч мэдээллийн ялгаа, онцлог



Фэйсбүүкийн шүгэл үлээгч Софи Жангийн мэдээлснээр, зохион байгуулалттай олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл тараах явдлыг Фэйсбүүк зогсоох талаар анхаардаггүй, жишээ нь Монгол Улсад 2019 онд сонгууль угтаж улс төрчийг дэмжихэд чиглэсэн хуурамч хариу үйлдэл, сэтгэгдэл бүхий Фэйсбүүк дэх хуурамч хаягуудыг мөрдөн шалгах, түүнийг устгах арга хэмжээ огт аваагүй байна.¹³⁶

18-40 насны 2494 иргэнийг түүврийн аргаар хамруулан 2020.05.14-2020.06.15-ны өдрүүдэд Хараат бус судалгааны хүрээлэнгээс хийсэн “Залуучуудын санал бодлын судалгаа”-ны

¹³⁵ Information Disorder: Toward an interdisciplinary framework for research and policy making. Council of Europe, October, 2017. pp. 20 <https://rm.coe.int/information-disorder-toward-an-interdisciplinary-framework-for-research/168076277c>

¹³⁶ Guardian News & Media Limited. “How Facebook let fake engagement distort global politics: a whistleblower’s account” 12 April 2021. <https://www.theguardian.com/technology/2021/apr/12/facebook-fake-engagement-whistleblower-sophie-zhang>

дүнгээс харахад, 70% нь интернэт, нийгмийн сүлжээг өдөр бүр хэрэглэж байна. Мөн 61% нь өдөр бүр буюу 7 хоногт хэдэн өдөрт хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээнд худал ташаа мэдээлэлтэй таарч байгаа бөгөөд фэйсбүүк дээр худал, ташаа мэдээллийн 91% нь байна. Мөн улсын хэмжээнд залуусын 35% нь, Улаанбаатарт 44% нь худал, ташаа мэдээлэлд хууртагдаж байсан.¹³⁷

Улсын Их Хурлын 2020 оны сонгуультай холбогдуулан хийсэн фэйсбүүк дэх сонгуулийн сурталчилгааны мониторингийн тайланд дурдсанаар ерөнхийдөө нийгмийн сүлжээнд улс төрийн сурталчилгааны агуулгыг олон нийтэд зохион байгуулалттай түгээх нь сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө ч ажиглагдсан ба үүнд нэр дэвшигчид ямар хэмжээний мөнгө зарцуулж байгааг одоогоор мэдэх боломжгүй, хяналт байхгүй байна. Сурталчилгааг нам, нэр дэвшихээр горилогч болон нэр дэвшсэн улс төрчдөөс гадна гуравдагч этгээд буюу намын дэргэдэх холбоод, бусад этгээд түгээх байдал ажиглагдсан. Түүнчлэн фэйсбүүк дэх нэр дэвшигчийн нэг бичвэрийг дунджаар 244 орчим удаа цааш нь түгээж байжээ. Тэдний бичвэрийг зохион байгуулалттайгаар түгээх тохиолдлууд ч ажиглагдсан. Нэр дэвшигч бүрийн бүх бичвэрт дор хаяж 10-30 хүн (фэйсбүүк аккаунт) нэг агуулга бүхий сэтгэгдэл зохион байгуулалттайгаар бичиж байгаа нь ажиглагдсан. Үүнд нэр дэвшигч хэдий хэмжээний мөнгө зарцуулж буй мэдээлэл ил тод бус бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны зүгээс ямар хяналт тавьсан нь тодорхойгүй байна. Энэ сонгуульд фэйсбүүкийг ашиглахдаа зарим нэр дэвшигч сонгогчдыг оршин суух байршлаар нь бүлэглэн жагсаалт үүсгэн зөвхөн өөрийн хүссэн тодорхой хорооны зорилтот бүлэгтээ мэдээлэл сурталчилгаагаа түгээх байдал ч ажиглагдсан. Фэйсбүүк дээр иргэд өөрийн гэрийн хаяг, утасны дугаар зэрэг хувийн мэдээллээ хүн бүрд харуулах буюу нээлттэй тохиргоотойгоор оруулсан бол мэдээллийг нь хэн ч авч болох ч дээрх жагсаалтын дотор мэдээллээ хаалттайгаар тохируулсан иргэд ч мөн багтсан байсан. Өөрөөр хэлбэл, өөрийн мэдээллээ нууцлахыг хүссэн иргэдийн мэдээллийг ямар аргаар олж ашигласан нь сонирхол татаж байна.¹³⁸

Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс нэр бүхий 4 шүүгдэгчийг “Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо Тусгаар тогтнолын ордны 4 давхар 411 тоотоос 2019.10.19, 2020 оны 01 дүгээр сараас 2020.04.21-ний өдөр хүртэл Z Shadow.online веб сайт болон Фишинг төрлийн үйлдлийн программыг ашиглан 14 фэйсбүүк хэрэглэгчдийн нэвтрэх нэр, нууц үгийг мэдэгдэлгүйгээр авч нууц үгийг өөрчлөх буюу цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж компьютерын өгөгдөл, системд нэвтэрч, танилцсан” гэх хэргийг хянан хэлэлцэж, 2021.08.23-ны өдрийн 583 дугаартай шийтгэх тогтоолоор тэдгээр шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “бусадтай бүлэглэн цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, өөрчилсөн, засварласан, мэдээлэл нэмж оруулсан, ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагаа алдагдуулсан” гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.¹³⁹ Тус хэрэгт шийтгүүлсэн Э.Г яллагдагчаар өгсөн мэдүүлэгтээ “...Сонгуулийн үед бид МАН-ын сошиал сувгуудыг хөгжүүлж ажиллах гэж байсан. Ингээд би тухайн намын байранд байрлаж ажилласан ба өөрийн IP хаягаас олон тооны фэйсбүүк хаяг нээх боломжгүй байсан тул би Б.Т, Э.Ч, М.Ж нартай нийлж бусдын фэйсбүүк хаягийг өөрийн болгож олзлох санаатай ажиллаж эхэлсэн...” гэж, шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Э.Г өгсөн мэдүүлэгтээ “Э.Ч, Б.Т, М.Ж нар орж ирсэн фэйсбүүк хаягийг Монгол Ардын намын цахим

¹³⁷ Хараат бус судалгааны хүрээлэн. “Залуучуудын санал бодлын судалгаа”. 2020.06.15. 65, 66, 69 дахь тал https://www.iri.org/sites/default/files/mongolia_ned_youth_poll_2020_-_public_deck_mongolian_final.pdf

¹³⁸ Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв. “Фэйсбүүк дэх сонгуулийн сурталчилгааны мониторинг”. 2020.12.13 <https://www.sanal.mn/story/7788/2020-12-16>

¹³⁹ Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021.08.23-ны өдрийн 583 дугаартай шийтгэх тогтоол https://shuukh.mn/single_case/59694?daterange=2021-08-23%20-%202021-08-23&id=1&court_cat=2&bb=1

бодлогын хэлтсийн ажилтан Содмагнай гэх хүнд өгдөг байсан. Тухайн олзолсон фэйсбүүк хаягуудыг Содмагнай нь сонгуулиар ашиглах гэж бид нараас фэйсбүүкийн мэдээллүүдийг авдаг байсан. Бид нарт анх ажлын санал тавих үедээ ‘олон тооны фэйсбүүк аккаунт авна’ гэж санал тавьж Содмагнай нь ‘фэйсбүүк аккаунт хөгжүүлэх ямар ч боломжгүй байна’ гэж хэлэхээр нь ‘Z shadow’ гэдэг программыг танилцуулахад ‘тухайн программаар фэйсбүүк аккаунт нийлүүл’ гэж хэлсэн” гэж, шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Э.Ч өгсөн мэдүүлэгтээ “...Анх Э.Г тус ажлын саналыг тавьж хамтран ажиллахаар болсон. Монгол Ардын намын цахим бодлогын хэлтсээс бид нарт 1000 гаруй утасны дугаар өгсөн байсан тул хохирогч нарын фэйсбүүк хаягийн утасны дугаарыг арилгаж шинэ утасны дугаар бүртгэдэг байсан. Тус олзолсон фэйсбүүк хаягийнхаа паспортыг сольсон зүйл байхгүй. Бид нарын хувьд нэвтрэх нэрийг солиод Монгол Ардын намын цахим бодлогын хэлтсийн Алтантуул гэх хүнд өгөөд тухайн хэлтэс нь нууц үгийг сольдог байсан” гэж, шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Т өгсөн мэдүүлэгтээ “...Хохирогч нарын фэйсбүүк аккаунт руу нэвтэрч ороод хүмүүсийн мэдээллийг цааш Монгол Ардын намын цахим бодлогын хэлтэс, хариуцсан багт өгөөд тухайн хүмүүс нууц үгийг сольдог байсан” гэж тус тус мэдүүлсэн.

Энэ нь улс төрийн гол тоглогч буюу Монгол ардын намын зүгээс хуурамч мэдээлэл буюу үзэл суртлын томоохон хэмжээний хөдөлгөөн зохион байгуулахын тулд цахим гэмт хэрэг захиалгаар үйлдүүлсэн, хамтран оролцсон болохыг харуулж байна. Гэвч шүүхээс “шүүгдэгч Э.Г, М.Ж, Э.Ч, Б.Т нар нь цахим мэдээлэлд хууль бусаар халдах гэмт хэргийг үйлдсэн болох нь хангалттай нотлогдож тогтоогдсон байх бөгөөд үүнд эргэлзээ төрүүлэхээр өөр ямар нэгэн баримт сэлт мөрдөн байцаалтаар авагдаагүй байх тул ‘...Монгол Ардын намын цахим бодлогын хэлтсийн ажилтнуудыг хэрэгт холбогдуулан шалгах тухай’ хүсэлт, гомдлуудыг хүлээн авах хууль зүйн үндэслэлгүй болно” гэж дүгнэсэн. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах зорилттой нийцээгүй байна. Мөн тус хуулийн 16.10 дугаар зүйлийн 2-т “мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй”, 4-т “Шүүх, прокурор, мөрдөгч хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооход ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах тухай шийдвэр гаргана” гэсэнтэй нийцээгүй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.6 дугаар зүйлийн 1.2-т “дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болох нөхцөл байдлыг шүүх анхаарч үзэлгүй орхигдуулсан бол” анхан шатны шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй гэж үзнэ гэж заасан.

Монгол Улсад 2020.08.04-2022.02.03-ны өдөр хүртэлх хугацаанд 213,397 ам.доллар бүхий 11,858 сурталчилгааг Фэйсбүүкт төлбөртэй нийтлүүлжээ.¹⁴⁰ Үүнээс Монгол ардын намын фэйсбүүк дэх хаягт 6,287 ам.доллар зарцуулсан бөгөөд түүний 4,355 ам.долларыг тус намын ажилтан Э.Содмагнай зарцуулжээ. Харин Ардчилсан намын хаягт 2,445 ам.доллар, Хөдөлмөрийн үндэсний намын хаягт 11,221 ам.доллар тус тус зарцуулжээ.¹⁴¹


Зураг 3. Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр буюу 2021.04.12-2021.05.11-ний хугацаанд намуудын фэйсбүүкт зарцуулсан зардлын харьцуулалт

¹⁴⁰ Meta Ad Library Report: Mongolia – Spending by advertiser. Aug 4, 2020 - Feb 3, 2022
<https://www.facebook.com/ads/library/report/>

¹⁴¹ Монгол ардын намын фэйсбүүк дэх @Ardinnam хаягийн сурталчилгаа <https://tinyurl.com/2p9389hj>
Ардчилсан намын фэйсбүүк дэх @dempartym хаягийн сурталчилгаа <https://tinyurl.com/2p98kh3k>
Хөдөлмөрийн үндэсний намын фэйсбүүк дэх @Hunnam.mn хаягийн сурталчилгаа <https://tinyurl.com/bdb4s472>



График 9. УИХ-д суудалтай намуудын 2020.08.04-2022.02.03-ны хугацаанд фэйсбүүкт зарцуулсан зардлын харьцуулалт (ам.доллар)



Хүснэгт 8. Фэйсбүүкт 2020.08.04-2022.02.03-ны өдөр хүртэлх хугацаанд төлбөртэй сурталчилгаа нийлүүлсэн байдал (2000 ам.доллараас дээш дүнтэй)

Фэйсбүүкийн нэр	Төлсөн этгээд	Төлбөр /\$/	Давтамж	Сонгуулийн үйл ажиллагаа
Энхбаярын Батшугар	Энхбаярын Батшугар	27353	122	УИХ-ын нөхөн сонгуульд МАН-аас нэр дэвшсэн
Хөдөлмөрийн Үндэсний Нам - ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний Нам - ХҮН	9644	227	УИХ-ын болон орон нутгийн сонгуульд оролцсон
Бадрахын Найдалаа	Бадрахын Найдалаа	8604	83	УИХ-ын сонгуульд ХҮН-аас нэр дэвшсэн
Жамбалын Ганбаатар	Ganbaatar Jambal	7888	187	УИХ-ын гишүүн
Монгол ардын нам	Sodmagnai Enkhjargal	4355	45	УИХ-ын, орон нутгийн болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон
Хассуурийн Ганхуяг	Khassuuri Gankhuyag	3981	96	УИХ-ын гишүүн
Purevdorj Bukhchuluun	Purevdorj Bukhchuluun	3894	49	УИХ-ын гишүүн
Баярсайхан Галигаа	Баярсайхан Галигаа	3697	15	Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн
Бадарчийн Одсүрэн	Saruulbayar Bat-Erdene	3498	54	Орон нутгийн сонгуульд оролцсон. Нийслэлийн засаг даргын орлогч
Сүхбаатарын Эрдэнэболд	Сүхбаатарын Эрдэнэболд	3234	30	УИХ-ын сонгуульд АН-аас нэр дэвшсэн
Эрдэнэ Бат-Үүл	Jargal Baldangombo	2649,	66	УИХ-ын нөхөн сонгуульд АН-аас нэр дэвшсэн
Дангаасүрэнгийн Энхбат	Хөдөлмөрийн Үндэсний Нам	2259,	16	Ерөнхийлөгчийн сонгуульд ХҮН-аас нэр дэвшсэн
Ардчилсан нам Democratic Party	Enkhmurun Erdenebat	2149	39	УИХ-ын, орон нутгийн болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон
Зөв ХҮН Электорат эвсэл	Tsatsral Tumur	2137	25	Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон
Батмөнхийн Өнөбат Unubat Batmunkh	Erkhembayar Khaitan	2081	41	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвөөс Улсын Их Хурлын 2020 оны сонгуультай холбогдуулан хийсэн фэйсбүүк дэх сонгуулийн сурталчилгааны мониторингийн тайланд дурдсанаар, сонгуулийн зардлын мэдээлэл бүхэлдээ ил тод бус байгаатай холбоотой нийгмийн сүлжээ сонгуульд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох боломжгүй нөхцөлд сонгууль явагдаж байна. Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд нэр дэвшигчийн өөрийн албан ёсны хуудсаар биш өөр хуудаснуудаар тухайн нэр дэвшигчийг дэмжсэн постыг төлбөртэйгөөр нийтлэх нь ажиглагдаж байлаа. Нэр дэвшихээр горилогчдын оруулсан 3 пост тутмын нэг нь төлбөртэй байв. Нэг төлбөртэй пост дунджаар 5-6 хоног үргэлжилж байв. Фэйсбүүк компаниас төлбөртэй сурталчилгаанд нэг хариу үйлдэлд тооцох мөнгөн дүнг нээлттэй зарлаагүй бөгөөд тогтсон үнэ байдаггүй. Тухайн сурталчилгааны зорилтот бүлэг, газар орны байршил зэргээс шалтгаалж харилцан адилгүй үнэ ханштай байдаг. Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийн олж авсан мэдээллээр (ажиглалт болон асуулгын аргаар) нэг хариу үйлдэлд оногдох төлбөрийн хэмжээ 0.02-0.2 ам.долларын хооронд хэлбэлзэж байв.¹⁴²

Эндээс цахим орчин дахь худал мэдээнд автахгүй байх, худал мэдээ дэлгэрэхээс сэргийлэх дараах арга замыг мэддэг байх, хэрэгжүүлэх нь чухал болж байна.

- Худал мэдээнд автахгүй байх арга зам: 1/ Худал мэдээг ялгаж сурах. Энэ хүрээнд мэдээний агуулга бодитой эсэхэд эргэлзэх; хэд хэдэн эх сурвалжийг харьцуулж хэвших. 2/ Мэдээнд сэтгэлийн хөдөлгөөнөөр хандахгүй байх. Худал мэдээ нь уншигч, үзэгчийг сэтгэл хөдлөлд автуулах, бодит баримтыг нуух хэв шинжтэй байдаг. 3/ Худал мэдээг бусдад дамжуулахгүй байх, зөвхөн бодит мэдээг дамжуулах.
- Худал мэдээ дэлгэрэхээс сэргийлэх арга зам: 1/ Тоохгүй орхих. 2019 онд фэйсбүүк дэх улс төрийн агуулга бүхий худал мэдээ АНУ-д 150 сая гаруй хүнд хүрсэн. Энэ нь худал мэдээг тоолгүй орхисон бол худал мэдээ дэлгэрэхгүй байхыг харуулж байна. 2/ Худал мэдээг устгуулах. Цахим сүлжээн дэх худал мэдээллийн талаар гомдол гаргах арга, технологийн зохицуулалт фэйсбүүк, гүүгл, твиттер, инстаграмд бий. Үүнийг тохиргооны хэсгээс нь олж мэдэх, тохируулах боломжтой. 3/ Худал мэдээг бусдад ойлгуулах, таниулах. Энэ нь арай илүү идэвхтэй байдлыг шаарддаг. Тодруулбал, бодит үнэнийг мэдээлэх замаар худал мэдээний үр дагавартай тэмцэх хэрэгтэй болдог. Бодит үнэнийг мэдээлэх замаар худал мэдээний үр дагавартай тэмцэхэд тодорхой арга зүй шаардлагатай. Тодруулбал, тухайн худал мэдээнд дурдсан агуулгыг үгүйсгэх, няцаахдаа худал ба үнэн, бодит нөхцөлийг харьцуулан харуулах нь оновчтой.¹⁴³

Дээрх арга замыг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн зүгээс “нягталсан мэдээлэл” тогтмол бэлтгэж хүргэх нь чухал хувь нэмэртэй болохыг Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төвийн хэрэгжүүлж буй “Fact Check Mongolia” хөтөлбөр, түүний <https://factcheck.mn/> цахим хуудас болон “Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн үүр төв” НҮТББ-ын “Mongolian Fact-checking Center”, түүний <http://www.mfcc.mn> цахим хуудас дахь нягталсан мэдээллээс харж болохоор байна. Хараат бус, тэнцвэртэй байхад сэтгүүлчийн баримтлах таван дүрэм бол 1/ бүх баримтаа ашиглах, 2/ янз бүрийн эх сурвалж ашиглан үзэл бодлыг тэнцвэржүүлэх, 3/ шүүмжлэлтэй байх, 4/ доод тал нь хоёр эх

¹⁴² Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв. “Фэйсбүүк дэх сонгуулийн сурталчилгааны мониторинг”. 2020.12.13 <https://www.sanal.mn/story/7788/2020-12-16>

¹⁴³ Л.Галбаатар. “Цахим орчин дахь тархи угаалт, худал мэдээллээс сэргийлэх нь”. Конрад-Аденауэр-Сангийн “Нээлттэй улс төр” сэтгүүл. Улаанбаатар. 2019 он

сурвалжаар үнэнийг нотлох, 5/ хувийн сонирхол, эрх ашигтайгаа холбоотой зүйл бичихгүй байх юм.¹⁴⁴

Хүснэгт 9. Сэтгүүлчдийн нягталсан мэдээллийн тойм, 2020-2022

Огноо	Нягталсан мэдээлэл	Эх сурвалж
2022.01.19	Өнгөрсөн хоёр жил утаа 47 хувь хүртэл буурсан, шахмал түлшний чанарыг 30 хувиар сайжруулсан гэх мэдээлэл #төөрөгдүүлсэн	Mongolian Fact-checking Center
2021.12.15	Байр, зуслангийн байшинтай бол нэмэлт татвар төлөх нь гэх мэдээлэл #худал, гэхдээ үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар нэмэгдсэн нь #үнэн	Mongolian Fact-checking Center
2021.12.03	2012 оноос хойш төрсөн хүмүүст 1072 хувьцааг олгох боллоо гэх мэдээлэл #худал	Mongolian Fact-checking Center
2021.11.22	Рио Тинто компани Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээг цуцлахаа мэдэгдлээ гэх мэдээлэл #худал	Mongolian Fact-checking Center
2021.10.12	Хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүдэд хүүхдийн мөнгийг 300,000₮ болгохоор хэлэлцэж байна гэх мэдээлэл #худал	Mongolian Fact-checking Center
2021.10.07	Төрийн албан хаагчдын цалинг 1.7 их наядаар бууруулахаар боллоо гэх мэдээлэл #төөрөгдүүлсэн	Mongolian Fact-checking Center
2021.09.20	Монгол, Солонгос иргэд харилцан визгүй зорчдог болох боломж бүрдлээ гэх мэдээлэл #худал	Mongolian Fact-checking Center
2021.09.10	Ард иргэдийнхээ өр зээлийг нэг удаа тэглэнэ гэх мэдээлэл #төөрөгдүүлсэн	Mongolian Fact-checking Center
2021.09.06	У.Хүрэлсүх шүүхийн томилгооноос татгалзсан анхны Ерөнхийлөгч боллоо гэх мэдээлэл #төөрөгдүүлсэн	Mongolian Fact-checking Center
2021.08.10	16 хүртэлх настай хүүхэдтэй өрх бүрт сар бүр 288000 мянган төгрөг он дуустал олгохоор болжээ — худал	Fact Check Mongolia
2021.08.02	Хэрэглээний зээлийг нэг удаа тэглэх санал гаргалаа гэх мэдээлэл #худал	Mongolian Fact-checking Center
2021.06.14	Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө У.Хүрэлсүхийн тараасан сурталчилгааны сонинд хийсэн factcheck	Fact Check Mongolia
2021.06.09	Сонгуулийн байранд саналын хуудсыг дугаарласан зөрчил гарсан нь #үнэн, шалтгааныг шалгаж байна	Mongolian Fact-checking Center
2021.05.18	1072 хувьцааны ногдол ашиг 690,000 төгрөг тараах боллоо гэх мэдээлэл #худал	Mongolian Fact-checking Center
2021.05.12	УИХ-ын гишүүн Ц.Анандбазар “Ам нээвэл” нэвтрүүлэгт орохдоо хэлсэн худал мэдээллээс	Fact Check Mongolia
2021.04.28	Шадар сайдын “Мэдээллийн урсгал”-аар өгсөн худал мэдээллүүд	Fact Check Mongolia
2021.04.28	Ерөнхий сайд асан У.Хүрэлсүхийн сурталчилгааны үнэн ба худал	Fact Check Mongolia
2021.04.22	Засгийн газар ирэх 7 дугаар сараас эхэлж таны цалингаас 36%-ийн шимтгэл суутгаж авна гэх мэдээлэл #төөрөгдүүлсэн	Mongolian Fact-checking Center
2021.04.17	Эрүүгийн хуулиар Монгол Улсын шүүхээс 2 жилийн тэнсэн харгалзах ял авч байсан Хүрэлсүх нэр дэвших эрхгүй — худал	Fact Check Mongolia
2021.03.02	Залуусыг фитнесст явуулахад 500 тэрбумыг төсвөөс зарцуулна #худал	Mongolian Fact-checking Center
2021.02.09	Цагаан сараар гадуур гарвал 500 мянган төгрөгөөр торгоно #үнэн	Mongolian Fact-checking Center
2021.01.26	Ерөнхий сайд асан С.Батболдтой холбоотой шүүхийн эргэн тойронд	Fact Check Mongolia
2021.01.12	ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнийн зөрүүтэй намтар	Fact Check Mongolia
2021.01.07	“Монгол Улсын 3 ерөнхийлөгч Оюутолгойн ордыг баялгийн хамт эзэмшигч Роберт Фридландтай хундага тулгаж байгаа байдал” – худал	Fact Check Mongolia
2020.12.14	Шахмал түлш хүхэрлэг хий, азотын давхар ислийг нэмэгдүүлжээ гэх мэдээлэл #үнэн	Mongolian Fact-checking Center

¹⁴⁴ Х.Наранжаргал. “Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй”. Улаанбаатар. 2021 он. 148 дахь тал


2020.11.16	11-р сарын 18-нд хөдөө орон нутгийн иргэдийг гаргана #худал	Mongolian Fact-checking Center
2020.11.09	Дэлхий даяар тав хоногт 3.6 сая удаа үзсэн “Монгол Улс covid-19-ийг давсан нууц” гэх контент төөрөгдүүлсэн	Mongolian Fact-checking Center
2020.10.15	Нийслэлийн 36 агентлаг, үйлдвэр, төслийн дарга нарыг ажлаас нь чөлөөлсөн гэдэг ташаа мэдээлэл	Fact Check Mongolia
2020.07.02	Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргах асуудлаар FATF онлайн уулзалт хийсэн тухай албан бус орчуулга төөрөгдүүлсэн	Mongolian Fact-checking Center
2020.06.08	Ц.Анандбазар Энэтхэгээс тэрбум доллар босгож, нефтийн үйлдвэрийн дэд бүтцийг хийж өгсөн — худал	Fact Check Mongolia
2020.06.04	УИХ-ын дарга ажлын тайландаа иргэдэд буруу ойлголт төрүүлэх мэдээлэл оруулжээ	Fact Check Mongolia
2020.06.04	Өргөдлийн байнгын хороо шатахууны үнийг бууруулсан гэдэг нь худал	Fact Check Mongolia

2.2. Эдийн засгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт эдийн засгийн нөхцөл байдлыг судалгааны асуулт бүрийн хүрээнд дүгнэв.

2.2.1. Бие даасан, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу редакцийн агуулга нь эзэд, улс төрийн эрх мэдэлтнүүдийн аливаа хязгаарлалтгүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг эсэх

Монгол Улсын хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын байдлаар 513 хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгаа бөгөөд 2021 онд 7 сонин үйл ажиллагаагаа зогсоож, сонины тоо 78 болж буурсан. Тодруулбал, өдөр тутмын болон сар тутмын тус бүр нэг сонин, долоо хоног тутмын болон бусад хэлбэрийн тус бүр хоёр сонин үйл ажиллагаагаа зогсоосон. Тухайлбал, өдөр тутмын “Засгийн газрын мэдээ” сонин, орон нутгийн “Дарханы мэдээ” сонин үйл ажиллагаагаа зогсоосон. Мөн “Барилга телевиз”, орон нутгийн “Замын-Үүд”, “Таны Сэлэнгэ” зэрэг телевизийн сувгууд үйл ажиллагаагаа зогсоосон. Харин мэдээллийн сайтын тоо 24-өөр нэмэгдэж 178 болсон.¹⁴⁵



Эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийт 4730 хүн ажиллаж байна. Үүний 49% нь сэтгүүлч (сурвалжлагч, редактор), 18% нь техникийн болон туслах ажилтан, 16% нь удирдах ажилтан, 12% нь захиргааны болон үйлчилгээний ажилтан, 5% нь бусад ажилтан байна.¹⁴⁶

¹⁴⁵ Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл – өнөөдөр” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021 он. 8, 44, 56 дахь тал

¹⁴⁶ Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл – өнөөдөр” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021 он. 72, 73 дахь тал

Салбараар нь авч үзвэл, сэтгүүлч, сурвалжлагч, редакторын олонх нь телевизэд ажиллаж байна.



Гэвч 2021 онд сэтгүүлчийн дундаж цалингийн хэмжээ 700,000 төгрөг байгаа нь санхүүгийн хувьд бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөлийг хязгаарлаж болзошгүй байна. Фридрих-Эбертийн сангийн захиалгаар Монголын Хэвлэлийн Хүрээлэн 19 аймаг, Улаанбаатар хотын 260 хэвлэл мэдээллийн хэрэгслийн 1100 сэтгүүлчдээс тэдний хөдөлмөрийн нөхцөл, байдлын талаар судалгаа авахад, сэтгүүлчид цалиндаа сэтгэл ханамжгүй бөгөөд харин хамт олны уур амьсгалдаа хамгийн сэтгэл хангалуун байна. Эдгээр сэтгүүлчийн 33% нь нэвтрүүлэг, нийтлэл гэх мэт хийсэн бүтээлээс болж гаднаас дарамт ирдэг гэж, 58% нь үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах явдалд өртдөг гэжээ. Мөн дарамт шахалтын 40% нь тухайн сэтгүүлчийн ахлах албан тушаалтан, 36% нь удирдах ажилтан, 18% нь нам, улс төрийн байгууллага, улстөрч, бизнесийнхнээс ирдэг гэжээ.¹⁴⁷ Энэ нь редакцийн агуулга нь эзэд болон улс төрийн эрх мэдэлтнүүдийн аливаа хязгаарлалтгүй эсэх талаарх тодорхой дүр зургийг бий болгож байна.

Хэвлэлийн Хүрээлэнгээс 2016 онд “Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторинг”-оор “Хэвлэл мэдээллийн эзэмшигчид санхүүгийн ашгийн төлөө гэхээс илүүтэй улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага үүсгэн байгуулж, эсвэл худалдаж авч байна хэмээн үзэж болохоор байна. Бизнес, улс төрийн нягт холбоо нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчдэд дарамт болж ирдэг. Тухайн мэдээллийн хэрэгсэл улс төрийн, эсхүл санхүүгийн хараат байдалд байх тохиолдолд олон нийтийн гэхээс илүү эзэн, санхүүжүүлэгчийн ашиг сонирхолд үйлчилнэ. Улмаар сэтгүүлчид мэргэжлийн үүрэг хариуцлагаа хараат бусаар хэрэгжүүлэх боломжгүй болж хэлэх үгээ хянаж эхлэх буюу өөрийн цензур газар авна. Нөгөө талаас сэтгүүлчид хэт их ажлын ачаалалтай, хэт бага цалинтай учир мэргэжлийн үүрэг хариуцлагаа ‘төлбөртэй мэдээллээр’ худалдах нь энгийн үзэгдэл болно.” гэж дүгнэсэн.¹⁴⁸ Сэтгүүлч Д.Нарантуяа “Редакцийн зурвас” номдоо энэ асуудлыг хөндөж, “редакцууд худалдагдсан, улстөрчдийн гар хөл боллоо гэж шүүмжлүүлдэг ч улс төрөө давж сэтгүүл зүйгээ хийх гэсэн хэдэн зуун сэтгүүлч өнөөдөр чадлаараа мачийж байгаа нь бодит үнэн юм” гэжээ.¹⁴⁹

“Splice Media” байгууллагын үүсгэн байгуулагч Алан Сүүн “Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн экосистемийг кодчилох, санхүүжүүлэх нь” илтгэлдээ “Монголын 500 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслийн ихэнх нь улс төр, бизнесийн ашиг сонирхлын гарт төвлөрч байна. Ихэнх хэвлэл мэдээллийн компаниудын хувьд хэвлэл мэдээллийн амжилттай

¹⁴⁷ Хэвлэлийн хүрээлэн, ХБНГУ-ын Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. “Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан”. Улаанбаатар. 2019.09. 53, 56 дахь тал <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/15695.pdf>

¹⁴⁸ Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторинг төсөл: “Хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэн эзэмшиж байна вэ?” 2016. <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-findings/translation-ownership/>

¹⁴⁹ Д.Нарантуяа. Редакцийн зурвас (сэтгүүлч, редактор, редакцийн тухай; нийтлэлүүд). Улаанбаатар. 2021 он. 88 дахь тал

ажиллах боломжтой бизнес байхын оронд маркетингийн компани байдлаар ажиллаж, улмаар чанар муутай контент бий болж байна. Энэ нь сэтгүүлчдийг нэг талыг барьсан, мэргэжлийн бус бөгөөд цахим орчинд бойжсон залуу үеийнхэнд хамаагүй гэсэн үзэл батжихад хүргэдэг. Бэлэн мөнгөний төлөө гацсан эдгээр бизнесүүд ажилтнуудын сургалтад хөрөнгө оруулахад анхаарах сөхөөгүй, цалин хөлсөө олгоход ч хэцүү байна. Зар сурталчилгааны орлого, төрийн бус байгууллагын санхүүжилтээс хэт хамааралтай байгаа нь өсөлт хөгжилт, хэрэглэгчидтэй гүнзгий харилцаа тогтоох боломжийг хязгаарладаг. Одоогийн сэтгүүлзүйн боловсрол нь хүмүүсийг ирээдүйн цахимжилтай холбоотой ажилд бэлтгэхгүй байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд хэвлэл мэдээллийн байгууллагуудад зориулсан бие даасан, жижиг боловч төвлөрсөн санг бий болгох хэрэгтэй. Энэхүү санг хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд болон төрийн бус байгууллагуудын хамтын нийгэмлэг удирдан чиглүүлэх нь зүйтэй. Гол санаа нь контентод бус, гарааны компани болон чөлөөт сэтгүүлчдийн ажлыг хэрхэн мэргэжлийн түвшинд хүргэхэд чиглэнэ. Энэ нь уламжлалт хэвлэл мэдээллийн бизнест ажиллаж буй дунд түвшний сэтгүүлчдийг орчин үеийн дижитал хэлбэрт шилжүүлэх сайн арга юм. Зориулалтын сан нь улс төрийн ашиг сонирхлоос ангижрахад түлхэц болно. Өөрөө бие даан шинээр эхлэх хүсэлтэй залуу, дижитал хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдэд чиглэсэн хэвлэл мэдээллийн амьдрах чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Сургалт нь бизнес төлөвлөгөө боловсруулах, буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт татах, бүтээгдэхүүний сэтгэлгээг бий болгох зэрэг агуулгыг хамарна. Хоёр дахь гол зүйл бол мэргэжлийн ёс зүйн зарчмыг хөгжүүлэх, түүнийг амжилттай хэрэгжүүлэх юм” гэжээ.¹⁵⁰ Дээр дурдсан нөхцөл байдалтай холбоотойгоор сэтгүүлч Д.Нарантуяа сэтгүүл зүйн редакцийн бизнес моделийг дэвшүүлжээ.¹⁵¹

Хүснэгт 10. Сэтгүүл зүйн редакцийн бизнес модель

Агуулга	Тайлбар
1/ Хараат бус, бие даасан, мэргэжлийн, хариуцлагатай байх	Хараат бус, бие даасан нийтлэлийн бодлоготой, хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүлчтэй, хараат бус, олон талын эх сурвалжтай контенттой байх нь редакц амьдрах, оршин тогтнох үндэс болно. Мөн ил тод байдал чухал. Эзэмшигч, хувь эзэмшигч, нийтлэлийн бодлого, зарлагын тайлан ил байх учиртай. Эдгээр мэдээлэл ил байх нь тухайн редакц эрэн сурвалжлах нийтлэл хийж байх үед онцгой ач холбогдолтой.
2/ Хэрэглэгчээ шүтэх	Уншигчийн хэрэгцээ, эрэлт ямагт зар сурталчилгаа өгөгч, хандивлагчдын эрх ашгаас дээгүүр тавигдах учиртай. Хэрвээ зар сурталчилгаа өгөгч компани, эсвэл хандивлагч танай уншигчийн мэдэх эрхийг боогдуулсан нөхцөл тавьж байгаа бол шууд татгалзах нь зөв. Ийм шийдвэр гаргах амар биш. Гэхдээ уншигчийн итгэл байхгүй бол бусад бүх зүйл байхгүй болно.
3/ Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах	Цаасан сонин, сэтгүүл гаргадаг байлаа ч заавал дижитал хэлбэрээр хэрэглэгчтэйгээ харилцаа үүсгэх нь өнөө цагийн шаардлага болж байна. Дан ганц уламжлалт хэвлэл мэдээллийн загвар үеэ өнгөрөөсөн. Цахим сайт ажиллуул, чаат ботоор мэдээллийн холбоосоо өг, чухал шуурхай мэдээллийг мессежээр түгээ.
4/ Туршлага, мэдлэгийг үнэл	Цахим орчинд шинээр бий болж, амжилттай яваа редакцийн дийлэнх нь уламжлалт медиад ажиллаж байсан сэтгүүлчдийн байгуулсан редакц байгааг “Олон улсын сэтгүүлчдийн сүлжээ” (IJNet) онцолсон байна. Тэдэнд байгаа туршлага, мэдлэг, нэр хүнд, хариуцлага, ёс зүйг хөрөнгө оруулагчид, спонсорууд хүндэтгэж, найдвар тавьж байгаа нь үүний шалтгаан гэж үзжээ.

¹⁵⁰ “Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв”-өөс 2022.01.14-ний өдөр зохион байгуулсан “Хэвлэл мэдээллийн зах зээлийн аудитын тайлан”-г танилцуулах уулзалтын бичлэг. <https://tinyurl.com/326v79mf>
 Alan Soon and Rishad Patel. “Mongolia: Codifying and funding the media ecosystem”. January, 2022
<https://splicemedia.com/our-work/mongolia-codifying-and-funding-the-media-ecosystem>

¹⁵¹ Д.Нарантуяа. Редакцийн зурвас (сэтгүүлч, редактор, редакцийн тухай; нийтлэлүүд). Улаанбаатар. 2021 он. 91, 92 дахь тал

5/ Олон нийтийн дэмжлэг авах	Хэрэглэгчийнхээ итгэлийг хүлээсэн редакцид олон нийт мөнгө төлөхөд бэлэн байдаг. Сүүлийн жилүүдэд олон нийтийн хандиваар тогтвортой ажиллаж байгаа редакц бусад улс оронд олширч байна.
------------------------------	---

Эрэн сурвалжлах нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж буй сэтгүүлчийн хувьд санхүүжилтыг хандиваар шийдвэрлэж болох бодит жишээг сэтгүүлч С.Будрагчаа дурдсан байна. Тэрээр *“Нэвтрүүлэг маань захиалгатай биш. Энэ нэвтрүүлгийг хийж байх явцад надад хөрөнгө мөнгөний маш их бэрхшээл тулгарсан. Үнэн. Гэхдээ би Монголын сэтгүүл зүйн түүхэнд анх удаагаа олон нийтээсээ хандив тусламж гуйсан лайв бичлэг хийж, цахим сүлжээнд байршуулсан. Үүний дагуу шударга ёсоор цангасан олон хүн 1000-888,000 хүртэл төгрөгийг ‘амжилт хүсье’, ‘шударга ёс ялна шүү’ гээд шилжүүлсэн. Би энэ мөнгөөрөө л санхүүжиж байгаа.”* гэж онцолжээ.¹⁵²

2.2.2. Тус улсад хэрэгжиж буй зохицуулалт буюу өөрийн зохицуулалт нь цахим платформ дахь сэтгүүл зүйн агуулгад зохих анхаарал хандуулахыг дэмждэг эсэх

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр тайлбарын 43-т “цахим хуудас, блог, эсвэл бусад интернэтэд суурилсан, электрон, эсвэл мэдээлэл түгээх бусад систем, түүнчлэн интернэтийн үйлчилгээ үзүүлэгч, хайлтын систем гэх мэт мэдээлэл харилцааг дэмжих тийм системийн үйл ажиллагаанд тавих аливаа хязгаарлалт нь гагцхүү Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгтэй нийцсэн нөхцөлд л зөвшөөрөгдөнө. Зөвшөөрөгдөх хязгаарлалт нь ерөнхийдөө онцгой агуулга байхаас бус тодорхой цахим хуудас, системийг ерөнхийлөн хориглох нь 3 дахь хэсэгт үл нийцнэ. Засгийн газар, эсвэл Засгийн газрын дэмжлэгтэй улс төр, нийгмийн тогтолцоог шүүмжилсэн гэх үндэслэлээр цахим хуудас, мэдээлэл түгээх системийг материал хэвлэн нийтлэхийг хориглох нь 3 дахь хэсэгт үл нийцнэ.” гэж онцолсон.¹⁵³

2012 оны 6 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл “Хүмүүсийн оффлайн орчин дахь эрхүүд, тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх эрх онлайн орчинд нэгэн адил хамгаалагдах ёстой” гэж тэмдэглэсэн. Үүнийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2013 оны 11 дүгээр сард баталгаажуулж, “хүмүүсийн оффлайн орчин дахь эрхүүд онлайн орчинд нэгэн адил хамгаалагдах ёстой” гэж тэмдэглэсэн.¹⁵⁴

Монгол Улсын одоогийн эрх зүйн зохицуулалт нь цахим орчин дахь мэдээллийн төөрөгдөл, үзэн ядалтыг дэвэргэсэн агуулгаас хамгаалах нэрийн дор Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг зохисгүйгээр хязгаарласан шинжтэй байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах”, 14.8 дугаар зүйлийн 1-т заасан “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараах” гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1-т заасан “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээх”, 17.1 дүгээр зүйлийн 7-д заасан “нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараах” зөрчилд хэрэглэж буй “худал мэдээлэл” ба “илт худал мэдээлэл” гэдгийг хуульд тодорхойлоогүй, түүнчлэн тухайн мэдээлэлд дурдсан этгээд холбогдох бодит, зөв мэдээллээ урьдчилж нийтэд мэдээлснээс хойш худал мэдээлэл тараасан эсэхийг харгалзах талаар орхигдуулсан байна. Тухайн асуудлаарх үзэл бодол, мэдээлэл нь

¹⁵² “С.Будрагчаа: Ж.Соронзон захирал хэвлэлийн эрх чөлөөнд халдаж, биднийг худалдаж авахыг санаархсан”. 2022.02.10 <https://isee.mn/n/31411>

¹⁵³ UN Human Rights Committee (HRC), General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression, 12 September 2011, CCPR/C/GC/34, available at: <https://www.refworld.org/docid/4ed34b562.html>

¹⁵⁴ Michael Karanickolas. Travel Guide to the Digital World: Surveillance and International Standards. London. 2014. p. 46

холбогдох мэдээлэл ил болоогүй буюу хуучирсантай холбоотой эсэх, эсхүл тийнхүү бодит, зөв мэдээлэл ил болсон байхад зориуд худал мэдээлэл тараасан эсэхийг харгалзахгүйгээр шийтгэл оноохоор зохицуулсан байна.

Монгол Улсад 2021 оны 6 дугаар сарын байдлаар Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн хүрээнд 2020 онд 251, 2021 оны эхний дөрвөн сарын байдлаар 119 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэснээс 25 хэрэгт л яллах дүгнэлт үйлджээ. 2020 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан 10 гэмт хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Эндээс худал мэдээлэл тараасан асуудлаар цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, хэрэгсэхгүй болсон хэргийн тоо олон, харин шүүхэд шилжүүлсэн хэрэг цөөн байгаа нь үг хэлэх эрх, нэр төртэй холбоотой иргэний хэргийн шинжтэй асуудлыг эрүүгийн журмаар хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, удаан хугацаагаар шалгаж байгаа нь мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах нөхцөл болж байна. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1-т заасан “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээх” зөрчил 2020 онд 1790 гарснаас, хялбаршуулсан журмаар 667 зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн 1123 хэрэг нээн шалгаж, 1480 хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулжээ. Цар тахлын үед төрийн байгууллага, албан тушаалтны албан ёсны, бүрэн, шинэ мэдээлэл хомс байсан бөгөөд төрөөс иргэдэд чиглэсэн мэдээлэл солилцох уялдаа холбоо хангалтгүй байдлын хариуцлагыг иргэдэд тохож, Зөрчлийн тухай хуулийн дээрх заалтаар шийтгэж байна.¹⁵⁵

Тухайлбал, иргэн Д.Мөнхбат нь “Энхсаран сувиллаас ковидын халдвар дамжин тархах эрсдэл байна” гэсэн асуудлыг өөрийн цахим хуудаст нийтэлсэн. Ингэж хувийн орон зайдаа үзэл бодлоо илэрхийлж, үг хэлснийх нь төлөө Зөрчлийн тухай хуулийн дагуу “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн” гэх үндэслэлээр 2021.01.18-нд Д.Мөнхбатад 500,000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан. Улмаар Д.Мөнхбат, түүний өмгөөлөгч Б.Пүрэвсүрэн 2021.01.21-ний өдөр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан байх бөгөөд үүнээс хойш таван сар орчмын дараа буюу 2021.06.04-ний өдөр шүүх хуралдаан болж, торгох шийтгэлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн. Үүнийг өмгөөлөгч Б.Пүрэвсүрэн “иргэд үг хэлэх эрх чөлөөтэй боловч, үг хэлснийхээ төлөө эрх чөлөөгүй байж болохгүй гэдгийг баталгаажуулах шийдвэр гаргасан” гэж онцолжээ.¹⁵⁶

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны 08 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”, баталсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 9.13-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020 оны А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”-ын зохицуулалт нь зөвхөн эрх бүхий байгууллагын дүгнэлт, саналд тулгуурлан цахим орчин дахь агуулгыг хязгаарлах, устгахад чиглэсэн байх бөгөөд тэрхүү дүгнэлт, саналд хөндлөнгийн этгээд буюу шинжээчийн дүгнэлт гаргуулах нөхцөл тусгагдаагүй нь цахим орчин дахь мэдээллийн төөрөгдөл, үзэн ядалтыг дэвэргэсэн

¹⁵⁵ Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг. “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик”. Нээлттэй Нийгэм Форум. Улаанбаатар. 2021 он. 45, 58 дахь тал https://forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1247&menu_id=3&resmenu_id=3

¹⁵⁶ Б.Пүрэвсүрэн. “Гудамжны хууль” – нийтлэл, тэмдэглэл, ярилцлага. Улаанбаатар. 2021 он. 228 дахь тал

агуулгаас хамгаалах нэрийн дор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг зохисгүйгээр хязгаарлах эрсдэлийг бий болгож байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх журмуудын дагуу шийдвэрлэж буй гомдлын агуулга, шийдвэрийн талаар тухай бүр цахим хуудсаараа дамжуулан ил тод мэдээлдэггүй, зөвхөн тоон мэдээг сүүлд товч дурдаж байгаа нь дээрх эрсдэл бодитой болохыг харуулж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо болон Фэйсбүүкийн хамтын ажиллагааны үр дүнд хууль бус контентын талаарх гомдол хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай “ногоон суваг” буюу шууд харилцах цахим сувгийг 2019 оны 6 дугаар сараас эхлэн Монгол Улсад анх удаа албан ёсоор нээсэн бөгөөд “Ногоон суваг”-ын хамтын ажиллагааг сайжруулах, хууль бус контентын талаарх гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилгоор 2021 оны 4 дүгээр сараас “Content Reporting System”-ийг нэвтрүүлэн Фэйсбүүктэй хамтран ажиллаж байна. Энэхүү хууль бус контентын талаарх гомдол, хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах хэм хэмжээ нь “Фэйсбүүк хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ (Community Standards)” юм.¹⁵⁷ Энэхүү хэм хэмжээгээр тогтоосон хууль бус контент нь Монгол Улсын дотоодын хууль тогтоомжоор тогтоосон хууль бус контенттой адил хэдий ч энэ талаарх гомдол, хүсэлтийг Фэйсбүүкээс хэсэгчлэн шийдвэрлэж байгаа нь анхаарал татаж байна. 2020 оны Улсын Их Хурал, орон нутгийн сонгууль, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр фэйсбүүк дэх агуулгатай холбоотой нийт 914 гомдол Харилцаа холбооны зохицуулах хороонд иржээ. Тэдгээр гомдлыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос Фэйсбүүкт шилжүүлсэн бөгөөд түүний 68%-д нь ямар нэгэн хариу өгч, 50%-г шийдвэрлэсэн бол 17%-г зөрчилгүй гэж үзсэн байна.¹⁵⁸

Энэ байдал нь цахим орчин дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөө зөвхөн Монгол Улсын эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын дүгнэлт, санал үндэслэл бүхий эсэхээс хамаарахгүй, Фэйсбүүкийн өөрийн зохицуулалт, үйл ажиллагаанаас хамаарч байна. Тодруулбал, Фэйсбүүкийн шүгэл үлээгч Софи Жангийн мэдээлснээр, зохион байгуулалттай олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл тараах явдлыг Фэйсбүүк зогсоох талаар анхаардаггүй. Жишээ нь Монгол Улсын 2019 оны Үндсэн хуулийн хямралын үеэр улс төрчийг дэмжихэд чиглэсэн хуурамч хариу үйлдэл, сэтгэгдэл бүхий Фэйсбүүк дэх хуурамч хаягуудыг мөрдөн шалгах, түүнийг устгах арга хэмжээ огт аваагүй байна.¹⁵⁹ Мөн Фэйсбүүкийн хэдэн арван мянган дотоод баримт бичиг, судалгааг түгээсэн шүгэл үлээгч Фрэнсис Хаугены мэдээлснээр, АНУ зэрэг англи хэлтэй барууны орнуудад хууль бус, хортой контентын эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авдаг бол хөгжиж буй орнууд дахь хууль бус, хортой контентын зөвхөн 16%-д хариу арга хэмжээ авч, тэдгээр контент өргөн хэмжээнд тархахад тусалж байна. Мөн улс орнуудын улс төрийн нөхцөл байдал нь Фэйсбүүкээс хуурамч мэдээллийн эсрэг үр нөлөөтэй ажиллахад саад болж байна. Тухайлбал, Вьетнам улсад Фэйсбүүкийг блоклоно гэсэн аюул заналтай холбоотойгоор тус улс дахь өөр санаа бодол, дуу хоолойг цензурдаж буйгаа Фэйсбүүкийн Марк Зукерберг өөрөө хүлээн зөвшөөрсөн байна.¹⁶⁰ Цахим орчинд буюу фэйсбүүк, твиттер, “WhatsApp”, “YouTube”, “Instagram” хэрэглэгчид рүү чиглэсэн төөрөгдүүлэх, тархи угаах үйл ажиллагаа явуулж буй улсын тоо өссөөр байна. Эдгээр улсад ийнхүү цахим орчинд төөрөгдүүлэх,

¹⁵⁷ “ХХЗХ, Фэйсбүүк компани “Ногоон суваг”-ын хүрээнд CRS системээр хамтран ажиллана”. 2021.03.26 <https://www.crc.gov.mn/k/37y>

¹⁵⁸ Харилцаа холбооны зохицуулах хороо. “Цахим орчны зохицуулалтын зөвлөмж” илтгэл. 2021.09.29

¹⁵⁹ Guardian News & Media Limited. “How Facebook let fake engagement distort global politics: a whistleblower's account” 12 April 2021. <https://www.theguardian.com/technology/2021/apr/12/facebook-fake-engagement-whistleblower-sophie-zhang>

¹⁶⁰ Mark Kolakowski. Facebook (FB) Papers. October 28, 2021 <https://www.investopedia.com/facebook-fb-papers-5207472>

тархи угаахдаа хүний үндсэн эрхийг зөрчих, улс төрийн өрсөлдөгчийг гутаан доромжлох, эсрэг буюу ялгаатай үзэл бодлыг хаах байдлаар нийгэм дэх мэдээллийг хянаж байна.¹⁶¹

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 82-т цахим орчинд хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг Засгийн газар санаачлах, Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан боловсруулж, өргөн мэдүүлэхээр тусгасан.¹⁶² 2021 оны 11 дүгээр сард тус хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах мэргэжилтнүүдийг бүрдүүлэхээр болсон байна.¹⁶³ Энэ хууль нь дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх үү, эсвэл цахим орчин дахь цагдан хяналтыг баталгаажуулсан хууль болох уу гэдгийг хэлэхэд одоогоор эрт байна.

2.2.3. Мэдээлэл түгээхийг хүссэн сэтгүүлчид боломжийн үнээр чанартай интернэт хэрэглэх боломжтой эсэх

Засгийн газрын 2005 оны 216 дугаар тогтоолын хавсралт “Цахим монгол” үндэсний хөтөлбөр 2005-2012 онд хэрэгжсэн бөгөөд Монгол Улсын интернэтийн гадаад гарцын багтаамж 2005 онд 78Мбит/с, интернэт хэрэглэгч 22000, өргөн зурвасын шилэн кабелийн урт 3251 км, үүрэн холбооны хэрэглэгч 551,000 байсан бол 2012 онд интернэтийн гадаад гарцын багтаамж 22Гбит/с, интернэт хэрэглэгч 654,009, өргөн зурвасын шилэн кабелийн урт 18123.8 км, үүрэн холбооны хэрэглэгч 3,409,005 болж өсчээ. Мөн 2017-2025 онд хэрэгжих Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”, 2019-2022 онд хэрэгжих Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр бий. Эдгээр баримт бичгийн үр дүнг дүгнэх хугацаа болоогүй байна. 2015 онд Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, өрх 1Mbps интернэтийг 13 мянган төгрөгөөр ашиглаж байхад орон нутгийн иргэд 55 мянга, байгууллагууд 75 мянган төгрөгөөр худалдан авч байсан. Орон нутгийн иргэд хотынхны хэрэглэж байгаагаас 4-5 дахин бага хурдтай интернэтийг 4-5 дахин илүү үнээр хэрэглэж байсан. 2016 оноос интернэтийн үйлчилгээний хурд, багтаамж хөдөө орон нутагт хоёр дахин нэмэгдсэн, нийслэл хотынхтой ижил үнэ тариф мөрдөж эхэлсэн гэж тухайн үед зарлаж байжээ.¹⁶⁴ Интернетийн үйлчилгээ эрхлэгч 68 компани байгаа бөгөөд түүнээс 28 нь улсын хэмжээнд, 17 нь Улаанбаатарт үйлчилгээ үзүүлж байна.¹⁶⁵ Эндээс төлөөлөл болгож, Монголын цахилгаан холбоо ХК, Скаймедиа корпораци ХХК, Юнивишн ХХК, Мобинет ХХК- ийн интернетийн хурд, үнийн мэдээллийг харьцуулан үзэхэд, сэтгүүлч нэг сард 20 mpps хурд бүхий интернетийг дунджаар 37,300 төгрөгөөр буюу сарын дундаж цалингийнхаа 5%- иар хэрэглэж байна. Үүнд анхны холболтын хураамж болон интернет суурилуулах үеийн төхөөрөмжийн үнэ ороогүй.

Хүснэгт 11. Хувь хэрэглэгчийн интернетийн сарын үнэ

Компанийн нэр	Хурдны ангилал, сарын төлбөр
---------------	------------------------------

¹⁶¹ Samantha Bradshaw, Philip N. Howard. The Global Disinformation Order: 2019 Global Inventory of Organised Social Media Manipulation. 2019 <https://comprop.oii.ox.ac.uk/wpcontent/uploads/sites/93/2019/09/CyberTroop-Report19.pdf>

¹⁶² Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”

¹⁶³ Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараас Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захиралд ирүүлсэн 2021.11.01-ний өдрийн 1/4242 тоот албан бичиг


¹⁶⁴ “Интернетийн үйлчилгээний ижил үнэ тарифыг энэ сарын 11-нээс мөрдөнө”. 2016.04.11 <https://www.crc.gov.mn/k/2Jk>

¹⁶⁵ Харилцаа холбооны зохицуулах хороо. “Интернэт ангиллын зөвшөөрөл эзэмшигчид” <https://www.crc.gov.mn/k/P/2W>

	Холболтын хураамж	1 mbps	5 mbps	10 mbps	20 mbps
Монголын цахилгаан холбоо ХК ¹⁶⁶	10,000₮	13,000₮	39,000₮	110,000₮	-
Скаймедиа корпораци ХХК ¹⁶⁷	10,000₮	-	29,500₮	-	39,500₮
Юнивишн ХХК ¹⁶⁸	20,000₮	15,900₮	-	-	36,000₮
Мобинет ХХК ¹⁶⁹	15,000₮	-	-	16,500₮	36,400₮

2.2.4. Хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл нь бүх хүнд адил тэгш хүртээмжтэйгээр хэвлэх, түгээх зохистой бөгөөд боломжийн нөөц бололцоогоор хангагдсан эсэх

2020 оны байдлаар өдөр тутмын сонины нэг дугаарын борлуулалтын үнэ 775 төгрөг, улирлын захиалгын үнэ 23,380 төгрөг байгаа бөгөөд 93%-ийг захиалгаар, 7%-ийг үүргийн худалдаагаар борлуулсан байна. Өдөр тутмын 7 сонины хувьд 2020 онд нийт орон даяар 8,883,200 сонин борлуулсан байна. 2020 онд бүх төрлийн нийт 10,831,888 сонин борлуулсан байна.¹⁷⁰ Нэг өрхийн сарын дундаж орлого 2020 онд 1,508,837 төгрөг, дундаж зарлага 1,519,398 байна.¹⁷¹ Эндээс харахад, өдөр тутмын сонины улирлын захиалгын үнэ нэг өрх сарын дундаж зарлагын 1.5%-тай тэнцэж байна.



Засгийн газрын 2011 оны 126 дугаар тогтоолын хавсралтаар 2010-2020 онд хэрэгжүүлэх “Өрх бүрт шуудан” хөтөлбөрийг баталсан бөгөөд түүний 4.8.4-т “сүлжээний явцуу дамжлага, давхардлыг арилган, дамжуулах, нэвтрүүлэх чадавхыг дээшлүүлж, шууданг долоо хоногт аймгийн төвд 2-оос доошгүй, сум, багт 1-ээс доошгүй удаа хүргэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх”, 4.10.1-т “өрх бүрийг шуудангийн хайрцагаар хангах төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх”-ээр заасан.¹⁷² Энэ хөтөлбөрийн дагуу сониныг шуудангаар түгээх зардалд таван хувийн хөнгөлөлт үзүүлсэн. Зөвхөн захиалагчтай сонинууд дээрх хөнгөлөлтийг эдлэх болзолтой. “Монгол шуудан” компани жилд нийт 400 сая төгрөгийн (200 мянган ам.доллар) хөнгөлөлт үзүүлэхээр болж, Монголын сонины холбоо, Өдөр тутмын сонины холбоотой тус тус гэрээ байгуулсан.¹⁷³

¹⁶⁶ Монголын цахилгаан холбоо ХК – интернетийн үнэ тариф <http://www.telecommongolia.mn/news/micomprice>

¹⁶⁷ Скаймедиа корпораци ХХК – Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ <https://www.skytel.mn/family-triple/new>

¹⁶⁸ Юнивишн ХХК – Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ <https://www.univision.mn/product/triple>

¹⁶⁹ Мобинет ХХК – Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ <https://mobinet.mn/service/6>

¹⁷⁰ Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл – өнөөдөр” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021 он. 9, 15, 17 дахь тал

¹⁷¹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага, хот, хөдөөгөөр, /1997-2020/ <https://1212.mn/>

¹⁷² Засгийн газрын 2011 оны 126 дугаар тогтоолын хавсралт “Өрх бүрт шуудан” хөтөлбөр

¹⁷³ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он. 62 дахь тал

2.2.5. Төрөөс зар сурталчилгаа болон хэвлэл мэдээллийн дэмжлэгийг олон төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн дунд шударгаар хуваарилдаг эсэх

Улсын Их Хурлаас 2002.05.30-ны өдөр баталсан Зар сурталчилгааны тухай хуулийг Монгол Улсын нутаг дэвсгэрт явагдах аливаа зар сурталчилгаанд хэрэглэх бөгөөд тус хуулийн 3.1.1-т “зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагааны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг ойлгоно гэж заасан.¹⁷⁴

Тус хуулийн 18.1-т “Мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл болон зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, түгээсний төлөө төлбөр авахыг хориглоно” гэж, Зөрчлийн тухай хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3.2-т зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч нь “мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл, зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, эсхүл түгээсний төлөө төлбөр авсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. Энэ зохицуулалт нь сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл, зар сурталчилгааны бус хэлбэртэй далд зар сурталчилгааны харилцааг хориглосон шинжтэй байна.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 9-т “Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.”, 9.1-т “Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана” гэж заасан. Далд сурталчилгаа гэдэг нь сэтгүүл зүйн бичлэгийн хэлбэр, төрөл зүйлээр бэлтгэсэн боловч редакцийн бүтээлээс ялгасан тэмдэглэгээгүй, олон нийтийн анхаарлыг татах зорилгоор пи-ар болон реклам сурталчилгааны арга техникийг ашигласан тодорхой этгээд, бүтээгдэхүүн үйлчилгээг илт дэмжсэн, эсвэл үгүйсгэж, хувь хүн, байгууллагын нэр хүндэд шууд халдсан бүтээл бэлтгэж түгээхийг хэлдэг. Далд сурталчилгааны аливаа хэлбэрт бичвэр, дүрс бичлэг, гэрэл зураг болон тэдгээрийн нийлбэр хэлбэрийг хамаатуулж ойлгоно.¹⁷⁵

Глоб интернэшнл төвийн судалгаагаар зөвхөн 2012 онд гэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газар (10 агентлагийг оруулаад) нийлээд нийт 4,1 тэрбум төгрөгийг (2,9 сая ам.доллар) хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн байна. Улсын Их Хурлын мэдээлэл сурталчилгааны зардал бараг 3 тэрбум (1,7 сая ам.доллар), Засгийн газрынх 758 сая төгрөг (380 мянган ам.доллар) байна. Улаанбаатар хотын захиргаа гэхэд 482 сая төгрөгийг (242 мянган ам.долларыг) зар сурталчилгаанд зарцуулснаа Глоб интернэшнл төвийн мэдээлэл авах хүсэлтэд хариу болгон ирүүлсэн.¹⁷⁶

Хэвлэлийн Хүрээлэнгээс 2016 онд “Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторинг”-ийн дүгнэснээр, сурталчилгааны зардлыг хэрхэн захиран зарцуулах талаар хуулийн заалт байхгүй бөгөөд шийдвэрийг гол төлөв тухайн төрийн байгууллагын удирдлага гаргадаг. Төрийн мэдээлэл сурталчилгааны төсвийг хэрхэн хуваарилж байгааг хянах механизм байхгүй. Мэдээлэл сурталчилгаанд зориулсан төрийн байгууллагын төсвийг хэрхэн зарцуулах ямар нэгэн дүрэм, журам, зохицуулалт байхгүй. Төрийн байгууллагын хэвлэлийн

¹⁷⁴ Зар сурталчилгааны тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002 он, №23

¹⁷⁵ Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим: Сэтгүүлчдийн гарын авлага”. Улаанбаатар. 2017 он. 20 дахь тал

¹⁷⁶ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он. 63 дахь тал

төлөөлөгчид зар, сурталчилгаа нийтлүүлэхдээ “хамгийн том мэдээллийн хэрэгсэл байх” ерөнхий таамгаар, эсвэл хамгийн хямд, эсвэл тухайн байгууллагын удирдлагын танил, хамаарал бүхий мэдээллийн хэрэгслийг сонгодог. Мэдээлэл сурталчилгааны төсвийг хуваарилахдаа төрийн байгууллагууд ямар нэгэн тендер зарладаггүй ба хэвлэл мэдээллийн аль нэг байгууллагатай гэрээ байгуулж, төсвийн мөнгийг хуваарилахаа үзэмжээр шийддэг. Хэвлэл мэдээллийн агуулгад хууль ёсны нөхцөл шаардлагаас бусад тохиолдолд хөндлөнгөөс нөлөөлөх эрх зүйн үндэслэл байхгүй ч, тухайлбал сурталчилгааны орлого хуваарилах нэрээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй “хамтран ажиллах гэрээ байгуулах”, тухайн байгууллага, албан тушаалтны талаарх сөрөг мэдээллийг нийтэлж, нэвтрүүлэхгүй байх шаардлага тавих зэрэг нь хэвлэл мэдээллийн салбарт түгээмэл тохиолддог.¹⁷⁷

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын дунд төрийн байгууллагуудын мэдээлэл сурталчилгааны мөнгөний төлөөх хүчтэй өрсөлдөөн явагддаг. 2016 оны судалгааны дагуу нэгэн аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчидтэй хийсэн ярилцлагаас харахад, тухайн орон нутгийн засаг дарга өөрийн намыг нь дэмждэг эсэхийг харгалзан хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгон шалгаруулдаг байжээ. Ингэхдээ, тухайн засаг дарга хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илүү мөнгө хуваарилан, өөрийгөө магтуулах гэх мэт тодорхой шаардлага бүхий гэрээ байгуулан өөрсдийн дуу хоолой болгон ашиглаж байсан. Түүгээр ч зогсохгүй, гэрээ байгуулсан сониныг аймгийн сургуулиудад “шахах” зэрэг харилцан ашигтай байдлаар тохиролцдог талаар ч тус аймгийн хэвлэл мэдээллийнхэн ярьж байгаа боловч энэ мэдээллийг батлан шалгах боломжгүй юм. Гэвч зарим аймаг тухайлбал, Дархан-Уул аймагт гэхэд мэдээлэл сурталчилгааны төсвийг борлуулалтын байдлаас үл хамааран, үйл ажиллагаа явуулж буй нийт хэвлэл мэдээллийн хэрэгслийн дунд тэнцүү хуваарилж байжээ.¹⁷⁸

“Максима Медиа” ХХК-иас 2021 онд танилцуулсан “2020 оны телевиз үзэлтийн судалгааны тайлан”-д дурдсанаар, “Топ 20 зар сурталчилгаа нийлүүлэгчид”-ийн 1-т Засгийн газар, 3-т Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, 9-т Авилгатай тэмцэх газар, 11-т Таван толгой түлш ХХК орсон байна.¹⁷⁹ Мөн Засгийн газрын хувьд 2014 онд Телевизийн “Топ 20 зар сурталчилгаа нийлүүлэгч”-ийн 19-т бичигдэж байсан бол 2018 оноос хойш тасралтгүй 1-т орж байна.

Хүснэгт 12. Телевизийн “Топ 20 зар сурталчилгаа нийлүүлэгч” дэх төрийн байгууллагууд

Төрийн байгууллага	Телевизийн “Топ 20 зар сурталчилгаа нийлүүлэгч”-ийн эзлэх байр			
	2014 он	2018 он	2019 он	2020 он
Засгийн газар	19	1	1	1
Нийслэлийн Засаг даргын тамгын газар	-	9	17	-
Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	-	-	-	3
Авлигатай тэмцэх газар	-	-	-	9
Таван толгой түлш ХХК	-	-	-	11

¹⁷⁷ Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторинг төсөл: “Төрийн зар сурталчилгааны орлогыг хуваарилах тогтсон дүрэм, журам байхгүй”. 2016 <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-findings/translation-media-regulation/>

¹⁷⁸ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он. 63, 64 дэх тал

¹⁷⁹ “Максима Медиа” ХХК. “2020 оны телевиз үзэлтийн судалгааны тайлан”. Улаанбаатар. 2021 он. 25 дахь тал <https://maxima.mn/2020-tam-tailan/>

Улсын Их Хурлаас 2005.01.27-ны өдөр баталж, 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17.1.5-д зааснаар улсын төсвийн дэмжлэг нь олон нийтийн радио, телевизийн санхүүжилтийн эх үүсвэрийн бүрдэлд хамаарна. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн хувьд 2019 оны төсөв дэх улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 9,000,000,000 төгрөг бөгөөд энэ нь түүний нийт төсвийн 47.5% юм. Тус радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс /хураамж/ болон нэвтрүүлгийн орлогын нийлбэр нь улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс бага хэмжээтэй байна.¹⁸⁰ Энэ нь Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз эдийн засгийн хувьд төрөөс хараат байх эрсдэл бодитой болохыг харуулж байна.

Улсын Их Хурлаас 2006.06.29-ний өдөр баталж, 2007.01.01-ний өдрөөс эхлэн үйлчилсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13.1.14-т зааснаар борлуулсан сониныг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. Гэвч Улсын Их Хурлаас 2015.07.09-ний өдөр баталж, 2016.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13 дугаар зүйлд заасан албан татвараас чөлөөлөх бараа, үйлчилгээний жагсаалтаас сониныг хассан.¹⁸¹

Улсын Их Хурлаас 2006.06.29-ний өдөр баталж, 2007.01.01-ний өдрөөс эхлэн үйлчилсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 12.1.12-т зааснаар мэргэжлийн сонин, сэтгүүлийн захиалгыг албан татвар ногдох орлогоос хасна.¹⁸² Гэвч энэ зохицуулалтыг 2019.03.22-ны өдөр батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хассан.¹⁸³

Улсын Их Хурлаас 2010.11.25-ны өдөр баталж, 2011.01.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Улсын тэмдэгтийн хураамжийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 5.1.8-д “сонин, сэтгүүл, радио, телевизийг бүртгэх”-д тэмдэгтийн хураамжийг хураахаар заасан. Гэхдээ 14 дүгээр зүйл буюу “Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ”-ний зохицуулалтыг 2015.01.29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.¹⁸⁴

2.2.6. Хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төрөөс олгож буй татаас, бусад төрлийн санхүүгийн дэмжлэгийн хариуд агуулгаа тохируулах шаардлагатай тулгардаг эсэх

Глоб интернэншл төвөөс 2018 онд сэтгүүлчдээс авсан асуулгад “Таны ажилладаг редакцид хаалтын гэрээтэй эсвэл бусад шалтгаанаар бичихийг хориглосон сэдвийн хар жагсаалт гэж бий юү” гэж асуухад нийт оролцогчдын 40 хувь нь “тийм” гэж хариулсан. Мөн “Таны нийтлэл, нэвтрүүлгийг нийтлэгдэх, нэвтрүүлэхээс өмнө хориглосон эсэх” гэж асуухад 23.3 хувь нь “тийм” гэж хариулсан бөгөөд дийлэнх нь хаалтын гэрээ эсвэл редакцийн удирдлагын заавраар нийтлэл, мэдээллээ гаргаж чадаагүйгээ хэлсэн юм. Энэ бүгдээс харвал хэвлэл мэдээллийн салбар дахь хаалтын гэрээ, бизнес улс төрийн ашиг сонирхлын хамаарлаас үүдэлтэй редакцийн цензур хэвшмэл зүйл болж эхэлжээ.¹⁸⁵

¹⁸⁰ Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз. “Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт /2019 оны 12-р сар/. <http://www.mnb.mn/shilendans/135>

¹⁸¹ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2006 он, №40, 2015 он, №29

¹⁸² Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2006 он, №38

¹⁸³ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2019 он, №23

¹⁸⁴ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2011, №1

¹⁸⁵ Глоб Интернэншл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017”. Улаанбаатар. 2018 он. 6 дахь тал

Мөн 2018 онд хийсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшин тогтоох” судалгаанд 300 сэтгүүлчийг хамруулснаас тэдний 52% нь редаксаас зарим асуудалтай холбоотойгоор нийтлэл, нэвтрүүлгийг нь хориглосон тухай дурджээ. Үүнээс үзэхэд, хэвлэн нийтлэх эрх чөлөөний тулгамдсан асуудлын нэг “хаалтын гэрээ” болж байна. Гэвч “хаалтын гэрээ” хэмээх тухайлсан гэрээ байдаггүй бөгөөд сурталчилгааны гэрээ, хамтран ажиллах гэрээ дотор байдаг ганцхан заалтыг нэрлэж болно. Тухайлбал, “захиалагч талын нэр хүндэд харшлах аливаа сөрөг мэдээ, мэдээллийг захиалагч талд мэдэгдэх, нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээнэ” гэдгийг “хаалтын гэрээ” хэмээх нэр томъёогоор ойлгож болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хаалтын гэрээ байгуулах нь хэвлэл мэдээллийн тэнцвэртэй, чөлөөт, олон ургалч, хараат бус байх зарчимтай үл нийцнэ.¹⁸⁶

Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын хэсгээс 2021 оны 3 дугаар сард 80 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын дунд хийсэн судалгаагаар, сэтгүүлч мэдээлэл олж авахад тулгардаг бэрхшээлийн нэг нь “хаалтын гэрээ” гэж 8 сэтгүүлч хариулсан, мэдээлэл түгээхээс өмнө хэвлэл мэдээллийн байгууллагад төрийн байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалт хийх, агуулгад цензур тавих гэх мэтээр ямар нэг байдлаар дарамт шахалт ирж байсан эсэх талаарх асуултад 8.8% нь огт үгүй, 23.8% нь ховор, 58.8% нь хааяа, 8.8% нь байнга гэж хариулсан байна.¹⁸⁷

Мөн 2019 оноос эхлэн сонгуулийн хууль тогтоомжид хаалтын гэрээг хориглосон шинжтэй зохицуулалт тусгах болсон. Тодруулбал, “Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно” гэх зохицуулалтыг Улсын Их Хурлаас 2019.12.20-ны өдөр баталж, 2019.12.23-ны өдрөөс үйлчилсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.7, 2020.12.24-ний өдөр баталж, 2020.12.30-ны өдрөөс үйлчилсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 43.6, 2020.01.30-ны өдөр баталж 2020.02.14-ний өдрөөс үйлчилсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47.8-д тус тус заасан. Үүнтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 19-д “Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. Гэхдээ энэ нь зөвхөн сонгуулийн сурталчилгааны үеийн цөөн хоног дахь зөрчилд хүлээлгэх хариуцлага юм. Гэвч энэ зохицуулалт нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад эдийн засгийн цагдан хяналт тогтоох эрсдэл дагуулж байна.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 6,690.3 сая төгрөг зарцуулжээ. Үүнээс сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглахад 644.2 сая төгрөг, цахим орчин ашиглахад 333.4 сая төгрөг, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийлүүлэхэд 30 сая төгрөг буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, нийтлэхэд нийт 1,007.6 сая төгрөг буюу нийт зардлын 15%-ийг зарцуулжээ.¹⁸⁸ Харин Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны

¹⁸⁶ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”. Улаанбаатар. 2021.05.03. 33 дахь тал

¹⁸⁷ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2021.01.13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/01 дүгээр тушаалаар байгуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөө, мэдэх эрхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын санал боловсруулах Ажлын хэсэг

¹⁸⁸ Үндэсний аудитын газар. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан. Улаанбаатар. 2021 он. 3 дахь тал

зардалд нийт 67,259.9 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 64,258.1 сая, бусад зардалд 3,001.8 сая төгрөг зарцуулжээ.¹⁸⁹ Үүнээс сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардалд 2,785.2 сая төгрөг, цахим орчин ашиглах зардалд 1,633.2 сая төгрөг, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардалд 981.7 сая төгрөг буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, нийтлэхэд нийт 5,400.10 сая төгрөг буюу нийт сонгуулийн үйл ажиллагааны зардлын 8.6%-ийг зарцуулжээ.



Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэж заасан. Энэхүү заалтад бүх төрлийн цензур хамаарна. Засгийн газраас хэвлэл мэдээллийн зарим байгууллагуудтай “хамтран ажиллах” гэрээ байгуулж байгаа нь төрийн хяналт цензурыг тогтоох эрсдэлтэйгээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн эрх ашигт нийцсэн мэдээ, мэдээлэл бэлтгэх үүргээ умартахад хүргэх сөрөг талтай. Мөн чанараараа чөлөөт хэвлэл мэдээлэл нь олон нийтийн үнэнийг мэдэх зарчимд үйлчилдэг, тэнцвэртэй, хараат бус байх ёстой бөгөөд аль нэг талын дагнасан зар сурталчилгаа, тэнцвэргүй мэдээ, мэдээлэл түгээх нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх биш юм.¹⁹⁰

2.2.7. Захиргааны ба санхүүгийн саад бэрхшээл нь хувийн хэвшлийн бие даасан, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг үүсгэн байгуулахад саад тотгор болдог эсэх

Хэвлэлийн хүрээлэнгээс 2021 онд гаргасан “Монголын хэвлэл мэдээлэл — өнөөдөр” мониторингийн тайланд дурдсанаар, Монгол Улсын хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын байдлаар 513 мэдээллийн хэрэгсэл /сонин, сэтгүүл, радио, телевиз, мэдээллийн сайт/ тогтмол ажиллаж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагуудын дийлэнх буюу 72% нь хувийн эзэмшилд буюу компанийн хэлбэртэй байна. Харин 17% нь төрийн бус байгууллага, холбооны хэлбэртэй байна.¹⁹¹ Компани байгуулах харилцааг Улсын Их Хурлаас 2011.10.06-ны өдөр баталсан Компанийн тухай хууль, 2018.06.21-ний өдөр баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар, төрийн бус байгууллага байгуулах харилцааг 1997.01.31-ний өдөр баталсан Төрийн бус байгууллагын тухай хууль, 2018.06.21-ний өдөр баталсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар тус тус зохицуулж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021.01.25-ны өдрийн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, индекс, код батлах тухай” А/55 дугаар тушаалын 11 дүгээр хавсралт “Хуулийн этгээдийн хэлбэрийн индекс”-д зааснаар сонин, сэтгүүл, радио, телевиз 09 индекстэй “Хязгаарлагдмал

¹⁸⁹ Үндэсний аудитын газар. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан. Улаанбаатар. 2020. 3 дахь тал

¹⁹⁰ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”. Улаанбаатар. 2021.05.03. 34 дэх тал

¹⁹¹ Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл — өнөөдөр” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021 он. 4, 5 дахь тал

хариуцлагатай компани /ХХХХМБ/” хэлбэртэй, 83 индекстэй “Холбоо /ХМБ/” хэлбэртэй байна.¹⁹²

Хүснэгт 13. Хязгаарлагдмал хариуцлагатай компани болон төрийн бус байгууллага байгуулахад бүрдүүлэх баримт, төлөх хураамж

Бүрдүүлэх баримт	Тайлбар
Өргөдөл	Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /гүйцэтгэх удирдлага; үүсгэн байгуулагч; итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан; итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд/ өргөдлийн маягтыг burtgel.gov.mn -с татаж авна.
Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт	Хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг өргөдөл гаргах эрх бүхий этгээд улсын бүртгэлийн байгууллагад биечлэн ирэх эсвэл цахимаар гаргаж болно. Засгийн газрын 2018 оны 339 дүгээр тогтоолын хавсралт “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам”-ыг баримтална. “Иргэний хууль”-ийн 27.3-г баримтлан улсын бүртгэлд бүртгүүлнэ. Цахимаар e-mongolia.mn хаягаар нэвтэрч, нэрээ илгээнэ.
Улсын тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлс төлсөн баримт	- Нэрийн баталгаажуулалтын үйлчилгээний хөлс 10,000 төгрөг - Тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох үйлчилгээний хөлс 10,000 төгрөг (Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолын хавсралт “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ”) - Тэмдэгтийн хураамж 44,000 төгрөг (Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15.1.1)
Үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл 1 хувь	Үүсгэн байгуулагчийн шийдвэрт: компани үүсгэн байгуулах тухай; хаяг, утас, эрхлэх үйл ажиллагаа /тусгай зөвшөөрөл авдаггүй үйл ажиллагаа бичих/; хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэг; гүйцэтгэх захирлыг сонгон, овог, нэр, регистрийн дугаарыг тусгаж /үүсгэн байгуулагч нь өөрөө гүйцэтгэх захирал байж болно/; компанийн дүрмийг хавсралтаар баталсан байх. Шийдвэр, дүрэмд үүсгэн байгуулагчид гарын үсэг зурна. Шийдвэр/тогтоол/-т: холбоо /төрийн бус байгууллага/-ыг үүсгэн байгуулах тухай шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл; хаяг, утас, эрхлэх үйл ажиллагаа; удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, овог, нэр, регистрийн дугаар; тогтоолоор Удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирлыг сонгож, Удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурсан байна.
Дүрэм 2 хувь	Компанийн тухай хуулийн 16.2-т заасныг тусгаж, үүсгэн байгуулагчид гарын үсэг зурж баталгаажуулна. Дүрэмд Төрийн бус байгууллагын тухай хуулийн 10, 23, 25 дугаар зүйлд заасныг тусгана.
Хуулийн этгээд байрших хаягийн нотлох баримт	Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ /хуулбар/, түрээсийн гэрээ. (Үүсгэн байгуулагчийн гэрийн хаягаар бүртгүүлэх боломжтой)
Хөрөнгийн нотлох баримт	Компанийн дансанд мөнгөн хөрөнгө байршуулсан баримт /дансны хуулга/. Хөрөнгийн хэмжээнд дээд, доод хязгаар байхгүй

Хүснэгт 14. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг байгуулах, ажиллуулахтай холбоотой тусгайлсан зохицуулалт, бүрдүүлэх баримт бичиг, төлөх хураамж

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Тусгай зөвшөөрөл	Бүрдүүлэх баримт бичиг	Хураамж, төлбөр
Сонин	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрлийг заасан. Сонины хувьд тусгай зөвшөөрөл шаардахгүй. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 14.1.1-т “сонин, сэтгүүлийг бүртгэж, гэрчилгээ олгоход 8800-22000 төгрөг” гэж заасныг 2015.01.29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.		
Сайт	Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011.02.24-ний 8 дугаар тогтоолын хавсралтаар “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл		

¹⁹² Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021.01.25-ны өдрийн А/55 дугаар тушаалын 11 дүгээр хавсралт “Хуулийн этгээдийн хэлбэрийн индекс”

	шаардлага” баталсан.¹⁹³ Түүнийг 2011 оны 3 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн. Тус нөхцөл шаардлагын 3.4-т “Харилцаа холбооны тухай хуулийн 12.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээ мэдээллийн веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хороонд бүртгүүлнэ” гэж заасан. 2015 оны 6 дугаар сарын байдлаар 106 вэбсайт, блог Харилцаа холбооны зохицуулах хороонд онлайнаар бүртгүүлжээ.¹⁹⁴ 2021 оны байдлаар нийт 53 вэб сайт Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлсэн байна.¹⁹⁵ Хэрэв веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлтэй бол “бүртгэлийн гэрчилгээ хүссэн өргөдөл”-г бөглөн бүртгэлийн хураамж 80,000 төгрөг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30.4-д заасан 20,000 төгрөгийг Харилцаа холбооны зохицуулах хорооны дансанд тушаана.¹⁹⁶
Радио, телевиз	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.6-д зааснаар “радио, телевизийн үйлчилгээ”, үүн дотроо а.олон нийтийн радио, телевиз; арилжааны радио, телевиз; в.өргөн нэвтрүүлгийн радио, телевиз; г.төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ нь тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагаа юм. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020.09.22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын хавсралт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”, 2021.05.14-ний 34 дүгээр тогтоолын хавсралт “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын дагуу өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг тусгайлан зохицуулж байна. Арилжааны радио, телевизийн радио давтамж, радио давтамжийн зурвас (хэт богино долгион; урт, дунд, богино долгион) ашиглах тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлд 5 жилийн хугацаагаар олгох, мөн хугацаагаар сунгах зохицуулалттай: 1/ Тухайн зурваст радио давтамжийн нөөцтэй байх; 2/ “Арилжааны радио, телевизийн үйлчилгээ” эрхлэх нөхцөл хангасан байх; 3/ Ашиглах радио давтамжийн зурвас дахь “Радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” баримт бичигт заасан нөхцөлийг хангасан байх; 4/ Харилцаа холбооны зохицуулах хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан төхөөрөмж ашиглах. Дараах баримт бичгийг бүрдүүлнэ: 1/ Радио давтамжийн зурвас ашиглахаар төлөвлөж буй шалтгаан, танилцуулга, 2/ Сүлжээний холболтын бүдүүвч зураг, схем, 3/ Радио төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, хамрах хүрээний тооцоолол, 4/ Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь, 5/ Радио төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн мэдэгдэл, итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн, сертификат. Арилжааны радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын баримт бичиг, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад заасан нөхцөлийг хангасан нөхцөлд 5 жилийн хугацаагаар олгох, мөн хугацаагаар сунгах зохицуулалттай. Сонгон шалгаруулалтын баримт бичигт бүрдүүлэх баримт бичгийг нарийвчлан заана. Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлд 5 жилийн хугацаагаар олгох, мөн хугацаагаар сунгах зохицуулалттай: 1/ Сонгон шалгаруулалтын баримт бичиг, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад заасан нөхцөлийг хангасан байх, 2/ Радио, телевизийн газрын сүлжээгээр дамжих техникийн боломж хангагдсан байх. Сонгон шалгаруулах баримт бичигт бүрдүүлэх баримт бичгийг нарийвчлан заана. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30.5-д “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 10,000-25,000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана”, 30.3.1-т “телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 20,000-50,000 төгрөг, аймагт 15,000-20,000 төгрөг”, 30.3.2-т “радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 15,000-40,000 төгрөг, аймагт 6000-15,000 төгрөг”-ийн тэмдэгтийн хураамж хураана гэж заасан. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021.04.28-ны өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 25 дугаар

¹⁹³ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011.02.24-ний өдрийн 8 дугаар тогтоолын хавсралт “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага” <https://crc.gov.mn/k/Bx>

¹⁹⁴ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он. 47 дахь тал

¹⁹⁵ Харилцаа холбооны зохицуулах хороо. “Сайт ангиллын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчид”.

<https://crc.gov.mn/k/4G/1s>

¹⁹⁶ “Веб сайтын үйлчилгээ эрхлэгчид бүртгэлийн гэрчилгээ шинээр авах”. 2021.04.08 <https://crc.gov.mn/k/4B>

	тогтоолд зааснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ өргөн нэвтрүүлгийн телевизийн хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрт 6 сая төгрөг, Улаанбаатарт 3 сая төгрөг, аймагт 800,000 төгрөг; өргөн нэвтрүүлгийн радиогийн хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрт 2.5 сая төгрөг, Улаанбаатарт 800,000 төгрөг, аймагт 200,000 төгрөг; арилжааны телевизийн хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрт 4.5 сая төгрөг, Улаанбаатарт 2.5 сая төгрөг, аймагт 600,000 төгрөг; арилжааны радиогийн хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрт 2.5 сая төгрөг, Улаанбаатарт 800,000 төгрөг, аймагт 200,000 төгрөг байна.¹⁹⁷
--	---

Харилцаа холбооны тухай хуулийн 12.3-т зааснаар тусгай зөвшөөрөл авах шаардлагатайгаас бусад харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлнэ. Мөн хуулийн 3.1.4-т “үйлчилгээ” гэж харилцаа холбооны сүлжээг ашиглан хэрэглэгчийн холбоо мэдээллийн хэрэгцээг хангах үйл ажиллагааг ойлгоно гэж заасан бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны хувьд мэдээ, мэдээллийн веб сайтын үйлчилгээ эрхлэгчийг бүртгэх тусгайлсан эрх олгогдоогүй байна. Үүнээс харахад, мэдээллийн вэб сайт үүсгэн байгуулахад саад тотгор байхгүй ч түүнийг ажиллуулахын тулд Харилцаа холбооны зохицуулах хорооны хууль бус хяналттай тулгарч байна.

Зураг 4. Вэб сайтын бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх дараалал



(Зургийн эх сурвалж: Харилцаа холбооны зохицуулах хороо)

2.2.8. Сэтгүүлчид бэлтгэж буй агуулгынх нь бодит байдлыг алдагдуулахуйц тансаг зэрэглэлийн урилга, аялах эрх, бусад хэлбэрийн урамшуулал авдаг эсэх

2012 оны “Азийн хэвлэл мэдээллийн барометр — Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”-нд “зарим редактор зардлаа нөхөх нэрийдлээр авилгал нэхдэг. Сэтгүүлчид үдийн хоол, оройн зоог, үнэ төлбөргүй амралт, зугаалга, байр, машин, албан тушаал, эсвэл Хятад, Солонгосоор аялах боломжийг алддаггүй. Харьцуулбал, 2000 оны үед авилга ил тод байсан. Одоо арай хумигдсан тал бий. Илүү далд хэлбэртэй болсон байж ч болох юм” гэж дурдаж байжээ.¹⁹⁸

¹⁹⁷ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021.04.28-ны өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 25 дугаар тогтоол <https://crc.gov.mn/k/38r>

¹⁹⁸ Фридрих-Эбэртийн сан. “Азийн хэвлэл мэдээллийн барометр – Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”. Улаанбаатар. 2012 он. 67 дахь тал

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 5-д “...мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана”, 5.1-т “Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана” гэж заасан. Энэ зарчмын талаар сэтгүүлчдийн гарын авлагад “Хувийн сонирхлын үүднээс зориудаар олж авсан мэдээ, мэдээллээрээ бусдыг дарамтлах, эдийн засгийн сонирхлоо хэрэгжүүлэх хэрэгсэл болгох нь ёс зүйн хувьд маш ноцтой зөрчил, хэвлэл мэдээллийн нэр хүндэд асар хохиролтой үйлдэл юм. ‘Төлбөртэй мэдээ’, ‘хаалтын гэрээ’ гэх мэт ойлголт мөн үүнд хамаарна. Эдгээрийг тогтооход төвөгтэй ч хэвлэл мэдээлэлд улс төр, эдийн засгийн бүлэглэл мөнгө төлж, болж буй үйл явдлын тухай мэдээлэл гаргах эсвэл гаргахгүй байхаар тохиролцох тохиолдол байдаг. Энэ тохиолдол тухайн хэвлэл мэдээллийг хариуцаж байгаа захирал, эрхлэгч нарын түвшинд хийгдэж байгаа учраас энэ үйлдлийн эсрэг редакцийн хувьд хатуу байр суурьнаас хандах ёстой. Тэгээд ч энэ үйлдлийг олон нийт мэдэж, ойлгож байгааг анхаарах ёстой. Гуравдагч талын санхүүжилтээр аялах тохиолдол сэтгүүлчдэд цөөнгүй гарч байгаа ч аяллыг санхүүжүүлэгчийн талаар тодорхой нэр дурдсан жишээ цөөн байна. Ийм тохиолдолд аялалд хамруулсан этгээдийн нөлөөлөлд ороогүй гэдгээ илтгэхийн тулд санхүүжилтийн талаарх мэдээллийг ил тод байлгах ёстой” гэжээ.¹⁹⁹ Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодоос “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 5.1-т “Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана” гэж заасныг зөрчсөн эсэх талаарх гомдол шийдвэрлээгүй байна.

2019 оны судалгаагаар бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлгийг нийтлэхийг хориглохын тулд мөнгө, бэлэг сэлт, бусад эд зүйлс өгөхөөр амлаж байсан тохиолдол ойролцоогоор 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ. Нэгэн сэтгүүлч энэ талаар “Эгчийнх нь, ахынх нь таньдаг хүн, би тэр хүнээс байр авчихсан юм, чи энийгээ устгаад өгөөч, мөнгө өгье, гэрээ хийлгэж өгье гэж сэтгүүлчид өөрсдөө яриад, гар хөл нь болоод байгаа нь улс төрчдөөс илүү хамгийн том аюул занал гэж би бодож байна” гэжээ. Сэтгүүлчдийн, салбарын нэр хүнд унасан байгаа нь хэн хүссэн нь мөнгө өгөөд сэтгүүлчдийн амыг барьж болно гэдэг ойлголтыг бий болгож ийм оролдлогууд хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн сэтгүүлчид мөнгө авч нийтлэл нэвтрүүлэг бэлтгэдэг, эсвэл бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгээ түгээхээ больдог, шантаажилдаг гэх зэрэг ойлголтыг олон нийтэд төрүүлж, салбарын нэр хүндийг унагах, сэтгүүлчдэд итгэх итгэлийг бууруулж байна.²⁰⁰

Сэтгүүлчид бэлтгэж буй агуулгынх нь бодит байдлыг алдагдуулахуйц урамшуулал амладаг жишээний талаар Nuuts.mn мэдээллийн сайтын ерөнхий редактор С.Будрагчаа хөндсөн бөгөөд тэрээр 2022 онд Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Монгол-Оросын хамтарсан гуравдугаар сургуулийн захирал Ж.Соронзонгийн талаар эрэн сурвалжлах нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж буй талаарх ярилцлагадаа “Максим Суяанз гэдэг хүнтэй ярилцлага хийсний дараа Ж.Соронзон захирал надтай хамт ажилладаг байсан ахаар минь дамжуулаад ойлголцлын зөрүү гараад байна гээд уулзах хүсэлт тавьсан. Тухайн үед би энэ хүний талаар сайн мэдэхгүй байсан учраас юу гэж ярихыг нь сонсьё гээд очиж уулзсан. Тухайн үед надад ‘Цай, кофе, ундаа уух уу, хоол идэх үү яг яамаар байна. Чи хүүхэдтэй юу, хүүхдээ манай сургуульд сургаач, би урьж байна. Манай сургуульд чинь дандаа дарга нарын бус жирийн ардын хүүхэд ч сурч болно ш дээ. Ер нь чи манай

¹⁹⁹ Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим: Сэтгүүлчдийн гарын авлага”. Улаанбаатар. 2017 он. 14, 15 дахь тал

²⁰⁰ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 41, 42 дахь тал

сургуультай хамтарч ажилла. Гэрээ байгуулъя. Би мөнгө төлөе гэдэг зүйл хэлсэн. Гэсэн ч би түүний саналыг хүлээж аваагүй. Энэ бүхнийг гэрчлэх хоёр хүн байгаа. Мөн Соронзон захирал ч бичлэг хийж авсан байгаа гэдэгт би 300 хувь итгэлтэй байна. Тэр бичлэгээ дэлгэх хэрэгтэй. Энэ бүхэн нь Эрүүгийн хуулийн 14.3 буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийн эсрэг гэмт хэрэг. Нэг ёсондоо өөрийнхөө муу муухайг илчлүүлэхгүйн төлөө бусдад эдийн болон эдийн бус зүйл санал болгож, тохиролцох гэж оролдож байгаа нь гэмт хэрэг учраас би үүнийг нь ч шалгуулна гэж бодож байгаа. Ийм хүмүүс чинь эхлээд аргалах гэж оролцож байгаа юм. Хүүхдээ сургуульдаа өг, мөнгө төгрөг өгье гэх мэтчилэнгээр худалдаж авах гэж үзнэ. Үүнд нь автахгүй болохоор дараагийн арга буюу нийтээр харлуулан гутааж, цахим сүлжээнд элдвээр доромжилдог. Харин айхгүй болохоор нь ажлыг нь хийлгэхгүйн тулд цагдаагийн газарт уяад байхыг хүсдэг. Яг энэ л процесс над дээр явагдаж байна.” гэж онцолжээ.²⁰¹

2.2.9. Улс төрийн эрх мэдэлтнүүд тодорхой хэвлэл мэдээллийн хэрэгсэлд давуу байдал олгох үүднээс зар сурталчилгаа захиалагчдад шахалт үзүүлдэг эсэх

“Максима Медиа” ХХК-иас 2021 онд танилцуулсан “2020 оны телевиз үзэлтийн судалгааны тайлан”-д дурдсанаар телевизийн топ 20 зар сурталчилгаа нийлүүлэгчдийн 16 нь хувийн хэвшлийн компани байна. Эдгээр компанийн хувь эзэмшилд улс төрийн эрх мэдэлтнүүд оролцож байгаа эсэхийг opendatalab.mn, opendata.burtgel.gov.mn болон xacxom.iaac.mn цахим хуудасны нээлттэй мэдээллээс тодруулав.

Хүснэгт 15. Телевизийн топ 20 зар сурталчилгаа нийлүүлэгчдийн хувь эзэмшил дэх улс төрийн эрх мэдэлтэн

Байгууллагын нэр	Хувь эзэмшил ба улс төрч
1/ Засгийн газар	-
2/ Монголсат Нэтворкс ХХК	-
3/ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	-
4/ Монос групп	-
5/ ДДэшТВ ХХК	Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг 2015.09.09-ний өдрөөс эхлэн тус компанийн хувь эзэмшилд бүртгэлтэй бөгөөд 51%-ийг эзэмшиж байна
6/ Юнител групп	-
7/ Таван богд групп	-
8/ Жигүүр гранд групп	-
9/ Авилгатай тэмцэх газар	-
10/ Оюуны ундраа групп	Улсын Их Хурлын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан 2019.06.06-ны өдрөөс эхлэн тус компанийн хувь эзэмшилд бүртгэлтэй бөгөөд хувьцааны 24%-ийг эзэмшиж байна
11/ Таван толгой түлш ХХК	-
12/ Скайтел групп	Улсын Их Хурлын гишүүн С.Батболд 2012.12.26-ны өдрөөс эхлэн тус компанийн хувь эзэмшилд бүртгэлтэй бөгөөд хувьцааны 12%-ийг эзэмшиж байна
13/ Баясах групп	-
14/ www.shuud.com	-
15/ Home Media	-
16/ MCS групп /М Си Эс монголиа ХХК/	Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан 2017 онд тус компанийн 3%, 2018-2019 онд 1.03%-ийг эзэмшсэн. 2019 оноос хувьцаа эзэмшигч биш болсон
17/ Номинхолдинг	-
18/ Orange entertainment /Медиагрупп ХХК/	-

²⁰¹ “С.Будрагчаа: Ж.Соронзон захирал хэвлэлийн эрх чөлөөнд халдаж, биднийг худалдаж авахыг санаархсан”. 2022.02.10 <https://isee.mn/n/31411>

19/ Номун-Интер трейд ХХК	Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн 50%-ийг эзэмшдэг Жем-Интернэшнл ХХК тус Номун-Интер трейд ХХК-ийг хамтран эзэмшдэг
20/ БСБ групп	-

Эндээс харахад, телевизийн топ 20 зар сурталчилгаа нийлүүлэгчдийн 4 нь улс төрч буюу нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдийн хамаарал бүхий компани байна. Энэ нь зар сурталчилгаа нийлүүлэгч 5 компани тутмын 1 нь улс төрийн эрх мэдэлтнүүдээс хамааралтай байх эрсдэлтэй болохыг харуулж байна. Гэхдээ тэдгээр эрх мэдэлтнүүд тодорхой хэвлэл мэдээллийн хэрэгсэлд давуу байдал олгох үүднээс зар сурталчилгаа захиалагчдад шахалт үзүүлдэг эсэхийг одоогоор нотлох боломжгүй байна.

2.2.10. Сэтгүүлчдэд байнгын ажил олгогчоос өөр байгууллагаас агуулгад нөлөөлөх зорилгоор мөнгө төлдөг эсэх

Сэтгүүлч Д.Нарантуяа “Редакцийн зурвас” номдоо энэ асуудлыг хөндсөн байна. Тэрээр “Хамтран ажиллах гэрээ нэрээр төсвийн мөнгөөр редакцуудтай гэрээ хийсэн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна гэсэн гэгээн зорилготой ч бодит байдал дээр энэ нь тухайн төрлийн байгууллагын удирдлагын суудлыг улс төрийн наймаагаар авсан улстөрч, тэр улстөрчийн харьяалагддаг намын сурталчилгаа болдог болсон. Энэ бол сэтгүүл зүйдээ ч, үнэн бодит мэдээлэл авах эрхтэй нийгэмдээ ч хорлонтой загвар. Мэдээж энэ мөнгөний хэмжээ сонгуулийн үечлэлээ дагаж өсч, буурдаг. Сэтгүүл зүй рүү цутгаж байгаа улстөрчдийн мөнгө өнгө төрхөө улам өөрчилж, ариун цагаан мөнгө мэт харагдах болтлоо төгсөрч байна. Хувь улс төрч, тухайлсан намыг магтан дуулахад зориулагддаг байсан мөнгө одоо нийгмээр нь нэг бодолтой байлгах үзэл суртлын зэвсэг болтлоо төрөл арилжиж байна. Eagle телевизийн “Бүрэн зураглал” нэвтрүүлгүүдийн 2016, 2020 оны УИХ-ын сонгууль, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх дугаарууд бол мэргэжлийн өнгөлөн далдлалтыг маш сайн хийсэн үзэл суртлын зорилготой контент юм. 2021 оны дөрөвдүгээр сарын 26-наас тавдугаар сарын 5-ны хооронд өдөр бүр өргөн нэвтрүүлгийн найман телевизээр цацагдсан “Мэдээллийн урсгал” хөтөлбөр хамгийн сүүлийн тод жишээ. “Мэдээллийн урсгал” хөтөлбөр сэтгүүл зүйд орж ирж байгаа улстөрчдийн мөнгөний урсгалыг таслан зогсоох цаг болсныг харуулсан онцгой жишээ юм.” гэжээ.²⁰²

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс дээр дурдсан “Мэдээллийн урсгал” хөтөлбөртэй холбоотой 2021.04.28-ны өдрийн мэдэгдэлдээ “Цар тахлын үед төрөөс хэрэгжүүлж буй эдгээр арга хэмжээнүүд нь хараат бус чөлөөт хэвлэлийн мөн чанарыг бүрдүүлэгч олон ургальч үзэл, олон талт эх сурвалж, редакцийн чөлөөт байр суурь, санхүүгийн бие даасан чадавх зэрэг хүчин зүйлүүдийг улам бүр сулрууллаа. Энэ бүхний эцэст асуудал улам бүр даамжирч, тодорхой зорилготой, зохион байгуулалттай мэдээллийн менежментийг чөлөөт хэвлэлүүд дээр хэрэгжүүлж, “Мэдээллийн урсгал” хэмээх хөтөлбөрөөр иргэдэд хайрцаглагдсан, засвартай мэдээллийг тулган хүлээлгэх, чөлөөт редакц, хэвлэлүүдийг нэг ижил агуулгатай үзэл суртлын талбар болгох, өөр үзэл бодол, байр суурийг чөлөөт өрсөлдөөнийг боомилох, эдийн засгийн аргаар шахан зайлуулах оролдлогыг тодорхой субъектүүдийн зүгээс хэрэгжүүлж байгааг эрс эсэргүүцэж байна.” гэжээ.²⁰³

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.6-д зааснаар өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбооноос гаргасан мэдэгдэлдээ “Дэлхий нийтийг хамарсан коронавирусийн цар тахал

²⁰² Д.Нарантуяа. Редакцийн зурвас (сэтгүүлч, редактор, редакцийн тухай; нийтлэлүүд). Улаанбаатар. 2021 он.

86 дахь тал

²⁰³ МСНЭ-ээс цаг үеийн асуудлаар мэдэгдэл гаргалаа. 2021.04.28 <https://gogo.mn/r/wv3w1>

улам хүрээгээ тэлж, Монгол Улсад хатуу хөл хорио тогтоосон энэ үед өргөн нэвтрүүлгийн долоон телевиз хамтран бэлтгэсэн “Мэдээллийн урсгал” нэртэй хөтөлбөрийг өөрсдийн эфирээр өнөөдрөөс цацаж эхэлжээ. Энэхүү нэгдсэн контентыг бэлтгэх болон нэг хөтөлбөр эфирээрээ зэрэг цацаж байгаа бүхий л үйл явц нь Монголын телевизүүдийн холбооны үйл ажиллагаатай ямар ч холбоогүй болохыг юун түрүүнд мэдэгдэж байна. Монголын телевизүүдийн холбоо нь иргэд, олон нийтийн мэдэх эрхийг хангах, телевизүүдийн ажилтан, уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өнөөг хүртэл хувь телевизийн дотоод үйл ажиллагаа, тэр тусмаа нийтлэлийн бодлогод хөндлөнгөөс оролцож, нөлөөлж байсан удаагүй билээ. Монголын телевизүүдийн холбоо нь өөрийн гишүүн телевизүүдийн цаашдын үйл ажиллагаа, нийтлэлийн бодлогод хөндлөнгөөс оролцох боломжгүйг дахин сануулахын зэрэгцээ хувь телевизүүдийн хамтарсан энэхүү хөтөлбөр нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэргээр баталгаажсан иргэдийн мэдэх эрхэд харшлахгүйгээр бодит мэдээллийг олон нийтэд хүргэнэ гэж найдаж буйгаа илэрхийлье.” гэжээ.²⁰⁴

Олон нийт, иргэдийн зүгээс хэд хэдэн телевизийн эфирээр зэрэг цацагдаж буй “Мэдээллийн урсгал” хөтөлбөрийг эсэргүүцэн цахим орчинд санал бодлоо хангалттай илэрхийлжээ.²⁰⁵

Эндээс харахад, сэтгүүлчдэд байнгын ажил олгогчоос өөр байгууллагаас агуулгад нөлөөлөх зорилгоор мөнгө төлдөг гэдгийг үгүйсгэх боломжгүй байна.

2.2.11. Хэвлэл мэдээллийн эздийн ашиг сонирхлын зөрчил нь сэтгүүлчдийг өөрийн цензурт автуулах түгээмэл шалтгаан мөн эсэх

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч гэдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзнийг илэрхийлэх боломжтой байна. Улсын Их Хурлаас 2013.05.31-ний өдөр баталж, тухайн өдрөөсөө хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 3.1.6-д “эцсийн өмчлөгч”-ийн талаар тодорхойлсон.²⁰⁶ Тодруулбал, хууль батлагдах үед “эцсийн өмчлөгч” гэж харилцагчийн үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээд өмчилж байвал тэдгээрийг анх үүсгэн байгуулсан хүнийг ойлгоно гэх тодорхойлолтыг 2018.04.26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулж, эцсийн өмчлөгчийг гурван нөхцөлөөр тодорхойлсон.

Хүснэгт 16. Эцсийн өмчлөгчийг тодорхойлох гурван нөхцөл

а.харилцагч нь хуулийн этгээд бол	б.харилцагч нь хувь хүн бол	в.хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд
тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүн	тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж байгаа хүн	тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүн
эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүн	эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүн	

²⁰⁴ Монголын телевизүүдийн холбоо “Мэдээний урсгал” хөтөлбөрийн талаар мэдэгдэл гаргажээ. 2021.04.27 <https://ivoice.mn/?p=9459>

²⁰⁵ “Мэдээллийн урсгал”-тай холбоотой үзэгчдийн бухимдсан постууд. 2021.04.27 <https://news.zindaa.mn/3oy4>

²⁰⁶ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2013 он, №24

эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүн		
---	--	--

Улсын Их Хурлаас 2019.03.22-ны өдөр баталж, 2020.01.01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд 2020.01.01-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн этгээд нь тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2021.01.01-ний өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ гэж заасан.²⁰⁷ Үүнтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020.08.19-ний өдрийн “Журам батлах тухай” А/1270 дугаар тушаалын хавсралтаар “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам” баталсан.²⁰⁸ Энэ журмын 3.2-т зааснаар “хөрөнгийн дийлэнх хэсэг” гэж Компанийн тухай хуулийн дагуу тухайн компанийн нийт хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувьцаа, хуулийн этгээдийн хөрөнгийн 33% түүнээс дээш хувь байна гэж тайлбарласан.

Хэрэв хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй эсхүл үнэн зөв мэдүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 15.23 дугаар зүйлд заасны дагуу учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгоно. Энд дурдсан учруулсан хохирол, нөхөн төлбөр гэдэгт зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг ойлгоно.²⁰⁹ 2020.10.01-ний өдрөөс 2020.12.04-ний хооронд эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлсэн 29948 хуулийн этгээд байна.²¹⁰

Үүнээс гадна Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2015 оны 15 тоот тогтоолоор баталсан “Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага”-ын 5.4-т “Зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшлийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлж, ил тод байлгана” гэж заасны дагуу телевиз, суваг, радио, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх мэдээллийг тус хороо 2020 оны байдлаар мэдээлсэн байна.²¹¹ Мөн Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.2-т зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Харилцаа холбооны зохицуулах хороонд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн гаргасан хувьцааных нь тав ба түүнээс дээш хувийг эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, компанийн эрх бүхий албан тушаалтны жагсаалт, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий бусад хуулийн этгээдэд эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ, хэрэв нөхөрлөл бол оруулсан эд хөрөнгийн хэмжээний талаарх мэдээлэл бүхий тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх дараах мэдээллийг хүргүүлнэ.

Нэг хүний хувьд нэгээс дээш телевизийн эзэмшигч байх явдал гарч байна. Тухайлбал, 2020 оны байдлаар Монголмасс Медиа ХХК, түүний үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч

²⁰⁷ Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2019 он, №22

²⁰⁸ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/1270 дугаар тушаалын хавсралт “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам” <https://burtgel.gov.mn/post/43978>

²⁰⁹ Өмгөөллийн “Абсолют Адвокатс” ХХН. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгүүлэх. https://gratanet.com/laravel-filemanager/files/3/UBO_MN_final.pdf

²¹⁰ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар. 2020.10.01-ний өдрөөс 2020.12.04-ний өдөр хүртэлх хугацаанд татварын цахим тайлангийн системээр хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ мэдүүлсэн бол хуулийн этгээдийн нэрсийн жагсаалт. <https://burtgel.gov.mn/post/57027>

²¹¹ Харилцаа холбооны зохицуулах хороо. “Тусгай зөвшөөрөлтэй телевиз, радио, сувгийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээлэл”. 2021.02.25 <https://crc.gov.mn/k/4x/9B>

Д.Баясгалангийн хувьд өргөн нэвтрүүлгийн 2 телевиз, арилжааны 5 телевизийн эзэмшигч байна. Түүнчлэн улс төрч, тэдгээртэй хамаарал бүхий хувь хүн, компанийн хувьд телевизийн эзэмшигч байх явдал байна.

Хүснэгт 17. Телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьцаа эзэмшигч бизнес эрхлэгч, улс төрчид, 2020

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Үйлчилгээний нэр	Хувьцаа эзэмшигч	Хувь	Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд
Өргөн нэвтрүүлгийн телевиз				
Медиа холдинг ХХК	ТВ9	Эскон ХХК. Түүний үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч Э.Батшугар /2021.10.21-ний өдрөөс УИХ-ын гишүүн/	100	Т.Баасансүрэн
Монгол телевиз ХХК	Монгол ТВ	Л.Чинбат	100	Ч.Номин /2021.01.29-ний өдрөөс Соёлын сайд/
Ийгл Бродкастинг ХХК	Ийгл ТВ	Монголмасс Медиа ХХК. Түүний үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч Д.Баясгалан	100	П.Сайнбилэг
Медиа боловсрол суваг ХХК	Боловсрол суваг	Гэр контент групп ХХК. Түүний үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч нь Монголмасс Медиа ХХК, түүний үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч Д.Баясгалан	100	Н.Мэндбаяр
Арилжааны телевиз				
Шууд Ти Ви ХХК	Лайв	Монголиамедиа Корперэшн ХХК. Түүний хувьцаа эзэмшигч Монголмасс Медиа ХХК, түүний хувьцаа эзэмшигч Д.Баясгалан	100	М.Тамир
Эйшн бокс ХХК	Asian box	Гэр контент групп ХХК. Түүний хувьцаа эзэмшигч Монголмасс Медиа ХХК, түүний хувьцаа эзэмшигч Д.Баясгалан	100	Н.Мэндбаяр
Мөүвибокс ХХК	Movie box	Гэр контент групп ХХК. Түүний хувьцаа эзэмшигч Монголмасс Медиа ХХК, түүний хувьцаа эзэмшигч Д.Баясгалан	100	Н.Мэндбаяр
Монгол масс медиа ХХК	Documentary Box	Монголмасс Медиа ХХК. Түүний үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч Д.Баясгалан	100	Н.Мэндбаяр
Мюзик бокс ХХК	Хөг-Жим	Монголмасс Медиа ХХК. Түүний хувьцаа эзэмшигч Д.Баясгалан	100	Н.Мэндбаяр
Мөрөөдлийн суваг ТББ	Dreambox	А.Амундра /2021 оноос Ерөнхий сайдын зөвлөх/	100	Н.Отгонбат
Медиа холдинг	TV9-2	Эскон ХХК. Түүний үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч нь Э.Батшугар /2021.10.21-ний өдрөөс УИХ-ын гишүүн/	100	Т.Баасансүрэн
Эвергрийнл айф ХХК	7-р суваг	А.Үйлстөгөлдөр /2016-2017 онд Шадар сайдын зөвлөх, 2017-2021 онд Ерөнхий сайдын зөвлөх, 2021 оноос Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга/	60	А.Үйлстөгөлдөр
		Н.Учрал /2016 оноос УИХ-ын гишүүн/	30	
		Нийслэлийн ЗДТГ-ын газрын дарга Л.Тулгабаатар	10	

Дэлхийн чимээ медиа групп ХХК	Live	Г.Гангамөрөн /Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч; Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ-ын дарга/	100	Д.Отгонжаргал
Волюм плас ХХК	Volume Plus	Ч.Номин /2021.01.29-ний өдрөөс Засгийн газрын гишүүн, Соёлын сайд/	50	Д.Уранзаяа
		Д.Уламбаяр	50	
Натурхаан медиа ХХК	TB1	Ч.Номин /2021.01.29-ний өдрөөс Засгийн газрын гишүүн, Соёлын сайд/	100	Ч.Номин

2012 оны “Азийн хэвлэл мэдээллийн барометр — Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”-нд дурдсанаар “Хөрөнгө оруулагч ба хөрөнгө оруулагчдын найз нөхдийн талаар муу юм бичиж болохгүй. Эрх мэдэл бүхий зарим хүнээс болгоомжлох хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч редакцийн бодлогыг тодорхойлох бөгөөд түүний бодлогыг ажилтан биелүүлэх үүрэгтэй.”²¹²

Үүний нэг шалтгаан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэж заасан бөгөөд хэвлэл мэдээллийн эздийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой цензурыг хязгаарлаагүй байгаатай холбоотой байж болох юм.

Хэвлэл мэдээллийн байгууллага нь өөрөө томоохон бизнесийн бүлэглэл, улс төрчдийн эзэмшилд байгаа нь редакцийн хараат байдлыг бий болгож, сэтгүүлчийн бэлдэхийг хүссэн нийтлэл, нэвтрүүлгийг дэмжихгүй байх, хориглох үндэс суурь нь болж байна. Нэгэн сэтгүүлч “Зөвхөн улс төр гэлтгүй, бизнесийн том бүлэглэлүүдийн ашиг сонирхол бас их хамаарч, хэвлэл мэдээллийн байгууллагууд эзний хамааралд орчхоод байна. Анхнаасаа өөрсдийнхөө нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага байгуулж байгаа нь редакцийн хараат байдлыг бий болгож байна” гэж онцолжээ.²¹³

Улсын Их Хурлаас 2019.12.12-ны өдөр баталж, 2020.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байгаа Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 18.2-т өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо батална гэж заасан бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2021.12.17-ны өдрийн 73 дугаар тогтоолын хавсралтаар “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам” баталсан.²¹⁴ Тус журмын 2.2-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээдээс хараат бус, бие даасан, мэргэжлийн Редакцийн зөвлөлтэй байна” гэж заасан. Энэ нь телевиз, радиод ажиллах сэтгүүлчдийг хэвлэл мэдээллийн эздийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой цензурт автуулахаас сэргийлсэн шинжтэй байх боловч тус заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид

²¹² Фридрих-Эбэртийн сан. “Азийн хэвлэл мэдээллийн барометр – Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”. Улаанбаатар. 2012 он. 65 дахь тал


²¹³ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 41, 42 дахь тал

²¹⁴ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 57 дугаар тогтоолын хавсралт “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”, 2021 оны 73 дугаар тогтоолын хавсралт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам”

орхигдуулсан байна. Мөн телевиз, радиогоос бусад буюу сонин, сэтгүүл, мэдээллийн сайтын хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээд нь хараат бус, бие даасан, мэргэжлийн редакцтай байх, тэдгээрийн ашиг сонирхлын зөрчил нь сэтгүүлчдийг өөрийн цензурт автахгаас сэргийлэх тусгайлсан зохицуулалт байхгүй.

2.2.12. Хэвлэл мэдээллийн эзэмшил хэр хэмжээнд төвлөрдөг эсэх

Хэвлэлийн хүрээлэнгээс 2021 онд гаргасан “Монголын хэвлэл мэдээлэл — өнөөдөр” мониторингийн тайланд дурдсанаар, хэвлэл мэдээллийн байгууллагуудын дийлэнх буюу 72% нь хувийн эзэмшилд байна. Телевизийн салбарт хувийн эзэмшлийн хэрэгсэл давамгайлж байгаа бол сэтгүүлийн салбарт төрийн бус байгууллагаас гаргадаг мэдээллийн хэрэгсэл олон байна.²¹⁵ Эндээс анхаарал татах зүйл бол, нийт сонины 3%-ийг улс төрийн нам, эвсэл, 12%-ийг төрийн байгууллага эзэмшиж байгаа явдал юм.



Түүнчлэн, “Монгол ньюс” группын хувьд сонин, телевиз, мэдээллийн сайттай, “Масс агентлаг”-ийн хувьд богино долгионы радио, телевиз, мэдээллийн сайттай, “Медиа групп”-ын хувьд телевиз, богино долгионы радио, мэдээллийн сайттай, “Нэйшнл ньюс корпорэйшн”-ий хувьд сэтгүүл, телевиз, мэдээллийн сайттай, “Эрхэт Монгол медиа” группын хувьд сонин, сэтгүүл, телевиз, мэдээллийн сайттай байна.²¹⁶ Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьцаа эзэмшигчдийн дунд хэвлэл мэдээллээс өөр салбарт хамаарал бүхий бүлгүүд байх явдал гарч байна. Тухайлбал, NTV телевиз, Эх дэлхий радио 107.0, Time.mn-н үндсэн хувьцаа эзэмшигч нь газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулдаг Шунхлай групп, Монгол масс медиа ХХК-ийн үндсэн хувьцаа эзэмшигч нь Голомт санхүүгийн нэгдлийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Баясгалан байна.

Хүснэгт 18. Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн давхар эзэмшил, 2021

Эзэмшил, харьяалал	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр	Хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн хамаарал бүхий бүлэг	Гүйцэтгэх захирал
<i>1/Холимог хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгууллага</i>			
Монгол ньюс групп	Өнөөдөр сонин	Б.Номинтүшиг /Балдорж сангийн тэргүүн/ Б.Нандинтүшиг /Өнөөдөр сонины Ерөнхий эрхлэгч/	Н.Шүр
	UB Post сонин		
	MN25 телевиз		
	Shop Mongolia телевиз Unuudur.mn		
Имержмедиа	Их Монгол FM 99.7	Н.Мөнхжаргал	Т.Ганзул

²¹⁵ Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл – өнөөдөр” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021 он. 4, 5 дахь тал

²¹⁶ Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл – өнөөдөр” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021 он. 5, 6 дахь тал

ХХК /Масс эженси групп 2020.09.18-нд татан буугдсан/	Масс телевиз		/2019-2021 онд Монголын телевизүүдийн холбооны гүйцэтгэх захирал; 2021.07.07-ны өдрөөс Засгийн газрын ХМОНХГ-ын дарга/
	ETV телевиз		
	Mass.mn		
Медиа групп ХХК	NTV телевиз	Шунхлай групп /үйл ажиллагаа: гадаад худалдаа; төсөл хэрэгжүүлэх; шатахууны бөөний болон жижглэн худалдаа, шатахуун хадгалах, тээвэрлэх/	А.Баярбат /2021.08.26-ны өдрөөс Монголын телевизүүдийн холбооны гүйцэтгэх захирал/
	Эх дэлхий радио 107.0		
	Time.mn		
Нэйшнл ньус корпорэйшн	Forbes Mongolia сэтгүүл	“Ти Ди Би Капитал” үнэт цаасны компани Худалдаа Хөгжлийн Банк Э.Энхцэцэг	Б.Батманлай
	Bloomberg TV Mongolia телевиз		
	Ubinfo.mn		
Чингис ньус ХХК	Улс төрч сонин	Г.Золбаяр Б.Ганзориг /Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбооны тэргүүн/	Б.Ганзориг
	Best of Mongolia сэтгүүл		
	Улс төрч сэтгүүл		
	Bestofmongolia.mn		
	Ulsturch.mn		
Эрхэт Монгол медиа групп	Өглөөний сонин	Х.Мандахбаяр /Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч асан/	Х.Доржпалам
	Долоо хоногийн толь сонин		
	Гранд сэтгүүл		
	TV8 телевиз		
	Zindaa.mn		
	Grandnews.mn		
	Breakingnews.mn		
	Factnews.mn		
	Zone.mn		
2/ Нэг төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгууллага			
Монцамэ агентлаг	Монголын мэдээ сонин /хятад хэлээр/	Засгийн газрын 2021.12.31-ний өдрийн 400 дугаар тогтоолын дагуу Засгийн газраас Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяанд 2022.01.01-ний өдрөөс шилжсэн	Б.Ганчимэг
	Монгол цушин сонин /япон хэлээр/		
	Монгол мессенжер сонин		
	Mongolia today сэтгүүл		
	Новости Монголии сонин		
	Хүмүүн бичиг сонин		
	Montsame.mn		
Эгэл ХХК /Орон нутгийн сонины холбоо/	Дундговийн амьдрал сонин	С.Шаравдорж /Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны тэргүүн/	С.Шаравдорж
	Завхан сонин		
	Алтайн мэдээ сонин		
	Монгол говь сонин		
Монгол масс медиа ХХК	Asianbox телевиз	Д.Баясгалан /Голомт санхүүгийн нэгдлийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/	М.Тамир
	Боловсрол суваг телевиз		
	Dreambox телевиз		
	Moviebox телевиз		
Эм Эм Жэй ХХК	Алаг хорвоо сонин	Я.Мөнхжаргал	Я.Мөнхжаргал
	Байлдан дагуулагч сонин		
	Болсон явдал сонин		
	Далд амьдрал сонин		
	Монгол бөх наадам сонин		
	Хоёулаа сонин		
	Янаг хорвоо сонин		

Хэвлэл мэдээллийн эзэмшлийг ил тод байлгах, эзэмшлийн хэт төвлөрлөөс сэргийлэх талаар холбогдох бодлогын баримт бичиг бий. Тодруулбал, Улсын Их Хурлаас 2010.07.15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.1.4-т “...Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна” гэж заасан.

Улсын Их Хурлаас 2019.12.12-ны өдөр баталж, 2020.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байгаа Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 18.1-т зааснаар хуулийн этгээд нь “радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ”, “олон суваг дамжуулах үйлчилгээ”, “өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ”-ний тусгай зөвшөөрлийн нэгээс илүүг буюу давхар эзэмшихийг хориглоно. Мөн хуулийн 18.2-т өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо батална гэж заасан. Түүнчлэн, Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.6-д Харилцаа холбооны зохицуулах хороо нь харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхтэй гэж заасан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2021.09.30-ны өдрийн 57 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”-д зааснаар Харилцаа холбооны зохицуулах хороо нь харилцаа холбооны зах зээлийн төлөв байдал, зохицуулалтын үйл ажиллагаанд шударга өрсөлдөх нөхцөл хангагдаж байгаа эсэхэд жил бүр төлөвлөлт, графикийн дагуу тогтсон аргачлалаар судалгаа, үнэлгээ, дүгнэлтийг хийнэ. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2021.12.17-ны өдрийн 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам”-д зааснаар Харилцаа холбооны зохицуулах хороо үнэлгээ хийнэ.²¹⁷ Эдгээр үнэлгээ, дүгнэлт одоогоор хийгдээгүй буюу олон нийтэд ил болоогүй байна. Дээр дурдсанаас өөрөөр хэвлэл мэдээллийн төвлөрлийг тусгайлан зохицуулдаг хууль тогтоомж байхгүй бөгөөд энэ салбар дахь төвлөрлийн тухай албан ёсны ямар нэгэн тодорхойлолт байхгүй. Хэвлэл мэдээллийн хэт төвлөрлөөс хамгаалах, эзэмшлийн төвлөрлийг хэмжих зохицуулалт, хэмжүүр, шалгуур байхгүй. Энэ нь хэвлэл мэдээллийн олон ургалч байдлыг эрсдэлд учруулж, иргэдийн олон талт мэдээлэл хүлээн авах эрхийг хязгаарлах эрсдэлтэй байна. Хэвлэлийн Хүрээлэнгээс 2016 онд “Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторинг”-оор хэвлэл мэдээллийн салбарын олон ургалч байдал өндөр эрсдэлтэй буйг тогтоохын сацуу голлох хэвлэл мэдээллийн хэрэгслийн 70-аас дээш хувь нь улс төрийн шууд хамааралд байна гэж дүгнэсэн.²¹⁸ Энэхүү байдлыг засаж сайжруулах эрх зүйн зохицуулалт дутмаг хэвээр байна. 2020 онд хэрэгжиж эхэлсэн Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд эзэмшлийн ил тод байдлыг хангах, хэт төвлөрлөөс хамгаалах зохицуулалтад ашиг сонирхлын зөрчлийг ил тод болгох талаар орхигдуулсан, давхар эзэмшлийн хязгаарлалтыг зөвхөн өргөн нэвтрүүлгийн салбарт хамаатуулсан учир хэт хэвлэл мэдээллийн салбар дахь төвлөрөл, улс төрийн шууд нөлөөллөөс үр дүнтэй хамгаалж чадахгүй гэж үзэж болохоор байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021.12.31- ний өдрийн 91 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-нд “хэвлэл мэдээллийн салбарт хэт төвлөрлөөс

²¹⁷ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 57 дугаар тогтоолын хавсралт “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”, 2021 оны 73 дугаар тогтоолын хавсралт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам”

²¹⁸ Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторинг төсөл. 2016 <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-findings/translation-media-regulation/>

хамгаалах зохицуулалтыг илүү тодорхой, үр дүнтэй болгох” талаар тусгаж, тус төлөвлөгөөг 2022 онд хэрэгжүүлэхээр заасан.²¹⁹

2.3. Эрх зүйн зохицуулалт

Энэ хэсэгт эрх зүйн зохицуулалтыг судалгааны асуулт бүрийн хүрээнд дүгнэв.

2.3.1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар хүлээсэн Монгол Улсын үүрэг, Үндсэн хуульд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан байдал

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966.12.16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 1-т “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй”, 2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”, 3-т “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж заасан.²²⁰ Энэхүү пактад Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан.²²¹

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулахад Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн зохицуулалтыг хэрхэн тусгах талаар хэлэлцэж байжээ. Тодруулбал, БНМАУ-ын Ардын их хурлын 1991.02.28-ны өдрийн хуралдаанд Б.Чимид “...Тэгэхээр хэд хэдэн санал гарч байна. Тэр хязгаар нь бидний барьж байгаа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт байгаа юм. Тэгэхээр пактын санаагаар хэн ч хэлэв, Шагдарсүрэн хэлэх шиг боллоо. Дөрөв, таван болзол байгаа юм. Тэр хүрээнд үүнийг найруулж үзвэл яасан юм бэ? Гэхдээ үүнээс бусад тохиолдолд хязгаарлаж болохгүй гэсэн тийм л юм хиймээр байна эрхийг хууль бусаар хязгаарлах, олон улсын эрх зүйгээс гажуудаар хязгаарлахгүй байх гэдэг санаа тавьж байгаа депутатуудын саналыг хүндэтгэж үзэх хэрэгтэй.” гэжээ.²²²

Ингэж хэлэлцэж, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй, 17-д төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй болохыг тус тус баталгаажуулсан.²²³

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 40 дүгээр зүйлийн 1-т “Энэхүү Пактад оролцогч улс түүгээр хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэх үүднээс арга хэмжээ, энэ талаар гарсан ахиц дэвшлийн тухай тайлан ирүүлж байх үүрэгтэй”, 4-т “Хороо энэхүү Пактад оролцогч улсаас гаргасан тайланг судална. Хороо нь өөрийн тайлан болон зохистой гэж үзсэн ерөнхий шинж чанартай анхааруулгыг оролцогч улсуудад илгээнэ. Түүнчлэн

²¹⁹ “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө IV”. 2021.12.31 <https://www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2021-2023/>

²²⁰ International Covenant on Civil and Political Rights. Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2200A (XXI) of 16 December 1966 entry into force 23 March 1976, in accordance with Article 49. <https://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CCPR.aspx>

²²¹ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт <https://old.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

²²² БНМАУ-ын Ардын их хурлын 1991.02.28-ны өдрийн хуралдааны протокол. Дугаар 17. 206, 207 дахь тал

²²³ Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он, №1

Хороо энэхүү Пактад оролцогч улсаас ирүүлсэн тайлангийн хувийг дурдсан анхааруулгын хамт Эдийн засаг, нийгмийн зөвлөлд явуулж болно” гэж заасан.

Монгол Улсын хувьд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаар ээлжит 6 илтгэлийг НҮБ-ын Хүний эрхийн хороонд хүргүүлж, тайлангийн талаар тус хорооноос холбогдох дүгнэлт, зөвлөмж гарсан.²²⁴

Хүснэгт 19. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тайлан, түүнд НҮБ-ын Хүний эрхийн хорооны өгсөн дүгнэлт, зөвлөмж

Тайлангийн товч утга	НҮБ-ын Хүний эрхийн хорооны хэлэлцүүлэг, зөвлөмж
<i>1/ Тайлагнах огноо: 1977.03.22; Тайлагнасан огноо: 1978.12.20</i>	
Үндсэн хуулийн 87-р зүйлд БНМАУ-ын төрийн байгуулалтыг бэхжүүлэх зорилгоор иргэдийн ашиг сонирхолд нийцүүлж БНМАУ-ын иргэдэд үг хэлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөө, хурал цуглаан хийх эрх чөлөө, жагсаал хийх эрхийг баталгаажуулсан. Эдгээр эрх, эрх чөлөө нь хөдөлмөрчид, тэдний байгууллагуудад эрхээ хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай материаллаг нөхцөлийг олгосноор хангагддаг.	Монголын иргэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх сурталчлахад аль хир эрх чөлөөтэй, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээхэд засгийн газар хатуу хяналт тавьдаг тухай асуулт гарав. Үүнтэй холбоотойгоор “Монголын хууль тогтоомжид өөрийнхөө саналыг илэрхийлэх, өөрийн санал бодолтой байхыг хязгаарладаггүй, төрөл бүрийн мэдээллийг хайх, хүлээн авах, түгээх эрхтэй, гэвч энэ эрхээ урвуулан ашиглаж бусдын нэр төрийг гутаах, улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, иргэдийн эрүүл мэнд, ёс зүйн эсрэг чиглэсэн үзэл санааг түгээхийг хууль зөвшөөрдөггүй” гэж тайлбар өгчээ.
<i>2/ Тайлагнах огноо: 1985.04.04; Тайлагнасан огноо: 1985.08.02</i>	
Хөдөлмөрчид болон тэдний олон нийтийн байгууллагад радио, телевиз, сонин хэвлэлийг ашиглах боломж олгож, гудамж, талбай, нийтийн барилга байгууламжийг хэрэглүүлж, мэдээллийг өргөн түгээж байна. Эрүүгийн хуулийн 92-р зүйлээр гүтгэх буюу бусдын нэр хүндийг гутаасан илтэд худал мэдээ тараахад, 93-р зүйлээр доромжлох буюу хүний нэр төр алдар хүндийг санаатайгаар гутаахад хүлээлгэх хариуцлагыг тодорхойлдог.	Хорооны гишүүд үндэсний болон орон нутгийн түвшинд хэвлэл мэдээлэлд улсаас ямар хяналт тавьдаг вэ? гэж асуув. Төлөөлөгч “Үндсэн хуулийн 86-р зүйлд иргэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэл түгээх эрх чөлөөгөө өргөн эдлэхийг заасан. Монголд жил бүр 37 сонин, 39 сэтгүүл, ойролцоогоор 600 орчим ном хэвлэгдэн гардаг. Хэвлэлд зөвхөн редакц нь хяналт тавьдаг ба улсаас ямар ч хяналт тавьдаггүй” гэсэн хариулт өгөв.
<i>3/ Тайлагнах огноо: 1990.04.04; Тайлагнасан огноо: 1990.11.29</i>	
Эрүүгийн хуулийн 143-р зүйлд шүүмжилсэн иргэнийг мөрдөн хавчсаны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Өнөөдөр манай улсад бүх нийтийн мэдээллийн хэрэгслээр чөлөөтэй илэрхийлэгдэж буй олон ургальч үзэл баттай бэхжиж байна. Зөвхөн сүүлийн жилд төрөл бүрийн нам, олон нийтийн хөдөлгөөнд харъяалагддаг 40 гаруй сонин, сэтгүүл хэвлэгдэн гарч байна.	Пактад баталгаажсан эрхийг дотоодын шүүхэд үр дүнтэй хамгаалж буй эсэхэд санаа зовниж байна. Мөн хуучин хууль тогтоомж, журмыг Пактад нийцүүлэн үргэлжлүүлэн шинэчлэх ажил удаашралтай байгаад Хороо санаа зовниж байна. Шүүх болон засгийн газрын холбогдох байгууллагууд Пактад баталгаажсан эрхийг бүрэн ойлгож, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн хүний эрхийн хэм хэмжээг зохих ёсоор хэрэгжүүлэх мэдлэг, чадвар олгоход чиглэсэн зохих сургалтыг хуульч, өмгөөлөгч, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулах шаардлагатай байна.
<i>4/ Тайлагнах огноо: 1995.04.04; Тайлагнасан огноо: 1998.04.20</i>	
Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д иргэн бүр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй гэж заажээ.	Хороо Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг сайшааж байна. Түүнчлэн Хороо Пактын аль ч заалтыг өнөөг хүртэл шүүхийн практикт хэрэглэсэн жишээ баримт алга гэдгийг тэмдэглэж байна. Пактын эрх дээгүүр статустай бөгөөд хуульд аливаа зөрчилдөөн үүссэн

²²⁴ UN Treaty Body Database. Ratification, Reporting & Documentation for Mongolia

https://tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/countries.aspx

Хүний эрхийн Үндэсний Комисс. “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс”. Нэгдүгээр боть. Улаанбаатар. 2021 он.

Улс төрийн намуудын тухай хууль, Хөдөлмөрийн хуульд улс төрийн үзлээр ялгаварлахыг хориглосон. Нийт 252 нэр бүхий сонин хэвлэл гарч байгаагаас 64 нь орон нутагт гарч байгаа. Төрийн нууцын тухай хуульд нууцыг олж авах зорилгоор хайх, бусдад тараахыг хориглосон нь иргэдийн мэдээллийн эрх хайх эрхийг хааж боогоогүй.	тохиолдолд дотоодын хуулиас дээгүүр байна гэдгийг тодорхой заах ёстой. Пакт болон Пактын нэмэлт Протоколын эх бичвэр, түүнчлэн эрх нь зөрчигдсөн тохиолдолд дотоодын шүүхэд, дараа нь Хүний эрхийн хороонд хандаж болно гэсэн тайлбар олон нийтэд нээлттэй, хүртээлтэй байх ёстой.
<i>5/ Тайлагнах огноо: 2003.03.31; Тайлагнасан огноо: 2009.09.14</i>	
1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн хүрээнд төрийн төв болон нутгийн захиргааны харьяалалд ажиллаж байсан бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийг татан буулгах, хувьчлах шийдвэрүүд гарч хэрэгжсэн бөгөөд хамгийн сүүлд 2005 онд “Олон нийтийн радио телевизийн тухай” хууль батлагдаж уг мэдээллийн хэрэгслийг Засгийн газрын харьяаллаас гаргаж олон нийтийн статустай болгосон. Өөрийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхдээ бусдыг гүтгэсэн, доромжилсон, худал мэдээ тараасан этгээд хуульд заасан хариуцлага хүлээх тухай зохицуулалт бий. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж байна. Уг хуулиар сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах, мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх харилцааг зохицуулах юм.	Сэтгүүлч, тэдний гэр бүлийнхэнд халдахаар заналхийлэх, айлган сүрдүүлэх тохиолдол байнга гардаг болон 2001 оны Мэдээллийн эрх чөлөөний хуулийн төсөл өнөө хүртэл боловсруулалтын шатанд байгаад Хороо зовинож байна. Мөн төрийн алба хаагчийг шүүмжилсэн сэтгүүлч, шүүхийн шийдвэрийг эсэргүүцсэн өмгөөлөгчийг хүний нэр төр, алдар хүндэд халдсан хэрэгт буруутгаж шийтгэдэгт Хороо харамсаж байна. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Пактад бүрэн нийцүүлэхэд Оролцогч улс анхаарч, хуулийг батлах хэрэгтэй байна. Нэр төр, алдар хүндэд халдсан хэргийг эрүүгийн гэмт хэргээс хасаж, сэтгүүлчийг аливаа сүрдүүлэг, заналхийллээс хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авахыг зөвлөж байна. Түүнчлэн сүрдүүлсэн, заналхийлсэн аливаа мэдээллийг хуулийн дагуу мөрдөн шалгаж, гэмтэнд хариуцлага хүлээлгэхэд Оролцогч улс анхаарна уу.
<i>6/ Тайлагнах огноо: 2015.04.01; Тайлагнасан огноо: 2016.03.30</i>	
Өөрийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөвхөн хуулийн хүрээнд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хязгаарлах бөгөөд энэхүү эрхээ эдлэхдээ бусдыг гүтгэсэн, доромжилсон, худал мэдээ тараасан этгээд хуульд заасан хариуцлага хүлээх хуулийн зохицуулалт бий.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл түүний дотор интернет мэдээллийн хэрэгсэлд тавьсан хууль ёсны хориг нэлээд өргөн хүрээтэй байгаад мөн эрх бүхий байгууллагаас гаргасан нууцлалын талаарх өргөн хүрээг хамарсан тайлбарын улмаас мэдээлэл олж авах байдалд хязгаарлалт тавьж байгааг Хорооны зүгээс сайшаахгүй байна. Эрүүгийн хуулиас гүтгэлэгтэй холбоотой ерөнхий заалтыг хассаныг тэмдэглэхийн зэрэгцээ Эрүүгийн хуульд хэвээр байгаа гүтгэлэгтэй холбоотой бусад заалтууд, мөн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд хэт хязгаарласан байж болох, үр нөлөөг хазаарласан, царцаасан иргэний хууль дахь гүтгэлгийг зохицуулсан зүйл, заалтыг хэрэглэх явдлыг ихэсгэж байгаа тухай мэдээллийн талаар Хороо зовниж байна. Хэвлэл, мэдээллийн ажилтнууд болон сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдэж байгаа үйлдлүүд болон аливаа бусад дайралтуудын тухай мэдээллийг мөн авч үзэж байна. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай Хорооны ерөнхий зөвлөмж №34 (2011)-өөс үүдэн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд аливаа хязгаарлалт тавихгүй байх, Пактын 19 (3) дүгээр зүйлд заасантай нийцэж буй эсэхийг Оролцогч улс нь нягтлах ёстой. Гүтгэлгийг бүрэн утгаар нь эрүүгийн хуулиас хасч, гэмт хэрэгт тооцохгүй байх, гүтгэлэг нь эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болохгүй байх, эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид заасан гүтгэлгийн талаарх зохицуулалтууд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг боогдуулахгүй байх ёстой талаар

	эргэцүүлэх шаардлагатай. Хэвлэл, мэдээллийн ажилтнууд болон сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдэж байгаа бүх хэлбэрийн заналхийлэл болон аливаа бусад дайралтаас хамгаалах, халдлага, дайралт тохиолдсон үед даруй мөрдөн шалгах, энэ төрлийн үйлдэл хийсэн хүмүүст хариуцлага тооцохын тулд шүүхээс хариуцлага оногдуулах ёстой.
--	--

Мөн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2016 оноос эхлэн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг”-ийн механизмаар дамжуулан НҮБ-ын гишүүн орнууд дахь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар баталгаажсан хүний эрхийн нөхцөл байдлыг үнэлж зөвлөмж өгч байна. Энэ хүрээнд Монгол Улсын зүгээс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд гурван удаа илтгэл хүргүүлж, холбогдох зөвлөмж авсан байна.

Хүснэгт 20. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн Монгол Улсын үндэсний илтгэл, тус зөвлөлөөс хүлээн авсан зөвлөмж

Үндэсний илтгэлийн товч утга	НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн зөвлөмж
1 дэх мөчлөг, 2010.11.02	
“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалтаар иргэд болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл нээлттэй байхаар хуульчилсан. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний харилцааг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зар сурталчилгааны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Садар самуунтай тэмцэх тухай хуулиудаар тус тус зохицуулж байна.	Үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандартад уялдуулах, олон улсын стандартуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс шүүгчид болон хууль хяналтын ажилтнуудад сургалт түлхүү явуулах. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдол бүхий хууль, эрх зүйн акт, механизм, ялангуяа хэвлэн нийтлэгчдийн бие даасан байдлыг хангах. УИХ болон Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгох, хууль тогтоомжийг олон нийтээр хэлэлцүүлэх явдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг бий болгох. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мөн энэхүү хэлэлцүүлгийн мөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дотоодын хүний эрхийн байгууллагуудыг хамруулах.
2 дахь мөчлөг, 2015.05.05	
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 онд батлан мөрдөж байна. Шилэн дансны тухай хуулийг 2014 онд баталсан. Энэ хуулийн дагуу төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагууд төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайланг байгууллагын нууцад хамааруулахыг хориглож, өөрсдийн цахим хуудсаар тогтмол мэдээлж байх үүрэг хүлээсэн.	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжоо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, Харилцаа, холбооны зохицуулах хорооны бие даасан байдлыг хангах, доромжлох үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцохгүй байх асуудлыг судлан үзэх. Интернет орчинг оролцуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг бүх орчинд баталгаатай эдлүүлэх. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд өөрсдийн үйл ажиллагаагаа олон улсын стандартад заасны дагуу шийтгэн цээрлүүлэх аливаа айдасгүйгээр чөлөөтэй эрхлэх бололцоог хангах.
3 дахь мөчлөг, 2020.11.04	
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд зарим хуулиудын зүйл заалт нийцэхгүй байгаа тул Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн боловсруулахаар төлөвлөсөн. Эрүүгийн хуульд нэр гутаах үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй харин үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилсан. Мэдээ мэдээллийн веб сайтуудад тавигдах нөхцөл шаардлагыг “Тоон контентийн	Гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх арга хэмжээ авах зэрэг замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд ямарваа шийтгэл хүлээхээс айж эмээх зүйлгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын стандартын дагуу чөлөөтэй явуулах нөхцөлийг хангах. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх заалтыг хүчингүй болгох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагын хараат бусаар мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд шийтгэл хүлээлгэх.

зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага"-д тодорхойлсон ба зөрчилтэй веб сайтын Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлдэг.	
---	--

Эндээс харахад, Монгол Улсын олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйл, Үндсэн хуульд баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг бусад хууль тогтоомжоор баталгаажуулах, тэдгээрийг хэрэгжүүлэх байдал хангалтгүй байгааг НҮБ-ын Хүний эрхийн хороо, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжид тодорхой дурдсаар байна.

2.3.2. Бусад хуульд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан эсэх

Улсын Их Хурлаас 1998.08.28-ны өдөр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталж, түүний 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.” гэж зохицуулсан.²²⁵ Үүнээс хойш 2019 оны байдлаар 40 гаруй хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөндсөн байх бөгөөд тэдгээр хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг баталгаажуулаагүй буюу хязгаарласан шинжтэй байна. Үүний шалтгааныг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судлаачид “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэт ерөнхий зохицуулалттай, тунхагийн шинжтэй” гэж тайлбарласан байна.²²⁶ Энэ тайлбарыг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргаж буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 16 дугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”, 70 дугаар зүйлийн 1-т “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн явдал юм.

Эрүүгийн хуульд хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүл зүйн үйл ажиллагааг хамгаалахад чиглэсэн тусгайлсан зохицуулалт бий. Тодруулбал, 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд “Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх” гэмт хэргийг тусгасан бөгөөд 139.1-т “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.”, 139.2-т “Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” гэж заасан.²²⁷ Энэ нь тус Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар хөнгөн гэмт хэрэгт хамаарна. Ийм хөнгөн гэмт хэрэгт бусдын бага бус хэмжээний эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хамаардаг.

²²⁵ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 1998 он, №10

²²⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлтэй үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэх болон тэдгээр хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”. Улаанбаатар. 2019 он. 19 дэх тал

²²⁷ Эрүүгийн хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2002 он, №5

Улсын Их Хурлаас 2015.12.03-ны өдөр баталж, 2017.07.01-ний өдрөөс үйлчилж буй Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.2 дугаар зүйл /Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах/-д зааснаар “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрхийг хэрэгжүүлэхэд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж саад учруулсан” бол 450,000-2,700,000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Мөн 14.3 дугаар зүйл /Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах/-д зааснаар “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн” бол 450,000-2,700,000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Энэ нь тус Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлд зааснаар хөнгөн гэмт хэрэгт хамаарна.

Гэвч 2002 оны Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд заасан “Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлээгүй байна. Харин Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэсэн 1 тохиолдол байна. Тодруулбал, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021.09.21-ний өдрийн 505 дугаартай шийтгэх тогтоолоор “Шүүгдэгч С.О нь 2019.03.25-ны өдөр Д телевизийн сэтгүүлч, редактор Ч.Д-ын 2017.03.17-ны өдөр Дундговь аймгийн Говь-Угтаал суманд үйл ажиллагаа явуулдаг Ч ХХК-ийн уурхайгаас бэлтгэсэн нэвтрүүлгээс өөрийн утсаар ярьж буй бичлэгийг гаргуулахгүй байхын тулд 2.500.000 төгрөг төлж зориуд нийтлүүлэхгүй байхаар завдсан” гэм буруутайд тооцож, 1.700.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн байна. Улсын Их хурлаас 2021.07.02-ны өдөр баталж 2021.07.06-ны өдрөөс дагаж мөрдөхөөр баталсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4.1-д зааснаар торгох ялыг өршөөн хэлтрүүлжээ. Мөн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн 2.500.000 төгрөгийг улсын орлого болгожээ.²²⁸

Энэ судалгааны 2.5-д буй сэтгүүлчийн аюулгүй байдал алдагдсан жишээ, баримттай харьцуулахад дээр дурдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэсэн 1 тохиолдол хангалтгүй байна. Энэ нь дээрх гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах буюу тэднийг мэргэшүүлэх шаардлага байгаа болохыг харуулж байна.

Эндээс үзэхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг Үндсэн хуулиас бусад хууль тогтоомжид үр дүнтэй баталгаажуулаагүй байна.

2.3.3. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай олон улсын хуульд нийцээгүй хязгаарлалт тогтоодог эсэх

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэхдээ тусгай үүрэг, хариуцлага үүрэх тухай заасан. Ийм учраас бусдын эрх, эсвэл нэр хүндийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, эсвэл

²²⁸ Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021.09.21-ний өдрийн 505 дугаартай шийтгэх тогтоол https://shuukh.mn/single_case/60279?daterange=2017-07-01%20-%202022-02-12&id=1&court_cat=2&bb=1

нийгмийн дэг журам, эсвэл нийгмийн эрүүл мэнд ба зан суртахууныг хамгаалахтай холбоотой байж болох шалтгаанаар хязгаарлалтыг хязгаарлагдмал хоёр хүрээнд зөвшөөрсөн байна.

Зураг 5. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах нөхцөл, шаардлага



Гэхдээ НҮБ-ын гишүүн улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавихдаа уг эрхэд өөрт нь аюул учруулж үл болно. “Аливаа улс, бүлэг буюу хувь этгээд энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн аливаа эрх, эрх чөлөөг үгүй хийх буюу тэдгээрийг түүнд зааснаас илүү хэмжээгээр хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах буюу үйлдэл хийх эрхтэй мэтээр энэхүү Пактын заалтуудыг мушгин тайлбарлаж болохгүй” гэсэн Пактын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг НҮБ-ын Хүний эрхийн хороо Гишүүн улсуудад сануулсан.²²⁹

Хүснэгт 21. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах нөхцөл, шалгуур ба түүнийг Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл хангаж буй эсэх харьцуулалт

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах нөхцөл, шаардлага	Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл /Худал мэдээлэл тараах/
1/ Хязгаарлах шаардлага	
1.1. бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх	Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалах
1.2. үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах	Хамааралгүй.
2/ Хязгаарлах баримт бичиг	
2.1. зөвхөн хууль	Тийм. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга
3/ Хязгаарлалтын шалгуур	
3.1. зөвхөн хууль ёсны зорилго, үндэслэлтэй байх	Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
3.2. зайлшгүй буюу гарцаагүй шаардлагатай байх	Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, түүнийг сэргээх талаар зохицуулсан тул Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл шаардлагагүй.
3.3. зохист хэмжээндээ байх	Эрүүгийн хуулийн зохицуулалт нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг сэргээх арга зам болохгүй. Мөн нэр төр, алдар хүнд, нэр хүнд, илт худал мэдээлэл гэх ойлголтыг тодорхойлоогүй бөгөөд түүнийг үзэмжээрээ тодорхойлох эрсдэлтэй. Нотлох үүрэг нь тухайн зөрчилд өртөж буй эзэнд биш гуравдагч этгээд буюу мөрдөгчид бий. Эрүүгийн хуульд өөрт нь заасан “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй”, “Хүний

²²⁹ UN Human Rights Committee (HRC), General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression, 12 September 2011, CCPR/C/GC/34, available at: <https://www.refworld.org/docid/4ed34b562.html>

	үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэсэн зарчимтай шууд харшилж байна. Тухайн тараасан мэдээлэлд дурдсан агуулгатай холбоотой урьдчилж бэлтгэсэн бодит, бүрэн мэдээлэл байсан эсэх, тийнхүү мэдээлэл байхад зориуд тухайн мэдээллийг тараасан эсэхийг заавал харгалзах нөхцөл байхгүй.
--	---

Эндээс харахад, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зохицуулалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуулиар хязгаарлах шаардлага дахь “зайлшгүй шаардлагатай байх”, “зохист хэмжээндээ байх” нөхцөлийг зөрчсөн буюу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд өөрт нь аюул учруулсан байна. Дээрх жишээгээр бусад хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж үзье.

- Зөвхөн хуулиар хязгаарлах дүрмийг зөрчсөн байдал:

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.2-т “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна” гэж заасан бөгөөд Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэснийг зөрчиж төрийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар биш Засгийн газрын тогтоолоор тогтоож байна.

- Зөвхөн хуулиар хязгаарлах; зохист хэмжээндээ байх дүрмийг зөрчсөн байдал:

“Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 9.13-т “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” гэж заасан бөгөөд Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020 оны А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам” баталсан.

Энэ зохицуулалт, журамд “олон нийтийг төөрөгдүүлэх”, “илт худал” гэх ойлголтыг тодорхойлоогүй бөгөөд түүнийг шийдвэрлэх албан тушаалтны үзэмжээс хамаарахаар байна. Улмаар цар тахлын холбогдолтой мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг журмаар хязгаарлаж байна. Мөн энэ журамд төрийн захиргааны байгууллагын дүгнэлт, саналаар асуудлыг шийдвэрлэж байгаа бөгөөд хөндлөнгийн этгээд буюу шинжээчийн дүгнэлт гаргуулах нөхцөл байхгүй, Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх журмын дагуу шийдвэрлэж буй гомдлын агуулга, шийдвэрийн талаар тухай бүр ил тод мэдээлдэггүй нь түүний шийдвэрийн хууль ёсны, үндэслэл бүхий эсэхийг тодорхойлох боломжгүй болгож байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүргийг заасан.

Ингэхдээ хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээ, сурвалжлага, нэвтрүүлгийн агуулгыг төрийн байгууллагаас хянах нөхцөлийг тусгасан.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.13-т “олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх” гэж, “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 14.1-т “Хэвлэл мэдээллийн байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын онцгой комисс болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн сэрэмжлүүлэг, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлнэ”, 14.2-т “Цар тахлын талаарх цаг үеийн болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой үнэн, бодит мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ” гэж, Засгийн газрын 2021.02.10-ны өдрийн “Түр хороо байгуулах тухай” 29 дүгээр тогтоолын 4-т “мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх” гэж, Цагдаагийн албаны тухай хуулийн 59.1.2-т “Шуурхай мэдээлэл нийтэд түгээх шаардлага гарсан тохиолдолд өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглах” гэж тус тус хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээ, сурвалжлага, нэвтрүүлгийн агуулгыг төрийн байгууллагаас хянах, цензур тогтоох нөхцөлийг тусгасан.

Ингэхдээ “илт худал мэдээлэл”, “баталгаатай эх сурвалж”, “шуурхай мэдээлэл” гэх хуульд тодорхойлоогүй ойлголтуудыг хэрэглэсэн байх бөгөөд түүнийг тухай бүр төрийн байгууллага, албан тушаалтан өөрөө тогтоох нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасан “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”, “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” гэж заасныг зөрчсөн шинжтэй байна.

- Зайлшгүй шаардлагатай байх; зохист хэмжээндээ байх дүрмийг зөрчсөн байдал:


Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1-т зааснаар “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх худал мэдээ, мэдээлэл түгээх” нь зөрчил бөгөөд шийтгэл оногдуулна. Ингэхдээ тухайн асуудлаарх эрх бүхий байгууллага, албан тушаалтан урьдчилж бүрэн, цэгцтэй, шинэ мэдээлэл өгсөн эсэхийг харгалзахгүй. Мөн “олон нийтийг төөрөгдүүлэх”, “худал” гэх ойлголтыг тодорхойлох хэмжүүр байхгүй, зөрчлийг шийдвэрлэх албан тушаалтны үзэмжээр тодорхойлогдох эрсдэлтэй байна.

Эндээс харахад, Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас бусад дотоодын хууль тогтоомжид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөвшөөрөгдсөн хязгаарлалтыг (бусдын эрхийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах) зөрчиж хэвлэлийн эрх чөлөөг боомилох зорилготой зохицуулалт тусгаж, тэдгээрийг хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эсрэг урвуулан ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.3.4. Хуулиар нэр төр гутаах хэрэгт баривчлах, хорих, эрх чөлөөг хязгаарлах ял оноодог эсэх

Гэмт хэрэгт баривчлах ял оноох эсэхийг Эрүүгийн хуулиар зохицуулдаг. 2002 оны Эрүүгийн хууль, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэр төр гутаахыг гэмт хэрэгт

2002-2007 оны байдлаар доромжлох 17 хэргийг анхан шатны шүүх шийдвэрлэсэн байх бөгөөд үүнээс 1 сэтгүүлч тус хэрэгт холбогдсон байна. Харин гүтгэх гэмт хэрэг 79 бүртгэгдсэнээс анхан шатны шүүх 4 хэргийг шийдвэрлэсэн байна. Дээрх бүртгэгдсэн хэрэгт нийт 23 сэтгүүлч холбогдсоноос 4 хэрэгт сэтгүүлчдийг гүтгэх гэмт хэрэгт гэмт буруутай гэж ял шийтгэжээ.²³⁰ 2002-2017 онд бусдын нэр төр, алдар хүндэд халдсан гэх нийт 80 хэргийг шүүхээс шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 38-д буюу 50 орчим хувьд нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан холбогдсон байна.²³¹



²³¹ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2020”. Улаанбаатар. 2021 он. 46-47 дахь тал

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 13.14 дүгээр зүйл /Худал мэдээлэл тараах/-ийн 1-т хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 450-1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж, 14.8 дугаар зүйл /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/-ийн 1-т сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол 450-5,400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-12 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж тус тус заасан.

2020-2021 онд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэгт 20 хүнийг гэм буруутай гэж шүүхээс шийдсэн бөгөөд үүнээс 19 хүнд торгох ял, 1 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял ногдуулсан байна.

Хүснэгт 22. Шүүхээс шийдвэрлэсэн нэр төр гутаах эрүүгийн хэргийн холбогдогчийн тоо, 2016-2021

Шийдвэрлэсэн байдал	2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт		2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын зохицуулалт	
	110.Доромжлох	111.Гүтгэх	13.14.Худал мэдээлэл тараах	14.8.Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах
Шийдсэн	3	10	20	-
Гэм буруутай гэж үзсэн	3	8	20	-
Хэрэгсэхгүй болгосон	3	5	-	-
Цагаатгасан	-	2	-	-
Торгох ялаар шийтгэсэн	-	7	19	-
Баривчлах, хорих ялаар шийтгэсэн	-	1	-	-
Зорчих эрхийг хязгаарласан	-	-	1	-

Эдгээр шийдвэрийн дагуу хохирогчоор тооцогдсон 20 хүний давхардсан тоогоор 11 нь иргэн, 9 нь албан тушаалтан байна. Үүнээс төрийн өндөр албан тушаалтан буюу Улсын Их Хурлын гишүүн 2 /Х.Нямбаатар, Б.Дэлгэрсайхан/ байна. Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалт тодорхой эсэх, тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд мөрдөгч, прокурор, шүүгчийн мэдлэг, ур чадвар хангалттай эсэхийг тодруулах зорилгоор төрийн өндөр албан тушаалтныг хохирогчоор тогтоосон шийдвэрт хийсэн дүн шинжилгээг энд авч үзье.²³² Тодруулбал, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын гомдлоор шүүхээс хоёр хүнийг “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт буруутгаж, ял шийтгэсэн байна.

Жишээ 1. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ /төрийн албан тушаалтны гомдолтой хэргийн жишээн дээр/

<u>Шийдвэрийн товч утга:</u> Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.08.20-ны өдрийн 689 дугаартай шийтгэх тогтоолоор “Шүүгдэгч Х.А нь 2020.05.15-ны өдөр Нийслэлийн нутаг дэвсгэрээс өөрийн

²³² “Х.Нямбаатарын талаар худал мэдээлэл тараасныг нотолсон гурван шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ”. 2020.12.23 <https://www.gic.mn/post/r/1562>

‘Гал Бороо’ нэртэй фэйсбүүк цахим хуудсаас олон нийтийн сүлжээгээр Улсын Их Хурлын хуулбар гишүүн буюу хохирогч Х.Нямбаатарыг ‘Нямбаатар чи 14-тэй охиныг яаг яасын!!! МАНАН чинь чамайг ингэж дасгалжуулаа юу...’ ‘Коммунистууд өөрсдөө бага насны охидуудаар зугаагаа гаргахаа бодоод нэгэнт баталж гаргасан 14 настай хүүхдийг хүчиндэж болох хуулиа өөрчлөхгүй’ ‘Тэр хүчирхийлэгчдэд нь чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн УИХ-ын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд’ гэж нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай” гэж үзэж иргэн Х.А-г 450.000 төгрөгөөр торгох ял оногдуулсан.

1/ Гэмт хэргийн шинжийн талаар:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл /Худал мэдээлэл тараах/-ийн 1-т зааснаар “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” бол 450,000 — аас 1,300,000 төгрөгөөр торгох, эсхүл 240 — 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 - 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Энэ зохицуулалтаас харахад, дараах ойлголт гарч ирж байна. Үүнд:

- хүний “нэр төр”, “алдар хүнд”,
- хуулийн этгээдийн “ажил хэргийн нэр хүнд”
- “илт худал мэдээлэл”
- “олон нийтэд тараах”.

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.08.20-ны өдрийн 689 дугаартай шийтгэх тогтоолд Х.Нямбаатарын нэр төр, алдар хүндийг тодорхойлоогүй, тухайн шүүгдэгчийн фэйсбүүкт оруулсан бичвэр нь илт худал мэдээлэл гэдгийг тодорхойлоогүй, “олон нийтэд тараах” гэдгийг “...бичвэр, зураг бүхий постыг 14 хэрэглэгч хуваалцаж /шэйрлэж/, 16 хэрэглэгч уг постонд дүрс зураг дарж постыг үзсэн болох нь тогтоогджээ” гэж тайлбарласан байна.

Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 2-т зааснаар Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй, 4-т зааснаар энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2-т зааснаар Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ. Тэгэхээр шүүхээс дээрх хэргийг шийдвэрлэхдээ хохирогч Х.Нямбаатарын “нэр төр”, “алдар хүнд”, түүнд халдсан “илт худал мэдээлэл” гэх ойлголтыг заавал тайлбарлах ёстой байжээ.

2/ Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.08.20-ны өдрийн 689 дугаартай шийтгэх тогтоолд дараах нотлох баримтыг шинжлэн судалжээ. Үүнд:

- Шүүгдэгч Х.А-гийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэг, мөрдөн шалгах ажиллагааны явцад яллагдагчаар өгсөн мэдүүлэг
- Хохирогч Х.Нямбаатарын мөрдөн шалгах ажиллагааны үед өгсөн мэдүүлэг
- Гэрч Г.Б-ын мөрдөн шалгах ажиллагааны үед өгсөн мэдүүлэг
- Галт Бороо нэртэй фэйсбүүк хаяганд үзлэг хийсэн тухай тэмдэглэл
- Гар утсанд үзлэг хийсэн тухай тэмдэглэл
- Шүүгдэгч Х.А-н эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас
- Шүүгдэгч Х.А-н иргэний үнэмлэхний лавлагаа, түүний хувийн байдлын талаарх баримтууд.

Эндээс харахад, “Галт Бороо нэртэй фэйсбүүк хаяганд үзлэг хийсэн тухай тэмдэглэл”-ийг тооцохгүй бол шүүхийн шийдвэр үндсэндээ мэдүүлэгт тулгуурлажээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүх хуралдааны явцад дараах байдлыг нотолно:

- гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал/;
- гэмт хэргийг хэн үйлдсэн;
- гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;
- Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
- гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
- гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Дээрх шүүхийн шийдвэрт гэмт хэргийн сэдэлт, зорилго; гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ; гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоогоогүй байна. Зөвхөн эдгээр асуудлаар “улсын яллагчийн эрүүгийн хариуцлагын талаарх санал, шүүгдэгч болон түүний өмгөөлөгчийн өмгөөллийн үг зэргийг тус тус харгалзан үзлээ” гэжээ. Харгалзан үзэх бус, нотлох ёстой зүйл юм.

Хохирогч Х.Нямбаатарын зүгээс “худал мэдээлэл тараах” гэмт хэргээс сэргийлэх арга хэмжээ авсан эсэхийг шүүх тодруулаагүй байна. Х.Нямбаатарын мэдүүлэгт “...хамгийн анх 2018 оны хавраас эхлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр намайг дээрх хуулийн заалтыг санаачилж батлуулсан мэтээр гүтгэж, доромжилсон илт худал мэдээлэл явагдаж эхэлсэн бөгөөд үүнийг эсэргүүцэж тайлбар хийх, олон нийтэд зөв ойлголт өгөх зав чөлөө тэр болгон гараад байдаггүй юм” гэж хэлснээс харахад иргэдэд үнэн, бодит мэдээлэл өгөөгүй нь тус гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөл болжээ.

Шүүгдэгч мэдүүлэгтээ “...цахим сайт болон олон нийтийн телевизээр 14 настай хүүхдийг насанд хүрсэн хүн гэж үзнэ гэсэн утгатай мэдээлэл явж байсан. Уг мэдээллийг уншихад УИХ-ын гишүүн Х.Нямбаатарын санаачилсан хуулинд тэгэж тусгагдсан байна гэсэн утга бүхий мэдээлэл фэйсбүүкээр яваад байхаар нь би үнэхээр тийм хууль санаачилж батлуулсан юм байх гэж бодоод, өөрөө охин хүүхэдтэй учир Нямбаатар гишүүний санаачилсан тэр хуулийг нь эсэргүүцэж пост бичсэн юм. Би Нямбаатар гишүүн үнэхээр тийм хууль санаачилсан эсэхийг нягтлаагүй, буруу ташаа мэдээллийг олон нийтийн сүлжээнээс харж өөрийн цахим хуудсанд байршуулж, бусдад түгээсэндээ маш их харамсаж байна. Би Нямбаатар гишүүнийг 14-тэй охинтой бэлгийн харьцаанд орж болно гэсэн хууль санаачлаагүй гэдгийг мэдээд өөрийн оруулсан постоо устгасан. Мөн өөрөөс нь фэйсбүүк чатаар нь уучлалт гуйсан” гэжээ.

Шийдвэрийн товч утга:

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.09.04-ний өдрийн 726 дугаартай шийтгэх тогтоолоор “Х.Г нь 2020.05.09-ний өдөр Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс өөрийн Х.Заяа нэртэй фэйсбүүк цахим хуудаснаас олон нийтийн сүлжээгээр Улсын Их Хурлын гишүүн буюу хохирогч Х.Нямбаатарыг ‘Нямбаатарын гаргасан хууль 14-тэй охин хүчиндвэл 450.000 төгрөгөөр торгуулаад л болоо, охины чинь хохь болно. Ийм новшийн юмнуудыг төрд дахин бүү гарга. Коммунистууд өөрсдөө бага насны охидуудаар зугаагаа гаргахаа бодоод нэгэнт баталж гаргасан 14 настай хүүхдийг хүчиндэж болох хуулиа өөрчлөхгүй. Тэр хүчирхийлэгчдэд чинь эрүүгийн хэрэг үүсгэх боломж байхгүй. Чи 14 настай. Өнөөгийн УИХ-ын гишүүдийг сонгож гаргасан ээж, аавдаа гомд’ гэж нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэм буруутай” гэж үзэж иргэн Х.Г-г 500.000 төгрөгийн торгох ял шийтгэсэн.

1/ Гэмт хэргийн шинжийн талаар:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.09.04-ний өдрийн 726 дугаартай шийтгэх тогтоолд тайлбарлаагүй, “шүүгдэгч Х.Г-гийн дээрх Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан ‘...үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх...’ гэсэн эрхээ эдэлж, одоогийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.5 дугаар зүйлд заасан ‘Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох’ гэсэн гэмт хэргийн төрлийг шүүмжилж, өөрийн ‘Х.Заяа’ нэртэй хувийн цахим хуудаснаас олон нийтийн сүлжээгээр тараахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх гэж заасан үүргээ биелүүлэлгүй ... гэж бичиж хохирогч Х.Нямбаатарыг уг гэмт хэргийн төрлийг шинээр санаачлан Эрүүгийн хуульд тусгаж хууль тогтоогчоор батлуулсан мэтээр бусдад ойлгуулан нэр төр, алдар хүндэд нь халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэжээ.

2/ Нотлох баримт, нотолбол зохих байдлын талаар:

Шүүхээс нотлох баримтыг жагсааж бичсэн байх бөгөөд аль нотлох баримтаар ямар үйл баримтыг нотолж байгааг тайлбарлаагүй байна. Тухайлбал, шүүгдэгч Х.Г-гийн “Самсунг Нөүте-8” маркийн гар утсанд ...2020 оны 5 дугаар сарын 09-ны өдрийн 22 цаг 6 минутад татаж авсан, 66.96 кв хэмжээтэй, 991x859 нарийвчлалтай, РВ-IMG-1589033806429.jpg гэсэн нэрээр хадгалагдсан Х.Нямбаатарын зурагтай “гаж донтнууд хууль зохиож баталсаар байх уу”, “14 настай охинтой бэлгийн харьцаанд орж болно...” гэсэн бичвэртэй 1 ширхэг зураг юуг нотолж байгаа талаар тайлбарлаагүй байна.

Дүгнэлт:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаарх шүүхийн шийдвэр хангалтгүй, үндэслэл бүхий байж чадахгүй байна. Энэ нь шүүгчийн төдийгүй мөрдөгч, прокурор, өмгөөлөгчийн туршлага, ур чадвартай хамааралтай байна.

Худал мэдээлэл тараах гэмт хэргийн үндсэн шинж болох “илт худал мэдээлэл”-ийг хууль тогтоомжид тайлбарлаагүй, хохирогчийн зүгээс тийнхүү худал мэдээлэл тараахаас сэргийлэх, худал мэдээллийг залруулах хангалттай арга хэмжээ авсан эсэхийг харгалздаагүй, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэж болох иргэний гэм хорын асуудлыг эрүүжүүлсэн нь буруу байна.

2.3.5. Хуулиар сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлалыг баталгаажуулдаг эсэх

Улсын Их Хурлаас 2005.01.27-ны өдөр баталж, 2005.07.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34.2-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Энэ зохицуулалт ёсоор мэдээллийн эх сурвалжийг албадан ил болгох эрхийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх бөгөөд олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакциас бусад этгээдийн хувьд дээрх мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхийг хуулиар баталгаажуулаагүй.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.1-т “гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогч, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг ойлгоно гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 1-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ”, 8.1 дүгээр зүйлийн 1-т “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ”, 2-т “Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргана” гэж заасан.

Гэвч сэтгүүлч, түүний эх сурвалжийн хувьд заавал дээр дурдсан гэрч, хохирогч байх шаардлагагүй этгээд бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хохироосон буюу хохироож болзошгүй талаар тайлагнах, өргөдөл гаргах, мэдээлэх, гомдол гаргах боломжтой этгээд юм. Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд сэтгүүлч, түүний нууц эх сурвалжийг хамгаалаагүй байна.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг 2021.11.11-ний өдөр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн барьсан.²³³ Энэ хуулийн төслийн 9.9-д “Шүгэл үлээгч эрх бүхий байгууллагад мэдээлэл өгсөн асуудлаар олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болно. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь шүгэл үлээсэн асуудлыг мэдээлсэн эх сурвалжаа нууцлах эрхтэй” гэж заасан.²³⁴ Мөн тус хуулийн төслийг дагалдуулан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд түүнд “5.1.Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгч хамаарна. 5.2.Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно. 5.3.Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, зээ охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно., 21.2.4.хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгчийг хамгаалах асуудлаар Хүний эрх хамгаалагчийн хорооны хүсэлтээр мөрдөгч” гэж заасан.

Гэвч дээрх хуулийн төслүүдэд сэтгүүлч бус зөвхөн олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь шүгэл үлээсэн асуудлыг мэдээлсэн эх сурвалжаа нууцлах эрхтэй байх, тэрхүү эх сурвалж нь заавал урьдчилж эрх бүхий байгууллагад мэдээлэл өгсөн буюу шүгэл үлээсэн байх шаардлагатай болж байна. Мөн сэтгүүлч, шүгэл үлээгч буюу сэтгүүлчийн нууц эх сурвалжийн хувьд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтад орохын тулд Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороонд хандах, тус хороо нотолгоо, баримт, мэдээлэл цуглуулах,

²³³ “Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг өргөн бариллаа”. 2021.11.11 <http://www.parliament.mn/n/naaon>


²³⁴ Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 2021.11.11 <http://forum.parliament.mn/projects/11197>

эрсдэлийн үнэлгээ хийх, хуралдах зэрэг ажиллагааны дараа мөрдөгчид хүсэлт гаргах үе шаттай буюу сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлалыг хангах, хамгаалахад үр нөлөөгүй буюу эрсдэлтэй шат дамжлагыг туулах хэрэгтэй болж байна. Иймд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлалыг баталгаажуулах шийдлийг оновчгүй тусгасан байна. Энэ нь сэтгүүлчид, редакторын эх сурвалжийг хамгаалах механизмыг хуульд тусгах шаардлагатай болохыг харуулж байна.

2.3.6. Нийтийн мэдээлэл авах эрхийг хуулиар баталгаажуулдаг эсэх

Улсын Их Хурлын чуулганы 2021.12.17-ны нэгдсэн хуралдаанаар “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн баталсан.²³⁵ 2022.05.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх тус хуульд нийтийн мэдээллийг “нээлттэй”, “хязгаарлалттай”, “хаалттай” гэж ангилсан бөгөөд түүний 7.2-т “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ”, 7.3-т “Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ” гэж, 7.4-т “Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж үзнэ” гэж тус тус заасан.²³⁶ Мөн хуулийн 8 дугаар зүйлд мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээний нийт 67 нээлттэй мэдээллийн жагсаалтыг тусгасан.

Гэвч төрийн мэдээлэл дээд зэргээр ил тод байх, нууцалбал зохих мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашгийн шалгуурт үндэслэн хуулиар тогтоосны үндсэн дээр нууцлах зарчимтай тус хууль нийцэхгүй байна. Тодруулбал, хуулийн 3.1-т “Хуулиар төрийн нууцад хамааруулахаар заасан мэдээллийг ил болгоход энэ хууль үйлчлэхгүй”, 7.6-д “Хаалттай, хязгаарлалттай мэдээлэлд хамаарах төрийн болон албаны нууцтай холбогдох Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэх заалтууд нь Төрийн болон албаны нууцын хуулийг огт хөндөөгүй, улмаар “төрийн нууц”, “албаны нууц” нэрийн дор олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлыг үл хайхран мэдээллийг нууцлах, мэдээлэл өгөхгүй байх, төрийн байгууллага, албан тушаалтны алдаа, дутагдлыг нуух, хаацайлах өнөөгийн байдлыг залруулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үр дүнгүй байх шинжтэй байна.²³⁷



²³⁵ “Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулиудыг эцэслэн баталж, эцсийн найруулга сонслоо”. 2021.12.17 <http://www.parliament.mn/n/5eaon>

²³⁶ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2022 он

²³⁷ Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын дэргэдэх “Засаглалд залуу сэтгүүлчдийн оролцоо хөтөлбөр”-ийн төгсөгчдийн холбоотой хамтран 2021.10.19-ний өдөр хэвлэл мэдээллийн салбарын эвсэл, холбоод, мэргэжлийн байгууллагын төлөөллийн оролцоотой зохион байгуулсан хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу УИХ-ын нэр бүхий гишүүдэд хүргүүлсэн санал. 2021.10.26 <https://www.mediacouncil.mn/a/310>

Дээрх графикт харуулснаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийн тоо 67, хаалттай мэдээлэл буюу Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт” дахь мэдээлэл 570 байна. Харин төрийн нууцад хамаарах мэдээллээс 3 дахин их мэдээлэл албаны нууцад хамаарч байгааг харгалзан хязгаарлалттай мэдээллийн тоог 1710 гэж тооцов.²³⁸

2.3.7. Сэтгүүлчдийн нэгдэх эрхийг хуулиар баталгаажуулдаг эсэх

Канадын “Хууль ба ардчилал” төвийн үүсгэн байгуулагч, захирал Тоби Мендел “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх нь тусдаа хоёр эрх юм. Эхний эрхийн хувьд, хүн бүр сэтгүүлзүйн үйл ажиллагаа эрхэлж болно гэдэг нь ойлгомжтой. Хоёр дахь эвлэлдэн нэгдэх эрхийн тухайд гэвэл, сэтгүүлчид өөрсдийн хүссэнээр ямар зохион байгуулалтад орох нь тэдний эрх юм. Сэтгүүлчдийг ямар нэг холбооны гишүүнчлэлтэй байхыг албадах нь хэвлэлийн эрх чөлөөний зөрчил болохын тодорхой нэг тохиолдол нь Коста Рика байсан бөгөөд энэ талаар 1985.11.13-ны Америк дундын хүний эрхийн шүүхийн шийдвэр хамгийн шилдэг жишиг тогтоосон билээ” гэжээ.²³⁹

“19 дүгээр зүйл” байгууллага “Олон улсын стандарт: Хэвлэл мэдээллийн ажилтнуудын зохицуулалт” хэмээх бодлогын бичиг баримтдаа мөн Коста Рикагийн тохиолдлыг жишээ татан, Америк дундын хүний эрхийн шүүхийн шийдвэрээс иш татаж, “Сэтгүүлчдийг мэргэжлийн эвлэл холбооны гишүүн байхыг хүчээр тулгах нь эмзэг асуудал юм. Практик дээр сэтгүүлчид сайн дураараа ийм байгууллагад идэвхтэйгээр нэгдэх, эсвэл өөрсдөө дундаа шинэ бүлэг, хэсэг байгуулдаг. Холбоо, үйлдвэрчний эвлэл байгуулах нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 22 дугаар зүйлээр баталгаажуулсан тусдаа хүний эрх юм. Сэтгүүлчдийн эвлэл, холбоо нь хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулахад тустай, мөн сургалт хийх, гишүүддээ үйлчилдэг ёс зүйн зарчим батлах замаар гишүүдийнхээ мэргэжлийн ба ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлэхэд туслах боломжтой” гэжээ.²⁴⁰

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2019.10.09-ний өдөр ажлын хэсгийн гишүүдэд зориулан танилцуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 18.2-т “Сэтгүүлчдийн холбоо нь сэтгүүлчдийн заавал гишүүнчлэлтэй, өөрийн удирдлагатай, ашгийн төлөө бус хуулийн этгээд байна” гэж бичсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т заасан сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн шинжтэй байжээ.

2.3.8. Олон ургалч үзэл санаа, редакцийн хараат бус байдлыг баталгаажуулах механизмыг хуульд тусгасан эсэх

Олон ургалч үзэл санаа, редакцийн хараат бус байдлыг баталгаажуулах зорилгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.”, 3.2-т “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” гэж заасан.

²³⁸ Тухайлбал, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд төрийн нууцад хамааруулах мэдээллийн тоо 17 бол, түүний албаны нууцад хамаарах мэдээллийн тоо 52 байна.

Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ”. Улаанбаатар. 2019 он. 43 дахь тал

²³⁹ Сэтгүүлч гэж хэн бэ? 2019.10.18 <https://gic.mn/post/r/1475>

²⁴⁰ Article 19. “International standards: Regulation of media workers”. 2012

<https://www.article19.org/resources/international-standards-regulation-media-workers/>

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23.7-д “Мэдээг олон талт эх сурвалжийг ашигласан, үйл явдлыг үнэн, шударга, тэнцвэртэй, хараат бус байхаар мэдээлнэ”, 27.3-т “Ивээн тэтгэгч иргэн, хуулийн этгээд мэдээ, нэвтрүүлгийн агуулга, хугацаа болон сэтгүүлч, редакцын бие даасан, хараат бус байдалд аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно”, 31.3.2-т “радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн редакцын бодлого, дүрэмтэй байх” гэж заасан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2021.12.17-ны өдрийн 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам”-ын 2.2-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээдээс хараат бус, бие даасан, мэргэжлийн Редакцийн зөвлөлтэй байна” гэж заасан.

Гэвч өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогоос бусад буюу сонин, сэтгүүл, мэдээллийн сайтын хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээд нь хараат бус, бие даасан, мэргэжлийн редакциятай байх, тэдгээрийн ашиг сонирхлын зөрчил нь сэтгүүлчдийг өөрийн цензурт автахаас сэргийлэх тусгайлсан зохицуулалт байхгүй. Редакцийн хараат бус байдалд халдсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид орхигдуулсан.

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд зааснаар “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт олон ургалч үзэл санаа, редакцийн хараат бус байдлыг баталгаажуулахад дангаараа хангалтгүй бөгөөд энэ судалгааны 2.1.3, 2.1.5, 2.2.1, 2.2.6, 2.2.7, 2.2.11-т заасан асуудлыг зайлшгүй хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна.

2.3.9. Эрх мэдэлтнүүд агуулгад, нэн ялангуяа, вэбсайт дахь агуулгад шүүхийн шийдвэргүйгээр цензур тавихыг хуулиар зөвшөөрдөг эсэх

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011.02.24-ний 8 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-д Харилцаа холбооны зохицуулах хорооны 2012 оны 18 дугаар тогтоол, 2014 оны 40 дүгээр тогтоол, 2015 оны 60 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан. Тус нөхцөл шаардлагын 3.4-т “Харилцаа холбооны тухай хуулийн 12.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээ мэдээллийн веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хороонд бүртгүүлнэ” гэж, 2014.09.25-нд нэмэлтээр оруулсан 3.5-д “Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагын танилцуулга, нийгмийн сүлжээ, хувийн блог, өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргэдэг веб сайтууд нь уг нөхцөл шаардлагад хамаарахгүй” гэж тус тус заасан.

“Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага” нь Хууль зүйн яамны улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хавсралт “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын 1.4-т “Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгэхгүй бөгөөд ийм шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй” гэж заасан. Улсын Их Хурлаас 2015.06.19-ний өдөр баталж, 2016.07.01-ний өдрөөс үйлчилсэн Захиргааны ерөнхий хуулийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, ‘Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл’-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.”, 67.3-т “Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн

тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан.²⁴¹

Гэвч “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага” нь хүчин төгөлдөр мөрдөгдөн цахим хуудасны агуулгад хяналт тавьж, хандалтыг хаах зэрэгт үндэслэл болгон хэрэглэж байна.²⁴² 2011 онд гаргасан “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий шаардлага” хэмээх журмын 7.1-т “Хэрэглэгчийн хандалтын дундаж нь нэг сарын хугацаанд өдөрт гурван мянгаас давсан тохиолдолд Зохицуулах хороонд бүртгүүлнэ” гэж заасан.²⁴³ Энэ талаар Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Б.Болдбаатар “Вэб хуудсын хандалтын тоог бид харах бололцоотой. Түүгээр нь хэмжинэ. Сарын туршид өдрийн дундаж гурван мянгаас дээш байвал манайд хандаж зөвшөөрөл авах ёстой гэж журамд заасан байгаа. Мэдээж огт ашиг олохгүйгээр томоохон вэб портал эрхэлнэ гэж байхгүй шүү дээ” гэж онцолж байжээ.²⁴⁴ Үүний дагуу олон нийтэд мэдээлэл түгээх болон арилжааны зориулалттай, өдөрт 3000-аас дээш хандалт бүхий цахим хуудсыг 2011 оны хавраас эхлэн бүртгэдэг болсон. Өдөрт 3000-аас дээш хандалттай 60 орчим цахим хуудас байсан бөгөөд эдгээрээс 17 нь бүртгүүлсэн. 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн өмнө, хоёрдугаар сард Цагдаагийн ерөнхий газар дээр “төрийн эрхийг хууль бусаар авахыг завдахаас сэргийлэх зорилгоор” ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд 2012 оны долдугаар сарын 4 хүртэл буюу сонгуулийг дуустал ажиллаж, 50 гаруй сайтыг хянасан байна.²⁴⁵

“Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын 6 дугаар зүйлд “Веб сайтын үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлага”-ыг заасан бөгөөд хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараах зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ:

- Зохицуулах хорооноос ажиллуулж байгаа үгийн шүүлтүүр программыг заавал ашиглах.
- Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлчилгээг ашиглахыг сануулсан нөхцөл шаардлагыг зөвшөөрсөн хэрэглэгчийг контент үүсгэх боломжоор хангах.
- Хэрэглэгч аль нэг өөр хэрэглэгчийн үүсгэсэн контентыг хууль бус, нийтийн ёс зүйд сөрөг нөлөөтэй гэж үзвэл саналаа илэрхийлэх, саналын тооноос хамааран тухайн контентыг арилгах боломжийг бүрдүүлэх.
- Хэрэглэгчийн интернет хаягийг (IP address) бүтнээр нь хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах. /2014 оны хорооны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/
- Хэрэглэгчийн үүсгэсэн контентыг Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон агуулгыг нийтлэхгүй байх заалтыг зөрчсөн гэж үзсэн тохиолдолд түүнийг арилгах.
- Хэрэглэгч дурын нэр /username/, имэйл хаягаар логин хийж сэтгэгдэл үлдээх боломжийг бүрдүүлэх /2014 оны хорооны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/
- Тухайн сэтгэгдэлтэй холбоотой үүсэх логийг багадаа 6 сар хадгалах /2014 оны хорооны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/
- Сайт нь сэтгэгдэлтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг хүлээн авснаас 24 хүртэлх цагийн дотор, хойшлуулшгүй нөхцөлд нэн даруй шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. /2014 оны хорооны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/

²⁴¹ Захиргааны ерөнхий хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2015 он, №28

²⁴² Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2012-2014”. 2015 он. Улаанбаатар. 12 дахь тал

²⁴³ “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”

<https://www.slideshare.net/jamuh/content-7247241>

²⁴⁴ “Харилцаа холбооны зохицуулалтын талаар”. 2011.03.17 <https://news.mn/r/553840/>

²⁴⁵ Фридрих-Эбэртийн сан. “Азийн хэвлэл мэдээллийн барометр – Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”. Улаанбаатар. 2012 он. 26 дахь тал

- Сэтгэгдэл бичигчдэд зориулсан зөвлөмж, анхааруулгыг сэтгэгдлийн талбарт харагдахуйц байршуулна. Тухайлбал: “Та сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг хүндэтгэнэ үү. Хэм хэмжээг зөрчсөн сэтгэгдлийг админ устгах эрхтэй” гэсэн анхааруулга байна. /2014 оны хорооны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/
- Хууль зөрчсөн сэтгэгдлийг устгах боломжийг заавал бүрдүүлж ажиллана. /2014 оны хорооны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/

Мөн 6.8-д “Энэхүү нөхцөл шаардлагыг биелүүлээгүй веб сайтын үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлана” гэж заасан. Мөн 7.2.2-т зааснаар Харилцаа холбооны зохицуулах хороо нь веб сайтын үйлчилгээ эрхлэгчээс шаардлагатай мэдээ, тайлан гаргуулах замаар хяналт тавина.

2012-2014 оны хооронд Харилцаа холбооны зохицуулах хороо нийт 172 цахим хуудасны хандалтыг гол төлөв оюуны өмчийн удаа дараа, ноцтой зөрчил гаргасан гэсэн оюуны өмчийн улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хаажээ. Тус хороо зөрчилтэй домэйн нэрийн жагсаалт, хаагдсан огноо зэргийг “хар жагсаалт”-д оруулан, <http://www.black-list.mn> цахим хуудсаар нээлттэй мэдээлж байсан. 2015 оноос эхлэн <http://www.black-list.mn> цахим хуудсаар дээрх жагсаалтыг танилцуулахаа больсон бөгөөд 2015.03.30-ны байдлаар нийт 214 вэб сайтыг хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа явуулж байгаа шалтгаанаар түүнд Монгол Улсаас хандах хандалтыг нь хязгаарлах арга хэмжээг авсан. 2012 оноос хойш зохиогчийн эрхийг зөрчсөн гэх шалтгаанаар 217 цахим хуудсыг хаасны дотор зохиогчийн эрхийн зөрчилтэй холбоогүй тохиолдлууд ч байсан.²⁴⁶

2014 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Amjilt.com вэб сайтын сэтгүүлч гэрэл зураг бүхий баримт дээр тулгуурлан “Ерөнхий сайдын ‘Хаан жимс’ амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гарчигтай нийтлэл байршуулжээ. Тус нийтлэл гарсны маргааш буюу 7 дугаар сарын 4-ний өдөр Харилцаа холбооны зохицуулах хорооны холбогдох албан тушаалтан тус сайтын удирдлага руу утастаж “Хаан жимс” амралтын газрын гомдлын дагуу ярьж байна” гээд нийтлэлээ устгахыг шаардаж “Гүтгэлгийн мэдээ байна. Залруулга гарга. Тэгэхгүй бол танай сайтыг цагийн дараа хаана” хэмээн сүрдүүлжээ. Энэ ярианаас хойш 3 цагийн дараа тус сайтыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хар жагсаалтад бүртгэн, хаажээ.²⁴⁷ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хэвлэлийн эрх чөлөөний төлөөлөгч Дуня Миятович Amjilt.com мэдээллийн вэбсайтыг үндэслэлгүйгээр хаасан үйлдэлтэй холбогдуулан мэдэгдэл гаргасан байна.²⁴⁸

Уг сайтын өмчлөгч шүүхэд хандсан бөгөөд Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх дээрх хэргийг 2014.12.18-ны өдөр хянан хэлэлцээд Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т заасныг баримтлан “Том-Амжилт” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, “Amjilt.com” сайтын дотоод хандалтыг хаасан үйлдлийг хууль бус болохыг тогтоож, тус сайтын хандалтыг нээхийг Харилцаа холбооны зохицуулах хороонд даалгаж шийдвэрлэсэн бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2015.03.20-ны өдрийн хуралдаанаараа анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн юм. Нэхэмжлэгч “Том-Амжилт” ХХК-ийн захирал Ж.Шижир “...Харилцаа холбооны зохицуулах хороо сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журамд заасны дагуу асуудлыг шийдвэрлэлгүй манай сайтын хандалтыг шууд хаасан үйлдлийг хууль бус болохыг тогтоож, уг хорооны хууль бус шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү” гэсэн нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргаад байсан юм. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар

²⁴⁶ Л.Галбаатар. “Онлайн эрх чөлөө болон нэрээ нууцлах эрх” илтгэл. 2015.05.03 <https://vip76.mn/content/31757>

²⁴⁷ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2012-2014”. 2015 он. Улаанбаатар. 22 дахь тал

²⁴⁸ OSCE media freedom representative concerned about blocking of news website in Mongolia. Vienna. 10 July 2014 <https://www.osce.org/fom/121076>

“Том-Амжилт” ХХК-ийн нэхэмжлэлтэй Харилцаа холбооны зохицуулах хороонд холбогдох хэргийг 2015.05.11-ний өдөр хянан хэлэлцэж, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэжээ.²⁴⁹

Гэвч шүүхийн эцсийн шийдвэр гарсан хэдий ч тус сайтыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос хаасан хэвээр байсан.²⁵⁰ Улмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Харилцаа холбооны зохицуулах хороонд хандаж, шүүхийн шийдвэрийн дагуу amjilt.com сайтын Монголоос хандах хандалтыг нээх, “хар жагсаалт”-аас гаргахыг шаардсаны дагуу 2015 оны 12 дугаар сард буюу шүүхийн шийдвэр гарснаас хойш 7 сарын дараа Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх хууль бус үйлдлээ зогсоосон байна.²⁵¹ Энэ нь Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүд шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх хэмжээнд хүртэл Ерөнхий сайдаас бүрэн хамааралтай, хараат байгааг харуулсан бодитой жишээ юм.

2.3.10. Сэтгүүлчдийг олноор эсвэл товлож тагнах, чагнах, мөрдөн мөшгих ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрдөг эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т “Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй,.... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална ...”, 19 дүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх” гэж заасан.

Үүний дагуу Улсын Их Хурлаас 2002 онд баталсан Эрүүгийн хуулийн 133 дугаар зүйл /Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих/-ийн 133.1-т “Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Мөн Улсын Их Хурлаас 2015 онд баталж, 2017.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 13.12 дугаар зүйл /Хууль бусаар мөрдөж мөшгих/-ийн 1-т “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн бол”, 2-т “Эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгисөн бол”, 21.13 дугаар зүйл /Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/-ийн 1-т “Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гүйцэтгэх ажлын тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол”, 2-т “Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажил явуулсан бол” тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Эдгээр заалт нь сэтгүүлчдийг олноор эсвэл товлож тагнах, чагнах, мөрдөн мөшгих ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрөөгүй болохыг харуулж байна. Гэвч, сэтгүүлчдийн хувьд түүнийг тагнаж, чагнах, мөрдөн мөшгихөөс өөрийгөө хамгаалахыг хориглосон. Тодруулбал, Улсын Их Хурлаас 2020.01.10-ны өдөр нэмэлт оруулсан Эрүүгийн хуулийн 21.13 дугаар зүйлийн 2-т “Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн хэсэг, Гүйцэтгэх ажлын тухай хуульд 2015.07.09-ний өдрийн хуулиар шинээр нэмсэн 6.3 дахь хэсэг буюу “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж ... илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл

²⁴⁹ Улсын Дээд шүүх. “Харилцаа холбооны зохицуулах хороог хууль зөрчсөн хэмээн үзэв”. 2015.05.13 <http://supremecourt.mn/news/print/1>

²⁵⁰ Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ. 2015 оны Хүний эрхийн тайлан. <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2015-human-rights-report-mn/>

²⁵¹ Amjilt.com сайт дахин “ирлээ”. 2016-03-02. <https://www.assa.mn/a/36455>

хэсэг, программ хангамжийг хэлнэ” гэсэн зохицуулалт нь иргэн, сэтгүүлчид тагнаж чагнуулахаас өөрийгөө хамгаалах багаж, хэрэгсэлтэй байхыг хориглосон байна.²⁵²

Техник технологи хөгжсөн үед хувь хүн, сэтгүүлч өөрийн хууль ёсны эрх, эрх чөлөө, хувийн нууцаа техник технологийн шийдэлгүйгээр хамгаалах боломжгүй юм. Жишээлбэл иргэний гэр орон, албан өрөөнд хэн нэгэн этгээд хууль бусаар чагнах төхөөрөмж, нууц камер байрлуулсан гэж үзвэл түүнийг яаж илрүүлэх вэ гэх асуулт хөндөгдөнө. Тусдаа “камер илрүүлэгч” /camera detector/ гэх техник хэрэгслээр гэр орон, албан өрөөнд байгаа нууц камерыг илрүүлэх боломжтой. Мөн хэн нэгэн этгээд хувийн болон албан өрөөнд нууцаар чагнах төхөөрөмж тавьсан бол мөн үүнийг “сүлжээ илрүүлэгч” гэх төхөөрөмжөөр илрүүлж болно. Эдгээр төхөөрөмж буюу “нууц камер илрүүлэгч”, “сүлжээ илрүүлэгч” нь дэлхийн олон оронд илээр, чөлөөтэй худалдан борлуулагддаг бөгөөд иргэд өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд зөвхөн өөрийн хэрэгцээнд ашиглахаар худалдан авч болдог. Үүнийг дэлхийн улс орнууд хуулиар хориглодоггүй. Учир нь өөрөө өөрийгөө хамгаалах эрх нь иргэний жам ёсны бөгөөд салшгүй эрх юм. Тухайлбал, Apple болон Android утас хэрэглэгчийн хувьд “Hidden Camera Detector” аппликейшнийг тус тус үнэгүй суулгаж хэрэглэх боломжтой. Мөн онлайн худалдаанаас нууц камер илрүүлэгчийг худалдан авах боломжтой.

Гэвч нэр бүхий иргэд Үндсэн хуулийн Цэцэд хандаж Улсын Их Хурлаас 2020.01.10-ны өдөр нэмэлт оруулсан Эрүүгийн хуулийн 21.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гүйцэтгэх ажлын тухай хуульд 2015.07.09-ний өдрийн хуулиар шинээр нэмсэн 6.3 дахь хэсэг буюу “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж ... илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэсэн хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэснийг, 13-т заасан халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэснийг, 19 дүгээр зүйлийн 1-т заасан төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх гэснийг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү гэснийг Цэц хүлээн аваагүй бөгөөд дээрх зохицуулалтыг “хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр нууц ажиллагаа хийх зэрэг ажилд саад учруулахаас сэргийлж буй төрийн бодлого юм” гэжээ.²⁵³

2.4. Нийгэм-соёлын нөхцөл байдал

Энэ хэсэгт нийгэм-соёлын нөхцөл байдлыг судалгааны асуулт бүрийн хүрээнд дүгнэв.

2.4.1. Мэдээний хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон түүний агуулгад итгэх иргэдийн итгэл өндөр эсэх

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх олон нийтийн асуулгыг судалгааг Хэвлэлийн хүрээлэнгээс 2011 онд явуулж, үр дүнг нь 1998 болон 2004 оны судалгаатай харьцуулжээ. Судалгаанаас харахад, 1998 оноос хойш мэдээллийн хэрэгсэлд бүрэн итгэдэг иргэдийн тоо 2011 онд ойролцоогоор 3 дахин нэмэгджээ.²⁵⁴ Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдлын талаарх иргэдийн үнэлгээг энэ асуулгатай дүйцүүлэн авч үзэж 2020

²⁵² Гүйцэтгэх ажлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1998 он, №3

²⁵³ Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2021.10.15-ны өдрийн “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тухай” 115 дугаар тогтоол

²⁵⁴ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ.

2016 он. 84 дэх тал <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245364>

Хэвлэлийн Хүрээлэн. “Хэвлэл мэдээллийн хариуцлага ба сэтгүүл зүйн хэм хэмжээ” үндэсний хэмжээний санал асуулга болон контент анализийн судалгаа. Улаанбаатар. 2011 он

оны нөхцөл байдлыг дараах хүснэгтэд нэгтгэн оруулав.²⁵⁵ Эндээс харахад, сүүлийн 10 жилийн хугацаанд хэвлэл мэдээлэлд олон нийтийн итгэх итгэл буурсан байна.

Хүснэгт 23. Хэвлэл мэдээлэлд итгэх олон нийтийн итгэл, 1998-2020

Иргэдийн хариулт	1998 он	2004 он	2011 он	2020 он
Бүрэн итгэдэг	6%	19.5%	20%	12%
Зарим үед эргэлздэг	70.5%	64%	65%	24.1%
Итгэдэггүй	16.5%	6.5%	5.5%	33.6%
Хэлж мэдэхгүй	7%	10%	9.5%	30.3%

Монгол Улсад 2021 оны 6 дугаар сарын байдлаар нийт 513 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол ажиллаж байна. Үүнээс сонин 78, сэтгүүл эмхэтгэл 69, радио 51, телевиз 137, мэдээллийн сайт 178 байгааг Хэвлэлийн хүрээлэнгийн “Монголын хэвлэл мэдээлэл-өнөөдөр” судалгаанд дурдсан байна.²⁵⁶ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон түүний агуулгад иргэдийн итгэх итгэл нь иргэдийн мэдээлэл авах эх сурвалжийн сонголттой холбоотой байж болох тул ямар эх сурвалжаас мэдээлэл авдаг талаар нас, хүйсийн хувьд ялгаатай нийт 7 иргэнээс 2021 оны 12 дугаар сард авсан бүлгийн ярилцлагын тоймыг дараах хүснэгтэд харуулав.²⁵⁷

Ярилцлага 1. Иргэдийн мэдээлэл авах эх сурвалжийн талаарх бүлгийн ярилцлагын тойм

Нас	Тойм
18-20 орчим насны иргэн	1/ Мэдээллийг ихэвчлэн интернэт болон Фэйсбүүкээс авдаг. Мөн баттай эх сурвалжаас мэдээлэл олж авахыг хичээдэг. Жишээ нь Ikon.mn сайтыг найдвартай гэж боддог. Мөн Монголын үндэсний телевизийн “Цагийн хүрд” үздэг.
	2/ Мэдээллийг фэйсбүүк, инстаграм гэх мэт нийгмийн сүлжээнээс хүлээн авдаг. Сонин дээрх мэдээллүүд илүү сайн эх сурвалжтай байдаг учраас тэндээс авдаг. Харин нийгмийн сүлжээний мэдээлэлд эх сурвалж байдаггүй учраас хуурамч талдаа байх магадлалтай гэж итгэдэггүй. Итгэл үнэмшлээ 10-аас үнэлбэл фэйсбүүк, инстаграмаар дамжуулсан мэдээ мэдээлэлд бараг итгэдэггүй 2-3 оноо өгнө. Харин мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл 10-аас 7-8 гэж дүгнэнэ.
20-25 орчим насны иргэн	3/ Мэдээллийг фэйсбүүк, сайтуудаас авдаг. Бид нарын мэдээлэл авах гол урсгал нийгмийн сүлжээ байдаг учраас тэнд түгээгдэж байгаа мэдээллийн сайтуудын мэдээллийг олж харах нь элбэг байдаг. Радио, телевиз ч юм уу тийм хэвлэл мэдээллийн хэрэгсэл үзээд байх боломж байдаггүй учраас өөрсдийн ашигладаг хэрэгслээр илүү их мэдээллийг авдаг. Хуурамч мэдээлэл маш их байдаг учир томоохон сайтуудаас мэдээлэл авахыг эрмэлздэг. Гэхдээ яг бүгдэд нь 100 хувь итгэдэггүй. 10-аас 7 гэж хэлмээр байна.
	4/ Одоо залуучууд телевиз, радио үздэггүй. Ikon, Gogo ч юм уу тийм сайтаас мэдээлэл авдаг. Энэ эх сурвалжийг тоогоор дүгнэвэл 10-аас 9 оноо өгнө.
40-50 орчим насны иргэн	5/ Хэвлэл мэдээллийн зарим цензуртай байгууллагад итгэдэг. Жишээлбэл “Засгийн газрын мэдээ”, “Өнөөдөр” сонинд итгэдэг. Телевизүүдээс МҮОНТ-ийн “Цагийн хүрд”, ТВ5 телевизийн “Цаг” хөтөлбөрүүдэд бүрэн итгэж үнэн зөв мэдээлэл авах дуртай. Бусад нийгмийн сүлжээний мэдээлэл бол хүн хүнээс дамждаг учраас итгэдэггүй.
	6/ Телевизээс хүлээн авдаг. Үүнд илүү их итгэдэг. “Монгол”, “Улаанбаатар”, “Ийгл” зэрэг телевиз үздэг. Үүнээс Ийгл үзэх дуртай. 10-аас 8 оноо өгнө.
50-60 насны иргэн	7/ Би насаараа судалгааны байгууллагад ажилласан хүн болохоор байнга мэдээллийг энд тэндээс хайх, судлах шаардлагатай байдаг. Сүүлийн үед Монголын үндэсний радио, телевиз, сониноос “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” зэрэг сониныг захиалж уншдаг. Сайтад тийм ч итгэлтэй байдаггүй. Зарим тохиолдолд мэдээллийг их гуйвуулан хүргэдэг юм шиг санагддаг. Ялангуяа намуудын нөлөөлөл орсон мэдээ шиг харагддаг. Нийт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг 10-аас 6 гэж дүгнэнэ.

²⁵⁵ Үндэсний статистикийн хороо. “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2017-2020 оны үр дүн. Улаанбаатар. 2021 он. 5 дахь тал

²⁵⁶ Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл - өнөөдөр”. Улаанбаатар. 2021 он. 4 дэх тал

²⁵⁷ Тус судалгааны багийн авсан асуулга. 2021.12

Эндээс харахад, дээрх 7 иргэний 5 нь одоогийн хэвлэл мэдээлэлд итгэх байдлыг оноогоор дүгнэсэн байх бөгөөд 10 хүртэлх онооноос дунджаар 7.6 оноогоор дүгнэсэн байна. Түүнчлэн, насны бүлгээс үл хамааран редакцтай хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илүү итгэдэг болохыг дээрх ярилцлагын тоймоос харж болохоор байна.

2.4.2. Шог зураачид үзэн ядах хөдөлгөөнд өртдөг эсвэл өөрийн цензурт автахад хүрдэг эсэх

Дээрх асуумжийн хүрээнд уран бүтээлээ ид туурвиж байгаа, олон нийтийн дунд танил болсон 4 шог зураачаас бүлгийн ярилцлагын аргаар судалгаа авлаа. Ингэхдээ 3 эрэгтэй, нэг эмэгтэй 30-50 насны төлөөллийг сонгов. Шог зураачдын хувьд Монгол Улсад уран бүтээл туурвих, олон нийтэд түгээх эрх чөлөөтэй гэж үзэж байна. Тэд уран бүтээлийн сэдвээ нийгмийн өдөр тутмын амьдрал, төр засгийн гаргаж буй шийдвэр, цаг үеийн шинжтэй үйл явдлаас сэдэвлэн туурвидаг. Тэдний уран бүтээлд аливаа нам, эсвэл, байгууллага, хуулийн этгээд, хувь хүнээс дарамт, шахалт, ялгаварлан гадуурхах хандлага гардаггүй гэв.²⁵⁸ Гэхдээ бүтээлээ нийтлэх, үзэсгэлэнд гаргах зэрэгт тодорхой хэмжээнд өөрийн цензурт автахад хүрдэг гэж үзэж болохоор байна.

Ярилцлага 2. Шог зураачид үзэн ядах хөдөлгөөнд өртдөг эсвэл өөрийн цензурт автахад хүрдэг эсэх талаарх ярилцлагын тойм

Шог зураач С.Цогтбаяр

- *Таны уран бүтээлийг энэ тэндээс хорих тохиолдол гарч байв уу? Жишээлбэл, энэ зураг чинь болохгүй байна, нийгмийн эсрэг дуугараад байна гэдэг ч юм уу. Цензурт автах тохиолдол гарч байсан уу?*

Би өөрөө мэргэжлийн уран бүтээлч гэдэг юм уу, хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил ажилласан. 1982 оноос хойш гэхээр чинь 40 орчим жил намын төв хэвлэлээс авахуулаад ажиллаж байна. Тийм болохоор магадгүй би ёс зүйгээ барьж чаддаг байх. Хүн доромжлох ч юм уу, эсхүл ямар нэг хуулиар хориотой зүйлд бусдыг уриалах ч юм уу, садар самуун, үймээн самуун, фашизм гэх мэт зүйлийг сурталчилсан юм хийдэггүй. Мэдээж бүтэхгүй байгааг шүүмжилнэ. Магадгүй тэр зургууд нь үнэн байдаг болоод ч тэр үү заргалдах хүн одоогоор гараагүй л байна. Би өөрийн хүссэн үзэл бодол, өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө байна.

- *Хэн нэгнийг шоглож зурсны дараа арай хэтрүүлчихлээ гэж бодоод больж байсан үе бий юу?*

Тийм тохиолдол бий шүү. Байлгүй яахав. Ганц хоёроор дутахгүй зураг байдаг. Энэ бас арай ч доромж өнгө аястай, арай онцгүй, муухай болчихлоо больё гээд хойш нь тавьсан зургууд байдаг.

- *Энэ тэндээс тавьсан хаалт, хориггүйгээр өөрөө шийдээд больсон гэсэн үг үү?*

Тэгэлгүй яахав. Би өөрөө бодоод шийддэг. Мэргэжлийн уран бүтээлчийн ёс зүй, хандлага байх ёстой л доо. Би шүүмжилж болох ч доромжилж болохгүй л байхгүй юу.

- *Улс төрчдөөс танд ямар нэг байдлаар зориудаар зураг зуруулах захиалга, санал өгч байв уу?*

Зориудаар биш л дээ. Жишээлбэл, миний үзэл бодолтой нэгдэж нийлсэн зүйл байвал хийж болно шүү дээ. Тухайлбал, Ардчилсан нам миний үзэл бодолтой их нийлдэг л дээ. Өөрөөр хэлбэл, би Ардчилсан нам гэдэг, ардчилал гэдэг үг ордог нам гэж тооцдоггүй юм. Хүн төрөлхтөний үнэт зүйл, ардчилал гэдэг зарчимд хамгийн ойр байгаа үзэл бодол, хандлагатай нь Ардчилсан нам л даа. Яахав энэ чиглэлийн намууд бол байсан. “Ардчилал” сонинд сонгуулийн жил болгонд дэмжээд зурагт хуудас хийгээд дэмждэг байсан. Энэ хүн маань сонгуульд ялаасай, хууль тогтоогч болоосой гэсэн хүмүүсээ дэмжих зүйл байсан. Харин тэр захиалга гэдэг чинь юу гэхээр би буруу гэдгийг нь мэдэж байгаа мөртлөө ямар нэг ашиг орлого, мөнгөний төлөө тэрийг хийж байвал тэр маш буруу.

²⁵⁸ Тус судалгааны багийн авсан асуулга. 2021.12

- Таны хувьд бүтээлээрээ дамжуулаад нийгэмд болохгүй байгаа зүйлийг шүүмжилдэг. Гэтэл эсрэгээрээ нийгмийн зүгээс ч юм уу, цахим орчинд таныг өөрийг тань шүүмжилж, доромжлох хандлага гардаг уу? Ерөнхийдөө зарим хүмүүстэй харьцуулахад гайгүй шүү. Ингээд хараад байхад манай Баабар энэ тэр бол маш их дайсантай. Элдэв муухайгаар нь хэлнэ. Царай зүсээр нь гоочилно, хужаагаар нь дуудна, доромжилно. Намайг бас эрлийз, хужаа гэж доромжилно. Тэд нар голдуу тролл ч юм уу, зохион байгуулалттайгаар нийгмийн сэтгэл зүйг хордуулж байгаа тэр хэсгийн л явуулж байгаа явуулга гэж боддог. - Таны аль нэг шог зурагнаас болоод таныг болоод таны гэр бүлийнхнийг гадуурхах, дарамтлах хандлага гарч байв уу? Одоохондоо тийм юм алга. Байхгүй гэж хэлнэ. Өмнө нь хэлсэнчлэн энэ үйл явдлын өрнөл энэ чигээрээ удаан үргэлжилбэл тийм зүйл ирэх нь гарцаагүй. Үг хэлэх эрх чөлөөг хааж боож, цензурдаж эхэлж байна шүү дээ. Эхлэлүүд нь элдэв торгууль, Зөрчлийн хууль гэх зэргээр илрээд байна. - Таны бодлоор хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үг хэлэх хэвлэн нийтлэх эрх чөлөө манай улсад ямар түвшинд байна вэ? Манайд харьцангуй гайгүй шүү. Харьцангуй гэж хэлнэ. Яахав үг хэлэх эрх чөлөө ч юм уу, эрх чөлөөний өгөгдөл ч юм уу, янз бүрийн судалгаагаар газрын зураг шиг гаргасан зүйлс их байдаг л даа. “Эрх чөлөөний индекс” гэдэг ч юм уу гүүглээр хайхаар ердөө Төв Азийн өндөрлөг газар, тэгш өндөрлөг дээр байгаа энэ олон улс орнууд дунд ганцхан өнгө ялгарч байдаг нь Монгол Улс байдаг. Орос байхгүй, Хятад байхгүй, Зүүн өмнөд Азийн зарим улс байхгүй, Арабын орнуудад бүр байхгүй, Африк бол бүр ч байхгүй. Энэ чигээрээ Еврази бол байхгүй. Мэдээж Европын ихэнх улс, урагшаа бол Өмнөд Солонгос, Япон байна. Тэгээд Австрали манайхтай адилхан өнгөтэй байдаг. Тийм учраас энэ хэсэгт байгаа манайх бол эрх чөлөөний баян бүрд байгаа юм. Энэ баян бүрд чинь өөрөө үгүй болох ч юм уу, хатмал цөл болох аюул бол байгаа. Гадна, дотнын нөлөөллүүд маш их байна. Монголын энэ өнгийг орчин тойронтой нь адилхан болгох гэсэн бодлого байна гэж хардаг. Энэ өнгө байна гэдэг нь тэр геополитикт аюултай том саад болоод байна л даа.
Шог зураач Ч.Цэцэгдарь - Таны уран бүтээлийг энэ тэндээс хорих тохиолдол гарч байв уу? Жишээлбэл, энэ зураг чинь болохгүй байна, нийгмийн эсрэг дуугараад байна гэдэг ч юм уу. Цензурт автах тохиолдол гарч байсан уу? Яг одоогоор бол байхгүй. Саяхан Төрийн ордонд шог зургийн үзэсгэлэн гарна гэж байсан юм. Тэгэхээр нь би УИХ-ын гишүүдэд зориулсан байсан шог зургуудаа больчихсон л доо. Тэр зургуудаа дэлгээгүй. УИХ-ын зарим шийдвэр, үйл ажиллагаанд бид шүүмжлэлтэй ханддаг. Тэрийгээ аж байдлын зургаар зурсан байснаа дэлгээгүй л дээ. - Та өмнө нь өөрийн цензурээр дэлгээгүй зураг байдаг гэлээ. Улс төрчдөөс ч юм уу аль нэг байгууллагаас хориг саад, битгий гаргаач гэдэг гуйлт ирж байв уу? Миний хувьд байхгүй. Яагаад гэвэл би шог зураачид дундаа залуу. Дөнгөж гарч ирж байгаа. Манай шог зураачдын дийлэнх нь ахмад хүмүүс байдаг. Тэр хүмүүсийн үед бол хорих, цензурдах асуудал байдаг байсан. - Улс төрчдөөс танд ямар нэг байдлаар зориудаар зураг зуруулах захиалга, санал өгч байв уу? Сонгуулийн үеэр иймэрхүү саналууд шог зураачдад ирдэг. Эсрэг намын хар пр ч юм уу, намын фактуудыг зуруулах захиалга ирдэг л дээ. Гэхдээ тийм зураг зурдаггүй. - Таны аль нэг шог зурагнаас болоод таныг болоод таны гэр бүлийнхнийг гадуурхах, дарамтлах хандлага гарч байв уу? Ёстой гарч байгаагүй. Манай зураачид маш эрх чөлөөтэй ажилладаг. Аль нэг намд ч юм уу захиалгаар зурахгүй л дээ. Захиалгаар зурна гэдэг чинь бидний өөрсдийн зарчим, үнэт зүйлд харшилна.
Шог зураач М.Моломжамц - Шог зураачид үзэн ядах хөдөлгөөнд нэгддэг, эсхүл өөрийн цензурт автахад хүрдэг үү? Өмнө нь та ямар нэгэн цензурт автаж байсан уу?

Автаж байсан тохиолдол бий шүү. Ер нь шог зураг зурна гэдэг чинь нэлээн дургүйцсэн, түүнийгээ илэрхийлж зурж байгаа зүйл шүү дээ. Зүгээр инээж байгаад шог зураг зурна гэж байхгүй л дээ. Болохгүй байгаа, нийгмийн буруу зөрүү зүйл, алдаа оноо, дутагдалтай талыг засахын тулд ард түмний дуу хоолой болж л явдаг урлаг шүү дээ. Мэдээж байнга үзэн ядалт явагдаад байна гэж юу байхав. Нийгмийн давлагаа хаашаа явж байна гэдгийг ажиглана.

- Таны уран бүтээлийг энэ тэндээс хорих тохиолдол гарч байв уу? Жишээлбэл, энэ зураг чинь болохгүй байна, нийгмийн эсрэг дуугараад байна гэдэг ч юм уу. Цэнзурт автах тохиолдол гарч байсан уу?

Үгүй шүү. Ардчилсан маягтай болчихсон байгаа одоогийн манай нийгэмд миний бүтээлийг болохгүй байна, чи ийм зураг зурлаа, наашаа ирж уулз барь гэсэн асуудал гардаггүй.

- Улс төрчдөөс танд ямар нэг байдлаар зориудаар зураг зуруулах захиалга, санал өгч байв уу?

Үгүй. Манай шог зураачдын дунд нэг уриа байдаг. Юу гэхээр шог зураач байхын тулд шударга бай гэдэг зарчим бидэнд байдаг. Шог зураач шударга биш, аль нэг нам, хүчинд үйлчлээд, захиалгаар зураад ирвэл тэр шог зураач биш болно л доо.

- Улс төрчдөөс танд ямар нэг байдлаар зориудаар зураг зуруулах захиалга, санал өгч байв уу?

Би өөрөө нам бус. Тийм захиалга, санал авч байгаагүй. Хараат бусаар ажилладаг.

Шог зураач, нийтлэлч Ч.Оргил

- Та хэн нэгнийг шоглож зурлаа гэж бодоход арай хэтрүүлчихлээ гэж бодоод олон нийтэд дэлгэхээс татгалзаж байсан уу?

Тийм. “Алтан босго” гэж ярьсан хоёр загвар өмсөгчийг зурснаас болж нэг нь их уурлаж зургаа устгахыг хүсэж байсан. Би эмэгтэй хүнийх нь хувьд хүндлээд нийтлэлээ эргүүлж авч байсан.

- Таны уран бүтээлтэй холбоотойгоор нийгмийн зүгээс, цахим орчинд шүүмжлэх, доромжлох хандлага гарч байсан уу? Тийм бол ямар үйлдлүүд илэрч байсан бэ?

Маш цөөн тохиолдолд гарч байсан. Байсан ч би нээх тоодоггүй. Үнэнг зурдаг болохоор хэн түүнийг доромжлох билээ дээ.

- Таны бодлоор Монгол Улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэн нийтлэх, үгээ хэлэх эрх чөлөө ямар түвшинд байна ?

Хангалттай сайн. Би хүссэн цагтаа фэйсбүүк ашиглан нийтлэлээ олон нийтэд хүргэдэг.

2.4.3. Сэтгүүл зүйн үйл ажиллагааг үндэстэн, нийгмийн гарал үүсэл, шашин шүтлэг, жендэр буюу хүйс, бэлгийн чиг баримжаа, хэлний шалгуур дээр үндэслэн хориглох эсвэл саад хийдэг эсэх

Сэтгүүлзүйн салбарт ажиллахад хуулийн хязгаарлалт байхгүй. Монголын хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй хүмүүсийн тал орчим хувь нь сэтгүүлч мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн байдаг. Гэхдээ сэтгүүлчээр ажиллах хүсэлтэй хүмүүст заавал мэргэжил эзэмших, аль нэг байгууллагын зөвшөөрөл авах зэрэг шаардлага байдаггүй бөгөөд тийм хууль журам ч байдаггүй. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ажилтнууддаа нийгмийн гарал үүсэл, үндэс угсаа, нийгмийн бүлэг, хүйс, үзэл бодол, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, наснаас үл хамааран тэгш боломжийг олгодог.²⁵⁹ Үндэстний цөөнх, шашин шүтлэг зэрэг нийгмийн олон талт байдлын нарийвчилсан үзүүлэлтээр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын дунд хийсэн судалгаа, мэдээлэл өнөөдөр хараахан байхгүй.²⁶⁰

²⁵⁹ Фридрих-Эбэртийн сан. “Азийн хэвлэл мэдээллийн барометр – Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”. Улаанбаатар. 2012 он. 23 болон 64 дэх тал <https://library.fes.de/pdf-files/bueros/asia-media/10292.pdf>

²⁶⁰ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он. 73 дахь тал <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245364>

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд дурдсанаар, 2020 оны байдлын мэдээллээр улсын хэмжээнд 410 сүм хийд үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Христийн 222, Буддын 150, Исламын 27, бусад 11 сүм хийд байна.²⁶¹ Дээрх шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сүм хийдээс хамааралтайгаар үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай албан бус мэдээллээр бол, Монголын бурханы шашинтны төв Гандантэгчинлэн хийдийн дэргэдэх “Лавайн эгшиг” радио, буддын шашныханд зориулсан арилжааны ТВ9 телевиз, Христийн шашны сургаалийг дамжуулдаг “Гэр бүлийн радио” 104.5, “Итгэл” радио болон Chuulgan.org христ итгэлийн цахим сан буюу сайт тус тус ажиллаж байна. Үндэстний цөөнх болон шашны чиглэлээр ажилладаг байгууллагын төлөөллөөс буюу Баян-Өлгий аймгийн сэтгүүлч, улс төр судлаачаас болон христийн шашинтай хамааралтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг “Гэр бүлийн радио” 104.5-ийн удирдлагын төлөөллөөс асуумжийн аргаар мэдээлэл цуглууллаа. Харин жендэр буюу бэлгийн чиг баримжааны төлөөллийн байр суурийг сонсохыг эрмэлзэн ЛГБТ төвд хандсан боловч албан ёсны бүртгэлтэй ЛГБТ сэтгүүлч байхгүй гэсэн хариултыг өгсөн болно.

Ярилцлага 3. Сэтгүүл зүйн үйл ажиллагааг үндэс, угсаа, шашин шүтлэг, хүйсийн шалгуур дээр үндэслэн хориглох, түүнд саад хийдэг эсэх талаарх ярилцлагын тойм

Ч.Сайнбаяр: “Гэр бүлийн радио” 104.5-д 9 дэх жилдээ ажиллаж байгаа христ итгэлтэй сэтгүүлч. Тус байгууллагад ажиллах болсон шалтгаан нь уран бүтээл хийхэд дэмждэг, өөрийн гэсэн алсын хараа зорилготой, хараат бусаар ажилладаг. Мөн байгууллагын талаарх олон нийтийн ойлголт хандлагаас шалтгаалан зарим тохиолдолд ярилцлага өгөх, зочноор оролцохоос татгалзах үйлдлүүд байдаг. Нийгмийн бүх чиг хандлагад нийцүүлэн ажиллахад зарим тохиолдолд хүндрэл учирдаг. Тодруулбал, соёлын хөндүүр сэдвүүдийн талаарх чөлөөтэй контент хийх боломжгүй.

Н.Ахмарал: Чөлөөт сэтгүүлчээр ажилладаг. Сэтгүүл зүйн салбарт 5 дахь жилдээ ажиллаж байна. Ажиллаж байх хугацаандаа дээрх асуумжийн хүрээнд буюу өөрийн шашин шүтлэг, жендэр, яс үндэс, нийгмийн гарал байдлаас болж ялгаварлан гадуурхалтад өртөн, сэтгүүл зүйн бүтээлээ хийлгүйгээр орхиж байсан. Тухайлбал, хоёр төрлийн асуудалтай тулгарч байв. 1. 2017 онд нэгэн улс төрийн өндөр албан тушаалтнаас яриа авах болж очиж байлаа. Эхлээд нэлээн ярилцах сэдвийнхээ талаар ярьж байгаад миний нэрийг асууснаа “ийм чухал асуудлаар казах сэтгүүлч явуулж байгаа юм уу” гэж манай эрхлэгчийн нэрийг хэлж байсан. Тухайн үедээ нэр сонсоод үнэлэмж нь буурах шиг л болсон. Тэгээд “надад уншуулж байж гаргаарай. Чи буруу зөрүү ойлгогдохоор бичсэн байвал нийтлүүлэхгүй шүү” гэж араас нь бас хэлж байв. Ингээд ярилцлага маань сайн болсны дараа автортайгаар сонин дээр тэр ярилцлага тавигдаж байсан юм. Казах сэтгүүлчээр ажиллаж эхлээд удаагүй гэдэг утгаараа юу, өөр хандлагад автаж байсан.

2. 2019 онд Барилга, хот байгуулалтын яаманд хэвлэл мэдээллийн ажилтнаар очихоор болж тухайн үеийн дэд сайдтай нь уулзалт хийж байлаа. Намайг казах гэдгийг мэдэж байсан. Тэр утгаараа ч тэр үү, “за архи хэр их ууж чадах уу, хэр их эрэгтэй танил талтай вэ, дарга ах нарын учрыг олж чадах уу, чи их жаахан биетэй ч юм, залуухан ч юм, хүн амьтныг нааш цаашаа зохицуулж чадах уу” гэж өрөөндөө дуудаад асууж байсан юм байна. Яг ялгаварлан гадуурхалт бол биш, гэхдээ залуу, тэгээд гадаад харагдах байдлаар нь үл хүндэтгэсэн байдалтай харьцаж байгаа нь илт мэдэгдэж байсан. Мөн өөрийн үзэл бодлоо нийгмийн цахим сүлжээнд илэрхийлснийхээ төлөө хувь чатаар доромжлуулах тохиолдол багагүй гарч байсан. Дээрх тохиолдлуудаас шалтгаалан ямар нэгэн бүтээл хийхдээ өөрийн цензурт автах хандлагатай болсон.

Эндээс харахад, сэтгүүл зүйн үйл ажиллагааг үндэс, угсаа, шашин шүтлэг, хүйсийн шалгуур дээр үндэслэн хориглохгүй хэдий ч шууд бус байдлаар саад хийдэг байдал ажиглагдаж байна.

2.4.4. Хүн амын олон ургалч үзэл бодол хэвлэл мэдээлэлд тусгагддаг эсэх

²⁶¹ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Сүм хийд 2020 https://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_3

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 2-т “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.” гэж заасан.²⁶²

Улсын Их Хурлаас 2005.01.27-ны өдөр баталж, 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 8.1-т “Олон нийтийн радио, телевиз улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг техникийн болон мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж нийтийн хүртээл болгоно.”, 8.2.2-т олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ “улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургалч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх”, 8.2.7-д “үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх” бодлого баримтална гэж заасан.

2011 онд МҮОНТ-ийн 8 хоногийн эфирийн нийт цагийн дунджаар 1.6%-ийг нийгмийн цөөнхөд, үүнээс үндэстэн, ястанд 0.2%, шашны бүлэгт 0.6%, хэлний бүлэгт 0.9%-ийг, малчид, тариаланчдад 0.4%, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 0%, орон нутгийн иргэдэд 0.2%-ийг тус тус зориулж байжээ. 2011 онд МҮОНТ-ийн мэдээллийн хөтөлбөрийн ердөө 17.4 хувийг хөдөө орон нутгийн тухай, тэнд өрнөж буй аж амьдрал, ахуйн асуудлыг хөндсөн мэдээлэл эзэлж байв.²⁶³

2013 оны 8 дугаар сард телевиз үзэгч 1198 иргэнээс санамсаргүй, олон шатат түүврийн аргаар асуулга авч, телевизүүдийн шүүмжлэлтэй талыг орон нутгийн иргэдээс тодруулахад 38.2% нь “боломжийн байгаа” гэж хариулжээ. Орон нутгийн иргэдэд хамгийн хэрэгцээтэй байгаа мэдээллийг тодруулахад судалгаанд оролцогчдын 31.7 хувь нь мэдээ, мэдээлэл гэж хариулсан нь орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдээлэл дутмаг байсныг илтгэж байгаа бөгөөд үүнийг телевизүүд хэт үйл явдлын араас хөөцөлдсөн, улс төрийн болон сенсацийн шинж чанартай мэдээлэлд ач холбогдол өгч байгаатай холбон тайлбарлаж болох талтай.²⁶⁴

Монгол Улсад 2017 онд хийсэн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны тайлангаас үзэхэд мэдээллийн хоёр сайтын эх сурвалжуудын 77% нь эрэгтэй, 23% нь эмэгтэй, өдөр тутмын сонины эх сурвалжуудын 26%, телевизүүдийн 29%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлж, зөвхөн МҮОНР болон “Гэр бүлийн радио”-гийн агуулга дахь эх сурвалжуудын 48% нь эмэгтэйчүүд байна. Мөн эрэгтэйчүүдийг ихэвчлэн ажил хэрэгч, албан тушаалтан, улстөрч дүрээр, харин эмэгтэйчүүдийг албаны бус зургаар, энгийн иргэн, ээж, гэргий, эсвэл мэргэжилтнээр илүүтэй дүрсэлдгийг уг судалгаанд онцолсон байна. Улсын Их Хурлын 2016 оны сонгуульд нэр дэвшигчдийн 25% нь эмэгтэйчүүд байсан бол сонгуулийн сурталчилгааны үеийн нийт контентын 14% нь л эмэгтэй нэр дэвшигчдийг дурджээ.²⁶⁵

²⁶² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт <https://old.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

²⁶³ Хэвлэлийн хүрээлэн, Нээлттэй нийгэм форум. “МҮОНТ-ийн шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ, нэвтрүүлгийн агуулгын мониторинг-3” судалгааны тайлан. Улаанбаатар. 2011 он. 26, 32 дахь тал. https://forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=928&menu_id=3&resmenu_id=59

²⁶⁴ Харилцаа холбооны зохицуулах хороо. Орон нутгийн үзэгчдийн телевиз үзэлтийн судалгаа. Улаанбаатар. 2013. <https://crc.gov.mn/k/2FX/6A>

²⁶⁵ Жендэрийн үндэсний хороо. “Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй” редакцияд зориулсан удирдамж. Улаанбаатар. 2021 он. 14 дэх тал

Хэвлэлийн хүрээлэн. “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцийн бодлого, сэтгүүлзүйн практик” санал асуулга, контент анализын судалгааны тайлан. Улаанбаатар. 2017 он

Нийгмийн олон янзын бүлгийн сонирхолд нийцсэн олон төрлийн мэдээлэл цацагдаж буй мэт харагдавч, нийгмийн бүх бүлгүүдийн эрх тэгш төлөөллийг хамруулахгүй байна. Гол хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болох өдөр тутмын сонинууд, телевизийн цаг үеийн мэдээллийн хөтөлбөрүүд улс төрч, эрх мэдэлтэн, албан тушаалтнуудын үзэл бодлыг гаргах нь маш түгээмэл. Сонин, телевизийн аль алинд нэг талын эх сурвалжаас авсан мэдээлэл давамгайлдаг, тэрхүү эх сурвалж нь ихэвчлэн сайд, дарга, сонирхлын бүлгүүд байх нь олон Өөрөөр хэлбэл, гол мэдээллийн хэрэгслүүд нийгмийн эмзэг бүлгийнхэн, энгийн иргэдийн дуу хоолойг бүрэн дүүрэн, өргөн хүрээнд илэрхийлж чадахгүй байна.²⁶⁶

Орчин үеийн хүйн хэвлэл мэдээллийн хөдөлгөөн анх 1940-өөд онд үүссэн түүхтэй. Тэгэхэд Болив улс дахь цагаан тугалганы уурхайчдад зориулсан хүйн радио, Колумби улсын католик сүмийн боловсролын радио, АНУ-д арилжааны бус богино долгионы (FM) радио байгуулагджээ. Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд нутгийн иргэдэд зориулсан, алдартай, ардын радиогийн тоо Америк тив даяар асар ихээр нэмэгджээ. Эдгээрт албан боловсролын бүтэц болон түүнд багтдаггүй боловсролын радио станцууд, нутгийн хэл, уламжлалд анхаарлаа төвлөрүүлдэг уугуул иргэдийн радио станцууд, нийгмийн хөдөлгөөний байгууллага, эмэгтэйчүүдийн бүлэг, сүм, үйлдвэрчний эвлэлийн ажиллуулдаг радио станцууд багтана. Европ тивд хүйн хэвлэл мэдээлэл нь саяхнаас түлхүү хөгжих болжээ. Хүйн сонин хэвлэл нь урт түүхтэй, харин хамгийн анхны электрон хүйн хэвлэл мэдээллийг оюутны радио гэж болно. “Student” радио 1967 онд Словени улсад анх өргөн нэвтрүүлгээ цацаж эхэлжээ. 1977 онд Италид Дээд шүүх нь төрийн монополийг хууль бус гэж тогтоосны дараа агаарын долгион нээлттэй болсон байна. Дараа нь 1983 онд Франц улс үүнийг дагаснаар, Баруун Европын дийлэнх улс хүйн өргөн нэвтрүүлгийн нарийвчилсан зохицуулалттай болжээ. Зүүн Европт 1990-ээд онд улс төрийн өөрчлөлт гарсан хэдий ч иргэний нийгэм нь радио долгионыг жинтэй ашигладаг улс орны тоо цөөн хэвээр байгаа юм. Эхэн үедээ Европт хүйн өргөн нэвтрүүлгийн хөдөлгөөний үүсэл нь богино долгионы радио эрхлэхэд тусгай зөвшөөрөл эзэмших шаардлагагүй байсантай холбоотой бөгөөд зохицуулалтын хүрээ хожим нь бий болжээ. Өнөөдөр шинэ хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд интернет чухал талбар болж байна. Африк тивд гэвэл 1990-ээд оны эхэн хүртэл колоничлолын хэв маяг хадгалагдан, төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн монополь байдал хэвийн байхын зэрэгцээ сонин хэвлэлийн тоо ширхэг хязгаарлагдмал, хотын боловсролтой элит бүлгүүдэд зориулагддаг байв.²⁶⁷

Хүйн хэвлэл мэдээлэл нь олон ургалч хэвлэл мэдээллийн аливаа орчны гол бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь олон нийтийн болон арилжааны хэвлэл мэдээллээс ялгарах хэрэгслийн хувьд иргэдийн оролцоонд чухал орон зайг эзэлнэ. Дэлхий даяар хүйн хэвлэл мэдээлэл л иргэдийн оролцоог амьд болгодог. Хүйн хэвлэл мэдээлэл нь хараат бус, нийгмийн ашиг тусын төлөө ашиг үл горилон үйл ажиллагаа явуулдаг, иргэний нийгэмд суурилдаг. Эдгээр нь нийгмийн хөдөлгөөн, хүйн холбоо бүхий ард иргэдэд суурилсан байгууллагуудын хувьд тэдний өмнө тулгарсан асуудал, санаа зовниж буй зүйл, соёл, хэлний илэрхийлэл болон дэлхийн бүхий л бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг. Хүйн хэвлэл мэдээлэл нь байнга засгийн газрын хяналтад байдаг үндэсний, олон нийтийн өргөн нэвтрүүлэг, мөн хувийн, арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгсэл аль алинд нь альтернатив байхаар байгуулагддаг. Тэдгээр нь нутгийн ард иргэдийн дуу хоолой болж, тэдний мэдээлэлтэй байх бололцоог хүртээмжтэй болгож, хүй олны түвшинд хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдээлэл мэдлэгээ

Хэвлэлийн Хүрээлэн. Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг. Улаанбаатар. 2016 он

²⁶⁶ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он. 72 дахь тал

²⁶⁷ НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Бээжин дэх Төлөөлөгчийн газар. “Хүйн хэвлэл мэдээлэл: сайн туршлагын гарын авлага”. 2013 он. 5, 6 дахь тал. Монгол хэлнээ хөрвүүлсэн Т.Аюушжав Д.Мөнхбүрэн, нягтлан шүүсэн Х.Наранжаргал.

хуваалцаж, нийтэд хамаатай шийдвэр гаргахад хувь нэмэр оруулдаг. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн туйлын шаардлага нь улс төрийн өргөн хүрээний өөрчлөлт, ялангуяа ардчиллыг гүнзгийрүүлэх, иргэний нийгмийг бэхжүүлэхтэй байнга холбогдоно. Хүйн хэвлэл мэдээлэл нь ядуу, шоовдорлогдсон иргэдийн дуу хоолойг хүргэх, тэднийг хүчирхэгжүүлснээр хөгжлийн зорилгоо илүү үр дүнтэй биелүүлэхэд чухал хэрэгсэл болох нь хүлээн зөвшөөрөгдсөн юм. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй газруудад тэдгээр нь олон нийтийн оролцоог хөхиүлэн дэмжих, соёл, хэлний олон талт байдлыг бэхжүүлэх, ядуу, эмзэг бусад бүлгүүдийн дуу хоолойг хүргэхэд онцгой хийгээд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсад хүйн хэвлэл мэдээллийг дэмжсэн төрийн бодлого, эрх зүйн дэмжлэг байхгүй бөгөөд Засгийн газраас ч энэ чиглэлд таатай орчин бүрдүүлэх, тэдэнд санхүүгийн болоод бусад төрлийн туслалцаа үзүүлэх талаар анхаардаггүй, хүйн хэвлэл мэдээлэлд нөөцөлсөн зурвас долгион байхгүй. Орон нутгийн болон хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих төрийн тусгай сан, санхүүгийн нөөц байдаггүй. Харилцаа холбооны зохицуулах хорооны журмаар үүнийг зохицуулаагүйгээс арилжааны радио, телевиз байгуулахад шаардлагатай техникийн үзүүлэлт, мэргэжлийн боловсон хүчин, нэг өдрийн нэвтрүүлгийн хамгийн доод хугацаа, орлого зэрэг өндөр шаардлагууд хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд адилхан тавигддаг нь хүйн хэвлэл мэдээлэлд хүндээр тусдаг. Засгийн газар энэ төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагын талаар ойлголт дутмаг байдгаас хүйн хэвлэл мэдээллийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх боломж өнөө хэр нь хомс байна.

Эдгээр саад бэрхшээлийг үл харгалзан, хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглоогүй учраас ихэнх тохиолдолд олон улсын донор байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах оролдлого хийгдсээр байна. Сүүлийн арван жилийн хугацаанд, хүйн хэвлэл мэдээллийн анхдагч нар хөдөөд нутгийн радио нэрийн дор төрийн бус байгууллагын дэмжлэгээр байгуулагдсан. Тухайлбал, “Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо” ТББ-ын дэргэдэх Бэст FM98.5 радио, Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Говийн долгион” FM радио, ЮНЕСКО болон Хэвлэлийн хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр Өвөрхангай аймагт байгуулагдсан “Ноён уул” радио зэргийг дурдаж болно. Харилцаа холбооны зохицуулах хорооноос радиод тусгай зөвшөөрөл олгохдоо ашгийн бус олон нийтийн үйл ажиллагаа явуулна гэдэг утгаар нь Гандангийн радио, Авто радио, Хийдийн радио, мөн дээр дурдсан Хараагүйчүүдийн нийгэмлэгийн радио зэрэг 4 радиод тусгай зөвшөөрлийг давамгайл эрх өгч тендергүйгээр шууд олгосон. Харин телевизийн хувьд “Боловсрол суваг” анх телевизийн зөвшөөрөл авахдаа ашгийн бус, төсвөөс санхүүжиж, боловсролын нэвтрүүлэг явуулна хэмээн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны хүсэлтээр тендергүйгээр тусгай зөвшөөрөл авсан. ТВ9 телевиз мөн ашгийн бус, шашны суваг нэрийн дор зөвшөөрөл авчээ. Хожим дээрх хоёр суваг аль аль нь арилжааны хэлбэртэй болсон. Харин 2012 онд “хүйн хэвлэл мэдээлэл” гэсэн нэрээр анхны 10 радио станцыг НҮБ-ын Хүний аюулгүй байдлыг хангах итгэлцлийн сангийн хүрээнд Япон улсын санхүүжилтээр ЮНЕСКО-гийн төслөөс үндэстний цөөнх оршин суудаг Баян-Өлгий, Увс, Ховд, Хөвсгөл аймагт байгуулсан байна. Удирдах зөвлөл, захирал, найруулагч, сайн дурынхнаас бүрдсэн эдгээр радио станцууд нэвтрүүлгээ цөөнхийн бүлгийн хэл дээр бэлтгэж, нутгийн ард иргэдтэй ойртон ажилладаг. Ихэнх хүйн радио орон нутгийн энгийн радиотой нэгэн ижил тусгай зөвшөөрөлтэй байдгаас гадна дийлэнх нь ямар нэг ТББ-ын нэрээр бүртгүүлж Монгол Улсад одоо мөрдөж буй ТББ-ын хуулийн дагуу ажилладаг. Ийм холимог систем байгаагийн гол шалтгаан нь хүйн гэх тодотголтой аливаа санаачилгад зориулан тусгай зөвшөөрөл олгох эрх зүйн үндэс байхгүй юм. Хүйн радио нь ТББ-ын бүртгэлтэй учир ашгийн төлөө бус тул орлого олох боломж хязгаарлагдмал. Олсон орлогоороо эргэн хөрөнгө оруулалт хийхийг ашгийн бус загвар гэж хүлээн зөвшөөрдөггүй. Энэ нь Монголд хүйн хэвлэл мэдээлэл өргөжин хөгжихөд саад бэрхшээл учруулдаг. Хэвлэл мэдээллийн олон байгууллагууд хүйн хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин бүрдүүлэхийн

төлөө нөлөөллийн ажил хийдэг. 2012-2013 оны турш хүйн хэвлэл мэдээллийн төлөөх хөдөлгөөн ид хүчээ авч, Монголын хүйн радиогийн холбоог Глоб интернэшнл төв, ЮНЕСКО, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтарсан дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулсан. 2013 оны эхний улиралд тус холбооноос хүйн радиогийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын санал санаачилга өрнүүлж, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлахаар яригдаж байгаатай холбогдуулан төв болон орон нутгийн засаг захиргааны шийдвэр гаргах түвшний хүмүүс, олон нийтийн дунд нөлөөллийн сургалт семинар хэд хэдэн удаа зохион байгуулсан.²⁶⁸

2012 онд “Хүйн радиогийн тогтвортой байдлыг дэмжих” төслийг хэрэгжүүлсэн бөгөөд Глоб интернэшнл төв нь МҮОНР, Радио, телевизийн сүлжээний газартай хамтран Ховд, Баян Өлгий, Увс, Хөвсгөл гэсэн дөрвөн аймгийн алслагдсан арван суманд хүйн радиог байгуулсан. Монголын Хүйн радиогийн холбоо 2015 онд Дэлхийн хүйн радиогийн холбооны гишүүн болсон. Эдгээр нь:

1. Ховд аймгийн Алтай суман дахь “Бодончийн долгион” радио
2. Баян-Өлгий аймгийн Толбо суман дахь Толбо нуур /Мендикол/ радио
3. Баян-Өлгий аймгийн Буянт суман дахь “Хөлцөөтийн цуурай” радио
4. Баян-Өлгий аймгийн Улаан-Хус суман дахь “Улаан-Хусын долгион” радио
5. Баян-Өлгий аймгийн Баяннуур суман дахь “Уушигтын цуурай” радио
6. Увс аймгийн Зүүнговь суман дахь “Өгөөмөр аялгуу” радио
7. Увс аймгийн Тэс суман дахь “Таван Тэсийн Долгион” радио
8. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суман дахь “Хотгойдын дуу хоолой” радио
9. Хөвсгөл аймгийн Цагаан-Нуур суман дахь “Тайгын Аялгуу” радио
10. Хөвсгөл аймгийн Улаан-Уул суман дахь “Шишигтийн дуу хоолой” радио.

Дээрх арван хүйн радиогийн тогтвортой байдлыг бий болгох зорилгоор хэд хэдэн удаагийн сургалт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, үлгэрчилсэн дүрэм, гарын авлага зэргийг гаргасан боловч үйл ажиллагаа саармагжсан байна. ЮНЕСКО, Глоб интернэшнл төвтэй хамтран 2019 эхний хагас жилд Хүйн хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын суурь судалгааг хийж, “Монголын хүйн радиог бэхжүүлэх нь” төслийн зөвлөлдөх уулзалтын хүрээнд энэ талаар танилцуулсан. Судалгаанаас үзэхэд боловсон хүчний дутагдалтай байдал, Засгийн газар, орон нутгийн удирдлагын дэмжлэг дутмаг, радиогийн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл дууссан гэх зэрэг хүчин зүйлээс шалтгаалан дээрх радиогийн үйл ажиллагаа зогссон байна. Мөн Баян-Өлгий аймгийн Толбо суман дахь радиогийн байр шатсан байна. Гэсэн хэдий ч Хөвсгөл аймгийн Улаан уул, Цагаан нуур, Цагаан уул суманд байрлах радио Ховд аймгийн Алтай сумын “Бодончийн долгион” гэсэн нийт дөрвөн радиогийн үйл ажиллагааг бүрэн сэргээх боломжтой байна. Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүйн радио нь 2018 оны 5 дугаар сар хүртэл хамгийн идэвхтэй, сайн ажиллаж ирсэн байна. Тогтмол 1000 гаруй сонсогчтой бөгөөд 10-19 цаг хүртэл ажиллаж байсан талаар Монголын хүйн радиогийн холбооны ерөнхийлөгч Ц.Оюунтунгалаг мэдэгдсэн юм. Түүнчлэн орон нутгийн иргэд хүйн радиогийн идэвхтэй сонсогчид байж чаддаг байна. Иргэд сумынхаа Засаг даргын шийдвэр төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэл, гомдол шийдвэрлэсэн байдал болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг радиогоор шууд хүлээн авах хүсэлтэй байгаа. Тэд сумын Хөгжлийн сан, банк, нийгмийн даатгал, тэтгэмж, хуулийн зөвлөгөө, эмэгтэйчүүдийн эрхийн асуудал, гэр бүлийн хүчирхийлэл, архи тамхитай тэмцэх тухай, эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл авах хүсэлтэйгээ илэрхийлсэн байна. Сурагчдад

²⁶⁸ ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он. 59, 60 дахь тал

танин мэдэхүй, орон нутгийн түүх, соёл, домог, гадаад хэлний тухай мэдээлэл хэрэгтэй талаар судалгааны явцад ярилцсан байна.²⁶⁹

Радиогоос бусад хэвлэл мэдээллийн тухайд авч үзвэл, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэвлэл мэдээллийн төв” 2001 оноос улирал тутмын “Хүмүүн заяа” сониныг, 2005 оноос телевизийн “Дуулга” студийг ажиллуулж байна. Студидээ сар бүр богино хэмжээний нэвтрүүлэг бэлтгэж, улиралд нэг удаа МҮОНТ-ээр цацдаг. Сонин хэвлэлийн хувьд, Эмэгтэйчүүдийн “Арулар” ТББ 2005 оноос казах эмэгтэйчүүдэд зориулсан “Арулар” нэртэй сэтгүүлийг улирал тутам эрхлэн гаргаж байна.

Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (community media)-ийн бодлого, зохицуулалтыг аль ч түвшинд хүлээн зөвшөөрөөгүй байна. Улсын Их Хурлаас 2019.12.12-ны өдөр баталж, 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.1, 7.3.4-т иргэн болон шашны байгууллагад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон нь хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хязгаарласан зохицуулалт болсон.²⁷⁰

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 1.8-д “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно” гэж заасан.²⁷¹ Энэ хэм хэмжээ нь олон нийтийн эрх ашгийг хөндсөн этгээдийн үйлдлийн талаар зайлшгүй мэдээлэх нь хэвлэл мэдээллийн үүрэг боловч ямар ч тохиолдолд өөрийн нийтлэлд буруутгагдаж, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх, байр сууриа илэрхийлэх боломж олгохыг эрмэлзэх ёстой болохыг илэрхийлж байна. Нөгөө талын эх сурвалж болгон ашиглах, олон нийтэд харьцуулалт хийж, учир холбогдлыг нь үнэлж, дүгнэх боломж олгох нь тэнцвэртэй мэдээлэл өгөхийн үндэс болох талаар Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын талаарх сэтгүүлчдийн гарын авлагад тусгасан байна.²⁷² 2015-2019 онд Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлд “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ыг зөрчсөн талаарх нийт 333 өргөдөл ирснээс 49.3%-д нь тус зарчмыг зөрчсөн гэж шийдвэрлэсэн байх бөгөөд ёс зүйн түгээмэл алдааны 14% буюу ойролцоогоор 23 тохиолдолд буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоогүй байна.²⁷³ Үүнийг олон ургалч үзэл бодол хэвлэл мэдээлэлд хэр тусгагддаг талаарх нэг үзүүлэлт гэж тооцож болох юм.

Коронавируст халдварын цар тахлын үед Монгол Улсын Засгийн газраас хилийн хориг тогтоосон шийдвэр, арга хэмжээ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Хэний ч эх орондоо ирэх эрхийг дур мэдэн хасч болохгүй” гэснийг зөрчсөн шинжтэй байсан.²⁷⁴ 2020 оны 11 дүгээр сард нийт 1,980 иргэнийг татан авахаар 10 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэхээр төлөвлөснөөс 7 нислэгийг цуцалж, тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.²⁷⁵ Улсын онцгой комиссоос иргэдийг тээвэрлэх ажиллагааг зохион байгуулж эхэлсэн үеэс эх орондоо буцах хүсэлт

²⁶⁹ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 43, 29 дэх тал

²⁷⁰ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”. Улаанбаатар. 2021.05.03. 32 дахь тал

²⁷¹ Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”. 2015 он

<https://www.mediacouncil.mn/p/7>

²⁷² Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим: Сэтгүүлчдийн гарын авлага”. Улаанбаатар. 2017 он. 8 дахь тал

²⁷³ Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” товхимол. Улаанбаатар. 2020 он

²⁷⁴ Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн. “Хөл хорио ба эх орондоо ирэх эрх” судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Улаанбаатар. 2021 он. 50 дахь тал

https://forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=1187&menu_id=3&resmenu_id=138

²⁷⁵ “Л.Мөнхтүшиг: 11-р сард үйлдэх байсан 9 тусгай нислэгийг цуцаллаа”. 2020.11.14 <https://gogo.mn/r/v4ddd>

гаргасан иргэдэд нэн хүндэтгэн үзэх шалтгаантай байхыг шаардаж, үүнд а) эрүүл мэндийн шалтгаантай (хүнд өвчний улмаас эмнэлгийн магадалгаагаар гадаад улсад эмчилгээнд явсан), б) жирэмсэн, в) бага насны (14 хүртэлх настай) хүүхэдтэй гэр бүл, г) хөгжлийн бэрхшээлтэй, д) өндөр настан (60-аас дээш настай) гэсэн таван шалгуурыг оруулсан. Эдгээр таван шалгуурын аль нэгийг хангахгүй иргэдийн хувьд “шаардлага хангаагүй” гэх үндэслэлээр тусгай үүргийн нислэгт багтаж чадаагүй. Жишээлбэл, 2020 оны 7 дугаар сарын байдлаар дэлхийн 55 орноос эх орондоо буцах хүсэлт гаргасан нийт 11,951 иргэний 5,497 нь Улсын онцгой комиссоос тавьж буй таван шалгуурт нийцээгүй гэсэн байна.²⁷⁶ Гадаадаас эх орондоо ирж байгаа нийт иргэдийн 57-58 орчим хувийг санхүүгийн хүндрэл, бэрхшээл болон бусад шалтгаантай иргэд, 17-18 орчим хувийг бага насны хүүхэдтэй иргэд эзэлж байжээ.²⁷⁷ Ийм хүнд нөхцөл байдалд “гадаадад гацсан иргэд”-ийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр хүргэж байсан.

Хүснэгт 24. “Гадаадад гацсан иргэд”-ийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр хүргэсэн тойм

Огноо	Хэвлэл мэдээлэл	Гарчиг	Товч утга
2020.04.23	Zuv.mn	“Гадаадад гацсан монголчуудын ‘арын хаалга’-тай нь чартер нислэгт багтаж байна” ²⁷⁸	“Эх орондоо яаралтай ирэхээр хүсэлт өгөөд байгаа монголчуудад аяллын визээр гараад хугацаа нь дууссан, байрлах газар идэх хоолны мөнгө байхгүй, оюутнууд нь байрандаа тусгаарлагдан гарцгүй орлогогүй болж, эмчилгээ хийлгэхээр явсан хүмүүсийн мөнгө нь дуусч хаана хэнд хандахаа мэдэхгүй байдал үүсчхээд байгаа юм. Бид зарим иргэдтэй холбогдож ярилцлаа.”
2020.05.28	“Засгийн газрын мэдээ” сонин	“Хүний нутагт гацсан хүүхэд, эхчүүдээ хөсөр хаясан Монголын эмгэнэл” ²⁷⁹	“Энд амьдардаг монголчууд маань тусалж, дэмжиж, Солонгосын эмнэлэгт хүсэлт гаргасны хүчинд хүүхдээ эмчлүүлээ. Транзит нислэгт суух ямар ч мөнгөний боломж алга. Анх төр засагтаа итгэж, тайван хүлээсэн. Гэтэл ингээд хүний нутагт хөсөр хаягдаж байна”
2020.06.05	Zaluucom.mn	“Г.Уянга: Гадаадад гацсан Монголчууд вирус биш” ²⁸⁰	“Тайланд улсад гацсан монголчуудын ар гэрийнхэн Онцгой байдлын ерөнхий газрын гадна талбайд жагссан. Тэд Зүүн Ази тэр дундаа Тайланд улсын нийслэл Бангкок хот руу шууд нислэг үйлдэхийг хүссэн хүсэлт, шаардлагаа УОК-т хүргүүлэхээ мэдэгдсэн. Тус улсад одоогоор нийт 160 гаруй монгол иргэн гацаад байгаа юм. Тэгвэл бид Тайланд улсад гацсан монголчуудын төлөөлөл болгон иргэн Г.Уянгатай холбогдож, ярилцлаа”
2020.07.10	“Үндэсний шуудан” сонин Npost.mn	“Б.Энхгэрэл: Гадаадад байгаа монголчууд онгоц, тусгаарлах байраа олсон ч УОК зөвшөөрөхгүй байна” ²⁸¹	“Унгарын Засгийн газрын тэтгэлгээр сурч байсан 78 оюутны тэтгэлэг нь зогссон. Мөн нөхцөл байдлаа Унгарын Засгийн газарт уламжилж, тэтгэлгээ үргэлжлүүлэхийг хүссэн ч зөвшөөрөөгүй. Дотуур байрнаас нь гаргаж, оюутнуудын талаарх мэдээллийг Элчин сайдын яаманд мэдээлсэн”

²⁷⁶ Л.Мөнхтүшиг: Дэлхийн 55 орноос 11,951 иргэн нутаг буцах хүсэлтээ гаргаад байна. 2020.07.24

<https://ikon.mn/n/1y0u>

²⁷⁷ Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн. “Хөл хорио ба эх орондоо ирэх эрх” судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Улаанбаатар. 2021 он. 34 дэх тал

²⁷⁸ “Гадаадад гацсан монголчуудын ‘арын хаалга’-тай нь чартер нислэгт багтаж байна.” 2020.04.23

<https://web.archive.org/web/20200423135825/http://www.zuv.mn:80/n29>

²⁷⁹ “Хүний нутагт гацсан хүүхэд, эхчүүдээ хөсөр хаясан Монголын эмгэнэл” нийтлэл, “Засгийн газрын мэдээ” сонин, 2020.05.28

²⁸⁰ Г.Уянга: Гадаадад гацсан Монголчууд “Вирус” биш. 2020.06.05 <http://www.zaluucom.mn/read/4cg1g874a>

²⁸¹ “Б.Энхгэрэл: Гадаадад байгаа монголчууд онгоц, тусгаарлах байраа олсон ч УОК зөвшөөрөхгүй байна”. 2020.07.10 <http://npost.mn/a/168737>

2020.07.23	Urug.mn	“Я.Содбаатарт хэлэх зөвлөгөө байна, “чи битгий хуц” ²⁸²	“Улс төрийн задлан” дугаар 6. Гадаадад гацсан Монголчуудаа загнаж суугаа Я.Содбаатарыг “загналаа”. Энэ үгсийг сэтгүүлч би дамжуулж, 13 мянган иргэний дуу хоолой болов.
2020.07.27	Eguur.mn	“Эгүүрийн сэдэв: Гадаадад гацсан иргэдээ гачлангүй татахыг хүлээсэн 10,600 зүрх” ²⁸³	“Иргэдээ бүрэн татан авахад агаарын тээвэр, эм, эмчилгээний зардал зэрэгтээ зохицуулалт хийх боломжтой. Хамгийн хүндрэлтэй асуудал нь тусгаарлах байр гэнэ. Нийслэлийн хэмжээнд 260 орчим зочид буудал байгаагаас байрны багтаамж, хоол үйлдвэрлэлийн чадамж, харуул хамгаалалт гаргах боломжтой зэрэг үзүүлэлтэд 27 нь л тэнцжээ. Гэвч эдгээр 27 зочид буудал тусгаарлалтын үйл ажиллагаа явуулахаас татгалзсан байна.”
2020.08.03	“Зууны мэдээ” сонин	Малайзад 5 сар гаруй гацсан А ²⁸⁴	“... Малайзад нэг хүүхэдтэй эгч тийзийн мөнгөгүйн улмаас үлдсэн. Хаачих юм бүү мэд. Бас нэг 60 настай хүн хэрэглээний мөнгөгүй, идэх хоолгүй гудамжинд сууж байсан. Яг аав шиг минь хүн хүний нутагт хаягдаад идэх хоол, орох оронгүй байгааг хараад их эмзэглэсэн. Тэгээд би өөрт байсан мөнгөнөөсөө илүүлэн хоол, ус, ундаа авч өгсөн. Тэр хүн цааш хэрхэн амь зогоохыг хэлж мэдэхгүй юм. Зарим нь хүүхдээ тэврээд элчингийн гадаа сууж байгаа. Энэ мэт ирж чадахгүй байгаа хүмүүстээ санаа зовниод байна”
2020.08.03	Itoim.mn	“Г.Эрдэнэзул: Найман хүн гадаадад гацах хугацаандаа нас барсан, энэ тоо өсөхөөс айж байна” ²⁸⁵	“Тусгай үүргийн онгоцоор Япон улсаас ирээд тусгаарлагдаж буй Г.Эрдэнэзултай ярилцлаа. Тэрээр Филиппин, АНУ, БНСУ, Япон, Турк зэрэг улсад гацсан монгол иргэдийн төлөөлөлтэй хамтран гадаадад гацсан иргэдээ авахын төлөө нэгдэн ажиллаж байгаа юм.”
2020.08.15	Posted.mn	“Гадаадад гацсан элэг нэгтнүүдээ төлөөлж бичсэн захидал”	“... Засгийн газрын тэтгэлэг авсан ирээдүйн боловсон хүчин, эх орны ирээдүй гэгдэж байсан би хэдхэн сарын дотор л “хөнөөлт вирус”, “3 сая хүний амь насанд учирсан аюул занал” болж хувирсан байв. Угтаа бол гадаадад гацсан иргэдийн ихэнх нь над шиг дундаж гэр бүлээс сайн боловсролын төлөө, боломжийн цалингийн төлөө, үр хүүхэд, гэр бүлийнхээ төлөө тодорхой хэмжээний золиос гаргаж явсан хүмүүс байгаа шүү дээ”
2020.09.08	Isee.mn	“Т.Нямцэрэн: Тусгай үүргийн онгоц хүлээж байгаад нас барсан аавын минь чандарыг дүү минь Монгол руу авч явна” ²⁸⁶	“Энэ удаад бид “хилийн чанадад байгаа хүүхдүүд дээрээ оччихоод ирье” гээд 50 жил ханилсан ханиа үлдээгээд ниссэн ч эргэж ирэлгүй хүний нутагт насан эцэслэсэн 70 настай нэгэн буурайн талаар охинтой нь ярилцлаа. ... Түүнийг эх оронд нь буцаах гэж хань нь олон удаа УОК дээр очсон ч хөөгдөөд гарч байсан удаа ч бий гэнэ.”
2020.11.17	Isee.mn	“Монгол буцах гээд байраа хүлээлгэн	“...нислэг нь хойшлогдсон иргэд хүнд хэцүү нөхцөлд өдөр хоногийг арайхийн өнгөрөөж

²⁸² “Я.Содбаатарт хэлэх зөвлөгөө байна, “чи битгий хуц”. 2020.07.23 <https://www.urug.mn/news/2764>

²⁸³ “Эгүүрийн сэдэв: Гадаадад гацсан иргэдээ гачлангүй татахыг хүлээсэн 10,600 зүрх”. 2020.07.27 <https://eguur.mn/125516/>

²⁸⁴ “Зууны мэдээ” сонин, 2020 оны 8 дугаар сарын 3, № 155 (6380)

²⁸⁵ “Г.Эрдэнэзул: Найман хүн гадаадад гацах хугацаандаа нас барсан, энэ тоо өсөхөөс айж байна”. 2020.08.03 <http://itoim.mn/article/16tLE/22901>

²⁸⁶ “Т.Нямцэрэн: Тусгай үүргийн онгоц хүлээж байгаад нас барсан аавын минь чандарыг дүү минь Монгол руу авч явна”. 2020.09.08 <https://isee.mn/n/13179>

		өгч, ажлаасаа гарсан иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна” ²⁸⁷	байна. Бид тэдний төлөөлөл болох О.Маралгоотой ярилцлаа”
2020.11.20	“Зууны мэдээ” сонин	“Тусгай үүргийн нислэгүүд цуцлагдаж, гадаадад гацсан 3800 иргэнээ яах вэ” ²⁸⁸	“...өнөөдөр тодорхой шийд гараагүй хэвээр байна. Гадаадад гацсан иргэд гарц хайхыг хүсч манай сонинд хандсаар байна. Тэдний заримынх нь байр суурийг хүргэе.”
2020.11.20	“Зууны мэдээ” сонин	БНСУ-д гацсан иргэнээс авсан ярилцлага ²⁸⁹	“Манай гэр бүл эх орондоо очихын тулд зөвхөн замын зардалд гэхэд 7,2 сая төгрөг зарцуулсан. Бүх зүйлээ төлөвлөж хүлээж байхад шууд ингээд тодорхой бус хугацаагаар хойшлуулахаар үнэхээр хүнд байна”
2020.11.23	Livetv.mn	“Монгол буцах гээд байраа хүлээлгэн өгсөн иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна” ²⁹⁰	“Нутаг буцах хүсэлтэй олон мянган иргэдийн ганц найдвар болсон тусгай үүргийн нислэг цуцлагдсанаар иргэд хүнд хэцүү нөхцөлд өдөр хоногийг арайхийн өнгөрөөж байна. Бид гадаадад байгаа иргэдийн төлөөлөл болох А.Долгорсүрэн, У.Анхмаа нартай холбогдлоо.”
2020.11.23	News.mn	“Шведэд Монгол руу буцах хүсэлтэй 50 хүн маш хүнд нөхцөлд байна” ²⁹¹	“Швед улсад гацаж, хүнд байдалд орсон бага насны хүүхэдтэй нэгэн гэр бүл манай сайтад хандсан юм. Ингээд Б.Тэмүүлэнгийн яриаг хүргэе.”
2020.11.23	Eguur.mn	“70 настай эмээтэйгээ ХБНГУ-ын оюутны байранд гацаад буй А.Долгорсүрэн манай редакцид хандлаа” ²⁹²	“Монгол Улсад коронавирусийн анхны тохиолдол бүртгэгдсэн цаг мөчөөс эхлэн бид өдгөөг хүртэл гадаадад гацсан элэг нэгт монголчуудынхаа санал хүсэлтийг редакцияраа дамжуулан, дуу хоолойг нь түмэн олондоо уламжилсаар ирсэн билээ. Тэр ч утгаараа бид Герман улсад суралцдаг А.Долгорсүрэн хэмээх оюутан бүсгүйтэй цахим сүлжээгээр холбогдож, түүний хүсэлтийг ярилцлагаараа дамжуулан уламжилж байгааг хүлээн авна уу”
2020.11.28	Gogo.mn	“Сөүлээс энэ сарын 11, 12-нд ирэх байсан иргэд зочид буудал, халуун усны газраар хоноглож, хүнд нөхцөлд байна” ²⁹³	“Цаг үеэс шалтгаалсан энэ гэнэтийн шийдвэрээс болж хамгийн их эрсдэл хүлээж, хохирсон нь 11, 12-ны онгоцоор эх орондоо ирэхээр Солонгос дахь ажил, орон байрнаасаа гарч, мөнгөө шавхан онгоцны тийз, Монголд ирээд тусгаарлагдах байрны мөнгөө төлсөн жирийн иргэд гэж хэлж болно. Ийн хүнд нөхцөлд үлдсэн иргэдээ төлөөлж БНСУ-ын Чүнбүг үндэсний их сургуулийн магистрант Б.Янжинлхам ярилцлага өглөө.”
2020.12.05	Itoim.mn	“Г.Мөнхшатар: Гадаадад хоноглох	“... Зарим эх сурвалжийн мэдээллээр энэ сард 2-3 удаагийн тусгай нислэг үйлдэж магадгүй

²⁸⁷ “Гадаадад гацсан иргэд: Монгол буцах гээд байраа хүлээлгэн өгч, ажлаасаа гарсан

иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна” 2020.11.17 <http://isee.mn/n/15579>

²⁸⁸ “Тусгай үүргийн нислэгүүд цуцлагдаж, гадаадад гацсан 3800 иргэнээ яах вэ”. Зууны мэдээ сонин, 2020.11.20 <http://www.zms.mn/a/81677>

²⁸⁹ “Зууны мэдээ” сонин 2020.11.20 № 223 (6448)

²⁹⁰ “Монгол буцах гээд байраа хүлээлгэн өгсөн иргэд халаасандаа сохор зоосгүй гудамжинд гарахад хүрээд байна”. 2020.11.23 <https://livetv.mn/p/268561>

²⁹¹ “Шведэд Монгол руу буцах хүсэлтэй 50 хүн маш хүнд нөхцөлд байна”. 2020.11.23 <https://news.mn/r/2375558/>

²⁹² “70 настай эмээтэйгээ ХБНГУ-ын оюутны байранд гацаад буй А.Долгорсүрэн манай редакцияд хандлаа”.

2020.11.23 <https://eguur.mn/155627/>

²⁹³ “Сөүлээс энэ сарын 11, 12-нд ирэх байсан иргэд зочид буудал, халуун усны газраар хоноглож, хүнд нөхцөлд байна”. 2020.11.28 <https://gogo.mn/r/nd7w2>

		газаргүй, хоол ундгүй яваа олон монгол иргэн тусгай нислэг ирэхийг хүлээж байна” ²⁹⁴	байгаа юм. Франкфуртэд гацсан иргэдийн нөхцөл байдлын талаар Монголын залуучуудын холбооны ХБНГУ дахь салбар зөвлөлийн тэргүүн Г.Мөнхшатараас тодрууллаа”
--	--	---	---

“Гадаадад гацсан иргэд”-ийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр хүргэсэн нь үр дүнгээ өгч, гадаад улсад амьдарч буй иргэдийг татан авахад шалгуур тогтоосон нь иргэдийн эх орондоо ирэх эрхийг зөрчиж, татан авах ажиллагаанд чирэгдэл учруулж байгаа талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 3/15 дугаар зөвлөмжид дурджээ.²⁹⁵ Мөн Хүний эрхийн Үндэсний комиссоос 2020.12.22-ны өдөр хүний эрх, эрх чөлөөний зөрчлийг таслан зогсоох, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт шаардлага хүргүүлжээ. Шаардлагад “Монгол Улсын иргэнийг коронавирусын халдварын улмаас ялгаварлан гадуурхалгүйгээр тусгай үүргийн нислэгт хамруулах боломжийг бүрдүүлэх, энэ нөхцөлд мөрдөгдөх халдвар хамгаалалтын журам боловсруулж, мөрдөх; Цар тахлын улмаас гадаад улсад хүнд нөхцөлд орсон иргэнээ хамгаалах, мэдээллээр хангах чиглэлийг Монгол Улсын элчин сайдын яамд, консулын газруудад бичгээр хүргүүлэх; Улсын онцгой комиссын шийдвэрээр тусгай үүргийн нислэг цуцлагдсаны улмаас санхүүгийн нэмэлт эрсдэл хүлээсэн хүмүүсийн хохирлыг төрөөс нөхөн төлөх.” талаар тусгажээ.²⁹⁶

2.4.5. Шүүн таслах ажиллагаа (торгууль, баривчилгаа), ажил мэргэжил, нэр хүндэд хохирол учрах, сэтгүүлчдийн буюу тэдний ойр дотнын хүмүүсийн ажлын байран дээр нь эсвэл гэр оронд нь бие махбодид халдах залхаан цээрлүүлэлтээс болж сэтгүүлчид өөрийн цензурт автдаг эсэх

2006-2017 оны байдлаар сэтгүүлчийн бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан 28 тохиолдол, сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан 137 тохиолдол, хууль, хүчний байгууллагын дарамт, шүүхэд нэхэмжлэл гаргасан 187 тохиолдол гарчээ.²⁹⁷

2018-2019 онд Глоб Интернэшнл төвийн захиалгаар Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хийсэн “Сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшин тодорхойлох” судалгаанд өдөр тутмын мэдээ мэдээлэл, эрэн сурвалжлах, нийгэм эдийн засгийн чиглэлээр бичдэг 300 сэтгүүлчийг хамруулсан. Судалгааны дүнгээс харвал мэдээлэл өгөхөөс татгалзсан, бичсэн нийтлэл, нэвтрүүлгээс ямар нэг дарамт, заналхийлэлд өртсөн, ажлын багаж хэрэгсэлд халдсан, нийтлэл, нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглосон, хориглохыг завдсан, нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан зэрэг зөрчлүүд хамгийн багадаа хоёр сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ. Эдгээр зөрчил нь телевиз, цахим сайт, сонинд ажилладаг 35 хүртэлх насны залуу сэтгүүлчдэд илүүтэй тохиолддог байна.²⁹⁸ Нийтлэл, нэвтрүүлгийг түгээхээс өмнө хориглосон тохиолдол ойролцоогоор таван сэтгүүлч тутмын гуравт тохиолдож байжээ.²⁹⁹

²⁹⁴ “Г.Мөнхшатар: Гадаадад хоноглох газаргүй, хоол ундгүй яваа олон монгол иргэн тусгай нислэг ирэхийг хүлээж байна”. 2020.12.05 <http://itoim.mn/article/BXd3Q/24780>

²⁹⁵ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл”. Улаанбаатар. 2021 он. 138, 366 дахь тал <https://nhrcm.gov.mn/doc/932/>

²⁹⁶ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүний 2020.12.22-ны өдрийн шаардлага, Дугаар 5/29 <https://nhrcm.gov.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%83%D0%BE%D0%BA-%D1%82/>

²⁹⁷ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017”. Улаанбаатар. 2018 он. 9 дэх тал

²⁹⁸ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2018”. Улаанбаатар. 2019 он. 6 дахь тал.

²⁹⁹ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран “GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд бэлтгэсэн “Хэвлэлийн эрх чөлөөний мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 29 дэх тал

Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын хэсгээс 2021 оны 3 дугаар сард 80 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын дунд хийсэн судалгаагаар, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын бие даасан, хараат бус, аюулгүй байдлын талаарх асуудлыг хөндөхөд, дарамт шахалт ирдэг эсэх талаар 80 хүний зөвхөн 8.8% нь үгүй гэж хариулжээ. Мөн тус судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар, хэвлэл мэдээллийн салбарт эрэн сурвалжлагч сэтгүүлчдийн 69.5%, улс төрийн сэтгүүлчийн 28%, мэдээний сэтгүүлчийн 13.4% нь өндөр эрсдэлтэй ажилладаг гэжээ. Түүнчлэн хуулийн байгууллагаас танай редакцид болон таны орон байранд мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой нэгжлэг, үзлэг, хураан авах ажиллагаа явуулж байсан эсэх талаар 27.6% нь тийм, бусад хүмүүст тийм зүйл тохиолдож байсныг мэднэ гэж хариулсан байна.³⁰⁰

Дээрх асуулгын хүрээнд 29-40 насны 2 эрэгтэй, 2 эмэгтэй сэтгүүлчээс асуумжийн аргаар судалгаа авав. Тэд ажиллах хугацаандаа эрх бүхий байгууллагын албан хаагчдын залхаан цээрлүүлэлтэд өртөж байсан. 2 эмэгтэй сэтгүүлчийн хувьд эрх бүхий байгууллагын залхаан цээрлүүлэлтээс болж тухайн асуудал дэвшүүлсэн сэдвээ орхиж байсан бол 2 эрэгтэй сэтгүүлчийн хувьд орхилгүйгээр илүүтэй тухайн асуудлаа нарийвчлан судалсан байна.

Ярилцлага 4. Залхаан цээрлүүлэлтээс болж сэтгүүлчид өөрийн цэнзурт автдаг эсэх талаарх ярилцлагын тойм

Сэтгүүлч	Хариулт
Б.Амаржаргал /Чөлөөт сэтгүүлч/	Сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулахад аливаа төрийн байгууллага бодит мэдээллийг өгдөггүй, эсрэгээрээ өөрсдийгөө гоё харагдуулах мэдээлэл өгдөг. Үнэгүй мэдээлэл хийлгэх гэж байнга утастаж өөрсдийн ажлыг сурталчлуулах гэж оролдох нь эрх бүхий байгууллагуудын залхаан цээрлүүлэлт гэж боддог. Эрх бүхий албан тушаалтнуудын талаарх бодит мэдээллийг цацсаны төлөө цагдаа, шүүхэд дуудагддаг. Үүнээс болж ажлаасаа гарч, торгох ялаар шийтгүүлж байсан. Дээрх асуудлаас болж хэвлэл мэдээллийн салбарт ажиллах хүсэл эрмэлзэлгүй болсон.
З.Батхуяг /Улстөрч.Мн сайтын эрхлэгч/	Баримт нотолгоотой мэдээлэл бичсэнийхээ төлөө хууль, шүүхийн байгууллагад дуудагддаг. Хууль, шүүхийн байгууллагуудад бидний ажил, үйл ажиллагааны эсрэг гомдол гаргах нь залхаан цээрлүүлэлт. Байгууллагын болон улс төрийн албан хаагч, байгууллагын даргын тухай бичсэний төлөө дуудагддаг. Үүнээс болж цагдаагийн шийтгэврээр 2 удаа 4 сая төгрөгөөр торгуулсан, шүүх түүнийг хэрэгсэхгүй болгосон.
С.Будрагчаа /Чөлөөт сэтгүүлч/	Цагдаа, шүүхэд өгөх, шантаажчин гэж нэр хоч авах, доромжлуулах, элдэв эвлүүлгээр гүтгүүлэх тохиолдол гардаг. Амь насанд заналхийлж байсан. Шүүхийн бүх процесс, цагдаагийн болон прокурорын дарамт их. Нэг удаагийн мэдүүлэг өгөхөд багадаа 3 цаг болдог. Өдөрт хоёр өөр цагдаад мэдүүлэг өгөхөд тэр өдрийн төлөвлөсөн ажил орхигддог. Мөн Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс дуудаж нэмэлт тайлбар, мэдүүлэг өгөхийг шаардах зэрэг тохиолдлууд нь залхаан цээрлүүлэлтийн нэг хэлбэр. Зөрчлийн хуулийн 6.21 дүгээр зүйлд заасан “гүтгэх” хэргээр 20 гаруй удаа, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” хэргээр 7 удаа, Иргэний хэргийн шүүхэд 4 удаа тус тус дуудагдсан байдаг. Иргэн П.Оюунчимэг, С.Гаваа нарыг гүтгэсэн хэмээн цагдаа торгосон, шүүх түүнийг нь хэрэгсэхгүй болгосон. Олон удаагийн гүтгэлгэд өртөж байсан. Сүүлийн жишээ бол “Анхзул, Будрагчаа нарын чат задарлаа” гэсэн эвлүүлэг нийгмийн сүлжээнд тархсан. Гэтэл иргэд түүнд итгэсэнд нь харамсдаг.
У.Болортуяа /Өрөг.Мн сайтын гүйцэтгэх захирал/	Нийгмийн сүлжээний дайралтад /тролл/ байнга өртдөг. Мэдээлэл өгөхгүй хаалттай байдал нь залхаан цээрлүүлэлт болдог. Хийсэн бүтээлийнхээ төлөө цагдаа, шүүхийн байгууллагад дуудагддаг. Гэхдээ шүүхээс ямар нэгэн шийтгэл авч байгаагүй. Гэхдээ цаг хугацаа, мөнгөөрөө хохирсон.

³⁰⁰ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”. Улаанбаатар. 2021.05.03. 41 дэх тал
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2021.01.13-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/01 дүгээр тушаалаар байгуулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөө, мэдэх эрхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын санал боловсруулах Ажлын хэсэг

2.4.6. Хэвлэл мэдээлэл нь улс төрийн, эдийн засгийн, шашны, цэргийн эрх мэдэлтнүүд, цагдаа/шүүх тогтолцоо, зохион байгуулалттай гэмт хэрэг, зэвсэгт бүлэглэлүүдийн талаарх мэдээллийг чөлөөтэй ил болгодог эсэх

Мэдээлэлтэй байх эрх буюу мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулдаг болохын хувьд түүнийг бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагаас үүдэн хуулиар хязгаарлаж болохын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан. Ингэхдээ мэдээлэлтэй байх эрхийг зүй бусаар хязгаарлахаас сэргийлсэн олон улсын стандартыг НҮБ-ын Хүний эрхийн хороо, Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн комиссоос тухай бүр НҮБ-ын Тусгай илтгэгчийн зохих тайлангийн тусламжтайгаар 1994-2011 оны хооронд нэгэнт тогтоожээ. Энэхүү стандартын дагуу мэдээлэл хамгийн ил тод байх ёстой бөгөөд мэдээллийг нууцлах нөхцөл нь дараах гурван нөхцөл буюу “мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлахад баримтлах шалгуур”-ыг нэгэн зэрэг хангасан байх ёстой. Үүнд:

- тухайн мэдээлэл нь хуульд заасан хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой байх,
- тухайн мэдээллийг ил болгох, задруулах нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд ноцтой хохирол учрахыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоосон байх,
- тэрхүү учрах ноцтой хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос илүү чухал байх.

Монгол Улсын хувьд, энэ шалгуурыг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зохицуулалт хангахгүй байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд мэдээллийг ил болгох буюу задруулахтай холбоотой хохирлын үнэлгээ, нийтийн ашиг сонирхлын эрэмбийн талаар зохицуулаагүй. Тодруулбал, тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.4-т “хууль ёсны ашиг сонирхол”-той холбоогүй буюу үйл явцын ерөнхий мэдээллийг задруулахгүй байхаар, 19 дүгээр зүйлийн 19.1-т “холбоотой” мэдээллийг нууцлахаар тус тусгаснаар илэрч байна. Мөн 18 дугаар зүйлийн 18.1.1-т “тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол” тухайн мэдээллийг бусдад задруулахыг хориглоно гэж зохицуулсан. Мөн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.2 дахь хэсгийн зохицуулалтад тухайн мэдээллийг ил болгох, задруулах нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд ноцтой хохирол учрахыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоох талаар тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэлийг хэрхэн тодорхойлох, үнэлгээний дүнг хэрхэн үнэлэх талаар зохицуулаагүй байна. Мөн 18 дугаар зүйлийн 18.1.3-т хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол мэдээллийг задруулахгүй гэж заасан. Ингэхдээ тухайн хүссэн мэдээлэл төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах эсэх, тийнхүү хамаарч буй бол ямар хэмжээнд задруулах эсэхийг хэрхэн тодорхойлох талаар тусгаагүй.

Эндээс үзэхэд, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зохицуулалт нь “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлахад баримтлах шалгуур”-ыг хангахгүй байна. Түүнчлэн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг тогтмол хянаж, хөндлөнгийн хяналт тавих механизм байхгүй нь иргэдийн мэдээлэлтэй байх эрх зөрчигдөх нөхцөл болж байна. “Мэдэх эрхийн талаарх олон улсын үнэлгээ”-гээр 2019 оны 8 дугаар сард Монгол Улсын Мэдээллийн ил тод байдал ба

мэдээлэл авах эрхийн тухай хуулийг боломжит 150 онооноос 87 оноогоор дүгнэсэн байна.³⁰¹

Төрийн болон албаны нууцын тухай хуулиар төрийн нууцын жагсаалтыг Засгийн газар батлахаар зохицуулсан. Ингэснээр, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд заасан төрийн нууцын тоо 60 байсан бол Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн нууцад хамаарах мэдээллийн тоо 570 болж эрс өссөн. Үүнээс гадна, албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг төрийн байгууллагын удирдлага өөрөө батлахаар тусгасан тул нууцалсан мэдээллийн жагсаалтын нэгдсэн тоо дээр дурдсанаар хязгаарлагдахгүй юм. Ингэснээр, мэдээлэлтэй байх эрхийг тодорхой шалгуурын дагуу зөвхөн хуулиар хязгаарлах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн зохицуулалт зөрчигдөх; хууль гаргахгүйгээр аливаа мэдээг төрийн болон албаны нууцад хамааруулах замаар иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг зохих үндэслэлгүйгээр хязгаарлах үр дагавартай байна.

Тодруулбал, мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, ил болгохтой холбоотойгоор тухайн байгууллагын ажлын хэсэг ямар бүрэлдэхүүнтэй байх, ажлын хэсэг тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, түүнд тагнуулын байгууллага санал өгөхөд ямар шалгуур баримтлах талаар хууль болон Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д тусгаагүй байна. Үүний улмаас нууцлах шаардлагагүй мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулж байна. Энэ нь Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн 196 дугаар тогтоолоор “*Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил, түүнд оролцуулах зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо хэмжээ...*”-г “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д нэмсэн хэдий ч, Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудас болон мэдээллийн хэрэгслээр 2019.05.24-ний өдөр “*...Сайншанд-Замын-Үүд чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай авто замын Сайншанд сум руу салсан дөрвөн замын уулзвараас нефть боловсруулах үйлдвэр хүртэлх хүнд даацын, тусгай зориулалтын 18.8 км авто замын ажлыг Зэвсэгт хүчний 7780-р ангийн бие бүрэлдэхүүн гүйцэтгэж байгаа юм. Зэвсэгт хүчний жанжин штабын дарга А.Ганбатын өгсөн мэдээллээр Зэвсэгт хүчний 7780-р ангийн 189 цэргийн алба хаагч Алтанширээ суманд ажиллаж байгаа бөгөөд хугацаат цэргийн алба хаагчдыг өвлийн сургалтад сурган, бүтээн байгуулалтын ажилд оролцуулж байгаа юм байна*”, “*Дорноговь аймгийн Мандах сумын Будран багийн нутагт өнөөдөр Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого*”-ын дагуу баригдах Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын нээлт боллоо Төмөр зам барьж байгуулахад нийт 3700 орчим хүн, 1352 машин механизм ажиллана. Бүтээн байгуулалтыг Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн цалинтайгаар хийж гүйцэтгэнэ” гэж мэдээлснээр илэрч байна.

Түүнчлэн, “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д заасны дагуу, тухайн байгууллага, албан тушаалтан 3 хүртэлх сарын хугацаанд нууцын жагсаалтад ороогүй мэдээллийг нууцлах боломжтой байна. Энэ нь мэдээллийг үндэслэлгүйгээр нууцлах, тухайн байгууллага, албан тушаалтны хууль бус, зохисгүй үйл ажиллагааны мэдээллийг нуун далдлах эрсдэл болж байна. Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад шинээр бие даасан гэмт хэрэг болгон тусгаж 19.11 дүгээр зүйлд заасан “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэргийн зохицуулалт нь иргэдийн мэдээлэлтэй байх эрхэд аюул занал болж буй бөгөөд төрийн болон албаны нууцын жагсаалтад нэмэлт,

³⁰¹ Global Right to Information Rating: Mongolia. 2019-08 <https://www.rti-rating.org/country-detail/?country=Mongolia>

өөрчлөлт оруулах үйл ажиллагааны боловсронгуй бус байдлыг ашиглан иргэн, сэтгүүлчийг тус гэмт хэрэгт буруутгах, эрүүгийн хариуцлагад татах, сэтгүүлчийн нууц эх сурвалжийг илчлэх эрсдэлтэй болж байна.

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын нууцын журам, нууцын жагсаалтын ил тод байдал хангалтгүй байх бөгөөд аймаг, дүүргийн засаг даргын тамгын газрын үйлчилж буй нууцын журмыг энгийн иргэд үзэхэд хүндрэлтэй байна. Энэ нь тодорхой албан тушаалтан өөрийн үзэмжээр тодорхой иргэдийн мэдээлэл авах хүсэлтийг байгууллагын нууц гэх үгээр халхавчилж мэдээлэл өгөхөөс татгалзах нөхцөл бий болгоход хүргэхээр байна. Мөн мэдээллийг ил болгох нөхцөлийг төрийн болон нутгийн захиргааны захиргааны байгууллагуудын олонх нь нууцын журамдаа тусгаагүй, орхигдуулж буй нь мэдээлэлтэй байх эрхийг зохисгүй хязгаарлах нэг эрсдэл болж байна. Түүнчлэн, нууцын жагсаалт дахь мэдээллийн зарим хэсэг нь хэт ерөнхий бөгөөд нууцлах шаардлагагүй мэдээллийг нууцад хамааруулсан байна.³⁰²

Зарим төрийн захиргааны төв байгууллага, түүний албан тушаалтны хувьд хууль бус үндэслэлээр мэдээлэл өгөхөөс татгалзаж буй нь тэдгээр төрийн байгууллагын албан тушаалтнуудын хувьд Төрийн болон албаны нууцын хууль тогтоомж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зохицуулалтын талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй байгааг харуулж байна.³⁰³

Олон нийтэд үнэнийг хэлэхийн төлөө мэргэжлийн эр зориг гаргаж хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахад оруулсан хувь нэмэр, хичээл зүтгэлийг үнэлэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан, байгууллагад Глоб Интернэшнл төв 2009 оноос эхлэн жил бүрийн Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр “Үнэний төлөө” хэвлэлийн эрх чөлөөний шагналыг гардуулж байна. Энэхүү шагналыг олгосон үндэслэлээс харахад, хэвлэл мэдээлэл нь улс төрийн эрх мэдэлтнүүд, эдийн засгийн эрх мэдэлтнүүд, шашны эрх мэдэлтнүүд, цэргийн эрх мэдэлтнүүд, цагдаа/шүүх тогтолцоо, зохион байгуулалттай гэмт хэрэг, зэвсэгт бүлэглэлүүдийн талаарх мэдээллийг ил болгодог хэдий ч тийнхүү ил болгох нь ихээхэн дарамт, саад бэрхшээл, эрсдэлтэй төдийгүй ихээхэн хүчин чармайлт шаардаж байна.³⁰⁴ Энэ нь дээрх мэдээллийг чөлөөтэй ил болгох нөхцөл бүрдээгүй гэж үзэхэд хүргэж байна.

Хүснэгт 25. “Үнэний төлөө” шагнал хүртсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, байгууллагууд, 2009-2021

Огноо	Шагналын эзэн	Хувь нэмэр, хичээл зүтгэл
2021	Г.Балжинням /Ийгл ньюс телевизийн сэтгүүлч/ Г.Балжинням нь “эх, хүүхдийг ХӨСҮТ рүү шилжүүлэхдээ ноцтой алдаа гаргасан” асуудлыг сурвалжилсан сурвалжилгаараа энэхүү шагналын эзэн болжээ. Тэрээр “эх хүүхдийг ХӨСҮТ рүү шилжүүлэхдээ ноцтой алдаа гаргасан асуудлыг хэн ч мартажгүй байх. Нэг минут ч хүрэхгүй сурвалжилга нийгэмд шуугиан тарьсан. Тэр дундаа эрүүл мэндийн салбарынхны хариуцлагагүйн багийг хуулж, үнэн төрхийг ил болгосон. Энэ сурвалжилгаараа сэтгүүл зүй ямар чухал үүрэгтэйг олон хүн ойлгосон гэдэгт итгэлтэй байна. Цар тахлын өмнөх нийгэм, эдийн засаг, улс төр одоогийнхтой харьцуулшгүй өөр	

³⁰² Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад “Хорооны даргаас дотоод мэдээлэл гэж тогтоосон бүх төрлийн мэдээ, мэдээлэл” гэж байгаа нь тухайн албан тушаалтны хувийн цензур нөлөөлж байгааг харж болохоор байна.

Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 43, 39 дэх тал

³⁰³ Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ”. Улаанбаатар. 2019 он. 47-49 дэх тал.

https://www.gic.mn/public/docs/publications/public_Restrictions_right_to_information_acts_pdf_2019.pdf

³⁰⁴ Глоб интернэшнл төв. “Үнэний төлөө” хэвлэлийн эрх чөлөөний шагнал. <https://gic.mn/post/r/630>

	байна. Мэдээлэл олж авах асуудал хүндрэлтэй болохын сацуу мэдээлэл зөвхөн нэг цонхоор явж байгаа нь эх сурвалжийн дутагдалд орох нөхцөлийг бүрдүүлж байна.” гэжээ.
2020	Г. Цолмон /“Өнөөдөр” сонины Эрэн сурвалжлах, экологийн мэдээллийн албаны дарга/ Г.Цолмон 2003 оноос хойш сэтгүүлчээр ажиллаж байгаа бөгөөд, эрэн сурвалжлах цуврал нийтлэлүүдээрээ энэхүү шагналыг хүртэх болзлыг хангасан.
2019	Мэдээллийн ikon.mn веб сайт ikon.mn сайт 2018 онд олон нийтийн сүлжээгээр анх гарсан ЖДҮХС-аас төрийн өндөр албан тушаалтнууд нэн хөнгөлөлттэй зээл авсан талаарх баримтыг АТГ-ын цахим хуудас дахь төрийн 35,000 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэгтэй тулган баталгаажуулж, Шилэн данс болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын burtgel.mn цахим хуудас дахь нээлттэй мэдээллийг шүүж боловсруулах замаар 100 гаруй мэдээллийг ил болгосон байна.
2018	У.Болортуяа /Ийгл Ньюс телевизийн сэтгүүлч/ Эрэн сурвалжлах цуврал нэвтрүүлгээрээ “Үнэний төлөө” хэвлэлийн эрх чөлөөний шагналын эзэн болжээ. У.Болортуяа нь 2012 оноос хойш “Эрэн сурвалжлагч” нэвтрүүлэг бэлтгэж, “Мартагдсан амь”, “Мартагдсан Д.Сүхбаатарын эрэлд”, “Амьд явах тулаан”, “Чимээгүй хашгираан”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээс төр нь харамласан 10 дугаар цэцэрлэгийн төсвийн мөнгө” зэрэг эрэн сурвалжлах цуврал нэвтрүүлэг бэлтгэсэн.
2017	Э.Лхагва /Монгол ТВ-ийн Мэдээний албаны дарга/ Монгол ТВ телевиз Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбоотой хамтран “Панамын баримтууд” гэх 210,000 орчим оффшор компаниудын талаарх нууц мэдээллийг анх удаа албан ёсны эрхтэйгээр цуврал сурвалжлагаар бэлтгэн үзүүлсэн юм. Энэ үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж эрэн сурвалжлах сэтгүүлч, Монгол ТВ-ийн мэдээ болон нийгмийн нэвтрүүлгийн албаны дарга Э.Лхагвад “Үнэний төлөө” хэвлэлийн эрх чөлөөний шагнал олгожээ.
2016	Л. Болормаа /“Mongolian Mining Journal” сэтгүүлийн үүсгэн байгуулагч/ Лунтангийн Болормаа нь 2015.11.21-ний өдөр зуурдаар таалал төгсөж, Монголын сэтгүүл зүйн салбарт нөхөж баршгүй хүнд гарз тохиосон. Тэрээр хараат бус, бие даасан “Mongolian Mining Journal” сэтгүүлийг 2008 онд үүсгэн байгуулж, эрхлэгчээр нь ажиллаж байв. Л.Болормаа нь эдийн засаг, уул уурхайн чиглэлээр дагнан бичдэг байсан бөгөөд түүний жинтэй, даацтай нийтлэлүүд уншигчдыг дагуулж байв. Тэр хараат бус сэтгүүл зүйн үлгэр дууриалал байсан.
2015	Ц. Эрдэнэцэцэг /“Өдрийн шуудан” сонины сэтгүүлч/ Ц.Эрдэнэцэцэгийг “Дугаарын бизнес дундраагүйгээр барахгүй илүү нарийн, илүү цадиггүй болон хөгжиж байна” гарчигтай нийтлэл бичсэний төлөө нэр төрд халдсан, гүтгэсэн, гүтгэлгийг олон нийтэд тараасан гэдэг үндэслэлээр хоёр жилийн турш шүүх, хууль хяналтын байгууллагаар явуулсны эцэст Дээд шүүх хэргийг хянаж Ц.Эрдэнэцэцэгийг цагаатгасан.
2014	ТВ9 телевизийн “Монгол коммент” нэвтрүүлэг 2011 оны 11-р сараас эхлэн 3 жилийн хугацаанд 800 орчим нэвтрүүлэг бэлтгэхдээ олон нийтийн үзэл бодлоо илэрхийлэх талбар болж чадсаныг үнэлэн “Үнэний төлөө” хэвлэлийн эрх чөлөөний шагналыг нэвтрүүлгийн редактор М.Батбилэгт гардуулжээ.
2013	Г.Батхишиг /SBN телевизийн мэдээний албаны сэтгүүлч/, А.Амарсанаа /зураглаач/ SBN телевизийн мэдээний албаны сэтгүүлч Г.Батхишиг, зураглаач А.Амарсанаа нар Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэстэй хамтран тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг баар цэнгээний газрууд хууль зөрчин, цаг хэтрүүлэн ажиллаж байгаа талаар сурвалжилж явахад хамгаалалтын ажилтнуудын халдлагад өртөж, зураглаач тархиндаа хүнд гэмтэл авсан бөгөөд камерыг дахин ашиглахааргүй болтол эвдэлсэн байна.
2012	Т. Данаасүрэн /Баянхонгор аймгийн Хонгор телевизийн сэтгүүлч/ “Хонгор” телевизийнхэн олон нийтэд тэнцвэртэй мэдээлэл хүргэх зорилгоор “Спейшл майнз” ХХК-ийн холбогдох ажилтнуудаас тодруулга авахаар очиход харуул хамгаалалтын ажилтнууд нь хэл амаар доромжлон, камерыг нь булаан гэрэл, чихэвчийг нь эвдэлж, тэднийг хүйтэн гэрт хоёр цаг гаруй саатуулан, камерт байсан бичлэгийг нь устгасан байна.
2011	Д.Болормаа /“Зууны мэдээ” сонины сэтгүүлч/ “Зууны мэдээ” сонин нь 2010 оны 8 сараас хойш Монголд өрнөж байгаа хүний наймаа болон насанд хүрээгүй охидыг бэлгийн мөлжлөгөд ашиглаж байгаа талаар 20 гаруй цуврал нийтлэл, сурвалжлага нийтэлсэн. Тус сонины эрэн сурвалжлах алба болон сэтгүүлч Д.Болормаа нь сэтгүүлзүйн энэхүү цуврал эрэн сурвалжлах ажлын хүрээнд бага насны (дунд сургуулийн 14-15 насны сурагчид) охидын онгон биеийг 500 ам.доллараар худалддаг, худалдан авдаг зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ байгааг илрүүлсэн.

	Сэтгүүлч Д.Болормаад Сүхбаатар дүүргийн цагдаагийн газарт эрүүгийн хэрэг үүсгэн прокурорт шилжүүлээд байгаа юм. “Өдрийн сонин”-ы Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн алба “Өдрийн сонин”-ы Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн албаны хамт олны “Эх сурвалжийн мэдээллийн мөрөөр үнэнийг хайсан нь” цуврал нийтлэлүүд жинхэнэ утгаар нь эрэн сурвалжилж олсон мэдээллээ зоригтой гаргаж тавьсан нь Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйд том тэсрэлт болсон.
2010	Б.Мягмарсүрэн /“Завхан” сонины эрхлэгч/ Завхан аймгийн “Завхан” сонины эрхлэгч Б.Мягмарсүрэн Яруу сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Засаг даргын орлогч зэрэг 7 албан хаагч - төрийн албан хаагчдын талаар шүүмжлэлт материал нийтэлсний төлөө анхан болон давж заалдах шатны шүүхийн 9 сая гаруй төгрөг гаргуулах, сониноороо дамжуулан няцаалт хийхийг даалгасан шийдвэрийг эс зөвшөөрөн Монгол Улсын Дээд шүүх хүртэл мэргэжлийн эрхээ хамгаалан тэмцэж, дээрх хэргийг дахин хэлэлцэх явцад гомдол гаргасан албан тушаалтнууд “энэ асуудлаар анхан болон давж заалдах шатны шүүхэд дахин нэхэмжлэл, гомдол гаргах эрхгүй гэдгээ ойлгож байна” хэмээн нэхэмжлэлээсээ татгалзсанаар хэргийг хүчингүй болгож 1 жилийн дараа “Завхан” сонины ялалтаар өндөрлөсөн байна. Х.Намуун-Уянга /“Өглөөний сонин”-ы сэтгүүлч, эрэн сурвалжлах, шуурхай мэдээллийн албаны дарга/ Өдөр тутмын “Өглөөний сонин”-ы эрэн сурвалжлах, шуурхай мэдээллийн албаны дарга Х.Намуун-Уянга сониныхоо 2008 оны есдүгээр сарын 11-ний өдрийн дугаарт цагдаагийн дэд хурандаа, Эргүүл тусгай хамгаалалтын газрын дэд дарга Н.Баярмагнай залилангийн хэргээр шалгагдаж байгаа талаар УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дэд дарга Ц.Батболдын мэдээлэлд үндэслэн “Цагдаагийн дэд хурандаа 20 сая төгрөгийн залилан хийжээ” гэсэн гарчигтай мэдээлж, Баянзүрх дүүргийн шүүх Н.Баярмагнайгийн нэр төрд халдсан гэж үзэн 2 сая төгрөг гаргуулах, сониноороо дамжуулан няцаалт хийхийг даалгасан шийдвэрийг зөвшөөрөөгүй сэтгүүлч Х.Намуун-Уянга давж заалдсан ч Нийслэлийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж 1 сая төгрөг гаргуулахаар шийдвэрлэжээ. Сэтгүүлч Х.Намуун-Уянга дээрх шийдвэрийг эс зөвшөөрч Улсын Дээд шүүхэд хандах үед Н.Баярмагнайд холбогдох эрүүгийн хэрэг дахин сэргээгдэн шалгагдаж байсан ч Улсын Дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Х.Намуун-Уянга Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дүгээр зүйлийг үндэслэн Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэрт хандан гомдол гаргажээ.
2009	Б.Бямба-Очир, Н.Ариунаа, Н.Батбаяр, Х.Эрдэнэбулган, Т.Анхтамир, Д.Ууганбаатар, Л.Өлзийбаяр, Б.Баасанбямба Монголын ардчилал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний сорил болсон 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдлыг шуурхай сурвалжлан олон нийтэд үнэнийг хэлэхийн төлөө мэргэжлийн эр зориг гарган хувь нэмэр оруулсан 8 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд анх удаа “Үнэний төлөө” хэвлэлийн эрх чөлөөний шагнал олгосон. 2008 оны 7-р сарын 1-нд УИХ-ын сонгуулийн үр дүнг эсэргүүцэгчдийн МАХН-ын үүдэнд хийсэн жагсаал цуглаан, түүний дараа үүсэж бий болсон эмх замбараагүй байдлыг сурвалжилж яваад халдлагад өртөн гэмтэж бэртсэн “Өнөөдөр” сонины гэрэл зурагчин Б.Бямба-Очир, “Монголын мэдээ” сонины гэрэл зургийн сурвалжлагч Н.Ариунаа, ТВ-8 телевизийн зураглаач Н.Батбаяр, МҮОНТВ-ийн ММ агентлагийн сэтгүүлч Х.Эрдэнэбулган, gogo.mn вэб сайтын зураглаач Т.Анхтамир, Ийгл ТВ-ийн зураглаач Д.Ууганбаатар, Л.Өлзийбаяр, энэ үеэр хүний амь эрсдсэн тухай хамгийн түрүүн олж мэдээлсэн МҮОНТВ-ийн ММ агентлагийн сэтгүүлч Б.Баасанбямба нар Хэвлэлийн эрх чөлөөний шагналын анхны эзэд болжээ.

Дээрх хүснэгтэд харуулсан олон нийтэд үнэнийг хэлэхийн төлөө мэргэжлийн эр зориг гаргаж хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахад хувь нэмэр оруулсан, хичээл зүтгэл гаргасан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, байгууллагуудын бүтээл нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйд хамаарч байна. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хувь хүн, байгууллагын хууль бус, нийтийн ашиг сонирхол, хэм хэмжээний эсрэг үйл явдлыг олон түмэнд илчилснээр нийгмийн хөгжилд чухал хүчин зүйл болох эрх чөлөө, ардчилал, ил тод

байдлыг хамгаалан, хэвлэл мэдээлэл хэмээх “дөрөв дэх засаглал” хүчтэй оршиж буйг харуулж байдаг.³⁰⁵

2.4.7. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь сөрөг хүчний хүчтэй эсэргүүцэл өдөөхгүйгээр соёлын хөндүүр сэдвүүдэд анхаарал хандуулж чадах эсэх

Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-ын 4-т “Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.”, 7-д “Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.” гэж заасан.³⁰⁶ Үүгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл соёлын хөндүүр сэдэвт анхаарал хандуулж, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхдээ баримтлах зарчмыг тогтоосон байна. Үүнтэй холбоотойгоор “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” зөрчсөн гэж Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлд гомдол гаргасан тохиолдлуудыг хэрхэн шийдвэрлэснийг авч үзлээ. Ингэхдээ бэлгийн дарамт, хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эрүүдэн шүүх, ялгаварлан гадуурхах, гэмт хэрэг, осол, гамшиг, авлига, ашиг сонирхлын зөрчил, эрүүл мэнд, соёл, уламжлалтай холбоотой сэдвийг мэдээлэхдээ ёс зүйн зарчим зөрчсөн эсэх тоймыг авч үзсэн. Эндээс харахад, соёлын хөндүүр сэдвүүдийг хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчихгүйгээр хөндөж мэдээлсэн сайн жишээ хэд хэд байна.

2.4.8. Нийгэм, соёлын бүлэглэлүүдийн зүгээс цензурт уриалан дууддаг эсэх

2019 оны 9 дүгээр сард “Босоо Хөх Монгол” ТББ-ийн хүмүүс ТВ-4 телевизийн хүмүүсийн хамт зочид буудалд байсан трансжендер эмэгтэйд халдаж, заналхийлж, хүчээр ярилцлага өгүүлж, түүнийгээ түгээсэн. Түүнчлэн халдагч этгээдүүд цаашид ч трансжендер хүмүүсийг үргэлжлүүлэн ялгаварлан гадуурхах болохоо цахим сүлжээнд зарласан. Түүнчлэн “үсийг нь хусна”, “нүцгэлж, зургийг нь авна” гэх зэргээр мэдэгдсэн. Мөн хэвлэлийн бага хурал зарлаж, трансжендер хүмүүсийг ил заналхийлсэн.³⁰⁷ Энэ нь хэт үндсэрхэг гэж тооцогдох бүлэглэлийн зүгээс ЛГБТ хүмүүсийн талаар мэдээлэх, сурвалжлах явдлыг цагдан хянах уриалгад тооцогдож байна.

2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Нийслэлийн зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Одсүрэн өөрийн фэйсбүүк хуудаснаа “Хүүхдэдээ ийм тоглоом авч өгсөн байсан юм. Гэтэл ижил хүйсийг дэмжсэн, өдөөсөн өнгө, лого, туг, яриа байдгийг олж мэдлээ. Онцгүй сэтгэгдэл төрлөө, тоглоомыг хогийн саванд хийсэн, мөн нийтийн тээвэрт мөнгө төлж рекламаа тавиулсан байсныг хуулуллаа.” гэсэн сэтгэгдлийг автобусны гадна талын сурталчилгааны наалтыг хуулуулж буй фото зургийн хамт байршуулан нийгмийн сүлжээгээр түгээсэн байна. Уг бичвэрийг түгээснээсээ хойш 30 орчим минутын дараа устгасан, сурталчилгааны материалыг автобуснаас хуулуулах чиглэл аль нэг байгууллага, албан тушаалтанд өгөөгүй гэх тайлбарыг Б.Одсүрэн Хүний эрхийн Үндэсний Комисст өгсөн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос “Бэлгийн цөөнх хүмүүсийг ялгаварлан гадуурхсан шинжтэй үзэл бодол нийгмийн сүлжээгээр илэрхийлсэн үйлдэлдээ олон нийтэд хүртээмжтэй арга хэлбэрээр, нэн даруй уучлалт гуйхыг Нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Одсүрэнд даалгах; Нийслэлийн нутгийн захиргааны

³⁰⁵ Бие даасан боловсрол, хөгжлийн төв ТББ. “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургалтын гарын авлага”. Энэхүү гарын авлагыг Авлигатай тэмцэх газар болон Глоб Интернэшнл Төв ТББ-ын захиалгаар эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургалтад оролцогчдод зориулжээ. Улаанбаатар. 2018 он. 8 дахь тал

³⁰⁶ Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”. 2015 он
<https://www.mediacouncil.mn/p/7>

³⁰⁷ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд Монгол Улсын иргэний нийгмийн байгууллагаас илгээсэн тайлан. 2019.10.03
<http://daccess-ods.un.org/access.nsf/Get?Open&DS=A/HRC/WG.6/36/MNG/3&Lang=E>
<http://lgbtcentre.mn/2019/10/29/submission-of-the-lgbt-centre-mongolia-for-the-36th-session/>

байгууллагуудын албан хаагчдад бэлгийн цөөнх хүмүүсийн хүний эрх, амьдралын нөхцөл байдал, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, хэм хэмжээ, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн талаар танилцуулга, мэдээлэл хийх; Бүрэн эрхийнхээ хүрээнд “ЛГБТ Төв” ТББ-д учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар зохистой бусад арга хэмжээг авахуулах” заалт бүхий 2021.09.16-ны өдрийн 3/31 дугаартай шаардлагыг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт гаргажээ.³⁰⁸

2.5. Сэтгүүлчдийн аюулгүй байдал

Энэ хэсэгт сэтгүүлчдийн аюулгүй байдлыг судалгааны асуулт бүрийн хүрээнд дүгнэв.

2.5.1. Өнгөрсөн хугацаанд сэтгүүлчид хүчирхийлэлд өртсөн эсэх

2006-2017 онд сэтгүүлчийн бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан 28 тохиолдлыг Глоб интернэшнл төв бүртгэжээ. Мөн хугацаанд сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан 137 тохиолдол бүртгэсэн байна.³⁰⁹ 2015-2017 онд гэмт хэргийн улмаас хохирсон нийт 70 сэтгүүлчийн 22 нь эрэгтэй, 48 нь эмэгтэй байна.³¹⁰

Глоб интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран 2019 онд хэрэгжүүлсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг”-ийн тайланд дурдсанаар гурван сэтгүүлч тутмын хоёр нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт өртөж байсан бөгөөд хамгийн түгээмэл хэлбэр нь утсаар заналхийлэх, эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг айлгаж, дарамтлах зэргээр илэрч байна. Сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, доромжлол гэх мэт зүйлд 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид илүү өртөж байгаа бол эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг болон гэр бүлийн гишүүдийг нь айлгаж, дарамтлах байдал эмэгтэй сэтгүүлчдэд илүү тохиолдож байна.³¹¹

Глоб интернэшнл төвөөс хэрэгжүүлж буй “Коронавируст халдвар буюу ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ иргэний болон улс төрийн эрхэд нөлөөлөх нь” мониторингийн тайланд сүүлийн нэг жил гаруйн хугацаанд хамаарах сэтгүүлчдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг бүртгэжээ.³¹²

Жишээ 2. Сэтгүүлч хүчирхийлэл, сүрдүүлэгт өртсөн жишээ, 2012-2022

2012.06.28-наас 29-нд шилжих шөнө 01 цагийн үед буюу УИХ-ын сонгуулийн санал хураалт явагдсаны дараа “Скай” телевизийн хөрөнгө оруулагч болох “Хөвсгөл Ньюс” компаний гүйцэтгэх захирал Б.Ганзориг хэсэг хүмүүсийн хамтаар тус телевизийн 4 сэтгүүлч, 4 зураглаачдыг нэг талыг барьсан мэдээлэл явуулсан, хөрөнгө оруулагчдынхаа талд үйлчилсэнгүй хэмээн зодож гэмтээсэн байна. Б.Ганзориг нь УИХ-ын сонгуулийн 17 дугаар тойрог буюу Хөвсгөл аймагт нэр дэвшигч Л.Мөнхбаатарын сонгуулийн сурталчилгааны ажлыг гардан гүйцэтгэгч нь бөгөөд сонгуулийн дүн гарсны дараа ийнхүү телевизийн зураглаач, сэтгүүлчдээ зодож танхайрсан болох нь дүрс бичлэгт үлджээ. Халдлагад өртсөн нэг сэтгүүлч,

³⁰⁸ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс. “Нийслэлийн засаг дарга Д.Сумъяабазарт шаардлага хүргүүлээ” 2021.09.17 <https://tinyurl.com/yc6jiyyne>

³⁰⁹ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017”. Улаанбаатар. 2018 он. 9 дэх тал

³¹⁰ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 13 дахь тал

³¹¹ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 35 дахь тал

³¹² Глоб интернэшнл төв. “Коронавируст халдвар буюу ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ иргэний болон улс төрийн эрхэд нөлөөлөх нь” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021.10

хоёр зураглаач тархиндаа хүнд гэмтэл авчээ. Шүүхээс Б.Ганзоригт 3.5 жилийн хорих ял ногдуулсан байна.
2012.09.13-ны өдөр “ТВ 8” телевизийн сэтгүүлчид сурвалжилга хийх явцдаа бусдад зодуулсан хэрэг гарчээ. “ТВ 8” телевизэд “Blue Sky” цамхагт ажилладаг нэг залуу ажлын байрандаа солонгос хүнд зодуулж байна гэсэн дуудлага ирсний дагуу сурвалжлах баг тус газар очжээ. Гэтэл хамгаалалтын албаны хүмүүс камертай сэтгүүлчдийг орохыг хориглож, харин гар хоосон сэтгүүлчдийг ажлын байр руу нэвтрүүлжээ. “ТВ 8” телевизийн сэтгүүлч гар утсаараа бичлэг хийж байтал солонгос, монгол хүмүүс нийлж гар утсыг нь булаан авч бүлэглэн зоджээ. Зодуулсан сэтгүүлчийн үс нь зулгарч гэмтсэн бөгөөд гар утсаа алдсан байна.
2012.09.28-наас 29-ний шилжих шөнө “SBN” телевизийн сурвалжлах багийн сэтгүүлч, зураглаачид Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэстэй хамтран тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг баар цэнгээний газрууд хууль зөрчин, цаг хэтрүүлэн ажиллаж байгаа талаар сурвалжилжээ. Гэтэл “ХО” баарны эзэн “Бидний ард том хүн байгаа. Та нар яаж ч чадахгүй” гэх зэргээр доромжилж, цагдаа нарын хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж, хамгаалалтын ажилтнуудаар сэтгүүлч, цагдаа нарыг зодуулжээ. Тэрээр “SBN” телевизийн сурвалжлагч, зураглаач нарыг шалгалтаар очсон хоёр цагдаагийн хамт баарандаа цоожилж, тухайн үед хийсэн бичлэгийг нь хүчээр устгахыг оролдсон байна. Мөн тус телевизийн зураглаачийг зодож, тархинд нь хүнд гэмтэл учруулсан бөгөөд SBN телевизийн камерыг дахин ашиглахааргүй болтол эвдэлжээ. ³¹³
2017 оны 11 дүгээр сард НИТХ-ын төлөөлөгч “А”-ийн төрсөн дүү “Б” олон нийтийн газар сэлэм эргүүлэн танхайрсан хэргийн тухай хамгийн анх манайх гаргаж тавихад захирал, редактор, сэтгүүлч, редакцийн бас ажилтны гээд 4 хүний утас өдөржингөө дуугарсан. Бид нар утсаараа ч ярьж чадахгүй, фэйсбүүк рүүгээ орж чадахгүй, олон хүн наад мэдээгээ авчихаач гээд байж байтал нөгөө “А” нь дүүтэйгээ орж ирээд “Наадхаа авчих” гэж сүрдүүлсэн. Манайх ч харьяа байгууллагынхаа хамгаалалтын албыг аваад би бас хэд хоног хамгаалалттай байсан. Тэгээд сүүлдээ манай толгой компаниар дамжуулж авахуулсан. Энэ мэтчилэнгээр редакц руу орж ирдэг юмнууд бол зөндөө байгаа. /33 настай, эмэгтэй сэтгүүлч/ ³¹⁴
2018.07.25-ны өдөр Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл болон холбогдох мэргэжлийн байгууллагууд Хавдар судлалын үндэсний төвд үерээс үүдэн үүсээд буй нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, зарим нэг асуудлыг шийдвэрлэхээр болсон юм. Энэ үеэр асуудалтай танилцаж байсан Хотын ерөнхий менежер Т.Гантөмөр ажлаа хийж, сурвалжлага бэлтгэж байсан UBS телевизийн зураглаачийг олны нүдэн дээр зодож дарамталсан байна. Тухайн үед зураглаач авах гэж байгаа дүрсэнд саад болсон Т.Гантөмөрт “Та жаахан зай тавиад өгөөч” гэсэн шаардлага тавьтал Т.Гантөмөр менежер зураглаач залууг цохиж зодсон талаар тухайн газар ажилласан сэтгүүлчид мэдээлсэн. ³¹⁵ Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс Т.Гантөмөрийг ажил үүргээ биелүүлж явсан зураглаачийн биед халдаж, улмаар тухайн газраас хөөж гарган, үүнийхээ дараа зураглаачийг гүтгэн хэвлэлээр ёс зүйгүй мэдэгдэл хийсэн тул энэхүү үйлдэлдээ албан ёсоор уучлалт гуйхыг шаарджээ. ³¹⁶
2018.07.27-ны өдөр Бүгд Найрамдах Турк Улсын иргэн Вейсел Акчайг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөлтэй оршин сууж байхад нь хулгайлахыг завдсан хэрэг гарсан бөгөөд монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үүнийг мэдээлж байлаа. Тухайн үеийг сурвалжилж байсан сэтгүүлчдийг ЦЕГ-ын Гэрч, хохирогчдыг хамгаалах хэлтсийн албан хаагчид цохиж, түлхэж, үсдэж зарим сэтгүүлчдийг авч шидсэн хэрэг гарсан. Eagle телевизийн сэтгүүлч Б.Батцэцэгийг цагдаагийн албан хаагч шанаадаж байгаа бичлэг камерт үлдсэн байдаг. Редакцаас нь цагдаагийн байгууллагад гомдол гаргасан боловч нэр бүхий албан хаагчийг ажлаа хийж байсан хэмээн үзэж хариуцлага тооцолгүй орхисон. ³¹⁷
2020.12.01-ний өдөр Төв аймгийн нэгэн хэлтсийн дарга сэтгүүлч Т.Саранчимэгийн мэдээлэл авах эрхэд саад учруулж, дарамталж, амь насанд нь заналхийлсэн.

³¹³ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2012-2014”. 2015 он. Улаанбаатар 20, 21 дэх тал

³¹⁴ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 13 дахь тал

³¹⁵ “УБ хотын менежер Т.Гантөмөр телевизийн зураглаачийг зодож танхайрчээ!” 2018.07.25 <https://niitlech.mn>

³¹⁶ Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн 2018.07.31-ний өдрийн мэдэгдэл <https://newspress.mn/v1/p/news/5472>

³¹⁷ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2018”. Улаанбаатар. 2019 он. 12 дахь тал

- 2021.05.03-ны өдөр ХӨСҮТ-ийн бохирын шугам задарч, ХӨСҮТ 8 цаг усгүй болж, халдвар тархах их эрсдэлтэй байгаа үйл явдлыг сурвалжилсан зураглаачийн камерыг цохиод шууд бичлэгийг нь хамгаалалтын ажилтнууд тасалсан байна.
- 2021.05.05-ны өдөр өлсгөлөн зарлаж буй үйл явдлыг сурвалжлахаар очсон NTV телевизийн сэтгүүлч Д.Уламбаярыг цагдаагийн албан хаагч түлхэж унагасан, мөн 2021.05.07-ны өдөр төв талбай руу нэвтэрч сурвалжлага бэлтгэсэн Парламент телевизийн сэтгүүлч Г.Гэрэлмааг түлхэж унагаасан бөгөөд тийнхүү мэдээлэл түгээх үйл ажиллагаанд саад учруулсан нь гамшгийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ч хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг хязгаарлаагүй холбогдох дүрэм журмыг зөрчсөн байна. Шүүхийн шинжилгээний хүрээлэнгээс сэтгүүлч Г.Гэрэлмаагийн гэмтэлд “Баруун дал, баруун өвдөг, баруун шилбэнд цус хуралт бүхий гэмтэл учирсан ч, гэмтлийн зэрэгт хамаарахгүй” гэх дүгнэлтийг 2020.05.12-ны өдөр гаргажээ.
- 2020.12.10-ны өдөр МҮОНРТ-ийн Хамт олны зөвлөлөөс зохион байгуулсан тус телевизийн Захирлын томилгоотой холбоотой Үндэсний зөвлөлийн шийдвэрийг эсэргүүцсэн жагсаалыг тодорхой үндэслэл, хуулийн тайлбаргүйгээр хязгаарлаж, сэтгүүлч Б.Пүрэвийг албадан авч явж, мэдүүлэг авсан.
- 2021.05.14-ний өдөр “Өнөөдөр” сонины сэтгүүлч Мягмаржаргалыг бичсэн нийтлэлтэй нь холбогдуулан Дархан Ар Шанд ХХК-наас 21:30 цагт утсаар дарамталж, нийтлэлээ устгахыг шаардсан. Мөн хамтран ажиллагч байгууллагын төлөөлөл ДБЭХС ТӨХК-аас редакц дээр нь очиж дарамталж, загнасан.
- 2021.06.03-ны өдөр Live.mn сайтын сэтгүүлч Б.Будрагчааг цагдаагийн байгууллагаас ажлаас нь албадан авч явж мэдүүлэг авсан.
- 2021.09.28-ны өдөр сэтгүүлч Ц.А-ын УИХ-ын гишүүний бэлгийн хүчирхийллийн асуудлаар бэлтгэсэн мэдээлэлтэй нь холбогдуулан гэр бүлийн гишүүдийг нь цахим орчинд хуурамч хаяг ашиглан сүрдүүлсэн. ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс 2021 оны 5-р сард сэтгүүлч Ц.А болон түүний гэр бүлийг хамгаалалтад авсан.
- 2021.10.21-ны өдөр Төв талбайд суулт зарлаад буй УИХ-ын гишүүн асан С.Жавхлан асуулт асуусан сэтгүүлчийн толгойг гар утсаараа тоншжээ. Тэрбээр [umiidur.mn](https://www.umiidur.mn) сайтын сэтгүүлчийн “Та, УИХ-д дахин нэр дэвших үү?” гэсэн асуултад хариулахаас татгалзаж, толгой руу нь гар утсаараа тоншоож “Бэлдэж өгсөн асуулттай ирлээ. 13:00 цагаас мэдээлэл хийнэ гэж ах нь өмнө нь мэдээлэл өгсөн. 13:00 цагтаа ир” гэж байгаа нь сайтуудын шууд дамжуулалтын бичлэгт үлджээ.³¹⁸
- 2021.12.31-ний өдөр шууд дамжуулалтын үеэр Ховд.мн сайтын сэтгүүлч рүү орилж, сэтгүүлчийн биед халдав.³¹⁹
- 2022.01.15-ны өдөр Нарантуул олон улсын худалдааны захын “Баялаг Ундраа” худалдааны төвийн удирдлагууд зураглаач, сэтгүүлчийн биед ноцтой халджээ.
- 2022.01.25-ны өдөр “Төсвийг мөшгөө: Сайд асан Ё.Отгонбаярын эхнэрийн хувьцаа эзэмшдэг компани Хөгжлийн банкинд 17.7 тэрбум төгрөгийн өртэй байна” нийтлэлийг [Zarig.mn](https://zarig.mn) мэдээллийн сайтад 2022.01.24-ний өдөр оруулсантай холбоотойгоор сайд асан Ё.Отгонбаяр өөрийн твиттер хаягаараа сэтгүүлч У.Оргилмаа руу “Чамайг олж ална аа. Миний амьдралыг алсан бол хариугаа авна. Ална. Заригтай чинь ална. Үнэн хорсож байна” гэж бичиж сэтгүүлчдийг ална гэж сүрдүүлжээ.³²⁰ Үүнтэй холбоотойгоор 2022.01.25-ны өдөр Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс гаргасан мэдэгдэлдээ “Улс орон, нийтийн эрх ашгийг ноцтой хөндсөн дээрх сэдвээр бичиж, нийтэлж,

³¹⁸ “С.Жавхлан сэтгүүлчийн асуултад хариулахаас татгалзаж, биед нь халдав”. 2021.10.20

<https://ikon.mn/n/2cyc>

³¹⁹ “Өдрийн сонин”. “Шууд дамжуулалтын үеэр сэтгүүлчийн биед халдав.” 2021.12.31

<https://www.facebook.com/dnn.mn/videos/625359762244784/>

³²⁰ “Сайд асан Ё.Отгонбаяр албан ёсны твиттер хуудсаараа сэтгүүлчийг ална гэж сүрдүүллээ”. 2022.01.25

<https://zarig.mn/veo>

“Төсвийг мөшгөө: Сайд асан Ё.Отгонбаярын эхнэрийн хувьцаа эзэмшдэг компани Хөгжлийн банкинд 17.7 тэрбум төгрөгийн өртэй байна” 2022.01.24 <https://zarig.mn/vdf>

сурвалжилж, олон нийтэд түгээн дэлгэж буй хэвлэл мэдээллийн тодорхой хэрэгслүүд болон сэтгүүлч, нийтлэлчдийг үүнийх нь төлөө төрийн сайд асан Ё.Отгонбаяр айлган сүрдүүлж, амь насыг нь заналхийлсэн үйлдэл гаргасныг Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс эрс эсэргүүцэж байна” гэжээ.³²¹

- 2022 онд Боловсрол, шинжлэх ухааны яамны яамны харьяа Монгол-Оросын хамтарсан гуравдугаар сургуулийн захирал Ж.Соронзонгийн талаар эрэн сурвалжлах нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж буй Nuuts.mn мэдээллийн сайтын ерөнхий редактор С.Будрагчаа сүрдүүлэгт автсан талаараа “Ж.Соронзон захирлын нөхөр нь ШЕЗ-ийн даргаар ажиллаж байсан, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, МУИС-ийн багш Н.Лүндэндорж гэж хүн байдаг. Энэ хүн ШЕЗ-ийн даргаас өндөр насны тэтгэвэртээ гараад өөрийнхөө эхнэрийн буюу төрийн өмчийн сургуульд багшаар ажилд орсон байдаг. Харин тэрбээр зарим багш нарын бүтэн жил ажиллаад гар дээрээ авдаггүй цалинг нэг сард авдаг байгаа юм. Тиймээс энэ асуудлыг өөрөөс нь тодруулж, хариу тайлбар авах гэхээр ‘Чи надтай ямар өс хонзонгоор үзээд байгаа хүүхэд вэ. Чи энэ чигээрээ хол явахгүй’ гэсэн. Үүнийг юу гэсэн үг юм бэ ‘Та намайг ална гэж байгаа юм уу’ гэхээр ‘Тийм’ гэж байгаа юм. Тэгэхээр миний гэр бүл, найз нөхөд гээд надтай холбоотой хүмүүсийн эрүүл мэнд, амь насанд ямар нэгэн зүйл тохиолдвол энэ хоёр хүнээс зайлахгүй. Эмээх зүйл бол байгаа. Гэхдээ айж, эмээлээ гээд дуугүй байж болохгүй болохоор сурвалжилсаар л байх болно. Үнэнийг бичихгүй бол үзэг барьсны хэрэг юу байх билээ.” гэжээ.³²²
- 2022 онд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн Х.Бат-Ялалт шүүхийн байранд сэтгүүлч Э.Баярмааг доромжилж, мэдээллийн сайт дахь гэрэл зурагчний биед халджээ. Энэ үйлдлийг бичлэгээр баримтжуулж авсан байна.³²³

2.5.2. Өнгөрсөн хугацаанд сэтгүүлчдийг эрүүдэн шүүсэн, хэрцгий, хүнлэг бусаар харьцаж шийтгэсэн тохиолдол гарсан эсэх

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1984.12.10-ны өдөр баталж, 1987.06.26-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс тус конвенцод 2000.11.02-нд нэгдэж орсон. Тус конвенцод зааснаар “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Монгол Улсын Эрүүгийн 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/-д зааснаар төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол 5400-27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-5 жил хорих ял шийтгэнэ. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn цахим хуудаст сэтгүүлчдийг эрүүдэн шүүсэн, хэрцгий, хүнлэг бусаар харьцаж шийтгэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

2.5.3. Өнгөрсөн хугацаанд сэтгүүлчдийн амь насыг хороосон хэрэг гарсан эсэх

Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хангахад тулгамдаж буй нэн чухал асуудлуудын нэг юм. ЮНЕСКО-ийн дэргэдэх “Амь үрэгдсэн сэтгүүлчдийн хэргийг ажиглах төв”-ийн мэдээлснээр, 1993 оноос хойш 1492 сэтгүүлчийн амийг хороосон эдгээр аллагын

³²¹ Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс гаргасан мэдэгдэл. 2022.01.25 <https://cmj.mn/94>

³²² “С.Будрагчаа: Ж.Соронзон захирал хэвлэлийн эрх чөлөөнд халдаж, биднийг худалдаж авахыг санаархсан”. 2022.02.10 <https://isee.mn/n/31411>

³²³ Сэтгүүлч Э.Баярмаа. 2022.02.08 <https://www.facebook.com/bayarmaa.enguun/posts/10226367186544015>

10 хэрэг тутмын 9 нь шүүхээр шийдвэрлэгдээгүй байна. Зэвсэгт мөргөлдөөнгүй орнуудад сэтгүүлчдийн ихэнх нь амь үрэгдсэн байна.³²⁴ Монгол Улсад сэтгүүлчийн амь насыг хороосон тохиолдол гараагүй байна.³²⁵

Сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл нь ихэвчлэн хууль дээдлэх ёс, шүүхийн тогтолцоо суларч буйг илтгэдэг. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2013 оны 68 дугаар чуулганаар A/RES/68/163 тоот тогтоол баталж, жил бүрийн 11 дүгээр сарын 2-ны өдрийг “Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр” болгон зарласан.³²⁶ Тэр цагаас хойш “Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр-ийг дэлхий даяар тэмдэглэж байгаа нь сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэхтэй тэмцэхэд оролцож буй бүх оролцогчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, харилцан яриа өрнүүлэх онцгой боломж бүрдүүлж байна. НҮБ-ын болон бүс нутгийн байгууллагууд, гишүүн орнууд, шүүх эрх мэдлийн байгууллагууд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийнхэн зэрэг олон талт оролцогчид сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх, хариуцлага тооцоход чухал үүрэг гүйцэтгэдэг.”³²⁷

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр гаргасан сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх тогтоолд НҮБ-ын гишүүн орнуудыг “хүний эрхийн олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүрэг, амлалтад хууль тогтоомж, бодлого, практикаа бүрэн нийцүүлэх, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын хараат бусаар, хөндлөнгийн оролцоогүйгээр ажлаа хийх боломжийг хязгаарласан хууль тогтоомж, бодлого, практикаа хянан үзэж, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг хүчингүй болгох, өөрчлөх”-ийг уриалсан.³²⁸

2.5.4. Өнгөрсөн хугацаанд сэтгүүлчдийг дур зоргоор баривчилсан эсвэл одоогоор баривчлаад буй тохиолдол бий эсэх

Глоб интернэшнл төв 2006-2017 онд сэтгүүлчийг түр саатуулсан, хорьсон 72 тохиолдлыг бүртгэсэн байна.³²⁹ Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2018-2019 онд хийсэн “Сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшин тодорхойлох” судалгаанд өдөр тутмын мэдээ мэдээлэл, эрэн сурвалжлах, нийгэм эдийн засгийн чиглэлээр бичдэг 300 сэтгүүлчийг хамруулсан байх бөгөөд тэдний 8% нь буюу 24 сэтгүүлчийг түр саатуулсан, хорьсон байна.³³⁰ Глоб интернэшнл төвөөс явуулсан судалгаагаар 2019 оны 5 сараас 2020 оны 5 сар хүртэлх хугацаанд сэтгүүлчид эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулсан, хорьсон 10 тохиолдол байна.³³¹

Жишээ 3. Сэтгүүлчдийг дур зоргоор баривчилсан, саатуулсан жишээ

Сэтгүүлч Л.Баяраа “Улс төрийн тойм” сонины 2012.05.21-ний дугаарт “УИХ-ын гишүүн Д.Одхүүгийн сонгуулийн нууц төлөвлөгөө алдагдав” гарчиг бүхий нийтлэл хэвлүүлжээ. Уг нийтлэлээс үүдэн Д.Одхүү нэр төрд халдсан, үндэслэлгүй мэдээлэл нийтэлсэн хэмээн гомдол

³²⁴ UNESCO Director-General's Report on the Safety of Journalists and the Danger of Impunity

<https://en.unesco.org/themes/safety-journalists/dgreport>

UNESCO observatory of killed journalists <https://en.unesco.org/themes/safety-journalists/observatory>

³²⁵ UNESCO observatory of killed journalists – Mongolia <https://en.unesco.org/themes/safety-journalists/observatory/country/223766>

³²⁶ UN General Assembly Resolution (A/RES/68/163) on Safety of Journalists and the Issue of Impunity (2013) https://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/68/163

³²⁷ “Бүх хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахын тулд сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэгтэй тэмцэх нь”. 2021.10.26 <https://gic.mn/post/r/1633>

³²⁸ Human Rights Council Resolution (A/HRC/45/L.42/Rev.1) on the Safety of Journalists (2020) https://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=A/HRC/45/L.42/Rev.1

³²⁹ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017”. Улаанбаатар. 2018 он. 9 дэх тал

³³⁰ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2018”. Улаанбаатар. 2019 он. 6 дахь тал

³³¹ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2018”. Улаанбаатар. 2019 он. 33 дахь тал

гаргасны дагуу сэтгүүлчид эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдөр хэргийг шүүхэд шилжүүлэх үеэр сэтгүүлчийг хавтаст хэрэгтэй нь танилцуулаагүй, шүүгчийн захирамжгүйгээр 3 цаг хорьж саатуулжээ. Сэтгүүлч Л.Баярааг шүүх хуралд 20 гаруй минут хоцорч очиход Баянгол дүүргийн шүүгчийн захирамжаар сэтгүүлчийг дахин баривчлан хорьжээ. 2012.07.26-нд болсон шүүх хурлаар сэтгүүлч Л.Баярааг гэм буруутай гэж үзэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 70 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу 9.828.000 төгрөгийн торгууль ноогдуулсан байна.³³²

Info.mn сайтын сэтгүүлч С.Баттулгад “Ноёд” группээс гаргасан мэдэгдлийг сайтдаа байрлуулсны улмаас эрүүгийн хэрэг үүсгэжээ. 2015.07.09-ний өдөр цагдан хорьсоныг Глоб Интернэшнл Төв эсэргүүцэж мэдэгдэл гаргав. Энэ өдөр шүүх хурал товлогдсон байсан хэдий ч өмгөөлөгчдийн нэг ирээгүй гэх шалтгаанаар шүүх хурлыг 2015.07.27 хүртэл хойшлуулах шийдвэр гаргаж, сэтгүүлч С.Баттулгыг бусад дөрвөн шүүгдэгчийн хамт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ тухай шүүгчийн захирамж гарсан байна. Сэтгүүлчийг нийт 22 хоног цагдан хорив. 2014 онд сэтгүүлчийг дээрх хэрэгтэй холбогдуулан мөн 32 цагаар саатуулж байжээ. 2014 оны 12 дугаар сард болсон анхан шатны шүүх хурлаас сэтгүүлчийг гэм буруутайд тооцож, 21 сая төгрөгөөр торгох ял ногдуулсан бөгөөд давж заалдах шатны шүүхээс хэргийг анхан шатны шүүхэд шилжүүлсэн юм.³³³

Баянхонгор аймгийн телевизийн сурвалжлах баг уул уурхайн асуудлаар нэвтрүүлэг бэлдэх зорилгоор тус аймагт үйл ажиллагаа явуулдаг уурхайг газар дээрээс нь сурвалжлахаар хэд хэдэн суманд ажиллажээ. Галуутын Шижир Аранжин уурхайгаас мэдээ бэлтгэх явцад оператор, жолооч, сэтгүүлч нарыг хоёр цаг орчим өрөөнд хорьсон хэрэг гарчээ. Тэд өрөөнөөс гарахын тулд техник хэрэгслээ барьцаанд үлдээсэн бөгөөд дараа өдөр нь техникээ хэрэгслээ авахад мемори картыг нь авсан байв. Тэд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд аймгийн цагдаад хандсан боловч хариу өгнө хэмээн 2-3 сар хүлээлгэж, дахин шаардахад, сахилгын хариуцлага тооцсон, төлж өгнө гэж хариулсан байна.³³⁴

2.5.5. Өнгөрсөн хугацаанд сэтгүүлчдийг хулгайлах эсвэл сураггүй алга болгосон тохиолдол гарсан эсэх

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлд “Хүн хулгайлах”, 13.3 дугаар зүйлд “Хүн барьцаалах”, 13.4 дүгээр зүйлд “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийг тусгасан. 2017 оноос хойш шүүх “хүн хулгайлах” 6 гэмт хэргийг, “хүн барьцаалах” 1 гэмт хэргийг тус тус хянан шийдвэрлэсэн байна. Харин “хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийг шийдвэрлээгүй байна. Шүүхээс шийдвэрлэсэн хэрэгт сэтгүүлчдийг хулгайлах эсвэл сураггүй алга болгосон тохиолдол тусгагдаагүй байна.³³⁵

2.5.6. Сэтгүүлчид эрхэлж буй ажилтайгаа холбоотойгоор сэтгэл санааны хохирол амсдаг эсэх

“Таны бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлэгтэй холбогдуулан шүүх, цагдаагийн байгууллагаас дуудаж байсан уу?” гэж асуухад судалгаанд оролцогчдын 36 хувь буюу 3 сэтгүүлч тутмын нэг нь тийм гэж хариулсан. Тодруулбал эрх мэдэл бүхий албан тушаалтан, улс төрчийн нэр хүндэд халдсан, баримтын алдаа гаргасан, бодит байдлыг гэмт хэргийн шинжтэй бичсэн гэх зэрэг шалтгаанаар шүүх, цагдаагийн байгууллагад дуудагдаж ажээ.

Ийнхүү олон удаа шүүхэд дуудагдах үндэслэл нь Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд заасан “Гүтгэх” зөрчил буюу “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”

³³² Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2012-2014”. 2015 он. Улаанбаатар. 20 дахь тал

³³³ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2015”. Улаанбаатар. 2016 он. 18 дахь тал

³³⁴ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2016”. Улаанбаатар. 2017 он. 18 дахь тал

³³⁵ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан <https://shuukh.mn/cases/2/1>

гэх зохицуулалт гэж сэтгүүлчид үзсэн.³³⁶ Мөн судалгаанд оролцогчид Зөрчлийн тухай хуулийг улс төрчдийн өөрсдийгөө хамгаалахын тулд баталсан хууль гэж үзэж байна. Энэхүү Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон хэдий ч мөн өдөртөө Эрүүгийн хуульд “13.14 дүгээр зүйл.Худал мэдээлэл тараах” гэмт хэрэг болгон нэмсэн. Шүүх, цагдаагийн газраас дуудсан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нь ямар нэг шийтгэл хүлээх, тэр дундаа торгууль хүлээхээс зайлсхийж, бэлтгэсэн мэдээллээ устгах зэргээр зөвшилцөх явдал цөөнгүй байдаг аж. Ямар нэг байдлаар хэвлэл мэдээллийн байгууллага буюу редакцийн буруу тохиолдолд 20 сая төгрөгөөр торгуулахаас зайлсхийж, сэтгүүлчид хэргийг үүрүүлж, 2 сая төгрөгөөр торгуулах замыг сонгож байжээ.

2.5.7. Сэтгүүлчид ажлын байран дээрээ сэтгэл санааны дарамтад өртдөг эсэх, сэтгүүлчид үйл ажиллагааныхаа улмаас ажил мэргэжлийн хувьд хор хохирол амсдаг эсэх

Глоб интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран 2019 онд хэрэгжүүлсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг”-ийн тайланд энэ асуудлыг хөндсөн байна.³³⁷

Эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдийн 23 хувь нь өөрийн редакцдаа мэдэгдсэн байна. Харин олон нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллага болон иргэний нийгмийн байгууллагад хандах, цагдаа шүүхийн байгууллагад хандсан тохиолдол цөөн байна. Ихэнх тохиолдолд тухайн зөрчлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хөөн хэлэлцдэггүй болох нь харагдаж байна. Тухайн зөрчлийг ноцтой биш, ямар нэг байдлаар их хэмжээний хохирол амсаагүй гэж үзсэн үед зохих байгууллагуудад мэдэгддэггүй байна. Учир нь сэтгүүлчдийн хувьд тухайн асуудлаа аар саархан асуудал мэтээр үзэж, хөөцөлдөж явах нь цагаа үрсэн явдал гэж үздэг түгээмэл ойлголтоос улбаатай ажээ.

Сэтгүүлчийн хувьд “Та эрсдэлтэй томилолтоос татгалзах эрх бий юу?” гэж асуухад судалгаанд оролцогчдын 56 хувь нь тийм, 24 хувь нь үгүй, 20 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан. Сэтгүүлчид эрсдэлтэй томилолтоос татгалзах эрхтэй гэж дийлэнх нь хариулж байсан ч, зарим тохиолдолд редакц, албаны дарга гэх мэтчилэн дээд албан тушаалтны даалгавар бол эрсдэлтэй байсан ч явах ёстой гэж ойлгож байна. Мөн эрсдэлтэй томилолтод явах нь сэтгүүлчийн олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж буй хэрэг гэж үзэж байна. Бие давхар эмэгтэйг эрсдэлтэй томилолтод явуулсан жишээнээс харахад, зарим редакцийн хувьд сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тал дээр анхаарах байдал хангалтгүй байгааг харуулж байна. Хэвлэл мэдээллийн байгууллага нь сэтгүүлчээ эрсдэлтэй томилолтод илгээхдээ өмнө нь орчин, эрсдэлийн талаарх мэдээлэл урьдчилан өгдөг эсэхийг тодруулахад 43 хувь нь тийм гэж хариулсан бол 39 хувь нь үгүй, 18 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан. Хэвлэл мэдээллийн байгууллага эрсдэлтэй томилолтод явж буй сэтгүүлчээ шаардлагатай даатгалд хамруулдаг уу? гэж асуухад судалгаанд оролцогчдын 20 хувь тийм, 50 хувь нь үгүй, 30 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан. Даатгалд хамруулдаггүй шалтгааныг хэвлэл мэдээллийн байгууллагын хэмжээ, цар хүрээ, тухайн байгууллагын санхүүгийн чадамжтай холбож тайлбарлаж байлаа.

Судалгаанд оролцогчдоос хөдөлмөрийн гэрээнд ажилтныхаа аюулгүй байдлын тухай ямар заалт оруулсан байдаг талаар тодруулахад байгууллагын нууц, ажлын хариуцлага гэх зэрэг

³³⁶ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 43-50 дахь тал

³³⁷ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 46, 47 дахь тал

байгууллагад хохирол учрахаас урьдчилан сэргийлсэн заалтууд байхаас биш сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх заалт байхгүй тухай ярьсан. Зарим байгууллагын тухайд сэтгүүлч нь бичсэн нийтлэл, нэвтрүүлгээсээ болж аюулгүй байдалд нь заналхийлэл учирсан бол гэрээтээр хамгаалалтын албатай хамтран ажиллаж, хэсэг хугацаанд хамгаалалтад байлгадаг. Ихэнх тохиолдолд тухайн сэтгүүлчийн гэр бүлийн хүн, эсвэл ойр дотнын хүн нь эрсдэлээс хамгаалдаг гэж байлаа.

Ярилцлага 5. Сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авдаг эсэх талаарх ярилцлагын тойм

Ноцтой биш бол хэн ч араас нь явахгүй шүү дээ. Яагаад гэвэл наад чинь цаг зав, хөдөлмөр хэрэгтэй ажил. Тэрийг хөөцөлдөөд явах завтай хүн редакцид байхгүй. Эрүүл мэндийн хувьд ноцтой гэмтэл авчихаагүй, техник тоног төхөөрөмж нь бүр хэрэглэх аргагүй болтлоо эвдрээгүй бол тэгээд л өөрсдөө аргалаад л өнгөрдөг /55 настай, эмэгтэй сэтгүүлч/
Цагдаа дээр нэг очиж өргөдлөө өгөөд, утсаар хэд ярина. Тэгээд л хаядаг. Цагдаа эзэн нь олдсонгүй гээд л хаячихдаг. /40 настай, эмэгтэй сэтгүүлч/
Хүндрэлтэй асуудал тулгарвал редакц дотроо хамгаалалт авах уу яах уу гээд л. Редакц шаардлагатай тохиолдолд хамгаалагч гаргаж өгнө. Гаргаж өгөхгүй бол тэр чигээрээ л байна. /33 настай, эмэгтэй сэтгүүлч/
2016 онд Америкийн иргэн Централ Тауэр дээр тэсрэх бөмбөг тавьсан тухай мэдээ бэлтгэх болж манай редактор нэг сэтгүүлчийг зураглаачтай яв гэсэн. Гэтэл тухайн сэтгүүлч “Би тийшээ явж чадахгүй ээ. Тэр чинь дэлбэрээд би үхчихвэл яах юм” гээд яваагүй. Тэгсэн чинь албаны дарга “Тэгвэл чи яв” гээд надад хэлсэн. Тухайн үед би төрөх гээд 7 орчим сартай, нэлээд том гэдэстэй байсан. Тэгээд явж байсан. Хэдий эрсдэлтэй томилолт ч гэлээ тэр үед би татгалзах эрх байгаа ч гэсэн олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг байгаа учраас би явахгүй гээд татгалзах нь бас хаашаа ч юм гэж бодоод явж байсан. /30 настай, эмэгтэй сэтгүүлч/

2.5.8. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажлын багаж хэрэгсэл, эд хогшлоо хураалгах буюу эвдүүлэх эрсдэл бий эсэх

Сэтгүүлчийн ажлын багаж хэрэгсэлд халдах явдал ойролцоогоор 5 сэтгүүлч тутмын гуравт нь тохиолдож байсан бөгөөд залуу сэтгүүлчид илүүтэй өртөж байна. Эмэгтэй сэтгүүлчдийн ажлын багаж хэрэгсэлд халдах байдал эрчүүдэд тохиолдох тохиолдлоос ялимгүй их байна. Сэтгүүлч, зураглаачийн зүгээс ажлын багаж хэрэгсэл нь их хэмжээгээр гэмтээгүй, дахин ашиглах боломжтой хэвээр байгаа бол цагдаагийн байгууллагад гомдол гаргах нь ховор. Тэдэнд хандлаа ч үр дүнгүй гэж үзэж байна.³³⁸

Жишээ 4. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ажлын багаж хэрэгсэл, эд хогшлоо хураалгаж, эвдүүлсэн жишээ

“Налайхын амьдрал” сонинд нийтлэгдсэн Налайх дүүргийн АН-ын бүлгийн дарга О.Ганболдоос авсан ярилцлагын улмаас Налайх дүүргийн ИТХ-ын төлөөлөгч С.Нэргүй сэтгүүлч Д.Батчимэгийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргасан боловч хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Үүнээс гадна С.Нэргүй нь сэтгүүлчээс эдийн бус гэм хорын хохиролд 200 сая төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна. Дээрх ярилцлага нийтэлсний дараа сэтгүүлчийг нууцалсан дугаараас заналхийлж, машины дугуйг нь хоёр удаа санаатайгаар хагалжээ. 2015 оны 5 дугаар сард болсон анхан шатны шүүх хурлаас сэтгүүлч Д.Батчимэгийг гэм буруутайд тооцож, сониноор дамжуулан залруулга гаргах, эдийн бус гэм хорын хохиролд 500,000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэжээ. ³³⁹
VTV телевизийн сэтгүүлч Л.Пүрэвням нь Төрийн ордонд нэвтрэх эрх бүхий парламентын сэтгүүлч юм. 2016 онд 3 дугаар сард Төрийн ордны үйлчилгээний журмыг хоёр удаа зөрчсөн

³³⁸ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 40 дэх тал

³³⁹ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2015”. Улаанбаатар. 2016 он. 18 дахь тал

гэдэг үндэслэлээр түүний үнэмлэхийг Төрийн ордны хамгаалалтын албаны орлогч дарга хураан авчээ. Хамгаалалтын албаныхан үнэмлэхийг хураахад, сэтгүүлч энэ талаар тайлбар шаардаж, үйл явцын бичлэг хийж байхад хамгаалалтын албаныхан түүний гар утсыг булаан авах оролдлого хийжээ.³⁴⁰
2016 оны 4 дүгээрд Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Баян-Өлгий аймагт ажиллаад буцсан. Гэтэл албан ёсны тэмдэг зүүсэн үнэмлэхтэй сэтгүүлчдийг тагнуулынхан урьдчилан шалгаж, юу хийхийг нь зааж сургах нь холгүй болсон нь нэг л хачирхалтай санагдсан ч сэтгүүлчид ажлаа хийж эхэлсэн. Ерөнхий сайдыг буцмагц тагнуулынхан ХМХ-ийг дахин шалгаж, бүх бичлэгийг хурааж авсан нь нэг л ойлгомжгүй сэтгэгдэл төрүүлээ. Ардчилсан нийгэмд амьдарч байгаа иргэдийн хувьд цочирдом ч явдал боллоо. Орон нутгийн сэтгүүлчид өөрсдийнхөө нэр хүндэд халдаж байсан аливаа оролдлогод дотроо уучлангуй хандаж, нэг их эсэргүүцэлгүйгээр явж ирсэн нь байдлыг ийн гааруулах тийшээ хандсан бололтой. Эрх мэдэлтэй хууль хяналтынхны өөдөөс олигтой дуугаралгүйгээр, өөрсдийгөө хамгаалалтгүй орхиж өдий хүрсэн нь орон нутгийн ХМХ-ийн гол алдаа болж хувирч байх шиг. Чөлөөт сэтгүүл зүйд хөндлөнгөөс тагнуул оролцож байгааг нь эмгэнэл гэж хэлье. Чөлөөт сэтгүүл зүйн үйл ажиллагаанд тагнуул болоод хүчнийхэн зэрэгцэн орвол Монголын сэтгүүл зүйн ардчилал суларч, ард түмний мэдээлэл авах суваг хаагдан бөглөрөх юм биш үү. /Рахметийн Сураган, МУСГЗ, Баян-Өлгий/³⁴¹
Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөлтэй дотоодын цөөн хэдэн компанийн нэг болох “Сод Монгол” групп Chuhat.mn сайтын редакцид зөвшөөрөлгүй нэвтэрч, сэтгүүлчдийг нь заналхийлэн, нэгжлэг хийж хэвлэлийн эрх чөлөөнд ноцтойгоор халдсан явдлыг Глоб Интернэшнл төвөөс буруушааж байна. 2018.01.26-ны өдөр 18.00 цагийн орчимд “Сод Монгол” группийн хуулийн зөвлөх, компьютерын инженер гэх хоёр хүн, Баянгол дүүргийн 5-р хорооны хэсгийн төлөөлөгч Н.Эрдэнэбилэг нарыг дагуулан тухайн сайтын редакцид шууд нэвтэрчээ. Ингэхдээ нэгжлэг хийх талаар шүүх, прокурорын ямар ч албан ёсны зөвшөөрөл үзүүлэлгүй түрэмгийлэн дайрч, тухайн сайтын админ эрхээр нь архивт нэвтэрч Ц.Анандбазар болон “Сод Монгол” групптэй холбоотой сөрөг мэдээллүүдийг түүж устгахыг шаардсан гэдгийг тухайн мөчид редакцид ажиллаж байсан сэтгүүлчид мэдүүлсэн. Мөн энэ үеэр “Сод Монгол” группийн ажилтнууд нь тус сайтын санхүүгийн тайланг авахыг завдсан төдийгүй сэтгүүлчдийн зургийг авч, байгууллагын компьютер, бусад өмчийг хураан авч явахыг завдсан аж. Chuhat.mn сайтыг эзэмшигч Б.Мөнхдөлийн тайлбарласнаар тус редакци шатахуун импортлогчдын талаарх мэдээллийг цувралаар нийтлэхээр төлөвлөж байсан бөгөөд 2015 онд “Үндэсний шуудан” сонинд нийтлэгдсэн “Сод Монгол” групптэй холбоотой материалыг эргэн сануулах зорилгоор сайтдаа нийтэлсэн нь энэ бүхний шалтгаан болсон гэж үзэж байгаа аж. Болсон явдалтай холбогдуулан Б.Мөнхдөл БГД-ийн цагдаагийн хэлтэс болон зохих ёсны төрийн албан байгууллагуудад хандсан ч тухайн хэсгийн төлөөлөгчийг ёс зүйн алдаа гаргасан гэх шалтгаанаар цалингийн 20 хувиар торгосноос өөр ямар ч арга хэмжээ аваагүй гэж мэдээлсэн юм.³⁴²
2018.12.12-ны өдөр сурвалжлага бэлтгэхээр “Шангри-Ла” зочид буудалд очсон “Засгийн газрын мэдээ” сонины сэтгүүлч Э.Батцэцэг, фото сэтгүүлч С.Батсайхан нарын сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд буудлын хамгаалалтын ажилтнууд халдлаа. АНУ-ын иргэн, зэвсэгт хүчний хошууч М.К.Стюарт гэх эр Улаанбаатар дахь “Шангри-Ла” зочид буудлын өрөөнд өөрийгөө боомилсон байдалтай нас барсан. Тэрбээр Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Төрийн департаментын хамтын ажиллагааны хүрээнд ажлын шугамаар манай улсад ажлаар иржээ. Хэргийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст шалгаж буй. Засгийн газрын мэдээ сонины фото сэтгүүлч С.Батсайхан 4 цаг хүлээсний эцэст талийгаачийн цогцсыг шүүх эмнэлгийн машин ирж авах үед гэрэл зургаар үйл явдлыг баримтжуулсан байна. Гэтэл хамгаалалтын албаныхан тухайн зурагчныг хөөж баривчлаад, зургийн аппаратыг нь булааж, гарыг нь мушгиад буудал руу чирч оруулжээ. Түүнчлэн редакцийн даалгавраар мэдээлэл бэлтгэж явсан сэтгүүлчийн биед нэгжлэг хийж, утсыг нь шалгаж, дотроос нь зургийг устгасан байна.³⁴³
УБТЗ шалгалт авах нэрийдлээр 50 гаруй насны эмэгтэйчүүдийг ажлаас нь халж буй тухай мэдээллийн мөрөөр тодруулга хийх гэж ороход тэндхийн хуулийн ахлах мэргэжилтэн нь манай зураглаачийг зодож, камерыг нь шууд булаасан. 2, 3 хүн нийлээд цохиод авч байх жишээний.

³⁴⁰ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2016”. Улаанбаатар. 2017 он. 18 дахь тал

³⁴¹ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2016”. Улаанбаатар. 2017 он. 18 дахь тал

³⁴² Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017”. Улаанбаатар. 2018 он. 10 дахь тал

³⁴³ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2018”. Улаанбаатар. 2019 он. 10 дахь тал

Гэтэл прокурор үүнийг хэрэгсэхгүй болгож, хэргийг манай зураглаачийн буруу байсан гэж үзсэн. /33 настай, эмэгтэй сэтгүүлч/

Эрүүл мэнд, техник гэхээсээ илүү мемори картыг нь авч яваад доторхыг нь устгаад буцаагаад өгчихдөг. Ингээд баримт нь байхгүй болохоор тэр хүн тэрийг үнэлэх боломжгүй, гомдол гаргаад явъя гэхээр хэн ч тоодоггүй, анхаардаггүй. Ийм юмнууд зөндөө гардаг. Тэгээд одоо нэгэнтээ өнгөрчихсөн энийгээ орхиё гээд л ингээд л цаашаа явдаг. Гомдол гэхэд хэцүү, биш гэхэд хэцүү. /37 настай, эрэгтэй сэтгүүлч/

2.5.9. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн сүлжээний хаягаа хакдуулах эсвэл блокуулах тохиолдол гарсан эсэх

Глоб интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл хамтран 2019 онд хэрэгжүүлсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторинг”-ийн тайланд дурдсанаар хувийн цахим хаяг (цахим шуудан болон нийгмийн сүлжээний хаягууд), түүнтэй холбоотой мэдээллүүдээ алдаж байсан гэж судалгаанд оролцогчдын 20 хувь буюу 5 сэтгүүлч тутмын нэг нь хариулсан. Хүйсийн хувьд ангилж харвал эмэгтэй сэтгүүлчид эрэгтэй сэтгүүлчдээс илүү хувийн цахим хаяг болон түүнтэй холбоотой мэдээллүүдээ алдаж байжээ. Тус сэтгүүлчдээс цахим халдлагад өртөхгүйн тулд ямар нэг програм хангамж болон цахим гэмт хэргээс сэргийлэх хамгаалалт хэрэглэж байсан эсэхийг тодруулахад 57 хувь тийм гэж хариулсан. Харин үлдсэн 43 хувь өмнөх хэв маягаараа ажиллаж байгаа болно. Харин 3 сэтгүүлч тутмын нэг нь интернет, мэдээллийн технологи, харилцаа холбооны компаниудаас цахим халдлагаас сэргийлсэн зөвлөгөө, сургалт, тусламж авч байсан гэжээ. Гэхдээ интернет орчин дахь болон мэдээллийн технологийн чиглэлийн мэдлэг дутмаг байгаа нь тухайн нөхцөл байдалд орсон эсэхээ тодорхойлж чадахгүй байдалд хүргэж байна. Мэдээллийн сайт халдлагад өртөж ажиллахгүй болсон тохиолдол бий.³⁴⁴

Жишээ 5. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн цахим хаягт халдсан жишээ

News.mn вэбсайт 2014 оны 8 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд “Хурандаа нарын ард хэн байв”, “АТГ-ын дээр “хөх тэнгэр” л бий” гарчигтай нийтлэлүүд гаргасны дараа буюу 6-ны үдээс хойшоос эхлэн вэбсайтын үйл ажиллагаа доголдож эхэлжээ. Редакцийн зүгээс үүнийг хянах боломжгүй болсон бөгөөд мэдээ нийтлэлийн гарчгууд өөрчлөгдөн, доромжилсон үг хэллэгээр солигдсон байна. Иймээс сайтын үйл ажиллагааг түр хаахаас аргагүй байдалд хүрчээ. Редакцийн хувьд контент үйлдвэрлэдэг, харин сайтын программ хангамжийг өөр компани гэрээгээр хариуцдаг байв. Орой сайт нээгдэхэд дээр дурдсан 2 нийтлэл устгагдсан байсан ба нийт 5 материалын гарчигийг доромжилсон үг хэллэгээр сольсон нь санаатай үйлдэл гэдэг дүгнэлтэд хүргэж байна. Сайтын зүгээс ТЕГ-ын Кибер аюулгүй байдлын газарт албан ёсоор хандсан боловч хоёр сарын дараа хэргийг үйлдсэн этгээдийг тогтоох боломжгүй гэсэн хариу авчээ.³⁴⁵

2015 оны 12 сарын 7-нд Хууль зүйн сайд асан Х.Тэмүүжинг гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг гээд 2 бичлэг сайт дээрээ гаргасан. Ерөөсөө 2 дахь нь гараад л тэр өдөр нь үдээс хойш манай сайт хакдуулсан. Бид зохих түвшинд нь, байж болох хэмжээнд нь явсан. Их хурал дээр хүртэл гомдол гаргасан ч хэн ч барагдуулаагүй. Бидэнд 2 IP хаяг илрүүлсэн, нэгнийх нь ард 3000 хэрэглэгч, нөгөөхийнх нь ард 4000 хэрэглэгч байна гэсэн хариу өгсөн. Сүүлд албан бус шугамаар сонсоход 2 залууг тогтоосон юм байна лээ. Гэхдээ энэ тухай бидэнд хэлээгүй. Түүнээс зөв зүгээр байж байгаад, зүгээр сууж байгаад за за энэ сайтыг хакдчихъя гээд хакдахгүй шүү дээ. Ямар нэг зорилготой л хийгдсэн ажил гэж боддог. /55 настай, эмэгтэй сэтгүүлч/³⁴⁶

³⁴⁴ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 43, 44 дэх тал

³⁴⁵ Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2012-2014”. 2015 он. Улаанбаатар. 22 дахь тал

³⁴⁶ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 43, 44 дэх тал

2.5.10. Эрх мэдэлтнүүд сэтгүүлчдийг хянах, тагнаж чагнах ажиллагаа явуулдаг эсэх

Улсын Их Хурлаас 2002 онд баталсан Эрүүгийн хуулийн 133 дугаар зүйлийн 133.1-т “Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Улсын Их Хурлаас 2015 онд баталж, 2017.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 13.12 дугаар зүйл /Хууль бусаар мөрдөж мөшгих/-ийн 1-т “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн бол”, 2-т “Эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгисөн бол”, 21.13 дугаар зүйлийн 1-т “Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гүйцэтгэх ажлын тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол”, 2-т “Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажил явуулсан бол” тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Энэ төрлийн гэмт хэргүүдийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг шүүхийн цахим санд нууцалсан байна.

Нэр бүхий есөн сэтгүүлч болон тэдний ар гэрийн 30 хүний мэдээллийг хууль бусаар олж аван тагнаж, чагнасан гэх мэдээлэл 2018.04.26-нд нийтэд ил болсон. Энэ хэрэгт холбогдуулан Тагнуулын ерөнхий газраас зохих албан тушаалтнуудад эрүүгийн хэрэг үүсгүүлэх хүсэлтээ Нийслэлийн прокурорын газарт албан ёсоор хүргүүлсэн байна. Энэ талаар Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Г.Бясман “Цагдаагийн байгууллагын нэр бүхий албан тушаалтнууд хамтарч Гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчиж, нэр бүхий сэтгүүлч, хувь хүнийг тагнаж, чагнасан гэх асуудлыг Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах хэлтсээс шалгаж, цагдаагийнханд эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татах саналаа манайд ирүүлсэн. Прокурор энэ хэргийг хянаж байна” гэсэн хариулт өгсөн байна. Энэ нь Монголд хэвлэлийн эрх чөлөө, цаашлаад Үндсэн хуулиар баталгаажсан хүний халдашгүй дархан байх эрх зөрчигдөж буйн илрэл тул дээрх хэргийг цаг алдалгүй, олон нийтэд нээлттэйгээр шалган шийдвэрлэх ёстой гэж Глоб Интернэшнл төв үзэж мэдэгдэл гаргасан байна.³⁴⁷

2019 онд хийсэн өдөр тутмын мэдээ мэдээлэл, эрэн сурвалжлах, нийгэм эдийн засгийн чиглэлээр бичдэг 300 сэтгүүлчийг хамруулсан санал асуулгад тэдний 21% нь “ажил хэргийн шалтгаанаар утсаар тагнаж, чагнаж байсан” гэж хариулсан.³⁴⁸

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутгаас их хэмжээний мод шилжүүлэн суулгах тусгай зөвшөөрөлтэй гэх нэрээр хэдэн зуун мянган зулзаган модыг дуртай газраасаа үндсээр нь булгалж, машин машинаар зөөж, Улаанбаатар хотын тансаг хотхонуудын ногоон байгууламжийг бүрдүүлэлцэж байгаа гэж мэдүүлээд “Тэрбум” мод-нд нийлүүлж, тоонд нь оруулж байж болзошгүй байдлыг эргэлт.мн сайтын сэтгүүлч 2021 оны намар газар дээрээс нь сурвалжилсан байна. Нөлөө бүхий, эрх дархтай мод шилжүүлэн суулгах тусгай зөвшөөрөлтэй 5 компанийн хууль бус үйлдлүүд, мөнгө угаах бизнесийг баримтаар цувралаар дэлгэж, тэд ч, Ерөнхийлөгчийн Тамгын газраас ч “Шилжүүлэн суулгах зориулалттай модыг ‘Тэрбум мод’ тарих аяны тоонд ёстой оруулаагүй” хэмээн мэдэгдэл хүртэл гаргаж байсан. Гэтэл 2022.01.31-ний өдөр Эргэлт.мн мэдээллийн сайтын редакцад Эрүүгийн цагдаагийн газраас шалгалт хийж, Ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүдийн гомдлоор нэгжлэг, ажлын байрны зураг авалт хийсэн. Ингэхдээ үзлэг, шалгалтын

³⁴⁷ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017”. Улаанбаатар. 2018 он. 12 дахь тал

³⁴⁸ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 39 дэх тал

зөвшөөрөл, бусад бичгийг үзүүлээгүй, үзүүлэх шаардлагагүй гэжээ.³⁴⁹ Ийм ажиллагаа нь хууль бус мөрдөн шалгах ажиллагаанд тооцогдоно. Тодруулбал, Улсын Их Хурлаас 2017.05.18-ны өдөр баталж, 2017.07.01-нээс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүний халдашгүй байх эрхэд хууль ёсны дагуу халдахад баримтлах хэм хэмжээг зохицуулсан бөгөөд 23.2 дугаар зүйлд хүний биед үзлэг хийх, 24.1 дүгээр зүйлд нэгжлэг хийх, 24.2 дугаар зүйлд хүний биед нэгжлэг хийх, 24.3 дугаар зүйлд орон байр, бусад газарт нэгжлэг хийх, 24.4 дүгээр зүйлд эд мөрийн баримт хураан авах, 24.5 дугаар зүйлд мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, 26.1 дүгээр зүйлд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, 26.2 дугаар зүйлд харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох, 26.3 дугаар зүйлд хяналт тогтоох, 26.4 дүгээр зүйлд ажиглалт явуулах, 27.10 дугаар зүйлд хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах талаар тус тус зохицуулсан бөгөөд эдгээр ажиллагааг явуулах хангалттай үндэслэл байгаа талаар мөрдөгч санал гаргаж, прокурорын зөвшөөрлийг авна. Ажиллагааны явцад хүний эрхийг хангах арга хэмжээний талаар прокурорын зөвшөөрөлд заахаар тусгасан.³⁵⁰ Эрүүгийн цагдаагийн газрын дээрх “шалгалт” нь хулгайг, цаашилбал хамтын худал хуурмаг, заль мэх, байгаль орчны эсрэг гэмт үйлдлийг нь ил гаргасан хэвлэлийг, сэтгүүлчийг гурван сар цагдаагийн үүдэнд “уяад”, байцаагаад, айлгаж, дарамтлах үйлдлийн үргэлжлэл болохыг тус сайтын редакц мэдэгдсэн байна.³⁵¹ Энэ нь эрх мэдэлтнүүд сэтгүүлчдийг хянах, тагнаж чагнах оролдлого юм.

2.5.11. Сэтгүүлчдийн эх сурвалжийг бие махбодь буюу сэтгэл санааны дарамтад оруулдаг эсэх

Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль одоо болтол байхгүй. Зөвхөн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороодын 2015.04.14-ний өдрийн нэгдсэн хуралдааны нэгдүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 8 дахь “Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална” гэсэн заалтаар сэтгүүлчдэд нууц эх сурвалжаа хамгаалах ёс зүйн үүргийг хүлээлгэдэг. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.5.6-д “мэдээлэл өгч байгаа иргэн, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх”, 4.1.8.2-т “эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох”, 4.1.8.3-т “хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх” гэж тус тус заасан.³⁵²

Монгол Улсын Их Хурлаас 2015.12.03-ны өдөр баталж, 2017.07.01-ний өдрөөс эхлэн үйлчилж буй Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад төрийн нууцтай холбоотой гурван гэмт хэргийг хуульчилсан. Ингэхдээ 2002 оны Эрүүгийн хуульд заасан “Төрийн нууц задруулах”, “Төрийн нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлийг үрэгдүүлэх” гэмт хэргээс гадна

³⁴⁹ Ergelt.mn “Тэрбум мод тарих аян Хүдэр сумын зулзган нарсан ойг сүйдэлж дууслаа” цуврал сурвалжилга. 2021.11.08, 2021.11.09 <https://ergelt.mn/news/176/single/15262>; <https://ergelt.mn/news/59/single/15297> “Уулын модыг шилжүүлэн суулгахыг зогсоо, Ерөнхийлөгч өө” 2021.11.15 <https://ergelt.mn/news/59/single/15423> “Ойн ангийнхан модны хулгайчидтай халаас нэгтгэж, уулын модыг зөөж байна, Ерөнхийлөгч өө” 2022.01.24, <https://ergelt.mn/news/59/single/17510>; 2022.01.25 <https://ergelt.mn/news/59/single/17560>

³⁵⁰ Л.Галбаатар. Халдашгүй байх эрхэд халдах зөвшөөрлийн тогтолцоо. “Нээлттэй нийгэм форум”-ын “Бодлогын асуудал” цуврал. №31, 2020 оны 6 дугаар сар

³⁵¹ Б. Энхмарт. “Эргэлт.мн мэдээллийн сайтын редакцияд Эрүүгийн цагдаагийн газраас шалгалт хийж байна”. 2022.01.30 https://www.facebook.com/100001498223449/posts/4862842577108968/?_rdc=1&_rdr 2022.01.30 <https://www.facebook.com/enkhmart.mart/posts/4863157327077493>

³⁵² Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”

агуулгын хувьд өөр “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 19.11 дүгээр зүйлд шинээр бие даасан гэмт хэрэг болгон оруулсан байна. Ингэснээр, зөвхөн төрийн нууцыг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд бус иргэн, сэтгүүлчийн хувьд энэ гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болох эрсдэлтэй болсон байна. 2004.12.06-ны өдөр НҮБ-ын үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (OSCE) Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх Төлөөлөгч, Америкийн орнуудын байгууллагын (OAS) Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний Тусгай илтгэгч нарын гаргасан Хамтарсан тунхаглалд “Төрийн нууцыг хамгаалах үүргийг зөвхөн түүнийг хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтан хүлээнэ. Сэтгүүлч, иргэний нийгмийн төлөөлөгч зэрэг бусад этгээдийн хувьд мэдээллийг нийтэлсэн, түгээсний төлөө хууль зүйн хариуцлага хүлээх ёсгүй. Төрийн нууц хариуцсан этгээд түүнийг түгээсний төлөө хариуцлага хүлээх нөхцөлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт тусгах ёстой” гэсэн нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд шууд хамаатай байна.³⁵³ 2019 онд Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд заасан “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэрэгт сэтгүүлчийг холбогдогчоор татсан тохиолдлыг Глоб интернэшл төв бүртгэсэн байна.³⁵⁴

2019 онд 300 сэтгүүлчийг хамруулан хийсэн асуулгын судалгаагаар, нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ. Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид хамгийн их тохиолдсон байна. Сэтгүүлчийн нас ахихын хэрээр дээрх тохиолдол буурч байна. Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдолд сэтгүүлчийн хүйсийн ялгаа хамааралгүй байна. Дунджаар нэг сэтгүүлч 4 удаа дээрх нөхцөл байдалд орж байжээ. Сэтгүүлчийн бичсэн мэдээ, нийтлэл гарсны дараа нэр дурдсан байгууллага болон эрх мэдэл бүхий албан тушаалтан ямар эх сурвалжаас мэдээлэл авсан тухай асуудаг. Мөн сэтгүүлчийн эсрэг шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхээс сэтгүүлчийг тухайн мэдээллийн баримтаа нотлохыг шаарддаг нь нууц эх сурвалжаа илчлэхээс өөр аргагүй байдалд оруулж байна.³⁵⁵

2019 оны 5 сараас 2020 оны 5 сар хүртэлх хугацаанд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой мэргэжлийн эрхийн зөрчлийг цахимаар нээлттэй асуулга явуулж бүртгэхэд нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан 44 зөрчил гарсан байна. Тодруулбал, судалгаанд оролцсон 86 сэтгүүлчийн 44 буюу 51.2% нь “Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан” тохиолдолтой тулгарч байсан байна.³⁵⁶ 2021 онд 80 сэтгүүлчийг хамруулан хийсэн асуулгын судалгаагаар, мэдээллийн эх сурвалжаа ил болгохыг эрх бүхий байгууллагаас шаарддаг тохиолдол судалгаанд оролцогсдын 81.5%-д нь тохиожээ.³⁵⁷ Эндээс харахад, Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль одоо болтол байхгүй тул сэтгүүлчдийн эх сурвалжийг бие махбодь буюу сэтгэл санааны дарамтад оруулах бодит эрсдэл өндөр байна.

Жишээ 6. Сэтгүүлчийг нууц эх сурвалжаа илчлэхийг шаардсан жишээ

Хөвсгөл аймгийн сэтгүүлч Ж.Энхцэцэгийн бэлтгэн TV9 телевизээр 2020.03.13-ны өдрийн дугаараар олон нийтэд цацагдсан мэдээлэлтэй холбогдуулан нууц эх сурвалжийг илчлэхийг орон нутгийн цагдаагийн байгууллагаас албадсан тохиолдол гарав. Олон нийтийн радио,

³⁵³ Joint Declaration by the UN Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, the OSCE Representative on Freedom of the Media and the OAS Special Rapporteur on Freedom of Expression. 6 December 2004. p.35 <https://www.osce.org/fom/99558?download=true>

³⁵⁴ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2019”. Улаанбаатар. 2020 он. 14 дэх тал

³⁵⁵ Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он. 42 дахь тал

³⁵⁶ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2019”. Улаанбаатар. 2020 он. 33 дахь тал

³⁵⁷ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”. Улаанбаатар. 2021.05.03. 41 дэх тал

телевизийн тухай хуулийн 34.2-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Үүнийг зөвхөн олон нийтийн радио, телевизийн ажилтанд хамаарах заалт гэж ойлгох нь учир дутагдалтай бөгөөд жишгийн эрх зүйгээр бүх сэтгүүлчдэд олгогдсон эрх юм. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 8-д “Мэдээллийн эх сурвалжаа чандлан хамгаална” гэж заасан нь сэтгүүлчийн заавал мөрдөх ёс зүйн үүрэг тул эх сурвалжаа илчлэхийг албадахыг хэрхэвч зөвшөөрөхгүй талаар Глоб интернэшнл төвөөс Хөвсгөл аймгийн цагдаагийн хэлтэст албан бичиг хүргүүлсэн байна.³⁵⁸

Архангай аймгийн сэтгүүлч А-ийн редакад тус аймгийн цагдаагийн хэлтсээс “мэдээ нийтэлсэн албан хаагчдын талаарх мэдээлэл шаардлагатай байх тул яаралтай ирүүлж хамтран ажиллана уу” гэсэн утга бүхий албан тоот ирсэн. Мөн Зариг.мн сайтад эх сурвалжаа илчлэхийг хүссэн албан тоот ЦЕГ-ын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах албанаас 2020.09.17-ны өдөр ирүүлсэн. Эндээс үзвэл, эх сурвалжаа илчлэхийг эрх бүхий байгууллагаас албадахаас илүүтэйгээр хамтран ажиллах нэрийдлээр шаардах нь ихэссэн байна. Гэвч Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34.2-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Энэ заалтыг зөвхөн олон нийтийн радио, телевизийн ажилтанд хамаарах заалт гэж ойлгох нь учир дутагдалтай бөгөөд жишгийн эрх зүйгээр бүх сэтгүүлчдэд олгогдсон эрх юм. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 8-д “Мэдээллийн эх сурвалжаа чандлан хамгаална” гэж заасан нь сэтгүүлчийн заавал мөрдөх ёс зүйн үүрэг тул эх сурвалжаа илчлэхийг албадахыг хэрхэвч зөвшөөрөх ёсгүй.³⁵⁹

³⁵⁸ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2019”. Улаанбаатар. 2020 он. 37 дахь тал

³⁵⁹ Глоб Интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”. Улаанбаатар. 2021.05.03. 45 дахь тал

3. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ЖИШИГ

3.1. Олон улсын нөхцөл байдал ба зөвлөмжийн тойм

3.1.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эсрэг аюул, заналхийлэл

Мэдээллийн үйлчилгээг онлайнаар хааж, сэтгүүлчдийг хууль бусаар тагнасан, хэвлэл мэдээллийн сайтуудыг хакдах тохиолдол дэлхий дахинаа хүчтэй үзэгдэл болж байна. Засгийн газрууд интернэт, гар утасны сүлжээ, эсвэл олон нийтийн мэдээллийн сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарласан тохиолдол 2019 онд оргил цэгтээ хүрч 213 тохиолдол бүртгэгдсэн нь онцгой тохиолдол юм.³⁶⁰ “Access now” байгууллагын мэдээлснээр 2020 он гарсаар Ковид-19 цар тахлын үед дэлхий даяар цахим орчинд мэдээлэл авах эрхийг хязгаарласан 155 тохиолдол 29 оронд бүртгэгджээ. 2019 онд 213 тохиолдол, 2018 онд 196 тохиолдол тус тус бүртгэгдэж байсантай харьцуулахад буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа ч энэ нь цахим орчин дахь мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хувьд бага тоо биш юм. Ялангуяа цар тахлын улмаас хөл хорио тогтоосон үед олон нийтийн мэдээлэл авах эрх зөрчигдөх нь олон сөрөг үр дагавартай байна. Жишээ нь Этиоп улсад цар тахлын оргил үед буюу хоёр долоо хоногийн турш үндэсний интернэт тасарсан нь 100 сая гаруй хүний амьдралд нөлөөлсөн байна. Мөн Бангладешийн Коксын Базар дахь Рохинга дүрвэгсдийн хуаран орчимд ойролцоогоор нэг сая орчим оршин суугчид 355 өдрийн турш интернэт, харилцаа холбоо тасарсны улмаас хохирчээ.³⁶¹

Глобалчлагдсан, цахим эрин үед цахим орчин дахь хэвлэл мэдээллийн зохих зохицуулалт байхгүй нь мэдээллийн эмх замбараагүй байдлыг бий болгож байна. Суртал ухуулга, сурталчилгаа, цуурхал зэрэг нь сэтгүүл зүйг зах замбараагүй шууд өрсөлдөөний талбарт оруулав. Ингэснээр арилжааны, улс төрийн мөн редакцийн агуулгын хоорондын төөрөгдөл нэмэгдэж байгаа нь үзэл бодол, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ардчилсан баталгааг тогтворгүй болгож байна. Улмаар хуурамч мэдээллийн тархалтыг хязгаарлах үүднээс бие даасан, шүүмжлэгч сэтгүүл зүйд хатуу дарамт бий болгох аюултай хуулиудыг батлахыг дэмжих үндэслэл болж байна. Жишээ нь Бенин болон Сингапур улсууд худал мэдээлэл, цахим гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой гэх боловч үнэн хэрэгтээ мэдээлэх эрх чөлөөг дур зоргоороо хязгаарлахад ашигласан хууль тогтоов. Цар тахал дэгдсэнээр цуу яриа, хуурамч мэдээний тархалт вирустэй адил хурдан хугацаанд түгэж байна. Орос, Энэтхэг, Филиппин, Вьетнам улсууд төрийн тролл армийг нийгмийн мэдээллийн хэрэгслээр хуурамч мэдээлэл, сурталчилгаа тараах зэвсэг болгон ашигласаар байна.³⁶² Зарим засгийн газар тодорхой төрлийн контентыг хаах эсвэл хэрэглэгчдийг онлайнаар мэдээлэл хайхад саад болох боломжийг сааруулахад интернэтийн “шүүлтүүр”, “тролл” зэрэгт хөрөнгө оруулж байна. Сүүлийн 5 жилд, томоохон интернэт платформууд дээр контент устгуулах засгийн газрын хүсэлт хоёр дахин нэмэгджээ.³⁶³

2022.01.22-нд Туркийн сэтгүүлч Седеф Кабасыг Ерөнхийлөгч Режеп Тайп Эрдоганыг доромжилсон зүйр үг твиттерт жиргэсний улмаас хэрэгт холбогдуулан баривчилсан. Кабас сөрөг хүчний телевизийн суваг болон өөрийн твиттер хуудастаа нэгэн зэрэг тус зүйр үгийг түгээж, засгийн газрын албан тушаалтнуудын зэмлэлийг хүлээх шалтгаан болжээ. Тэрээр

³⁶⁰ Access now. Keep it on report. March 2021 https://www.accessnow.org/cms/assets/uploads/2021/03/KeepItOn-report-on-the-2020-data_Mar-2021_3.pdf

³⁶¹ Access Now. #KeepItOn coalition report. 2020

https://www.accessnow.org/cms/assets/uploads/2021/03/KeepItOn-report-on-the-2020-data_Mar-2021_3.pdf

³⁶² Reporters Without Borders. RSF 2020 Index: Asia-Pacific — hyper-control and national-populist excesses. <https://rsf.org/en/rsf-2020-index-asia-pacific-hyper-control-and-national-populist-excesses>

³⁶³ UNESCO6 Freedom of Expression and Media Development, Journalism is a public good. World Trends in Global Report 2021/2022 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000379826/PDF/379826eng.pdf.multi>

твиттер хуудастаа “Бух ордонд орж ирлээ гээд хаан болдоггүй, ордон нь амбаар болдог” гэж нийтэлжээ. Энэ талаар Олон улсын хэвлэлийн холбооноос сэтгүүлч Кабасыг нэн даруй суллахыг шаардаж “Хэвлэл мэдээллийн амыг хаах үед ардчилал гэж үгүй болно” гэж мэдэгджээ. Цахим эрин дэх хэвлэл мэдээллийн бие даасан байдал, олон талт байдлын талаарх хамтарсан тунхаглалд улс орнуудыг оффлайн болон онлайн орчин дахь үзэл бодлын илэрхийлэлд хатуу ял шийтгэл оноох, шаардлагагүй хууль гаргахаас татгалзах ёстой, хэрэв хязгаарлах шаардлагатай бол олон улсын эрх зүй, хязгаарлалтын шалгуурын дагуу буюу хууль ёсны ашиг сонирхлын аль нэгэнд үйлчлэх, тэрхүү ашиг сонирхлыг хамгаалахын тулд зохих хэмжээгээр хязгаарлах ёстой гэсэн байдаг.³⁶⁴ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэгч, сэтгүүлчдийг гагцхүү Засгийн газар, эсвэл Засгийн газрын дэмжлэгтэй улс төр, нийгмийн тогтолцоог шүүмжилсний төлөө шийтгэл ногдуулахыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зайлшгүй хязгаарлалт гэж үзэх боломжгүй.³⁶⁵

2020 он гарснаас хойш Ковид-19-ийн нийгмийн эрүүл мэндийн хямралын нөлөөгөөр хараат бус сэтгүүл зүйд тулгамдаж буй асуудлуудыг Хил Хязгааргүй Сурвалжлагчид (RSF) байгууллагаас тодорхойлжээ. Үүнд геополитикоос үүдэлтэй хямрал хамгийн эхэнд бичигдэж байгаа бөгөөд энэ нь дарангуйлагч эрх баригч, популист дэглэмийн удирдагчид мэдээллийг нуун дарагдуулж, олон талт, хараат бус сэтгүүл зүйгүйгээр дэлхий ертөнцийг үзэх үзлээ тулгах бүхий л хүчин чармайлтыг гаргаж байгааг онцолжээ. Эрх мэдэл хэт нэг гарт төвлөрсөн засаглалтай улс орнууд хэвлэлийн эрх чөлөөний индексээрээ хамгийн доогуур байрыг эзэлсэн хэвээр байна. “Дэлхийн хэвлэл мэдээллийн шинэ дэг журам” тогтоохыг оролдож байгаа БНХАУ мэдээллийн хэт хяналтын системээ хадгалсан хэвээр байна. Үүний улмаас нийгмийн эрүүл мэндийн хямралын үед дэлхий нийтэд үзүүлэх сөрөг үр дагавар нь харагдсан. Хятад, Саудын Араб, Египет хэвлэлийн эрх чөлөөгөөрөө хамгийн доогуур байранд жагсаж эдгээр улс орнууд нь сэтгүүлчдийн хувьд хамгийн том шорон гэгдэж байна. Мөн ОХУ онлайн мэдээллийг хянахын тулд улам нарийн аргуудыг ашиглаж байгаа бол Энэтхэгийн зүгээс Кашмирт түүхэн дэх хамгийн урт цахим хөл хориог тогтоов. Харин Египетэд “хуурамч мэдээ” гэх шалтгаанаар вэбсайт, цахим хуудаснуудыг хааж үйл ажиллагаа явуулах боломжгүй болгожээ.³⁶⁶ Үүнээс харахад хэвлэл мэдээлэлд нөлөөлөх төрийн шууд болон шууд бус хяналт нь хувь хүний үзэл бодлын эрх чөлөөнд нөлөөлөхөөс гадна өргөн утгаараа нийгэм, улс орон, дэлхий даяар үзүүлэх олон сөрөг нөлөөллийг бий болгох эрсдэлтэй байна.

2022 он гарсаар авторитар төрийн дэглэмтэй Казахстаны Алматы хотод шингэрүүлсэн хийн түлшний үнэ огцом нэмэгдсэнтэй холбогдуулан ард иргэдийн дунд хүчтэй эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөж улмаар цагдаа, цэргийн хүчнийг хамарсан цуст мөргөлдөөн бий болсон. Үймээний үеэр 2500 гаруй хүн шархдаж, 224 хүн амь насаа алдсан хэмээн “The Guardian” цахим хуудастаа мэдээлжээ.³⁶⁷ Үүний дотор эсэргүүцлийн жагсаалыг сурвалжлахыг оролдсон сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд халдлагын золиос болж 1 хэвлэл мэдээллийн ажилтан амь насаа алдсан байна. Бослого үймээний үеэр худал мэдээлэл тараасан нөхцөлд 3-7 жилээр ял шийтгэл эдлүүлнэ хэмээн ерөнхийлөгч Токаев мэдэгдэлдээ онцлон дурдсан нь хэвлэлийн эрх чөлөөнд ноцтой заналхийлэл учруулсан алхам юм. Бослогын үеэр Төв Азид мэргэшсэн бие даасан мэдээллийн агентлаг “Fergana”-ийн редактор Данил Кисловыг 1 дүгээр сарын 7-нд нийтэлсэн засгийн газар доторх

³⁶⁴ Joint Declaration on Freedom of Expression and responses to conflict situations, 6 May 2014

<https://www.ohchr.org/en/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=15921&LangID=E>

³⁶⁵ UN Human Rights Committee (HRC), General comment no. 34 (42), Article 19, Freedoms of opinion and expression, 12 September 2011, CCPR/C/GC/34, available at: <https://www.refworld.org/docid/4ed34b562.html>

³⁶⁶ Reporters without borders. RSF 2020 Index: Asia-Pacific — hyper-control and national-populist excesses <https://rsf.org/en/rsf-2020-index-asia-pacific-hyper-control-and-national-populist-excesses>

³⁶⁷ The Guardian. Kazakhstan authorities raise death toll from unrest to 225. Jan 16, 2022

<https://www.theguardian.com/world/2022/jan/16/kazakhstan-authorities-raise-death-toll-from-unrest-to-225>

бүлэглэлүүдийн тэмцлийн тухай нийтлэлийг устгахыг шаардсан байна. Тус агентлаг шаардлагыг биелүүлэхээс татгалзаж, эрх баригчдаас уг нийтлэлийн аль хэсэг нь “Казахстаны нийгэм, улс төрийн аюул занал” болохыг тодруулахыг хүссэн байна. Үүнээс хэдэн цагийн дараа тус агентлагийн вэбсайтад нэвтрэх эрхийг хаасан байна.³⁶⁸

2016-2020 оны хооронд ажил үүргээ гүйцэтгэж яваад 4000 сэтгүүлч амь насаа алдсан гэсэн ЮНЕСКО-ийн тоон мэдээлэл байна. Мөн ковид-19 нийгмийн эрүүл мэндийн хямрал нь хэвлэлийн эрх чөлөөний зөрчлийг халхавчлах таатай боломж болсон юм. Тухайлбал мэдээлэл авах эрхийн хязгаарлалт 102, баривчлах шийтгэх 102, цензурдэх 95, бие мах бодид халдах болон үг хэлээр доромжилж дайрах 238 тохиолдол бүртгэгдсэн байна.³⁶⁹ Дэлхий дахинаа өнөөдөр ч хэвлэлийн эрх чөлөөний төлөө сэтгүүлчид амь насаа алдсаар байна. Мөн эрх мэдэлтнүүд, төр засгийг шүүмжилснийхээ төлөө зөвхөн сэтгүүлчид төдийгүй энгийн ард иргэд ч ял шийтгэл эдэлж байна. 2022 он гараад удаагүй байгаа ч дэлхий дахинаа нийт 12 хэвлэл мэдээллийн ажилтан амь насаа алдсан. Үүнээс 10 нь сэтгүүлчид байна. Мөн 365 сэтгүүлч, 102 иргэний сэтгүүлч, 24 хэвлэл мэдээллийн ажилтнууд ял шийтгэл эдэлж буй гэсэн тоо баримтыг “Хил Хязгааргүй Сурвалжлагчид” (RSF) мэдээлжээ. Эдгээр тоон үзүүлэлтээс харахад Хятад, Саудын Араб, Мьянмар, Вьетнам зэрэг дарангуйлал, эрх мэдэл хэт төвлөрсөн улс орнуудад хэвлэлийн эрх чөлөө ихээр зөрчигдөж байгаа нь ажиглагдаж байна.³⁷⁰

Сүүлийн таваас арван жилийн хугацаанд дан ганц сэтгүүлчдийн үйл ажиллагаанд нөлөөлж, хорих цагдах гэхээс илүүтэйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн бие даасан байдалд нөлөөлөх илүү нарийн оролдлогууд ардчилал, чөлөөт хэвлэлтэй орнуудад гарч буй нь ажиглагдаж байна. Ингэхдээ засгийн газрын оролцоотойгоор хэвлэл мэдээллийн өмчлөлийн өөрчлөлт, зохицуулалт хийх болон санхүүгийн дарамт, шударга сэтгүүлчдийг олон нийтэд илтэд буруушаах зэрэг явдал юм. Мөн засгийн газрууд гэрээ, зохицуулалтын таатай шийдвэр гаргах, төрийн мэдээллийг давуу эрхтэйгээр авах боломж зэрэг шууд бус аргуудыг ашиглан найрсаг аргаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дэмжлэг, нөлөө үзүүлэх замаар хэвлэл мэдээлэлд нөлөөлөх төрийн шууд бус оролцооны аргуудыг ашиглаж байна. Энэ нь улмаар хэвлэлийг олон нийтэд гэхээсээ илүү эрх мэдэлтэй хүмүүст үйлчилдэг болгох зорилгыг агуулж байна.³⁷¹

Дэлхий дахинаа 1400 сэтгүүлчээс авсан судалгаагаар, нийт сэтгүүлчдийн 2/3 буюу 65 хувь нь ажил үүргээ гүйцэтгэж байхдаа аюулгүй байдлыг бага мэдэрдэг гэсэн хариулт өгчээ.³⁷² Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь редакцийн үүрэг төдийгүй сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах тухай ойлголт нь хүний эрхийг хамгаалах улс төрийн үүрэг хариуцлагатай салшгүй холбоотой. Сэтгүүлчийн ажил “галын шугам” дээр өрнөж байдаг учраас мэргэжлийн онцлогийг харгалзан үзэж тэдний эрх, аюулгүй байдал зөрчигдөж байгаа эсэхийг тусгайлан авч үзэх хэрэгтэй. Улс, орнууд сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахын тулд зохих хууль тогтоомж, дүрэм журам, бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхийг ЮНЕСКО-ийн сэтгүүлчдийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдэд дурджээ. Төрөөс сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангаж нэр төр гутаах, айлган сүрдүүлэх, яллах зорилготой

³⁶⁸ Reporters Without Borders. RSF refers violence against reporters covering protests in Kazakhstan to UN, 2022.01.12 <https://rsf.org/en/news/rsf-refers-violence-against-reporters-covering-protests-kazakhstan-un>

³⁶⁹ World Trend in in Freedom Expression and Media Development, Global report 2021/2022, page 12, UNESCO, 2021 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000379826/PDF/379826eng.pdf.multi>

³⁷⁰ Reporters Without Borders. Violations of press freedom barometer. The figures in 2022 <https://rsf.org/en/barometer>

³⁷¹ Freedom and the Media, Media Freedom downward spiral, Sarah Repucci, 2019 <https://freedomhouse.org/report/freedom-and-media/2019/media-freedom-downward-spiral>

³⁷² International Center for Journalists. Trust me, I'm a journalist, Sharon Mashovi, Jan 4 2022 <https://www.icfj.org/news/trust-me-im-journalist>

ямар нэг хууль тогтоомж батлахгүй байх тухай дээрх шалгуур үзүүлэлтэд дурдсан.³⁷³ Харамсалтай нь өнөөдөр дэлхий дахинд хамгийн багадаа 160 улс орон гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэгт тооцон ял шийтгэл эдлүүлсэн хэвээр байгааг ЮНЕСКО-ийн өгөгдөл харуулж байна. Мөн 2016 оноос хойш 44 улс хамгийн багадаа 57 хууль, тогтоомжийг баталж, өөрчлөн найруулж цахим орчин дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөнд аюултай хуулиудыг бий болгожээ.³⁷⁴

Дэлхий дахинаа найдваргүй эх сурвалж бүхий мэдээ цацсан, нийтэлсэн гэх шалтгаанаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үл итгэх байдал нэмэгдсээр байна. Олон нийтийн байгууллагуудад итгэх итгэлийг судалдаг “Edelman Trust Barometer”-ийн сүүлийн судалгаагаар санал асуулгад оролцсон хүмүүсийн 57% нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь найдваргүй мэдээлэл түгээдэг гэж үзсэн байна. Энэхүү итгэлцлийн хямралаас болж сэтгүүлчид Ирак, Ливан, Чили, Болив зэрэг дэлхийн олон оронд болж буй томоохон эсэргүүцлийн жагсаалын үеэр олон нийтийн уур хилэнгийн бай болсоор байна.³⁷⁵ Сэтгүүлч, редакцийн хараат бус, бие даасан, аюулгүй байдлыг хамгаалах, түүний ач холбогдлыг нь засгийн газар, улс төрийн бүлгүүд сэтгүүлчдийн эвлэл, мэргэжлийн байгууллага, иргэний нийгэм, академик боловсролын байгууллага зэрэг нийгмийн бүхий л нэгжид хамаатай болохыг нийтээрээ ухамсарлах шаардлагатай болж байна.

3.1.2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тулгарч буй эдийн засгийн асуудал

Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) олон улсын байгууллагын тодотгосноор, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тулгарч буй эдийн засгийн асуудлууд нь нийгмийн үр дагавар болон дэлхий даяарх хэвлэл мэдээллийн редакцийн эрх чөлөөнд нөлөөлдөг. Эдийн засгийн байдал нь хүнд байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аливаа дарамт шахалтыг эсэргүүцэх чадваргүй байдаг. Эдийн засгийн хямрал нь өмчлөл төвлөрлийн үзэгдлийг бий болгож улмаар ашиг сонирхлын зөрчлөөс үүдэн сэтгүүл зүйн олон талт, хараат бус байдалд заналхийлж байна.³⁷⁶

Интернэтийн эрин үед арилжааны хэвлэл мэдээллүүд урт хугацааны хямралд дээд цэгтээ хүрч байна. Уламжлалт хэвлэл мэдээллийн арилжаа, зар сурталчилгааны орлого буурснаар сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтны ажлын байр буурч байна. Энэ хямрал нь хэвлэмэл хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хүчтэй цохилт болсон ч өдөр тутмын сонинууд эдийн засаг, улс төрийн шийдвэр гаргагчид болон мэдээ мэдээллийн гол эх сурвалж хэвээр байна. Дэлхийн зарим улс оронд энэ хямралаас үүдэн сэтгүүлчдийн ажлын байр 50 хүртэлх хувиар буурчээ. Европын орнуудад уламжлалт хэвлэл мэдээлэлд тулгарч буй дээрх асуудлыг шийдвэрлэх үүднээс хоёр төрлийн бодлого баримталж байна. Үүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үзүүлэх шууд болон шууд бус дэмжлэг буюу татаас. Шууд бус дэмжлэгт тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд татварын хөнгөлөлт үзүүлэх, төрийн сурталчилгаа явуулах зэрэг хэтийн төлөвтөө хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үр ашиг багатай дэмжлэг юм. Шууд дэмжлэг гэдэг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид болон байгууллагын хэтийн төлөвийн алдагдлыг бууруулахад зориулсан голчлон арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ашгийг хамтран эзэмшихэд чиглэгддэг. Харин олон нийтийн телевизүүдийг төрөөс тогтвортой санхүүжүүлж байгаа нь улс төрийн зөв шийдвэр болох нь

³⁷³ Journalists' Safety Indicators: International Level Based on the UNESCO's Media Development Indicators, 25 July 2013, <https://en.unesco.org/themes/safety-of-journalists/journalists-safety-indicators>

³⁷⁴ UNESCO. World Trend in in Freedom Expression and Media Development, Global report 2021/2022, page 12, 2021 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000379826/PDF/379826eng.pdf.multi>

³⁷⁵ Reporters Without Borders. 2020 World Press Freedom Index: “Entering a decisive decade for journalism, exacerbated by coronavirus” <https://rsf.org/en/2020-world-press-freedom-index-entering-decisive-decade-journalism-exacerbated-coronavirus>

³⁷⁶ Reporters without borders. RSF 2020 Index: Asia-Pacific – hyper-control and national-populist excesses <https://rsf.org/en/rsf-2020-index-asia-pacific-hyper-control-and-national-populist-excesses>

олон улсад ажиглагдаж байна. Мөн “гуравдагч хэсэг” болох ашгийн бус хүй олны хэвлэл мэдээлэл олон янзаар хөгжиж байна. Тухайлбал эрэн сурвалжлах сэтгүүл зүй, мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх зэрэг чухал сэдвүүдийг олон нийтийн анхааралд хандуулах үйл ажиллагаа хүйн хэвлэл мэдээллийн оролцоотойгоор идэвхжиж байна.³⁷⁷ Энэ нь хариуцлагатай, олон талт, хараат бус шударга хэвлэл мэдээллийн хэрэгслийн орчинг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Засгийн газрууд хэвлэл мэдээллийн эздэд ердийн аргаар буюу голдуу татварын хөнгөлөлт үзүүлэх, төрийн сурталчилгаа болон бусад хэлбэрээр шууд бус аргаар дэмжлэг үзүүлж байна. Европын ихэнх орнууд болон бусад бүс нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тэр дундаа сонинууд нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулж, зарим нь татвараа тэглүүлдэг. Тухайлбал нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээ Сербид 8%, Монтенегро 7% болгон бууруулж, Хорват улс сүүлийн 10 жилийн хугацаанд хоёр ч удаа татварын хувийг бууруулах арга хэмжээ авсан байна. Ингэхдээ анх 2007 онд татварын хөнгөлөлтийг 22% байхаас нь эхлэн бууруулж 10% болгосон нь жилд дунджаар 46,6 сая евро хөнгөлсөн гэсэн тооцоо гарчээ. Хэдийгээр ийнхүү татварын хөнгөлөлт эдэлж байгаа ч сонинуудын худалдан борлуулах үнэ буурсангүй, эсрэгээрээ үнэ нь өссөн байна. Зар сурталчилгааны тоо буурахын хэрээр сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн ажлын орон тоо багасч байна. Үүний нөлөөгөөр мэдээ, мэдээллийн чанар буюу сэтгүүл зүйн бүтээлийн чанар буурах эргээд борлуулалт, арилжаа сурталчилгааны тоо буурах гэх мэт харилцан урвуу хамаарал ажиглагдаж байгаа юм. 2013 онд сонины эздэд засгийн газраасаа дахин татварын хөнгөлөлт эдлүүлэхийг шаардан 5% хүртэл бууруулсан юм. Тухайн үед ажилгүй болсон олон сэтгүүлчид ашгийн бус, бие даасан хүй олны хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулж эхэлжээ. Татварын хөнгөлөлт эдэлж жилд дунджаар 17,5 сая евро хэмнэснийхээ төлөө арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгслийн эздэд ажилчдынхаа цалинг нэмдэг үү, тэдгээр мөнгө хаашаа явдаг вэ зэрэг асуултыг тэдгээр бие даасан сэтгүүлчид эрх баригчид болон хэвлэл мэдээллийн эздээс сөргүүлэн асууж эхэлсэн.

“Zenith” агентлагийн судалгаагаар сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхийн зар сурталчилгааны дундаж зарцуулалтад огцом өөрчлөлт гарчээ. Тухайлбал интернэтийн зар сурталчилгаа 2010 онд 17% байсан бол 2021 онд 54% болон өсчээ. Харин телевизийн зар сурталчилгаа 40-өөс 27 хувь, сонины зар сурталчилгаа 21-ээс 5 хувь, сэтгүүл 10-аас 3 хувь хүртлээ буурсан үзүүлэлттэй байна.³⁷⁸ Цахим экосистем нь контентын өрсөлдөөний үерийг бий болгож, интернэтийн томоохон компаниудыг шинэ гарц болгон хувиргаж байна. Сошиал медиа хэрэглэгчдийн тоо 2016 онд 2.3 тэрбум байсан бол 2021 онд 4.2 тэрбум болж бараг хоёр дахин өссөн нь контент, дуу хоолойгоо заавал сэтгүүл зүйн бүтээлээр дамжуулах шаардлагагүй нэмэлт боломжийг олгож байна.³⁷⁹ Тиймээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн зар сурталчилгааны орлого нь интернэт компаниуд руу огцом шилжиж байна. Google, Facebook гэсэн хоёр компани (саяхан Мета хэмээн зарласан) одоогийн байдлаар дэлхий даяарх дижитал зар сурталчилгааны зарлагын бараг тал хувийг нь төвлөрүүлж байна. Санхүүгийн хямралд өртсөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бодит мэдээллийн эх сурвалж түгээх боломжгүй болж байгаа нь иргэний орон зайд бодит аюул учрах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мөн үүнээс гадна ковид-19-ийн нөлөөгөөр өдөр тутмын сонины борлуулалт улам бүр мууджээ. 2018-2019 оны хооронд сонины борлуулалтын

³⁷⁷ Milan F. Živković. Alternative models for independent media funding: Who will pay for journalism? 2016 <https://mediaobservatory.net/sites/default/files/Alternative%20Models%20for%20Media%20Funding%20-Who%20Will%20Pay%20for%20Journalism.pdf>

³⁷⁸ UNESCO. World Trend in in Freedom Expression and Media Development, Global report 2021/2022 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000379826/PDF/379826eng.pdf.multi>

³⁷⁹ DataReportal.com; Kemp, S. Digital 2021: Global Overview Report. Kepios, 27 January, 2021. <https://datareportal.com/reports/digital-2021-global-overview-report>

бууралт 3%-иас ихгүй байсан бол 2019-2020 оны хооронд 13%-иар буурсан нь дэлхийн хэвлэлийн зах зээлийг улам бүр доройтуулсаар байна.³⁸⁰

3.1.3. Хэвлэл мэдээллийн редакцийн хараат бус байдал

Хэвлэл мэдээллийн байгууллагууд эдийн засгийн хараат байдлын улмаас бие даасан үйл ажиллагаа явуулж чадахгүйд хүрч хөрөнгө оруулагч, эздийнхээ ашиг сонирхлыг хамгаалах, томоохон бизнесийн бүлэглэлийн талын байр суурийг голлох зэрэг нөлөөнд автах эрсдэл бий болдог. Тухайлбал Чехийн тэрбумтан Төв Европын Хэвлэл Мэдээллийн Байгууллагуудыг (СМЕ) худалдаж авсан нь нөлөө бүхий телевизийн сувгуудыг хянадаг Зүүн Европын хэд хэдэн орныг түгшээж байна. Японд редакциуд “keiretsu” буюу бизнесийн ашиг сонирхлыг нэгдүгээрт тавьж, компанийн дарга нарынхаа нөлөөнд автсан хэвээр байна.³⁸¹

Дэлхийн өнцөг булан бүрт сэтгүүлчид хувь хүн болон шийдвэр гаргагчид зэрэг гаднын хүчин зүйлийн нөлөөтэй дайралт, дарамт шахалтад өртсөөр байна. Засгийн газар, хүч давуу сонирхлын бүлгүүд хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг алдагдуулах үзэгдэл сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдсээр байна. Энэхүү үзэгдэл нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг удирдах зохицуулалтын механизм, төрийн буюу төрийн хяналтад байдаг хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, сэтгүүл зүйн санхүүжилтэд ашиглагддаг нийтийн сан, хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгслийн эзэмшилд илрэн гарч байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ингэж хүчгүйдүүлэх нь сэтгүүл зүйн бие даасан байдал алдагдаж, олон нийтэд хүртээмжтэй, үнэн зөв мэдээг бохирдуулахад хүргэж байна.³⁸²

Дээрх хүчин зүйлсээс гадна редакцийн хараат бус байдалд дараах хүчин зүйлс нөлөө үзүүлж байна. Үүнд:

- Хэтрүүлэн пи-ар (Public Relations) хийх буюу хүчтэй зар сурталчилгааны нөлөөлөл
- “Churnalism” буюу урьдчилан бэлтгэсэн пи-ар мэдээллийг мэдээний олон эх сурвалжтай нэгтгэсэн контент
- Технологийн нөлөөлөл буюу бизнес моделиуд хэвлэл мэдээллийн “уламжлалт сурталчилгаа”-г сорилтод оруулж байна. Тухайлбал төлбөртэй мэдээ, мэдээллүүд жинхэнэ сэтгүүл зүйн мэдээлэл мэт харагдах.

Хэдийгээр интернэтийн хүртээмж урьд хожид байгаагүйгээр нэмэгдсэн сайн талтай ч энэ нь мөн хараат бус хэвлэл мэдээлэлд сөрөг нөлөөлөл үзүүлж байна. Өгөгдөлд суурилсан зар сурталчилгааны модел бүхий томоохон интернэтийн компаниуд (amazon, e-bay, google гэх мэт) төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч санхүүгийн хямралд өртөхийн зэрэгцээ олны анхаарлыг тогтоон барихын тулд дуулиан шуугиантай, “нянтай” мэдээлэл түгээх алхам хийж байна. Мөн жөндөрийн талаарх ойлголт хэвлэл мэдээллийн дунд асуудал хэвээр үлдэж, тэнцвэргүй, олон талт мэдээлэл багассан зэргээр редакцийн хараат бус байдлын утга учрыг үл тоомсорлосон асуудлууд гарч байна.³⁸³

Сүүлийн жилүүдэд редакцийн хараат бус байдалд үзүүлэх дарамт шахалт нэмэгдэж байгаа ч иргэний нийгэм, сэтгүүлчид, олон улсын байгууллага, интернетийн компаниуд, хэвлэл мэдээллийн байгууллагууд дээрх нөлөөллийг бууруулахын тулд хариу үйлдлүүд үзүүлж

³⁸⁰ UNESCO. World Trend in in Freedom Expression and Media Development, Global report 2021/2022 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000379826/PDF/379826eng.pdf.multi>

³⁸¹ Reporters Without Borders. 2020 World Press Freedom Index: “Entering a decisive decade for journalism, exacerbated by coronavirus” <https://rsf.org/en/2020-world-press-freedom-index-entering-decisive-decade-journalism-exacerbated-coronavirus>

³⁸² UNESCO. Reporting Facts: Free from Fear or Favour, 2021 https://en.unesco.org/sites/default/files/unesco_infocus_mediaindependence.pdf

³⁸³ UNESCO. Reporting Facts: Free from Fear or Favour, 2021

байгаа тухай ЮНЕСКО-оос боловсруулсан “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хөгжлийн дэлхийн чиг хандлагын талаарх фокус тайлан”-даа дурджээ. Үүнд:

1. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд санхүүгийн шинэ загваруудыг туршиж, амжилттайгаар хэрэгжүүлж байна.
2. Төвлөрсөн бус, хил дамнасан эрэн сурвалжлах сүлжээ бүхий сэтгүүлзүй нь хэвлэл мэдээллийн орчин дахь олон хязгаарлалтаас зайлсхийж, сурвалжлах хүчирхэг жишээ хэвээр байна.
3. Их хэмжээний санхүүжилттэй, засгийн газрын дэмжлэгтэй, суртал ухуулгын удирдлага бүхий хэвлэл мэдээллийн эсрэг сэтгүүлчдийн эв нэгдлийн жишээ бага ч атугай бий болж байна. Ялангуяа өнөөгийн хэвлэл мэдээллийн орчинд санхүүгийн хямрал нүүрлэж байгаа ч үүний эсрэг үйл ажиллагаа улам бүр тэсрэлттэй болж байна.
4. Иргэний нийгмийн хариу үйлдэл нь гол төлөв олон нийтийн эсэргүүцэл, өмгөөллөөр илэрч, зарим тохиолдолд эдийн засаг, улс төр, эрх баригчдын хүчийг сулруулахад нөлөө үзүүлж байна.
5. Засгийн газар хоорондын байгууллага болон дэлхий дахины төрийн бус байгууллагууд зэрэг олон улсын янз бүрийн байгууллагуудын дэмжлэгээр улс орнууд дахь хэвлэл мэдээллийн өмчлөгчдийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд туслав.³⁸⁴

Хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг баталгаажуулах чиглэлд гарсан дээрх ахиц дэвшлийг тухайлан дэлгэрүүлэн авч үзье.

1/ Интернэт, цахим хэрэглээ нэмэгдсэнээр уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд санхүүгийн тогтвортой байдлаа хангахын тулд цаг үеэ даган өөрчлөгдөх хэрэгцээ шаардлага урган гарч байна. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүд цахим захиалга буюу “subscription” бий болгож уншигчдаас орж ирэх орлогоос санхүүжилтаа бүрдүүлэх чиг хандлагатай байна. Ингэснээр чөлөөт зах зээлийн шударга зарчим хэвлэл мэдээллийн байгууллагуудад үйлчлэх, улмаар редакцийн хараат бус байдал хангагдаж, бодит мэдээ, мэдээллийн үнэ өсөн нэмэгдэх сайн талтай. Цахим захиалгын үйлчилгээ нь цоо шинэ ойлголт биш хэдий ч өнгөрсөн хоёр жилийн хугацаанд үргэлжилсэн Ковид-19 нийгмийн эрүүл мэндийн хямралын нөлөөгөөр энэ үзэгдэл улам эрчимжиж цаашид ч цахим захиалгын үйлчилгээ зөвхөн хэвлэл мэдээлэл төдийгүй нийгмийн бүхий л салбарын үйл ажиллагааны эдийн засгийн гол арга хэрэгсэл байх талаар Ройтерс сэтгүүлзүйн судалгааны хүрээлэнгийн (RISJ) жил бүр гаргадаг “Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, технологийн чиг хандлага” сэдэвт 2021 оны тайланд дурджээ. Нийт 43 орны 234 хэвлэл мэдээллийн эздийг судалгаанд хамруулсан бөгөөд өөрсдийн компанийн дижитал орлогыг нэмэгдүүлэх хамгийн чухал салбар бол цахим захиалга гэж тодорхойлсон байна.³⁸⁵

2/ Хил дамнасан эрэн сурвалжлах сэтгүүлчдийн нөлөө, нэр хүнд өсөн нэмэгдэж улс төрийн бодлого, зохицуулалтад нөлөөлсөн нэг тод жишээ бол 2016 онд Панамын баримт бичгийг илрүүлсэн явдал юм. Энэхүү баримт бичиг нь дэлхийн хөрөнгөтэй, хүчирхэг бүлэг оффшор татварын диваажинг хэрхэн ашиглаж байгааг харуулсан олон тооны авлигын мөрдөн байцаалт, татвараас зайлсхийсэн явдлыг таслан зогсоох үндэс болж олон арван шинэ хуулиуд батлахад хүргэсэн. Мөн 2019 онд Нью-Йорк Таймсын сурвалжлагаар Европын Холбооноос тариаланчид, хөдөө орон нутгийн иргэдийг дэмжих зорилготой олгосон 65

³⁸⁴ UNESCO. Reporting Facts: Free from Fear or Favour, 2021

https://en.unesco.org/sites/default/files/unesco_infocus_mediaindependence.pdf

³⁸⁵ 50 ways to make media pay: Subscriptions, Damian Radcliffe, Jan 27, 2022 <https://whatsnewinpublishing.com/50-ways-to-make-media-pay-subscriptions/>

тэрбум долларын татаасыг Унгар болон Төв, Зүүн Европын олигарх, популистууд болон “хөдөө аж ахуйн мафи”-г санхүүжүүлэхэд ашигласан тухай илчилж шуугиан дэгдээж байв.³⁸⁶

3/ Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын эв нэгдэл, хамтын ажиллагаа редакторын хараат бус байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулах, түүний хүчийг сулруулахад чухал нөлөөтэй байна. Үүнтэй холбогдуулан редакциас сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах тодорхой дүрэм журам, эрх зөрчигдсөн тохиолдолд хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны тодорхой чиглэлтэй байх ёстой. Ингэснээр сэтгүүлчид хараат бус, айх айдасгүй, аюулгүй ажил үүргээ гүйцэтгэх итгэл үнэмшилтэй болно. Сэтгүүлчдийн эв нэгдэл, хамтын ажиллагааны нөлөөллөөр өөрсдийн эрхээ хамгаалуулахыг төр засаг, хариуцлагаа ухамсарлахыг эздээсээ шаардсан үйл ажиллагаа эрчимжиж байна. Тухайлбал хэвлэл мэдээллийн салбарт нүүрлээд буй эдийн засгийн хямралаас үүдэлтэйгээр дэлхий дахинаа уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сорилтод ороод байгаа билээ. Тухайлбал, Йордан улсын “Аль-Рай” сонины сэтгүүлчид олон сарын турш цалингаа аваагүй тул сонины ерөнхий захирлыг албан тушаалаас нь огцруулсан байна. Аль-Рай сонин нь Йорданы хамгийн том өдөр тутмын сонин бөгөөд Йорданы Нийгмийн хамгааллын хөрөнгө оруулалтын сан (SSIF) хувьцааны ихэнх хувийг эзэмшдэг байна. Энэ асуудалд сэтгүүлчид захирлуудын зөвлөлөө хянадаг тус хөрөнгө оруулалтын санг буруутгаж байгаа бөгөөд олон жилийн турш туршлагагүй захирал, дарга нарыг томилж, санхүүгийн хямралыг улам хурцатгаж, сониныг шинэ цахим эринд удирдаж чадаагүй гэж буруутгаж байгаа юм.³⁸⁷ Сонины эдийн засгийн байдал Ковид-19 нийгмийн эрүүл мэндийн хямралтай зэрэгцэн доройтож эхэлсэн бөгөөд сүүлдээ ажилтнуудынхаа цалинг тавьж чадахгүйд хүрсэн байна. Энэ тухай Олон улсын сэтгүүлчдийн холбоо (IFJ)-ны ерөнхий нарийн бичгийн дарга Антони Белангер “Бидний нэг хэсэг болох Аль-Рай дахь хамт олныхоо нэгдлийг дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Сэтгүүлчид, тэдний ар гэрийнхэн нь өлсөж байхад тус сонины удирдлагууд баяжиж байгаа нь ичмээр юм. Сэтгүүлчдийн нийгмийн болон мэргэжлийн эрхийг дээдэлж, эзэд нь санхүүгийн үүргээ биелүүлж, цалингаа цаг алдалгүй төлөх ёстой” гэж мэдэгдсэн байна.

4/ Иргэний нийгэм бол иргэд өөрсдийн нийтлэг эрх ашгийнхаа төлөө эвлэлдэн нэгдэх үйл ажиллагааны талбар билээ. Энэ талбарын зохистой орчинг бий болгоход хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал нөлөөтэй. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа бол иргэний нийгмийн орон зайн чухал хэсэг юм. Иргэд мэдлэг, мэдээлэлтэй үед л төрөөс ил тод байдал, эгэх хариуцлага шаардах чадвартай байдаг. Иймд мэдээлэлжсэн нийгмийг бий болгоход сэтгүүлчдийн идэвх чармайлт, түүний үр дүнд иргэний нийгмээс үзүүлэх хариу үйлдлүүд нийгэм даяар чухал ач холбогдолтой байна.

5/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөө ба олон ургалч үзэл нь Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн 10 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Хэвлэл мэдээллийн өмчлөлийн ил тод байдал нь редакцийн хараат бус байдалд чухал нөлөөтэй. Тиймээс хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах олон улсын байгууллагууд хэвлэлийн мэдээллийн эзэд болон хамаарал бүхий хүмүүсийг нээлттэй ил тод зарлах нь эрүүл ардчилсан тогтолцооны баталгаа гэж үзэж байна. Өмчлөлийн ил тод байдал нь олон ургалч үзлийг дэмжихийн зэрэгцээ мэдээллийн эх сурвалжид итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж улмаар хэвлэл мэдээллийн салбарын

³⁸⁶ The New York Times, “The EU spends \$65 billion a year on farm subsidies, intended to support farmers and keep rural communities alive. Our investigation found that in Hungary and Central and Eastern Europe that money funds oligarchs, populists and the agricultural Mafia. Nov 5, 2019 <https://twitter.com/nytimes/status/1191438731678568449>

³⁸⁷ International Federation of Journalists. Jordan: Al-Rai newspaper journalists protest over unpaid salaries, press releases, 14 Feb 2022 <https://www.ifj.org/media-centre/news/detail/category/press-releases/article/jordan-al-rai-newspaper-journalists-protest-over-unpaid-salaries.html>

эдийн засгийн хүч чадал, үр ашгийг дэмждэг.³⁸⁸ Эдгээр олон янзын мэдээлэл нь үзэл бодлын хүртээмжтэй байдлыг хангах, үүний үндсэн дээр хувь хүмүүс өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл, санал солилцох боломжийг бүрдүүлэхэд тусалдаг тул ардчилсан нийгмийн үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Цаашилбал, хэвлэл мэдээллийн өмчлөлийн ил тод байдал нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн ард редакцийн бодлогод нөлөөлж болох өмчлөлийн бүтцийг олон нийт болон зохицуулах байгууллагуудын ухамсарт хүргэх замаар хэвлэл мэдээллийн олон ургалч үзлийг үр дүнтэй болгоход тусална.

Цаашид редакцийн хараат бус байдалд нөлөөлөх эрсдэлтэй хүчин зүйлсийг ЮНЕСКО-с гаргасан фокус тайланд дараах байдлаар тодорхойлж, хүн бүр редакцийн аюулгүй байдлыг хамгаалахад хувь нэмэр оруулахыг уриалжээ.³⁸⁹

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих хяналтыг нэмэгдүүлэх эрсдэл (ялангуяа Covid-19-ийн дараа)
 - o Зохицуулагч болон эрх бүхий байгууллагад хэвлэл мэдээллийн хэрэгслийг бүртгүүлэх шаардлагууд тавих.
 - o Сэтгүүлчдийг цензурдахын тулд хуурамч контентыг буруу хэрэглэх зохицуулалтын тухай заалтууд бий болгох.
 - o Сэтгүүлчийн үйл ажиллагааг зогсоохын тулд хувийн мэдээлэл, хувийн нууцад нөлөөлөх агуулгыг нийтлэхийг оролдсон мэтээр эрх баригчид сэтгүүлчидтэй зүй бусаар харьцах
- Төрийн нөлөө хэвлэл мэдээллийн хэрэгсэлд илрэх эрсдэл
 - o Засгийн газраас улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үзүүлэх нөлөө ихсэх
 - o Олон улсын түвшинд суртал ухуулга бүхий хэвлэл мэдээлэлд хөрөнгө оруулалт нэмэгдэх
- Сэтгүүл зүйн санхүүжилтийн өөрчлөлтөд илрэх эрсдэл
 - o Бие даасан хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүгийн томоохон хямрал
 - o Засгийн газраас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс редакцийн хараат бус байдал хангагдах талаарх баталгаажуулалтыг шаардах нь нэмэгдэх зэрэг эрсдэлийг дурдаж болно.

3.1.4. Төрөөс хэвлэл мэдээллийн олон талт байдлыг хангах асуудал

НҮБ-ын Хүний эрхийн хорооноос хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн (үндэстний болон хэлний цөөнхийн гишүүдийг оролцуулан) эрхийг хамгаалах нь тэдэнд өргөн хүрээтэй мэдээ, мэдээлэл ба санаа оноог хүргэх явдал ба үүний тулд Гишүүн орнууд бие даасан олон ургалч хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжихэд онцгой анхаарал тавих ёстой хэмээн мэдэгдсэн. Хэвлэл мэдээллийн салбар олон төрөлтэй байх нь олон нийтийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах гол шинж чанар болдог. Хэрэв үзэгч, сонсогч, уншигчид олон төрлийн хэвлэл мэдээллээр дамжуулан мэдээ, мэдээлэл авч чадахгүй бол нийгмийн амьдралд утга учиртай, үр нөлөөтэй оролцох боломжгүй. Олон төрөлт байдал нь иргэдэд хүртээмжтэй мэдээ мэдээлэл, санал бодлын олон талт байдлыг бий болгохын төлөө төрөл бүрийн арга хэмжээг авч дэмжлэг үзүүлэх ёстой гэсэн эерэг үүргийг улс орнуудад хүлээлгэдэг.

Олон улсын дөрвөн тусгай илтгэгчийн өргөн нэвтрүүлгийн олон төрөлт байдлын талаарх Хамтарсан Тунхаглалд ардчиллын тулгуур, үзэл бодлын эрх чөлөөний чухал шинж болох олон төрөлт байдлын ач холбогдлыг онцгойлон дурдсан. Энэхүү хамтарсан тунхаглалаар

³⁸⁸ Recommendation CM/Rec(2018) of the Committee of Ministers to member States on media pluralism and transparency of media ownership (Adopted by the Committee of Ministers on 7 March 2018 at the 1309th meeting of the Ministers' Deputies) https://search.coe.int/cm/Pages/result_details.aspx?ObjectId=0900001680790e13

³⁸⁹ UNESCO. Reporting Facts: Free from Fear or Favour, 2021 https://en.unesco.org/sites/default/files/unesco_infocus_mediaindependence.pdf

хэвлэл мэдээллийн олон ургалч үзэл ба олон төрөлт байдлын гурван шинжийг тодорхойлсон. Үүнд, а/ эх үүсвэр: өмчлөлийн олон төрөлт байдал, хэвлэл мэдээллийн өмчлөл хэт төвлөрөх, б/ хэлбэр: өргөн нэвтрүүлгийн янз бүрийн төрөл, мэдээллийг олон өнцгөөс хүргэх боломжтой олон нийтийн, арилжааны ба хүйн өргөн нэвтрүүлэг байх, в/ агуулга: нийгмийн бүх гишүүдийн ашиг сонирхол ба шаардлагад нийцүүлэн үйлчлэх өргөн хүрээг хамарсан агуулгатай байх.³⁹⁰

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өмчлөлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх үүднээс эх үүсвэрийн олон төрөлт байдлыг сайтар хангахтай холбогдуулан НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан мэдэгдэлдээ “Орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжлөөс үүдэлтэй, хүн бүрийн үзэл бодлын эрх чөлөөний эрхэнд халдаж болзошгүй, иймэрхүү хяналт хэвлэл мэдээлэлд үүсэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ зайлшгүй хэрэгтэй. Төр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд монополий хяналт тавихгүй, харин хэвлэл мэдээллийн олон ургалч байдлыг хөхиүлэн дэмжих ёстой. Үүнээс үүдэн төрөөс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакттай нийцүүлэн хэвлэл мэдээлэлд өмчлөлийн төвлөрөл үүсэх, хувийн өмчлөлтэй хэвлэлийн том бүлгүүд монополий эрхтэй ноёрхох нь эх үүсвэрийн олон төрөлт байдалд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зохистой арга хэмжээ авах ёстой” гэж онцолсон.³⁹¹ Нөхцөл байдлаас харахад ихэнх ардчилсан орнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өмчлөл төвлөрөх асуудалд анхаарлаа хандуулан, энэ талаар тусгайлан дүрэм боловсруулж, хэт төвлөрлийн эсрэг ерөнхий дүрмийг мөрдөж байна.

Сэтгүүл зүйн уламжлалт бизнесийн загварууд үр дүнгүй болсон, улмаар хэвлэл мэдээллийн олон ургалч үзэлд улам бүр заналхийлж байгаа нь редакцуудыг гаднын оролцогчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд, удирдлагуудын дарамт шахалтад илүү өртөмтгий болгож байна. Мэдээллийн хэрэгсэл эрх чөлөөтэй мэт боловч хараат бус байдал алдагдсан үед хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшилдээ оруулах хэлбэр нь улам нэмэгдэж буй аюул заналхийлэл хэвээр байна. Тухайлбал, 2021 онд 151 орны төрийн мэдлийн 546 хэвлэл мэдээллийн байгууллагыг хамруулан хийсэн судалгаагаар тэдний 80 шахам хувь нь редакцийн хараат байдалтай байгааг тогтоожээ.³⁹²

Төрөөс арилжааны, олон нийтийн, хүйн гэсэн өргөн нэвтрүүлгийн гурван төрлийг хөхиүлэн дэмжих ёстой ба эс бөгөөс арилжааны төрөл зах зээл дээр ноёрхох хандлагатай байна. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн газар зүйн хамрах хүрээ өргөн, нэвтрүүлгийн бодлогоо арилжааны бус хэлбэрээр төлөвлөн хүргэдэг байх, хүйн өргөн нэвтрүүлэг нь хувь хүмүүс, хүй олны дуу хоолойг хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилготой. Хэвлэл мэдээллийн олон янз байдлыг хөхиүлэн дэмжих нь улс орон бүрийн үүрэг. Энэ нь мэдээлэл хүлээн авах эрхтэй холбоотой. Хэрэв хэвлэл мэдээллийн салбарт нэг эсвэл цөөн тооны хувь хүн, компаниуд давамгайлж байвал тэдгээр нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэт их нөлөө үзүүлж, улмаар хэвлэл мэдээллийн чөлөөт үйл ажиллагааг хязгаарладаг. Хэвлэл мэдээллийн олон ургалч үзлийг нэмэгдүүлэхийн тулд улс орнууд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчидтэй зөвшилцөн мэргэжлийн мэдээллийн хэрэгсэл, чанартай хараат бус, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжих стратеги, механизм, тэр дундаа хүмүүсийн олон талт хэрэгцээ, ашиг сонирхлыг хангахуйц

³⁹⁰ Joint Declaration on Diversity in Broadcasting, The UN Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, the OSCE Representative on Freedom of the Media, the OAS Special Rapporteur on Freedom of Expression and the ACHPR (African Commission on Human and Peoples' Rights) Special Rapporteur on Freedom of Expression and Access to Information, 7-8 December, 2007
https://eos.cartercenter.org/uploads/document_file/path/234/jointdec2007.pdf

³⁹¹ CCPR General Comment No. 10: Article 19 (Freedom of Opinion), available at
<https://www.ohchr.org/Documents/Issues/Opinion/CCPRGeneralCommentNo10.pdf>

³⁹² Center for Media, Data, and Society. The state of the media: A global analysis of the editorial independence of state media and an introduction of a new state media typology. 2021
<https://cmds.ceu.edu/sites/cmcs.ceu.hu/files/attachment/article/2091/thestateofstatemediapdf>.

мэдээллийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ёстой. Төрөөс санхүүгийн бус дэмжлэгээс гадна улс орнууд сурталчилгаа, татаас гэх мэт янз бүрийн хэлбэрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг дэмждэг. Түүнчлэн улс орнууд сэтгүүлзүйн боловсрол, хэвлэл мэдээллийн судалгаа, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн олон ургалч үзэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бэхжүүлэх шинэлэг арга барилтай холбоотой төслүүдийг дэмжихийг Европын Холбооны сайд нарын хорооноос гаргасан хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод, олон талт байдлын зөвлөмжид уриалжээ.³⁹³

Хэвлэл мэдээллийн олон янз байдал нь нийгэмд янз бүрийн үзэл бодлыг сонсож, мэтгэлцэхийг баталгаажуулдаг. Мөн цөөнхийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалахын зэрэгцээ мэдээлэл эрж хайж, хүлээн авах, түгээх эрхийг хамгаалдаг.³⁹⁴ Цахим эрин дэх хэвлэл мэдээллийн бие даасан, олон талт байдлын хамтарсан тунхаглалд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, онлайн платформууд хүний эрхийг хүндэтгэх үүргээ ухамсарлахыг зөвлөсөн. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, онлайн платформууд нь хүний эрхийн мэдрэмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хүндэтгэхийн зэрэгцээ контент түгээхэд туслах, орлогоо хуваалцах зэрэг өөр олон аргаар дэмжих ёстой.³⁹⁵

Тогтвортой хөгжлийн зорилтуудад тусгагдсан тэгш байдлыг хангахын тулд олон нийтийн салбарт эмэгтэйчүүдийн бүрэн оролцоо зайлшгүй чухал бөгөөд энэ нь эргээд мэдээллийн хангамж, шинж чанар, хүртээмж зэрэгт жендэрийн асуудлыг хөндөж байна. Харамсалтай нь олон арга хэмжээнүүдийн дагуу мэдээллийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн ахиц дэвшил сүүлийн таван жилд зогсонги байдалтай хэвээр байна. Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн төслийн тооцоолсноор, уламжлалт мэдээллийн хэрэгсэл дэх жендэрийн тэгш байдлын дундаж ялгааг арилгахад одоогийн хурдаар ахин 67 жил шаардлагатай болно гэж дүгнэжээ.

Хүний эрхийн мэдлэг ойлголт, мэдрэмжтэй байх нь редакцийн олон талт байдлыг хангахад үндсэн чиг шугам болох бөгөөд нийгмийн бүхий л бүлгүүдэд хүртээмжтэй байдлаар мэдээ, мэдээлэл түгээхдээ анхаарах шаардлагатай. Тухайлбал цахим хуудсууд хараагүй иргэдэд зориулан мэдээ, мэдээлэл дуу хоолойгоор хүргэдэг байх, угсаатны цөөнхийн хэл соёлыг хүндэтгэн тэгш хүртээмжтэй мэдээлэл авах эрхийг нь хангахын тулд боломжит бүхий л нөөцөө ашиглах, сэтгүүлчид мэдээ, мэдээлэл бэлтгэхдээ жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх зэргээр олон талт байдлыг хангахад дотоод хүчин зүйлээс хамааралтай бүхий л алхам хийхийг эрмэлзэх шаардлагатай байна.

Ардчилал баталгаажсан улс орны засгийн газрууд нь үндэсний аюулгүй байдлыг сэтгүүл зүйн эрх чөлөөг хааж боох шалтаг болгон дуртайяа ашигладаг. Жишээ нь Өмнөд Солонгост эмзэг/аюултай гэж үзсэн мэдээлэл нийтлүүлэхэд, ялангуяа Хойд Солонгостой холбоотой мэдээлэлд хатуу шийтгэл оногдуулахыг хуулиар заасан. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил улам цөөхөн гарт төвлөрч байгаа нь Ази болон Номхон далайн ардчилсан орнуудын хэвлэлийн эрх чөлөөнд заналхийлж буй хамгийн том аюулын нэг хэвээр байна. Японд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд менежментийн нөлөөнд буюу бизнесийн ашиг

³⁹³ Recommendation CM/Rec(2018) of the Committee of Ministers to member States on media pluralism and transparency of media ownership, (Adopted by the Committee of Ministers on 7 March 2018 at the 1309th meeting of the Ministers' Deputies) https://search.coe.int/cm/Pages/result_details.aspx?ObjectId=0900001680790e13

³⁹⁴ Centre for Law and Democracy. Background Paper: Freedom of Expression and International Law. November 2021

³⁹⁵ Joint Declaration on Media Independence and Diversity in the Digital Age. The United Nations (UN) Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, the Organization for Security and Co-operation in Europe (OSCE) Representative on Freedom of the Media, the Organization of American States (OAS) Special Rapporteur on Freedom of Expression and the African Commission on Human and Peoples' Rights (ACHPR) Special Rapporteur on Freedom of Expression and Access to Information, 4 May 2016 and 3 March 2017 <https://www.osce.org/files/f/documents/1/e/379351.pdf>

сонирхлоо нэгдүгээрт тавьдаг хувьцаа эзэмшигчдийн нөлөөнд ихээхэн автсан хэвээр байна.

3.1.5. Хараат бус зохицуулах байгууллага

ЮНЕСКО-оос гаргасан хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлтэд хараат бус зохицуулах байгууллагын шалгуур үзүүлэлтийг тодорхойлжээ.³⁹⁶ Хэвлэл мэдээллийн зохицуулах байгууллагууд улс төр, арилжааны оролцооноос хараат бус, бие даасан байж, гишүүдээ ил тод, ардчилсан үйл явцаар сонгох, тэдний эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хуулиар тогтоох ёстой гэжээ. Хараат бус зохицуулах байгууллагын тогтолцоог хуулиар баталгаажуулах шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлсон.

- Бие даасан байдал, намын болон арилжааны хөндлөнгийн оролцооноос хараат бус байх хуулийн тодорхой баталгаа
- Зохицуулах байгууллагын хараат бус байдлын эрх зүйн баталгаа
- Зохицуулагчийн бүрэн эрх, хариуцлагыг хуульд тодорхой заасан байдал
- Намын болон арилжааны буюу хөндлөнгийн оролцооны эрсдэлийг бууруулах зорилготой ил тод, ардчилсан үйл явцаар сонгогдсон зохицуулах байгууллагын гишүүд
- Зохицуулах байгууллагын бие даасан байдал, хараат бус байдлыг хамгаалахын тулд зохих, тууштай санхүүжилтийг хуулиар баталгаажуулсан байдал.³⁹⁷

Харин бие даасан, ил тод зохицуулалтыг тогтолцооных нь хувьд болон түүнд тавигдах шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Зохицуулалтын тогтолцоо нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор хүй олны өргөн нэвтрүүлгийн давтамжийн долгионд тэгш нэвтрэх боломжийг олгодог
- Олон нийт, хувийн болон хүй олны өргөн нэвтрүүлгийн хооронд давтамж хуваарилах тухай шийдвэр гаргах үйл явц нээлттэй
- Олон нийт, хувийн болон хүйн өргөн нэвтрүүлгийн хооронд давтамж хуваарилах тухай шийдвэр гаргах үйл явцыг улс төрийн болон арилжааны аливаа хөндлөнгийн оролцоо буюу хяналтаас ангид байлгадаг.³⁹⁸

Өргөн нэвтрүүлгийн эрх чөлөөг хүндэтгэх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгааны чухал хэсэг боловч өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл зохицуулалтгүй байх ёстой гэсэн үг биш юм. Өргөн нэвтрүүлгийн хувьд ашигласан дуу, дүрс бичлэгийн долгион нь хязгаарлагдмал нөөц бөгөөд хөндлөнгийн оролцооноос зайлсхийж, тэгш хүртээмжтэй байхын тулд боломжит байдлаар, шударга хуваарилах ёстой тул бүрэн зохицуулалтгүй өргөн нэвтрүүлгийн салбар нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд сөргөөр нөлөөлдөг. Жишээ нь хэрэв 100 хүн өргөн нэвтрүүлгийн лиценз авахыг хүсэж байх үед бүгд лиценз авах ижил эрхтэй ч зөвхөн 10 давтамжийг хуваарилах боломжтой.³⁹⁹

Хэвлэл мэдээллийн олон ургалч байдлыг дэмжихийн тулд зарим улс бие даасан контент бүтээгчдэд зориулсан цаг гаргахыг өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс шаарддаг бөгөөд хамгийн бага квот тогтоох зохицуулалтыг хийдэг. Үүний цаад санаа нь өөр өөр дуу хоолойг агаарын давлагаанд нэвтрэх боломжийг өргөжүүлэхийн зэрэгцээ хүлээн авагчдад

³⁹⁶ UNESCO, Independent regulation of broadcasting: A Review of International Policies and Experiences, 2016 <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000246055/PDF/246055eng.pdf.multi>

³⁹⁷ UNESCO. Media Development Indicators: A framework for assessing media development Endorsed by the Intergovernmental Council of the International Programme for the Development of Communication (IPDC) at its 26th session (26-28 March 2008) <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000163102/PDF/163102eng.pdf.multi>

³⁹⁸ UNESCO. Media Development Indicators: A framework for assessing media development Endorsed by the Intergovernmental Council of the International Programme for the Development of Communication (IPDC) at its 26th session (26-28 March 2008) <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000163102/PDF/163102eng.pdf.multi>

³⁹⁹ Organization for Security and Co-operation in Europe .The Media Self-Regulation Guidebook. Miklós Haraszti. 2008. <https://www.osce.org/files/f/documents/1/d/31497.pdf>

илүү өргөн цар хүрээтэй үзэл бодол, бүтээлч авьяасыг хүргэх боломжийг хөхиүлэн дэмжих явдал юм. Мөн бие даасан бүтээгдэхүүний квотыг хуваарилах нь хэвлэл мэдээллийн төвлөрлийн сөрөг нөлөөг багасгахад тусалж, бие даасан хүчирхэг бүтээгдэхүүний салбарын өсөлтийг дэмжиж чадна. Тухайлбал Европын Холбооны дотор бүх телевизийн өргөн нэвтрүүлэгчид нийтийн болон хувийн, бие даасан контент үйлдвэрлэгчдэд зориулсан хуваариа 10%-д барихыг шаардаж байна.⁴⁰⁰

Өргөн нэвтрүүлгийн салбарын зохицуулах байгууллагын хүлээх үүрэг ба бие даасан байдлын талаар Европын Зөвлөлөөс 2000 онд гаргасан зөвлөмжид зохицуулах байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэн хангах дараах аргуудыг онцлон дурдсан. Үүнд:

- Хууль тогтоомжид бие даасан байдлыг тусгайлан зааж баталгаажуулах
- Санхүүгийн эх үүсвэртэй, өөрийн үйл ажиллагааны салбарт албан ёсоор бие даасан, нэр нөлөөтэй байгууллагаар дамжуулан ажиллах
- Хариуцлагын системийн үндэс суурийг хангах, нөлөөллөөс ангид байлгахын тулд тухайн сонгосон байгууллагад юунд оролцох болон оролцохгүйг зааж эрх бүхий итгэмжлэл олгох
- Тухайн байгууллагын дүрэм журмаас ангид байхаар бодож ажлаа хэрхэн явуулах тухай нарийвчилсан зааварчилгаа өгөх
- Томилогдсон гишүүдээр дамжуулан ажиллах.⁴⁰¹

Мөн дээрх зөвлөмжид зохицуулах байгууллагын удирдах гишүүдийн хэрхэн томилох талаар хоёр гол загварыг онцолжээ. Үүнд:

- Салбараас сонгон томилох, гишүүдийг салбар бүрээс сонгох. Тухайлбал, эрдэмтэд, хуульчдын холбооны төлөөлөгч гэх мэт. Гишүүдийн хүрээ тэлэх тусам улс төрчид системийг хянах боломжгүй болдог.
- Баталсан журмын дагуу хамгаалах. Янз бүрийн салбарын хүмүүсийг оролцуулан нээлттэй ил тод хэлбэрээр бие даасан байдлыг хянах журам боловсруулах. Үүнд иргэний нийгэм төлөөллөө дэвшүүлж, парламентаас гишүүдийг сонгож, ерөнхийлөгч албан ёсоор баталж болно. Энэхүү сонгох үйл явц иргэдийн идэвхтэй оролцоотой, нээлттэй явагдсанаар хараат бус зохицуулах байгууллагын удирдах гишүүдийг томилох боломжтой гэж үздэг.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын хараат бус байдал хангагдахад хамгийн наад зах нь засгийн газарт алба хашиж буй хүмүүс, төрийн албан хаагч, улс төрийн нам, сонгогдсон төлөөлөгчид, өргөн нэвтрүүлгийн болон харилцаа холбооны салбарт хөрөнгө оруулагч нар томилогдох боломжгүй байх юм. Гишүүдийн томилгоог хийхдээ өмнө нь ил тод зарлаж, олон нийтэд танилцуулсан байх нь ардчилсан зарчимтай нийцнэ.

3.1.6. Мэдээлэлтэй байх эрх ба тогтвортой хөгжил

Төрөөс мэдээллийн ил тод байдлыг хангах хууль тогтоомж баталсан эсэх, хэвлэл мэдээллийн тухай хуулийг олон улсын гэрээ, пактын хүрээнд боловсруулсан эсэх нь ардчилсан нийгэм дэх чөлөөт хараат бус хэвлэл мэдээллийн үндсэн шалгуур үзүүлэлт болдог. “Мэдээлэл авах эрхийг төрөөс хуулиар баталгаажуулснаар өргөн утгаараа төрийн үйл ажиллагааг иргэдэд хянах боломж олгох, төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх,

⁴⁰⁰ UNESCO. Media Development Indicators: A framework for assessing media development Endorsed by the Intergovernmental Council of the International Programme for the Development of Communication (IPDC) at its 26th session (26-28 March 2008) <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000246055/PDF/246055eng.pdf.multi>

⁴⁰¹ Council of Europe Committee of Ministers, Recommendation Rec (2000)23 of the Committee of Ministers to member states on the independence and functions of regulatory authorities for the broadcasting sector (Adopted by the Committee of Ministers on 20 December 2000 at the 735th meeting of the Ministers' Deputies) <https://rm.coe.int/16804e0322.See>

сонгогдсон төлөөлөгчдийн эгэх хариуцлага нэмэгдэх практик ач холбогдолтой юм. Мэдээлэл авах эрх нь хүмүүст иргэний болон улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ илүү сайн эдлэх боломжийг олгодог бөгөөд энэ нь тэдэнд илүү мэдээлэлтэйгээр сонголт хийх боломжийг олгодог”.⁴⁰² Өнөөдөр дэлхийн 97 улс орон мэдээлэл авах эрхийг Үндсэн хуулиараа тусгайлан баталгаажуулсан байна. Мөн дэлхийн хүн амын 91 гаруй хувь нь мэдээлэл авах эрхтэй 130 гаруй улсын аль нэгэнд амьдарч байгаа бол бусад олон оронд энэ хуулийн төсөл хүлээгдэх шатандаа байна.⁴⁰³

Мэдээлэл авах эрх нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилго (ТХЗ)-уудын нэг хэсэг бөгөөд хүний үндсэн эрх юм. Мэдээлэл авах эрх нь хүн бүрт төрийн байгууллагаас аливаа мэдээллийн баримт бичиг, өгөгдлийг олж авах эрхийг олгодог. Байгууллагууд нь хялбар, шуурхай, үр дүнтэй, хүртээмжтэй мэдээллээр хангах ёстой. ТХЗ-ын 16.10 дахь зорилтод НҮБ-ын гишүүн улсууд мэдээлэл авах эрхийг бодлого, хууль тогтоомжоор баталгаажуулахыг уриалсан байдаг.⁴⁰⁴ “Тогтвортой хөгжлийн зорилго” нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болсон “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл юм. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн. ТХЗ-д тусгагдсан нийт 17 зорилго, 169 зорилтын хүрээнд НҮБ-ын гишүүн улс орон бүр ахиц дэвшил гаргаснаар дэлхий нийтээрээ тогтвортой хөгжих нь энэхүү баримт бичгийн үндсэн зорилго билээ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрх ТХЗ дахь 16 дугаар зорилго буюу “Энх тайван, шударга ёсыг цогцлоох” зорилгод илүүтэй хамаарч байгаа юм. 16 дугаар зорилго дотроо нийт 12 зорилт, түүний хэрэгжилтийг үнэлэх 24 шалгуур үзүүлэлттэй. 16.10 дугаар зорилтод “Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах” хэмээн тодорхойлжээ.⁷⁹

Дээрх зорилтын хэрэгжилтийг үнэлэх дараах хоёр шалгуур үзүүлэлт бий. Үүнд: 1/ Сүүлийн 12 сарын хугацаанд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, Үйлдвэрчний эвлэлийн болон хүний эрхийг хамгаалах байгууллагын ажилтнуудын амийг хөнөөсөн, хулгайлсан, хүчээр сураггүй алга болгосон, дур зоргоор баривчлан эрүүдэн шүүсэн батлагдсан тоо, 2/ Мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан байдал.⁴⁰⁵

ТХЗ-ыг хэрэгжилтийг хангахад улс орнуудын засгийн газар, яамд, төрийн бусад байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, орон нутгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, холбогдох бусад байгууллагууд болон иргэд оролцох шаардлагатай. ТХЗ-ын хэрэгжилтийг хэрхэн хангах, ахиц дэвшил гаргахад цаашид юуг анхаарах талаар улс орнууд сайн дураараа Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ)-ээ бэлтгэн НҮБ-д танилцуулдаг. ҮСДИ-ийн зорилго нь ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг үнэлэх, улс орнууд хоорондоо туршлага солилцох болон ТХЗ-ын хэрэгжилтийг түргэсгэхэд оршино.

Монгол Улс 2019 онд анх удаа ТХЗ-ийн хэрэгжилтийн тухай Үндэсний сайн дурын илтгэл бэлтгэж, 2019 оны 7 дугаар сард зохион байгуулагдсан НҮБ-ын Улс төрийн өндөр хэмжээний жил тутмын чуулга уулзалтаар танилцуулсан. Энэхүү илтгэлд ТХЗ-ын 16.10 дэд зорилтын хоёр дахь шалгуур үзүүлэлт (Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт)-ийн дагуу тодорхой дүн шинжилгээ хийгээгүй. Тус илтгэлд зөвхөн “...олон нийтийн үйл

⁴⁰² Article 19. Open Development. Access to Information and the Sustainable Development Goals. July 2017. <https://www.article19.org/wp-content/uploads/2017/07/Open-Development-Access-to-Information-and-the-SDGs-2017.pdf>

⁴⁰³ Article 19. Global: Exercise your right to information. September 28, 2021 <https://www.article19.org/resources/global-exercise-your-right-to-information/>

⁴⁰⁴ Article 19. Global: Exercise your right to information. 2021.

⁴⁰⁵ Үндэсний статистикийн хороо. <https://sdg.1212.mn/Home/Detail?id=16>

ажиллагааны ил тод байдлыг баталгаажуулах, мэдээлэл авах, мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг улам сайжруулах шаардлагатай байна” хэмээн дурджээ.⁴⁰⁶ Иймд Монгол Улсын хувьд мэдээллийн хүртээмж, мэдээлэл авах эрх нь ТХЗ-ын ерөнхий хэрэгжилтэд чухал болохыг тодотгох, тусгайлан ач холбогдол өгөх талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Монголын иргэний нийгмийн байгууллагууд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг сурталчлах, мөн хуулийг хэрэгжүүлснээр Засгийн газрын ил тод байдал, төрийн үйлчилгээнд хяналт тавихад ихээхэн туршлага хуримтлуулсан. Гэсэн хэдий ч Монгол Улс мэдээлэл авах эрхийг хүний эрхийнх нь хувьд төдийгүй хүний бусад эрхээ эдлэхэд зайлшгүй шаардлагатай болохын хувьд дэмжих нь чухал юм. Мэдээлэлтэй байх эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь ил тод, эгэх хариуцлагатай засаглалд зайлшгүй чухал тул хүчин чармайлтаа улам бэхжүүлэх шаардлагатай. Мэдээлэл авах эрх нь нийгмийн бодлого, шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах урьдач нөхцөл болдог.⁴⁰⁷

Дэлхийн улс орнууд дахь мэдээлэл авах эрхийг хуулиар баталгаажуулсан байдлаар нь 150 оноогоор үнэлэхэд Монгол улс 87 оноогоор үнэлэгдэж байна. Энэхүү жагсаалтад мэдээлэл авах эрхийг хуулийн хүрээнд хангалттай баталгаажуулсан орноор Афганистан, Мексик, Серб, Шри Ланка, Словен, Албани, Энэтхэг, Гамбиа, Кротиа, Либер зэрэг зэрэг улсууд эхний 10 байранд бичигджээ. Харин мэдээлэл хамгийн хаалттай буюу мэдээлэл авах эрхийн хууль сул улсаар Австри, Палау, Лихтэнштэйн, Бүгд Найрамдах Беларусь, Манок, Филиппин, Тажикистан, Зүүн Тимор, Бенин, Герман улс оржээ.⁴⁰⁸ Мэдээлэл авах эрхийн дэлхийн үнэлгээ (RTI Rating) нь дэлхийн өнцөг булан бүрээс мэдээлэл авах эрхийн хууль эрх зүйн орчны бат бөх байдлыг харьцуулан үнэлдэг аргачлал юм. Мэдээлэл авах эрхийн үнэлгээг хэрэглэх аргачлалын гол цөм 61 үзүүлэлт байдаг бөгөөд тус бүр нь мэдээлэл авах эрхийн тодорхой онцлогт тохирсон байдаг. Үзүүлэлт бүрийн хувьд хууль, эрх зүйн орчин үзүүлэлтэд хэр нийцэж байгаагаас хамааран улс орнууд тогтоосон онооны хүрээнд (ихэнх тохиолдолд 0-2) оноо цуглуулж, нийт 150 оноо авдаг. Шалгуур үзүүлэлтүүд нь хүртээмж, хамрах хүрээ, хүсэлт гаргах журам, үл хамаарах болон татгалзах, давж заалдах, шийтгэл, хамгаалалт, сурталчилгааны арга хэмжээ гэсэн долоон өөр ангилалд хуваагддаг.

Мэдээлэл авах эрхийн энэхүү зэрэглэл нь хууль, эрх зүйн орчныг хэмжихээр хязгаарлагддаг бөгөөд хэрэгжилтийн чанарыг хэмждэггүй гэдгийг анхаарах нь чухал. Зарим тохиолдолд харьцангуй сул хуультай орнууд хэрэгжүүлэх эерэг хүчин чармайлтын улмаас маш нээлттэй байж болох ч харьцангуй хүчтэй хууль ч зохих ёсоор хэрэгжихгүй бол нээлттэй байдлыг хангаж чадахгүй. Эдгээр тохиолдлуудаас үл хамааран мэдээлэл олж авах эрхийн тухай хууль нь нээлттэй байдлыг ахиулах, түүнийг ашиглаж буй хүмүүст мэдээлэл авах эрхийг хамгаалах, дэмжихэд нь туслах гол түлхүүр юм. Нээлттэй байдал нь мэдээлэл авах эрхийн хууль эрх зүйн хүрээнээс давсан хүчин зүйлсийг хамарч байгаа хэдий ч хүчтэй хууль эрх зүйн орчин нь мэдээлэл авах эрхийг бүрэн хэрэгжүүлэх нэн чухал урьдчилсан нөхцөл гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.⁴⁰⁹

Тухайлбал дээрх долоон үзүүлэлтийн хүрээнд Афганистан улс нь мэдээлэл авах эрхийг Үндсэн хуулиар хамгаалсан хүчирхэг хуультай улс орон гэж харагдаж байгаа боловч Хил Хязгааргүй Сурвалжлагчид (RSF)-аас гаргасан Хэвлэлийн эрх чөлөөний индексээр 180

⁴⁰⁶ Монгол Улсын Засгийн Газар. Монгол Улсын Үндэсний сайн дурын Илтгэл 2019

<https://nda.gov.mn/backend/files/WPzFZWdaebnpM4M.pdf>

⁴⁰⁷ Глоб Интернэшнл төв. Мэдээллийн түгээмэл хүртээмжийн олон улсын өдөрт зориулан “Open Talks-2019” арга хэмжээг зохион байгууллаа. 2019.10.06. <https://www.gic.mn/post/r/1469>

⁴⁰⁸ The RTI rating. Analyses of the quality of the World’s access to information laws. Global Right to information Rating map. <https://www.rti-rating.org/>

⁴⁰⁹ RTI. Methodology. <https://www.rti-rating.org/methodology/>

орноос 122-т бичигдэж байгаагаас харахад мэдээлэл авах эрхийн хуулийн хэрэгжилт хангалтгүй хэмээн дүгнэж болохоор байна.⁴¹⁰ Энэ талаар Эмнести Интернэшнлийн Өмнөд Азийн дэд захирал Омар Варайч “Афганистанд мэдээлэл олж авах тухай хатуу хууль байдаг ч зохих ёсоор хэрэгжихгүй байна. Афганистаны сэтгүүлчид төрийн байгууллагын мэдэлд байгаа мэдээллийг авах эрхтэй ба тэднээр дамжуулан мэдээлэл авах нь олон нийтийн эрх юм. Афганистаны сэтгүүлчид дэлхийн хамгийн зоригтой сэтгүүлчдийн нэг. Тэд хамгийн хүнд нөхцөлд ажиллаж байхдаа хийж буй ажлынхаа төлөө заналхийлэл, айлган сүрдүүлэх, хүчирхийлэлд өртөж байна. Засгийн газар тэдний ажлаа чөлөөтэй, айдасгүйгээр хийх таатай орчныг бүрдүүлэх ёстой” гэж мэдэгджээ. 2019 онд “Най” мониторингийн бүлгийн мэдээлснээр Афганистанд арван сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан Талибан зэрэг зэвсэгт бүлэглэлийн гарт амиа алдсан байна.⁴¹¹

Харин Австри улс дэлхийн хамгийн сул мэдээллийн эрхийн хуультай улсуудын нэг бөгөөд “RTI” үнэлгээгээр байнга доогуур байранд ордог. 1987 онд батлагдсан Австри улсын Мэдээлэл авах эрхийн тухай хуульд одоо тогтсон стандарт гэж тооцогддог хэд хэдэн арга хэмжээ байхгүй. Хамгийн гол нь мэдээлэл авахыг эрх баригчдын зүгээс хориглохыг хуулиар хязгаарлаагүй бөгөөд эрх баригчид мэдээллийг хэзээ задруулах талаар тодорхой зааварчилгаагүй болно. Тус улсын Үндсэн хуульд заасан хамгийн бага хамгаалалт нь онцгой байдлын зохих горим байхгүй тохиолдолд мэдээлэл авах эрхийг бодитой хамгаалахад хангалтгүй юм. Мөн хууль нь зөвхөн төрийн эрх бүхий хязгаарлагдмал байгууллагад үйлчилдэг, хэрэв холбогдох эрх бүхий байгууллага эрх мэдэлгүй бол эрх баригчдад мэдээлэх замаар тухайн хүссэн мэдээллийн баримтыг өгөх шаардлага гардаг гэх мэт процедурын гол элементүүд байхгүй тул оноо алддаг. Мөн хүсэлтэд хариу өгөх найман долоо хоногийн хугацаа нь олон улсын сайн туршлагаас хамаагүй урт юм.⁴¹² Гэсэн хэдий ч Австри улс нь Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2021 оны байдлаар 180 орноос 17-д жагсдаг.⁴¹³ Үүнээс харахад төрөөс мэдээлэл авах эрхийг хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулахын зэрэгцээ хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарах нь чухал юм. “Access Info” байгууллагаас Австрийн мэдээллийн эрх чөлөөний тухай шинэ хуулийн төсөлд хууль зүйн дүн шинжилгээ хийж, мэдээллийн явцуу тодорхойлолт, хараат бус хяналтын байгууллага байхгүй, дагаж мөрдөөгүй тохиолдолд хариуцлагын дэглэм байхгүй зэрэг дутагдалтай байгааг онцлон хуулийг батлахаас өмнө төслийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна хэмээн үзэж Австрийн Парламентын хэлэлцүүлэгт дараах зөвлөмжийг өгчээ.⁴¹⁴

- Мэдээллийн тодорхойлолтыг төрийн эрх бүхий байгууллагын нэрийн өмнөөс эсвэл эзэмшиж буй бүх материалыг хамруулан өргөжүүлэх.
- Төрийн байгууллага бүр мэдээллийн бүртгэлд яг юуг идэвхтэй нийтлэх ёстойг зааж өгөх
- Өргөдөл гаргагчид ажлын 5 хоногоос илүүгүй хугацаанд хүсэлт гаргасны дараа баримт, мэдэгдлийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх
- Төрийн албан хаагчид хүсэлт гаргагчид хүсэлтээ боловсруулахад нь туслах үүрэгтэй болгох
- Хариу өгөх хугацааг олон улсын жишигт нийцүүлэх
- Хүчтэй, эрх мэдэл бүхий мэдээллийн комиссар байгуулах.

⁴¹⁰ Reporters Without Borders. 2021 World Press Freedom Index. <https://rsf.org/en/ranking#>

⁴¹¹ Amnesty International. Afghanistan: Implement Access to Information Law. Feb 05, 2020 <https://www.amnesty.org/en/latest/news/2020/02/afghanistan-implement-access-to-information-law/>

⁴¹² RTI. Global Right to Information Rating. <https://www.rti-rating.org/country-data/Austria/>

⁴¹³ Legal Analysis of the Austrian Freedom of Information Act. https://www.parlament.gv.at/PAKT/VHG/XXVII/SNME/SNME_85202/imfname_947137.pdf

⁴¹⁴ Access Info. Legal Analysis of the Austrian Freedom of Information Act. 19 April 2021. https://www.parlament.gv.at/PAKT/VHG/XXVII/SNME/SNME_85202/imfname_947137.pdf

Мэдээлэл авах эрхийг баталгаажуулж, хуулийн хэрэгжилтийг хангахад төрийн үүрэг оролцоо чухал нөлөөтэй бөгөөд сэтгүүлчид төдийгүй олон нийтийн мэдээллийн хүртээмж сайжирч ардчилсан нийгэм дэх иргэдийн утга учиртай оролцоо, төрийн ил тод байдал, эгэх хариуцлага нэмэгдэнэ.⁴¹⁵

3.2. Европын хүний эрхийн шүүхийн жишиг шийдвэрийн тойм: Сэтгүүлчийн эх сурвалжаа хамгаалах эрх

1950 онд батлагдаж, 1953 онд хүчин төгөлдөр болсон Европын Хүний эрхийн конвенцын 10 дугаар зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, түүн дотроо мэдээлэл, үзэл санааг төрийн хөндлөнгийн нөлөөгүйгээр хил хязгаараас үл хамааран хүлээн авах эрхийг баталгаажуулсан бөгөөд түүний зохицуулалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлтэй дүйцдэг.⁴¹⁶ Тус конвенцын 10 дугаар зүйлийг Европын хүний эрхийн шүүх хэрэглэж гаргасан шийдвэрүүддээ “сэтгүүл зүйн эх сурвалжийг хамгаалах нь хэвлэлийн эрх чөлөөний нэг гол нөхцөл юм. Ийм хамгаалалтгүйгээр эх сурвалжийн хувьд олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар олон нийтэд мэдээлэл хүргэхэд хэвлэлд туслахаас татгалзах болно. Үүний үр дүнд хэвлэл мэдээллийн хоточ нохойн амин чухал үүрэг алдагдаж, хэвлэлийн үнэн зөв, найдвартай мэдээлэл өгөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй юм. . . . Олон нийтийн ашиг сонирхлын үүднээс нэн тэргүүний шаардлагаар зөвтгөгдөөгүй л бол эх сурвалжийг илчлэх үүрэг хүлээлгэх нь Конвенцийн 10 дугаар зүйлд нийцэхгүй” гэж онцолсон.⁴¹⁷

Хүснэгт 26. Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах асуудлаар Европын хүний эрхийн шүүхээс гаргасан шийдвэрийн тойм

Огноо / талууд	Шийдвэрийн товч утга
1996.03.27 Goodwin v. ИБУИНХУ	Энэ хэрэгт сэтгүүлчийг компанийн нууц төлөвлөгөөний талаарх эх сурвалжаа илчлэхийг даалгасан. Европын хүний эрхийн шүүхээс эх сурвалжийг илчлэх шийдвэрийн хууль ёсны зорилго болон энэ зорилгод хүрэхийн тулд ашиглаж буй арга хэрэгслийн хоорондын зохистой харьцаа байгаагүй гэж үзсэн. Сэтгүүлчийг эх сурвалжаа илчлэхийг шаардсан шийдвэр, тэрхүү шийдвэрийг биелүүлэхээс татгалзсаныг нь төлөө оногдуулсан торгуулийн аль аль нь Европын хүний эрхийн тухай конвенцийн 10 дугаар зүйлд заасан сэтгүүлчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн.
2005.12.08 Nordisk Film; TV A/S v. Дани	Энэ хэрэг нь сэтгүүлч Дани улсад педофилийн тухай баримтат кино хийж байхдаа нууцаар ажиллаж, сэтгүүлчийн олж авсан педофилийн холбоонд холбогдох судалгааны материалыг задруулах үүрэг хүлээлгэсэн шийдвэртэй холбоотой юм. Шүүх илт үндэслэлгүй тул сэтгүүлчийн гомдлыг хүлээн авах боломжгүй гэж мэдэгдэв. Дотоодын шүүхийн шийдвэр нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэслэлтэй, ялангуяа хүүхдийн хүчирхийллийн ноцтой хэрэгтэй холбоотойгоор сэтгүүлчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд зохих зөвшөөрөгдсөн хэмжээнд хөндлөнгөөс оролцсон нь үндэслэлтэй гэж үзжээ.
2007.11.22 Voskuil v. Голланд	Зэвсгийн наймаатай холбоотой эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны талаар сонинд бичсэн хоёр нийтлэлтэй нь холбогдуулан сэтгүүлчийн эх сурвалжаа задруулахгүй байх эрхийг нь хасч, тийнхүү эх сурвалжийг нь хэлүүлэхийн тулд сэтгүүлчийг хоёр долоо хоног гаруй хугацаанд саатуулсан. Голландын Засгийн газар сэтгүүлчийн эх сурвалжийг мэдэх гэсэн ашиг сонирхол нь түүнийг илчлэхгүй байх гэсэн сэтгүүлчийн ашиг сонирхлоос илүү гэж үзэхэд хангалтгүй гэж шүүх дүгнээд Конвенцийн 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэв. Мөн сэтгүүлчийн халдашгүй, чөлөөтэй байх эрх буюу Конвенцийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзсэн.

⁴¹⁵ UNESCO. Media development indicators: a framework for assessing media development. 2008

<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000163102>

⁴¹⁶ European Convention on Human Rights. 1950 https://www.echr.coe.int/documents/convention_eng.pdf

⁴¹⁷ European Court of Human Rights. Factsheet – Protection of journalistic sources. December 2021

https://www.echr.coe.int/Documents/FS_Journalistic_sources_ENG.pdf

2009.12.15 Financial Times Ltd v. ИБУИНХУ	Энэ хэрэг ИБУИНХУ-ын дөрвөн сонин болон мэдээний агентлагаас Белгийн шар айраг үйлдвэрлэгч компанийн тендертэй холбоотой анхдагч мэдээллийг хэвлэлд илчилсэн эх сурвалжийн талаарх мэдээллийг шаардсантай холбоотой. Шүүх конвенцийн 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзсэн. Нууц мэдээллийг ил болгох замаар цаашид хохирлыг арилгах, нууцлалыг зөрчсөнтэй холбоотой хохирлыг тодорхойлох ашиг сонирхол байгаа хэдий ч тэр нь сэтгүүлчдийн эх сурвалжийг хамгаалах олон нийтийн ашиг сонирхлоос давж гарахад хангалтгүй гэж үзсэн.
2010.09.14 Sanoma Uitgevers B.V. v. Голланд	Энэ хэрэг нь хууль бус автомашины уралдааны тухай нийтлэлд ашиглах гэрэл зургуудтай холбоотой байсан бөгөөд нууц эх сурвалжийг илчлэх магадлалтай материалыг задруулахыг сэтгүүлчид эрс эсэргүүцэж байсан ч Голландын сэтгүүлийн компани өөр гэмт хэргийн мөрдөн байцаалтын явцад цагдаад хүлээлгэн өгсөн юм. Үүнийг шүүх конвенцийн 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзсэн.
2012.11.22 Telegraaf Media Nederland Landelijke Media B.V. v. Голланд	Голландын хуулийн дагуу бүртгүүлсэн хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу өдөр тутмын “De Telegraaf” сонины компаниас сэтгүүл зүйн эх сурвалжийг тодорхойлохуйц баримт бичгийг гаргаж өгөхийг шаардсан талаар болон төрийн тусгай хүчнийг ашигласан талаар хоёр сэтгүүлч шүүхэд гомдол гаргасан. Шүүхээс хоёр сэтгүүлчийн хувийн халдашгүй чөлөөтэй байх эрх буюу конвенцийн 8 дугаар зүйл болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх буюу 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзсэн. Голландын холбогдох хууль нь тусгай хүчин сэтгүүлчдийг мөрдөн мөшгих замаар сэтгүүл зүйн эх сурвалжийг олж мэдэх гэсэн оролдлогоос хангалттай урьдчилан сэргийлж чадахгүй байна гэж үзсэн. Сэтгүүл зүйн эх сурвалжийг тодорхойлохуйц баримт бичгийг хэвлэлийн компаниас шаардсан захирамж нь конвенцын 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж шүүхээс үзсэн. Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах нь хэвлэлийн эрх чөлөөнд чухал болохыг онцгойлон дурдаж, эх сурвалжийг илчлэхийг даалгах нь тэрхүү эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг дурдаж, хэвлэлийн компанид нууц баримт бичгүүдийг нийлүүлсэн тусгай албаны ажилтныг олж тогтоохын тулд эх сурвалжийн талаарх баримт бичгийг гаргаж өгөхийг шаардах нь буруу гэж шүүхээс үзсэн.
2017.10.05 Becker v. Норвеги	Энэ хэрэг нь сэтгүүлчийн эх сурвалжийн нэг бөгөөд зах зээлд манипуляци хийсэн гэх эрүүгийн хэрэгт буруутгагдаж буй Х-ийн эсрэг нотлох баримтыг гаргаж өгөхийг сэтгүүлчид даалгасантай холбоотой. Х-гийн хувьд тухайн сэтгүүлчийн 2007 онд бичсэн Норвегийн газрын тосны компанийн санхүүгийн хүнд байдлын талаарх нийтлэлийн эх сурвалж байсан гэдгээ цагдаад мэдүүлсэн. Улмаар Х-г санхүүгийн зах зээлийг удирдах зорилгоор сэтгүүлчийг ашигласан хэргээр буруутгасан. Сэтгүүлч нь Х-ийн эсрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд мэдүүлэг өгөхөөс татгалзсан тул дотоодын шүүхүүд түүний эх сурвалж аль хэдийн ил болсон тул хамгаалах эх сурвалж байхгүй гэж үзэн Х-тэй холбоотой байсан талаар мэдүүлэг өгөхийг даалгасан. Мөн сэтгүүлчийн нотлох баримт хэргийг тодруулахад шүүхүүдэд ихээхэн тус болно гэж үзсэн. Гэхдээ тийнхүү нотлох баримт гаргаж өгөхийг даалгасан эцсийн шийдвэр гарахаас өмнө Х-д ял оногдуулсан. Сэтгүүлчийн зүгээс түүнийг эх сурвалжтайгаа холбоо тогтоосон талаар нотлох баримт өгөхийг тушаасан шийдвэрийн эсрэг Европын хүний эрхийн шүүхэд гомдол гаргасан бөгөөд тэрхүү шийдвэр нь бусад эх сурвалжийг олж тогтооход хүргэж болзошгүй гэж үзжээ. Мөн эх сурвалжийнхаа эсрэг ямар ч хэрэгт мэдүүлэг өгөх ямар ч бодит шаардлага байхгүй гэдгийг сэтгүүлч гомдолдоо дурдсан. Шүүхээс конвенцийн 10 дугаар зүйлийн зөрчсөн гэж үзсэн. Ингэхдээ эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгүүлчийн эх сурвалжийн эсрэг нотлох баримт хэрэгтэй байсан эсэх талаарх үнэлгээ өөрчлөгдсөн гэж үзсэн. Сэтгүүлч эх сурвалжаа задруулахаас татгалзсан нь Х-г буруутгах мөрдөн байцаалтын ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар ч саад учруулаагүй гэдгийг онцолсон. Үнэхээр, сэтгүүлч мэдүүлэг өгөөгүй байхад прокурорын дүгнэлтийн дагуу анхан шатны шүүхээс Х-д ял оногдуулсан бөгөөд сэтгүүлчийн мэдүүлэг өгөх үүрэгтэй эсэх талаарх эцсийн шийдвэр гарахаас өмнө дээрх хэрэг аль хэдийн хаагдсан. Тухайн сэтгүүлчийн сэтгүүлзүйн арга барил хэзээ ч эргэлзээ төрүүлж байгаагүй бөгөөд түүнийг ямар нэгэн хууль бус үйл ажиллагаанд буруутгадаагүй гэдгийг шүүх анхаарч үзсэн. Түүнчлэн, тухайн эх сурвалж тодорхой болсон, тэрхүү эх сурвалж ямар үйлдэл хийсэн эсэхээс үл хамааран сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах эрхийг үгүйсгэж болохгүй гэж үзсэн.

2020.10.06 Jecker v. Швейцарь	Энэ хэрэг нь сэтгүүлч хар тамхины наймаачны тухай сонинд нийтлэл бичсэний дараа эрх баригчид түүнээс эх сурвалжаа ил болгохыг шаардаж, хар тамхины наймааны хэрэг дэх мөрдөн шалгах ажиллагааны явцад сэтгүүлчийг мэдүүлэг өгөхийг албадсантай холбоотой. Сэтгүүлчийн эх сурвалжаа илчлэхгүй байх эрхэд хөндлөнгөөс зүй бусаар халдсан гэж үзэж тэрээр гомдол гаргасан. Европын хүний эрхийн шүүх конвенцийн 10 дугаар зүйлд заасан сэтгүүлчийн эрхийг зөрчсөн гэж үзсэн. Швейцарийн холбооны дээд шүүхээс хар тамхины хэрэгтэнд ял оногдуулах нь олон нийтийн ашиг сонирхол бөгөөд эх сурвалжийг хамгаалах ашиг сонирхлоос илүү чухал гэж үзсэн. Харин Европын хүний эрхийн шүүх олон нийтийн ашиг сонирхлын үүднээс нэн тэргүүний шаардлагатайгаас бусад тохиолдолд сэтгүүлчээс эх сурвалжаа илчлэхийг шаардах нь Конвенцийн 10 дугаар зүйлд заасан ардчилсан нийгэм дэх хэвлэлийн эрх чөлөөнд нийцэхгүй гэж үзсэн.
2021.05.25 Big Brother Watch v. ИБУИНХУ	Европын хүний эрхийн шүүхэд тус гомдлыг АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын агентлагийн гэрээт ажилтан асан Эдвард Сноуден АНУ, ИБУИНХУ-ын хоорон дахь мөрдөн мөшгих, тагнах хөтөлбөрийн талаар илчилсний дараа гаргасан. Энэ хэрэг нь сэтгүүлчид, хүний эрхийн байгууллагуудын зүгээс тагнуулын дэглэмтэй холбоотой дараах гурван асуудлаар гаргасан гомдолтой холбоотой: (1) харилцаа холбоог их хэмжээгээр тасалдуулах; (2) гадаадын засгийн газар болон тагнуулын агентлагаас олзолсон материалыг хүлээн авах; (3) харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчдээс харилцаа холбооны мэдээлэл авах. Шүүхээс эхний хоёр асуудлыг Конвенцийн 8 дугаар зүйл буюу хувийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн, 10 дугаар зүйл буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн гэж үзсэн.
2021.12.07 Standard Verlagsgesellsc haft mbH v. Австри	Энэ хэрэг нь Der Standard сонины вэбсайт болох derStandard.at сайтад сэтгэгдэл бичсэн бүртгэлтэй хэрэглэгчдийн бүртгэлийн мэдээллийг илчлэхийг хэвлэл мэдээллийн компанид даалгасан шүүхийн шийдвэртэй холбоотой юм. Улс төрчдийг авлига, неонацистуудтай холбож бичсэн сэтгэгдлүүдийн дараа тэдгээр сэтгэгдлийг устгасан ч компани сэтгэгдэл бичсэн хүмүүсийн мэдээллийг задруулахаас татгалзсан байна. Сэтгэгдэл бичигчдийн мэдээллийг гаргуулах тухай шүүхийн шийдвэр нь ардчилсан нийгэмд шаардлагагүй зүйл гэж Европын хүний эрхийн шүүхээс үзэж, дээрх шийдвэрийг Конвенцийн 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж дүгнэсэн. Хэрэглэгчийн өгөгдөл нь “сэтгүүл зүйн эх сурвалж”-ийн хамгаалалтад хамаарахгүй ч дотоодын хэрэглэгчийнхээ нэрээ нууцлах эрхийг компани хамгаалж буй явдлыг Конвенцийн 10 дугаар зүйлд баталгаажсан үзэл санаа, мэдээллийг чөлөөтэй түгээх явдлыг дэмжиж байна гэж үзсэн.

Дээр дурдсан Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрийн тоймоос харахад дараах дүгнэлт хийж болохоор байна:

- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, үзэл санаа, мэдээллийг хил хязгаар үл хамааран чөлөөтэй түгээхийн бүрэлдэхүүн хэсэг нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө бөгөөд түүнийг нэг гол хэсэг нь сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах эрх юм.
- Сэтгүүлч нууц эх сурвалжаа хамгаалах эрхтэй байх нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхолд хамаатай бөгөөд тэрхүү эрхийг хөндөхийн тулд шүүхээс зохих үнэлгээ хийж, олон нийтийн бусад ашиг сонирхлыг хангахад сэтгүүлчийн эх сурвалжийг илчлэх нь шууд хамааралтай, зайлшгүй шаардлагатай болохыг нотлох ёстой. Тийнхүү нотлоогүй нөхцөлд сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах эрхийг зөрчсөн гэж үзнэ.

Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрээр тогтоосон жишиг нь Европын хүний эрхийн конвенцийн гишүүн орнууд буюу Европын Зөвлөлийн гишүүн 47 орны хувьд нэгэн адил баримтлах хэм хэмжээ болно.

3.3. Гаднын зарим улсын сайн туршлага

“Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагаас тогтмол эрхлэн гаргадаг “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд “маш сайн” ба “сэтгэл хангалуун”-тай гэж дүгнэсэн улсуудаас тивийн төлөөлөл байх, эрх зүйн тогтолцооны хувьд Монгол

Улсад жишиг болох, дээр дурдсан Европын хүний эрхийн шүүхийн харьяалалд байх нөхцөлийг харгалзан сайн туршлагыг нь судлах гадаад улсуудыг сонгов. Энэ хүрээнд хэвлэлийн эрх чөлөөний хувьд “маш сайн” үзүүлэлт бүхий Норвеги, “сэтгэл хангалуун” үзүүлэлт бүхий Австрали, ИБУИНХУ, БНСУ, АНУ-ын туршлагыг танилцуулж байна.

Хүснэгт 27. “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний 2021 оны индекс” дэх дээгүүр байр бүхий улсууд

Улсын нэр	Хэвлэлийн эрх чөлөөний байр	Тив	Эрх зүйн тогтолцоо
<i>Хэвлэлийн эрх чөлөөний маш сайн үзүүлэлттэй улс</i>			
Норвеги	1	Европ	Холимог эрх зүйн тогтолцоотой - Иргэний, нийтлэг болон заншлын эрх зүйн тогтолцоо
<i>Хэвлэлийн эрх чөлөөний сэтгэл хангалуун үзүүлэлттэй улс</i>			
Австрали	25	Австрали	Нийтлэг эрх зүйн тогтолцоотой - Английн загварт суурилсан
ИБУИНХУ	33	Европ	Нийтлэг эрх зүйн тогтолцоотой
БНСУ	42	Ази	Холимог эрх зүйн тогтолцоотой – Европын иргэний эрх зүй, Англо-Америкийн эрх зүй
АНУ	44	Америк	Нийтлэг эрх зүйн тогтолцоотой - Английн загварт суурилсан — холбооны түвшинд

Ингэхдээ тухайн улсын хэвлэл мэдээллийн бодлого /хэвлэл мэдээллийн хууль тогтоомж, хариуцлагын тогтолцоо, зохицуулах байгууллагууд/-той холбоотой улсын онцлог бөгөөд шинэлэг туршлагыг танилцуулна.

3.3.1. Норвегийн Хаант Улсын туршлага

“Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд сүүлийн 5 жилд буюу 2017-2021 онд 1 дүгээр байрт орсон буюу хэвлэлийн эрх чөлөөний “маш сайн” үзүүлэлттэй улс бол Норвегийн хаант улс юм. Үүнээс өмнөх хугацаанд тус улс хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлтээр тогтмол эхний гурван байрт орсон.⁴¹⁸

Хэвлэл мэдээллийн хууль тогтоомж:

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг 1814 онд батлагдсан Норвегийн хаант улсын Үндсэн хуулийн 100 дугаар зүйл болон 1950 онд батлагдсан Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцын 10 дугаар зүйлээр хамгаалсан.⁴¹⁹ 2014 онд Норвегийн парламентын зүгээс Үндсэн хууль дахь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний зохицуулалтыг шинэчилж, өргөжүүлсэн бөгөөд засгийн газарт хэвлэл мэдээллийн олон талт байдал, нийтийн шүүмжийг дэмжих үүрэг хүлээлгэсэн нь чухал нэмэлт болсон.⁴²⁰

Хэвлэл мэдээллийн бодлого, зохицуулалтыг парламентаас баталсан хууль тогтоомж, Соёлын яам, Норвегийн Хэвлэл мэдээллийн газраас тогтоосон дүрэм, улсын төсөвтэй холбоотой парламентын шийдвэр, тухайн нэг тохиолдолтой холбоотой Яам, Хэвлэл мэдээллийн газрын шийдвэрээр тус тус тодорхойлно. Хүүхдийг хамгаалах зорилгоор киноноос бусад тохиолдолд хэвлэн нийтлэхийн өмнөх цагдан хяналтыг хориглодог. Норвегийн Хэвлэл мэдээллийн газар (Medietilsynet) нь Соёлын яамны дэргэдэх агентлаг бөгөөд өргөн нэвтрүүлэг, сонин, кинотой холбоотой олон чиг үүргийг хэрэгжүүлэхээр 2005.01.01-нд засгийн газрын гурван агентлаг болох Норвегийн киноны ангиллын зөвлөл (Statens filmtilsyn), Норвегийн Хэвлэл мэдээллийн өмчлөлийн газар (Eierskapstilsynet), Масс

⁴¹⁸ Reporters Without Borders: Norway <https://rsf.org/en/norway>

⁴¹⁹ - The Constitution of the Kingdom of Norway. 1814 <https://lovdata.no/dokument/NLE/lov/1814-05-17>
- European Convention on Human Rights. 1950 https://www.echr.coe.int/Documents/Convention_ENG.pdf

⁴²⁰ Helge Østbye. Norway - Media Landscapes Expert Analyses of the State of Media. European Journalism Centre (EJC). 2019 <https://medialandscapes.org/country/norway>

хэвлэл мэдээллийн газар (Statens medieforvaltning)-ыг нэгтгэсний үндсэн дээр байгуулагдсан.⁴²¹ Радио, телевизийг “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулиар, киног “Кино, дүрс бичлэгийн тухай” хуулиар тус тус зохицуулах бөгөөд интернэт, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх тусгайлсан хууль тогтоомж багатай.

2005 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд хэвлэл мэдээллийн тусгайлсан ашиг сонирхлыг хөндөх садар самуун, гүтгэлэг, төрийн нууц, хувь хүний халдашгүй байдлыг хамгаалах зэрэг зохицуулалтыг тусгасан. 2005 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн батлахад бурхан, ариун зүйлсийг доромжлох, хараах хэсгийг хассан бөгөөд энэ нь 2015 оноос хүчин төгөлдөр болж үйлчилж байна. Эрүүгийн хуулиар сонин, сэтгүүл, өргөн нэвтрүүлгийн агуулгыг хариуцах редактортой байхыг шаарддаг.⁴²²

Засгийн газар болон төрийн өмчит өргөн нэвтрүүлгийн компани (NRK) хоорондын харилцаа их эмзэг. Ерөнхийдөө технологи, захиргаа, шинэ үйлчилгээтэй холбоотой асуудлыг засгийн газар, парламент шийдэх эрх хэмжээтэй хэдий ч Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар эдгээр эрх бүхий байгууллага нь хувь хөтөлбөрийн асуудалд хөндлөнгөөс оролцохыг хориглодог. Зөвхөн өргөн нэвтрүүлгийн дарга тухайн хөтөлбөрийг зогсоох, өөрчлөхийг шаардах эрхтэй. Гэхдээ засгийн газар болон парламентын зүгээс төрийн өмчит өргөн нэвтрүүлгийн компани NRK-ийн тусгай зөвшөөрлийн хөлсийг шийдэх бөгөөд энэ нь улс төрийн эрх мэдэлтнүүд тус компанид тодорхой эрх мэдэлтэй байх нөхцөл болдог.

2016.04.17-ны өдөр батлагдсан Хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдлын тухай хууль нь өдөр тутмын сонин, телевиз, радио, цахим мэдээллийн хэрэгсэл эрхэлдэг аж ахуйн нэгж, түүнчлэн эдгээр аж ахуйн нэгжид өмчлөх, хамтран ажиллах гэрээгээр дамжуулан нөлөөлөх аж ахуйн нэгжүүдэд хамаарна. Хуулийн үйлчлэлд хамаарах хэн бүхэн Хэвлэл мэдээллийн газарт шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй. Тэрхүү мэдээлэлд Норвеги дэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн талаарх мэдээлэл, хамтын ажиллагааны гэрээний талаарх мэдээлэл багтах бөгөөд редакцийн бүтээл дэх нөлөөллийн талаар тусгасан байна. Мэдээллийг амаар буюу бичгээр гаргаж өгөх бөгөөд тодорхой хамрах хугацаатай байна. Дурдсан мэдээллийг гаргаж өгөхөд нууцын хууль тогтоомж, мэдээллийн нууц хадгалах үүрэг саад болохгүй. Тийнхүү гаргаж өгөх мэдээллийн хамрах хүрээ, холбогдох харилцааг зохицуулсан журам яамнаас гаргаж болно. Хэвлэл мэдээллийн газар нь хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах этгээдэд торгууль ногдуулж болно. Торгуулийг хуваан төлөх, нэг удаа бөөнд нь төлөхөөр шийдвэрлэж болно. Торгууль ногдуулах нөхцөл, торгуулийн хэмжээ, хугацаа хэтрүүлсэн төлбөрийн хүүгийн талаар яамнаас журам гаргаж болно. Хэвлэл мэдээллийн газрын шийдвэрийн талаар Хэвлэл мэдээллийн асуудлаарх давж заалдах зөвлөлд гомдол гаргаж болох бөгөөд тус зөвлөл өөрийн санаачилгаар Хэвлэл мэдээллийн газрын шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхгүй.⁴²³

2020.05.29-ний өдөр батлагдаж 2020.07.01-ний өдрөөс үйлчилсэн “Редакцийн хараат бус байдал ба редакцийн хяналттай сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хариуцлагын тухай” хууль буюу Хэвлэл мэдээллийн хариуцлагын тухай хууль нь сэтгүүл зүйн тогтмол нийтлэл, мэдээ, цаг үеийн мэдээ, олон нийтийн мэтгэлцээн, нийтийн ашиг сонирхлын бусад контент нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаарна. Харин маркетингийн зорилго бүхий хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаарахгүй.⁴²⁴ Редактор нь

⁴²¹ The Norwegian Media Authority (Medietilsynet) <https://www.medietilsynet.no/>

⁴²² Norway – The Penal Code. 2005 <https://lovdata.no/dokument/NLE/lov/2005-05-20-28>

⁴²³ The Norwegian Media Authority - Media Legislation. <https://www.medietilsynet.no/english/media-legislation/>

⁴²⁴ Norway - Lov om redaksjonell uavhengighet og ansvar i redaktørstyrte journalistiske medier (medieansvarsloven) https://www.medietilsynet.no/globalassets/engelsk-dokumenter-og-rapporter/210216-unoff-210216_eng-versionact-relating-to-the-editorial-independence-and-liability-of-editor.pdf

хэрэглэгчийн үүсгэсэн контент болон мэдээллийн хэрэгсэл дэх редакцийн агуулгын хооронд тодорхой ялгааг хадгалж, ямар контентыг хэрэглэгч үүсгэж болохыг зааж өгнө. Редактор нь хууль бус хэрэглэгч үүсгэсэн контентыг мэдээлэх ажлыг хөнгөвчлөнө. Хэрэглэгчийн үүсгэсэн контентыг устгасан эсвэл хууль бус гэж үзсэний улмаас контент руу нэвтрэх эрхийг хориглосон тохиолдолд редактор нь аль болох түүний зохиогчид мэдэгдэж, давж заалдах боломжийн талаар мэдэгдэнэ. Редактор нь хэвлэл мэдээллийн үндсэн зарчим, зорилгын хүрээнд редакцийн ажлыг удирдаж, редакцийн асуудлаар шийдвэр гаргана. Нийтлэгч, өмчлөгч эсвэл компанийн бусад удирдлага нь редакцийн асуудлаар редакторт заавар өгөх, редакцийн шийдвэрийг хүчингүй болгох эрхгүй, мөн урьдчилан хэвлэл, бичвэр, зураг үзүүлэхийг шаардах, эсвэл нэвтрүүлгийн материалыг олон нийтэд нээлттэй болгохоос өмнө сонсгох, үзүүлэхийг шаардах эрхгүй. Эдгээр зохицуулалтын дагуу редакц, редактор нь түүний хянасан, зөвшөөрсөн агуулга хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх, хохирол барагдуулах бөгөөд энэ зарчим нь өмчлөгч, нийтлэгчид нэгэн адил хэрэглэгдэнэ. 2020.12.18-ны өдөр батлагдаж, 2021.01.01-ний өдрөөс үйлчилж буй Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай хууль нь хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны урьдчилан таамаглах боломжтой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах, хэвлэл мэдээллийн дэмжлэгийг нэмэгдүүлэх замаар Норвеги даяар редакторын хяналттай олон төрлийн сэтгүүлзүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжихэд оршино. Засгийн газар Норвегийн өргөн нэвтрүүлгийн компанид зориулсан тогтмол, урт хугацааны санхүүгийн тогтолцоо болон дөрвөн жилийн удирдлагын мөчлөгөөр дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслийг шууд дэмжих буцалтгүй тусламжийн схемийг санал болгоно. Энэхүү саналыг парламентын сонгуулийн дараах жилийн төсвийн төсөлд хамт тусгана.⁴²⁵ Хэвлэл мэдээлэлд шууд дэмжлэг үзүүлэх буцалтгүй тусламжийн схемтэй холбоотой журмыг яам гаргаж болно. Цаг үеийн мэдээ, мэдээллийн хэрэгслийн бүтээгдэхүүнд зориулсан тэтгэлэг нь бичвэрт суурилсан цаг үеийн мэдээ, мэдээллийн хэрэгслийг дэмжих замаар олон нийтэд чиглэсэн өргөн хүрээтэй сэтгүүл зүйн агуулга буюу олон талт байдлыг дэмжих зорилготой. Түүнчлэн энэхүү тэтгэлгийн схем нь өндөр чанартай хараат бус сэтгүүл зүйг дэмжих, ялангуяа жижиг зах зээлд амьдрах чадваргүй цаг үеийн мэдээ, мэдээллийн хэрэгслийг дэмжих юм. Энэхүү тэтгэлгийг үйл ажиллагааны зардал хэлбэрээр олгох бөгөөд тэтгэлэг авах нөхцөл нь аль болох бодитой байх ёстой. Түүнчлэн тус хуульд үндэстний цөөнхийн мэдээ, мэдээллийн хэрэгслийн бүтээгдэхүүнд олгох тэтгэлэг, инновац, хөгжлийн тэтгэлэг, орон нутгийн дуу-дүрст мэдээллийн хэрэгсэлд олгох тэтгэлэг, сонин түгээх зардлыг бууруулах тэтгэлгийн талаар зохицуулсан. Норвегийн Хэвлэл мэдээллийн газар тэтгэлгийн талаарх хүсэлтийг хүлээн авч, тэтгэлэг олгох, хуваарилах шийдвэр гаргах бөгөөд тэтгэлгийн санд аудит хийлгэнэ. Мөн тус газар нь төрийн өмчит өргөн нэвтрүүлгийн компани NRK-д олгох тэтгэлгийг парламентын баталсан төсвийн талаарх шийдвэрийн дагуу хуваарилна. Норвегийн Хэвлэл мэдээллийн газрын шийдвэрт хаан, албан тушаалтнууд нөлөөлөх, түүний шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгохыг хориглоно.

Хариуцлагын тогтолцоо:

Норвегийн хэвлэлийн холбоо (Norsk Presseforbund) нь хэвлэл мэдээллийн ёс зүйг ерөнхийд нь хариуцдаг. Хэвлэлийн холбоо нь Норвегийн хэвлэл болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн ёс зүйн дүрмийг (Vær varsom-plakaten) хамгаалах, хөгжүүлэх үүрэгтэй. Хэвлэлийн холбооноос Хэвлэлийн мэргэжлийн хороо (Pressens Faglige Utvalg) буюу Хэвлэлийн зөвлөлийг томилох бөгөөд тус хороо нь ёс зүйн дүрмийг зөрчсөн тухайн нэг тохиолдолд үнэлгээ хийнэ. Тус хорооны гишүүдийн олонх нь хэвлэл мэдээллийн салбарын

⁴²⁵ Norway - Lov om økonomisk støtte til medieene (mediestøtteloven)

<https://www.medietilsynet.no/globalassets/engelsk-dokumenter-og-rapporter/200106-the-media-support-act---unofficial-translation.pdf>

хүмүүс байх бөгөөд олон нийтийн төлөөллөөс гишүүн байдаг. Хэвлэлийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шийтгэл ногдуулахгүй ч ёс зүйгүй нийтлэл, нэвтрүүлэг, сэтгүүлчдийн ёс зүйгүй үйлдэлтэй холбоотой Зөвлөлийн дүгнэлтийг нийтлэхийг зөрчил гаргасан этгээдээс шаардаж болно. Энэ тогтолцоо нь мэргэшсэн, шударга гэж тооцогддог тул төрөөс сэтгүүлчийн ажилд албан ёсны хяналт тавих шаардлагатай гэж үзээгүй байна.

Өргөн нэвтрүүлгийн компанийн радио, телевизийн хөтөлбөрийн эсрэг Хэвлэлийн зөвлөлд гомдол гаргаж болно. Гэхдээ зэрэгцүүлэн Өргөн нэвтрүүлгийн зөвлөлөөр (Kringkastingrådet) дамжуулан тухайн хэргийг шийдвэрлүүлэх арга зам бий. Өргөн нэвтрүүлгийн зөвлөлийн гишүүдийг Соёлын яам сонгодог бөгөөд түүний 8 гишүүнийг Хаан, 6 гишүүнийг парламент батламжлан томилдог. Радио, телевизийн сувгууд тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах бөгөөд тусгай зөвшөөрлийн гэрээгээ зөрчсөн тохиолдолд тэрхүү тусгай зөвшөөрлөө алдана. Одоогоор ийм төрлийн шийтгэл ногдуулсан нь ховор.

Мөн хуулийн системийг хэвлэл мэдээллийн эсрэг ашиглах нь бий. Дээр дурдсанчлан Эрүүгийн хуульд гүтгэх, хувийн нууцад халдахыг хориглох гэх мэт зүйл заалтууд байдаг бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл шүүх дээр хэрхэн ажиллах, зохиогчийн эрхийн хууль тогтоомж гэх мэт үйл түүний ажиллагаа явуулахтай холбоотой тодорхой хуулиуд бий.

Зохицуулах эрх бүхий байгууллагууд:

Радиог 2017 онд, телевизийг 2007-2008 онд тоон болгох хүртэл радио, телевизийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэхэд Соёлын яамнаас, орон нутгийн хэмжээнд нэвтрүүлэхэд Норвегийн Хэвлэл мэдээллийн газраас тусгай зөвшөөрөл авах шаардлагатай байсан. Тоон сүлжээний эзэд нь тухайн сувгийг сүлжээнд нэвтрэх боломж олгоно. Төрийн өмчит өргөн нэвтрүүлгийн компани NRK болон TB2, Теленор гэсэн гурван газрын тэнцүү эзэмшил бүхий Норвегийн телевиз 2021 он хүртэл тоон телевизийн сүлжээг эрхлэн ажиллуулсан. Тоон радиогийн сүлжээг Теленорийн эзэмшил бүхий Норклинг А.С эзэмшдэг. Богино долгионы платформ дээр ажилладаг орон нутгийн радио станцууд Норвегийн Хэвлэл мэдээллийн газраас авсан тусгай зөвшөөрөлтэй байх шаардлага хэвээр байна. Теленор нь техникийн аналог болон тоон сүлжээний чухал зохион байгуулагч, хаалгач байсаар ирсэн. Өргөн нэвтрүүлгийн хувийн компаниуд, нэвтрүүлгийн компаниуд сурталчилгааны талаарх зохицуулалтыг (цаг, хувь, нэвтрүүлгийн сурталчилгааны завсарлага гэх мэт) дагаж мөрдөх ёстой. Гэхдээ эдгээр нөхцөлүүд цаг хугацааны явцад либералчлагдсан. Төрийн өмчит олон нийтийн өргөн нэвтрүүлгийн компани NRK нь Норвегийн хэвлэл мэдээллийн системийн олон талт байдалд чухал хувь нэмэр оруулдаг гэж үздэг.

Сонин, номын хувьд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгддөг. Энэхүү чөлөөлөлтөд сэтгүүлийг хамруулах талаар хэлэлцүүлэг өрнөсөөр байна. Сүүлийн жилүүдэд хэвлэмэл контенттой ижил цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр төвлөрсөн адил хэлэлцүүлэг өрнөж байна. 2016 онд мэдээллийн цахим үйлчилгээг нэгэн адил нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн тухай Сангийн яамнаас мэдэгдсэн. Орон нутгийн өрсөлдөөн, үндэсний олон янз байдлыг хадгалахын тулд сонины татаасын тогтолцоо бий болгосон. 2017 онд шууд татаасын хэмжээ нийт 313 сая крон буюу ойролцоогоор 35 сая евро болсон бөгөөд энэ нь сонины нийт орлогын 2 орчим хувийг эзэлж байна. Үндэсний үзэл суртлын буюу улс төрийн сонин, орон нутаг дахь өрсөлдөөн бүхий №2 сонин, орон нутгийн хамгийн жижиг сонинд хүргэхийн тулд татаасыг тодорхой шалгуурын дагуу хуваарилдаг. Сами хэл болон сами хүн амд анхаарлаа хандуулдаг сонинуудад тусдаа татаас байдаг. Эдгээр татаасыг сонин хэвлэлд ямар шалгуураар хуваарилах талаар байнга хэлэлцүүлэг өрнөж, санал асуулга явуулж байна.

1990-ээд оны дунд үеэс хойш хэвлэл мэдээллийн эзэмшлийн асуудал хэвлэл мэдээллийн бодлогын чухал асуудал болсон. Хэвлэл мэдээллийн бүх салбарт өмчийн төвлөрөл их

байна. Зарим өмчлөгч нь хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан эрх мэдлийг хэрэгжүүлэх хандлагатай байдаг. Дани, Финлянд, Норвеги, Шведийн хэвлэл мэдээллийн эздийн дунд хүчтэй нэгдэл бий. Данийн (Egmont and Aller) болон Шведийн (Kinnevik/MTG and Bonnier) хэвлэл мэдээллийн компаниуд Норвегийн хэвлэл мэдээллийн чухал эзэмшигчид байдаг. Норвегийн төр өргөн нэвтрүүлгийн компани NRK-ийг эзэмшдэг бөгөөд цахилгаан холбоо, хиймэл дагуул, кабелийн сүлжээ, өргөн нэвтрүүлгийн газрын түгээлтийн үйл ажиллагаа явуулдаг Теленор компанийн голлох томоохон эзэмшигч юм. “Schibsted” бол Норвеги дахь хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн том эзэмшигч юм. Гурав дахь томоохон эзэмшигч нь Норвегийн хэвлэл мэдээллийн групп компани “Amedia” юм. Америкийн телевизийн голлох тоглогч “Discovery” нь Норвегийн телевизийн зах зээлд томоохон байр суурь эзэлдэг бөгөөд Германы Бауэр Медиа Групп нь радио өргөн нэвтрүүлгийн салбарт ижил байр суурьтай байдаг.

1998 онд Норвегийн парламент өмчлөлийн төвлөрлөөс урьдчилан сэргийлэх хууль буюу Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөлийн тухай хууль баталсан. Шинэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд Хэвлэл мэдээллийн өмчлөлийн газрыг (Eierskapstilsynet) байгуулсан бөгөөд тус газрыг дараа нь Норвегийн Хэвлэл мэдээллийн газарт (Medietilsynet) нэгтгэсэн. Тус хуулиар хэвлэл мэдээллийн бүлгүүдэд ямар нэгэн телевиз, радио, сонины хувьцааны 1/3-ээс дээш хувийг эзэмшихийг хориглосон.⁴²⁶ Хэвлэл мэдээллийн өмчлөлийн газар өдөр тутмын хэвлэл, телевиз, радио, цахим мэдээллийн хэрэгслийн зах зээлийн нөхцөл байдал, өмчлөлийн байдалд хяналт тавьж, хэвлэл мэдээллийн өмчлөл илүү нээлттэй байх, энэ талаарх ойлголт, мэдлэгийг бий болгоход тусалсан. Хэвлэл мэдээллийн өмчлөлийн газар нь нэг аж ахуйн нэгжийн гарт хэвлэл мэдээллийн зах зээл дэх “томоохон эзэмшил”-ийг буюу үндэсний зах зээлд 1/3 буюу түүнээс дээш хувийг эзэмшихээс сэргийлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн ашиг сонирхолд хөндлөнгөөс оролцож болно. Энэ нь худалдан авалтыг хориглох, олж авсан эзэмшлээ цуцлах даалгавар өгөх, эсвэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, иж бүрэн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих хуулийн зорилгод нийцэж буй нөхцөлд худалдан авахыг зөвшөөрөх зэргээр илэрнэ.

2016 онд Хэвлэл мэдээллийн өмчлөлийн тухай хуулийг хүчингүй болгож, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх төвлөрлийг Өрсөлдөөний газар (Konkurransetilsynet) хянаж байна.⁴²⁷ Үүний зэрэгцээ “Хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдлын тухай хууль” шинээр батлагдсан. Энэ хуулийн дагуу Норвегийн Хэвлэл мэдээллийн газар нь хэвлэл мэдээллийн эзэмшлийн бүтцийн талаарх мэдээллийг цуглуулах, системчлэх, мэдээллийг олон нийтэд хүргэх замаар хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн ашиг сонирхлын талаарх илүү ил тод байдал, ойлголт, мэдлэгийг бий болгодог.

Салбарын байгууллагууд:

Үйлдвэрчний эвлэлүүд Норвегийн нийгэмд чухал үүрэг гүйцэтгэдэг. 900,000 гаруй гишүүнтэй Норвегийн хамгийн том үйлдвэрчний эвлэл “Landsorganisasjonen”-д хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажиллаж буй техникийн болон бичиг хэргийн ажилтнууд ч мөн хамаарна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн захиргааны ажилтнууд 340,000 гишүүнтэй UNIO, 220,000 гишүүнтэй “Yrkesorganisasjonenes sentralforbund”, 185,000 гишүүнтэй “Akademikerne” зэрэг социалист бус үйлдвэрчний эвлэлийн гишүүд байдаг.

Норвегийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо нь бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх сэтгүүлчдийн бие даасан байгууллага юм. Энэ байгууллага нь сэтгүүлчдийг үндэсний хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд төлөөлдөг. Ихэнх сэтгүүлч гишүүнчлэлтэй байдаг.

⁴²⁶ Alexandra Arkin. Norway's policies on media ownership and transparency, and media pluralism make it "faultless" for press freedom. April 19, 2018 <https://www.msuir.org/msuir-legalforum-blogs/2018/4/19/norways-policies-on-media-ownership-and-transparency-and-media-pluralism-make-it-faultless-for-press-freedom>

⁴²⁷ Ole Kristian Aabø-Evensen, Private mergers and acquisitions in Norway: Overview. 2017 [https://uk.practicallaw.thomsonreuters.com/0-539-8165?transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true&bhcp=1](https://uk.practicallaw.thomsonreuters.com/0-539-8165?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true&bhcp=1)

Сүүлийн жилүүдэд сэтгүүлчид ажлаа алдсантай холбоотойгоор тус байгууллагаас хэвлэл мэдээлэлтэй хамтран чухал хэлэлцүүлгүүд зохион байгуулсан. Цалин хөлсний асуудлаарх хэлэлцээний нөгөө талд Норвегийн хэвлэл мэдээллийн бизнесийн холбоо байсан. Тус холбоо мөн хэвлэл мэдээлэл дэх улс төрийн асуудлаарх мэтгэлцээнд оролцдог. Норвегийн редакторуудын холбоо нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх мэтгэлцээн, сэтгүүл зүйн ажилтай холбоотой хууль, эрх зүйн асуудлаарх чухал дуу хоолой болдог.

Сэтгүүлчийн эх сурвалжийн нууцлалын хамгаалалт:

Норвегийн иргэний хэрэг болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад сэтгүүлчдэд эх сурвалжаа илчлэхгүй байх эрхийг олгосон зохицуулалтыг тусгасан. Гэхдээ энэ эрх нь огт хөндөгдөхгүй гэсэн үг биш юм. Тухайн хэргийн эх сурвалжийн талаарх нотлох баримтыг гаргуулан авах нь тухайн тохиолдолд олон нийтийн ашиг сонирхолд онцгой ач холбогдолтой бол шүүхээс сэтгүүлчийг эх сурвалжаа илчлэхийг үүрэг болгоно.⁴²⁸

Тодруулбал, Норвегийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Нотлох баримт” гэсэн 3 дугаар бүлгийн “Гэрч” гэсэн 10 дугаар хэсгийн 125 дугаар зүйлд зааснаар хэвлэмэл нийтлэлийн редактор тухайн нийтлэл, сурвалжлагын зохиогч хэн болох, түүнд агуулагдаж буй мэдээллийн эх сурвалжийн талаарх асуултад хариулахаас татгалзаж болно. Энэ нь редакторын зүгээс ажилдаа ашиглахаар нууцалсан бусад мэдээллийн эх сурвалж нь хэн бэ гэсэн асуултад нэгэн адил хамаарна. Редактороос гадна хэвлэн нийтлэгч, редактор, хэвлэлийн агентлаг, хэвлэн нийтлэгч зэрэг ажил үүргийн хүрээнд зохиогч буюу эх сурвалжийн талаар мэдэх болсон бусад этгээд дээр дурдсан эрхийг нэгэн адил эдэлнэ. Олон нийтийн чухал ашиг сонирхлын үүднээс мэдээлэл өгөх шаардлагатай бөгөөд тийнхүү мэдээлэл өгөх нь хэргийг тодруулахад чухал ач холбогдолтой бол шүүх ерөнхий үнэлгээний үндсэн дээр гэрчийн нэрийг илчлэхийг даалгаж болно. Зохиогч, эх сурвалжийн зүгээс нийгэмд чухал ач холбогдолтой зүйлийг илчилсэн бөгөөд нэн шаардлагатай гэж үзвэл гэрчийн нэрийг ил болгохыг даалгаж болно. Тийнхүү гэрчийн нэрийг шүүхийн даалгаснаар мэдэгдсэн үед түүнийг зөвхөн шүүхэд болон нууцын баталгаа авсны үндсэн дээр хаалттай хуралдаан дээр талуудад танилцуулахаар шүүхээс шийдвэрлэж болно. Энэ зүйлийн зохицуулалт нь сонин, өргөн нэвтрүүлгийн болон түүнтэй адил зорилго бүхий бусад хэвлэл мэдээллийн байгууллагын захирал, ажилтанд нэгэн адил хамаарна.⁴²⁹

Мөн Норвегийн Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Нотлох баримт” гэсэн 5 дугаар бүлгийн “Нотлох баримтын талаарх нийтлэг зохицуулалт” гэсэн 21 дүгээр бүлгийн “Эх сурвалжийг хамгаалах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл нотлох баримт гаргах үүргээс чөлөөлөх” гэсэн 22.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хэвлэмэл нийтлэлийн редактор тухайн нийтлэл, сурвалжилгын зохиогч буюу түүн дэх мэдээллийн эх сурвалжийг тодорхойлохуйц нотлох баримтыг гаргаж өгөхөөс татгалзаж болно. Энэ заалт нь редактор үйл ажиллагаандаа ашиглахаар нууцалсан бусад мэдээллийн эх сурвалжийн талаарх нотлох баримтад нэгэн адил хамаарна.”, 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нотлох баримт нь олон нийтийн ашиг сонирхолд нэн шаардлагатай бөгөөд тухайн хэргийг тодруулахад нэн чухал байх бөгөөд ерөнхий үнэлгээний үндсэн дээр шүүхээс эх сурвалжийг ил болгохуйц нотлох баримтыг гаргаж өгөхийг даалгаж болно. Зохиогч, эх сурвалжийн зүгээс олон нийтийн ашиг сонирхолд чухал ач холбогдолтой зүйлийг илчилсэн бөгөөд зөвхөн нэн шаардлагатай гэж үзвэл гэрчийн нэрийг ил болгохыг даалгаж болно.”, 3 дахь хэсэгт “Энэ хэсгийн зохицуулалт дараах зүйлд хамаарна: а/ ажил үүргийн хүрээнд зохиогч, эх сурвалжийг мэдэх болсон хэвлэн нийтлэгч, редактор, хэвлэлийн агентлаг, хэвлэлийн газар, б/ сонин, өргөн нэвтрүүлэгтэй адил зорилго бүхий өргөн нэвтрүүлэг, бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хувь нэмрээ оруулагчид” гэж тус тус заасан.⁴³⁰

⁴²⁸ Jon Wessel-Aas. Protection of journalistic sources in Norwegian law. 2020 <https://www.uhuru.biz/?p=1974>

⁴²⁹ Norway - The Criminal Procedure Act of 22 May 1981 No. 25

https://www.legislationline.org/download/id/8290/file/Norway_Criminal_Procedure_Act_1981_am2013_en.pdf

⁴³⁰ Norway - Act relating to mediation and procedure in civil disputes (The Dispute Act) — 2005.

3.3.2. Австралийн Холбооны Улсын туршлага

Австралийн Холбооны улс “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд сүүлийн 5 жилд буюу 2017-2021 онд 19-25 дугаар байрын хооронд байгаа хэвлэлийн эрх чөлөөний “сэтгэл хангалуун” үзүүлэлттэй улс юм.⁴³¹

Хэвлэл мэдээллийн хууль тогтоомж:

2020.04.20-ны өдөр Австралийн Засгийн газраас Австралийн шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт хандаж Австралийн мэдээллийн хэвлэл мэдээллийн бизнесүүд болон цахим платформууд, ялангуяа Google болон Facebook-ийн хүч тэнцвэргүй тохиролцоог арилгахын тулд заавал дагаж мөрдөх ёс зүйн дүрмийг боловсруулахыг хүссэн. 2020.07.31-нд Австралийн шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас дүрмийн төслийг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгийн дараа олон талт оролцогчдын саналыг тусган тус газраас Засгийн газарт зөвлөмж өгсөн. Засгийн газар эдгээр зөвлөмжийг авч үзээд хууль тогтоомжийн төслийн сүүлийн хувилбарыг боловсруулсан. Энэхүү хуулийн төслийг 2021.02.25-ны өдөр хоёр танхим баталсан бөгөөд хууль Холбооны улсын хууль тогтоомжийн бүртгэлд орсон.⁴³²

Тодруулбал, 2021.02.25-нд батлагдсан Төрийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль буюу Мэдээллийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба цахим платформын хооронд хэлэлцээр хийх дүрэм нь Австралийн мэдээллийн бизнесүүд болон тэдгээрийн хүч тэнцвэргүй байдлаас ихээхэн ашиг хүртдэг “тодорхой” цахим платформуудын хоорондын арилжааны харилцааг зохицуулдаг ёс зүйн дүрэм юм. Энэхүү тэнцвэргүй байдлыг арилгах нь Австралийн мэдээний хэвлэл мэдээллийн салбарын тогтвортой байдлыг дэмжихэд зайлшгүй шаардлагатай гэж Австралийн шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар үзжээ.⁴³³

Онлайн контентод чиглэсэн дээрх дүрэм нь 2021 оны 3 дугаар сарын 2-ноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2022 онд Австралийн Төрийн сан түүнийг зорилгодоо нийцсэн эсэхийг шалгана. Энэ дүрмийн дагуу түүний үйлчлэлд хамаарах цахим платформыг Сангийн сайд тогтоож болно. Ингэхдээ Австралийн мэдээллийн бизнес болон цахим платформын хооронд хүч тэнцвэргүй байдал бий эсэх, тухайн платформ мэдээний агуулгад нь урамшуулал олгох гэрээ байгуулах замаар Австралийн мэдээллийн салбарын тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулсан эсэхийг харгалзана. Австралийн Харилцаа холбоо, мэдээллийн газрын хувьд тус дүрэмд хамаарах хүсэлтэй мэдээллийн бизнесүүдийн чадавхыг үнэлэх, хэлэлцээр хийх талуудад туслах зуучлагчдыг томилох, хэлэлцээрт оролцогч талууд арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх талаар тохиролцож чадахгүй бол арбитрчдыг бүртгэж, томилох үүрэгтэй оролцоно.⁴³⁴

Энэхүү дүрмийг нэвтрүүлсний дараа Google болон Facebook (одоогийн Мета) хэвлэл мэдээллийн олон тооны жижиг байгууллага болон бүс нутгийн 30 гаруй байгууллагатай сайн дурын арилжааны гэрээ байгуулжээ. Тэд мөн Google-ийн “Цахим Мэдээний Академи”, Метагийн “Сэтгүүл зүйг хурдасгах төсөл” зэрэг Австралийн сэтгүүл зүйг дэмжих сайн дурын санаачилгыг хэрэгжүүлсэн. Google болон Meta-тай хийсэн эдгээр гэрээ нь жилд хэдэн зуун сая доллар болж, Австралийн сэтгүүлчдийг ажилд авах таатай нөхцөлийг бүрдүүлсэн

https://lovdata.no/dokument/NLE/lov/2005-06-17-90/KAPITTEL_5#KAPITTEL_5

⁴³¹ Reporters Without Borders: Australia <https://rsf.org/en/australia>

⁴³² Australia - Federal Register of Legislation - Treasury Laws Amendment (News Media and Digital Platforms Mandatory Bargaining Code) Act 2021 <https://www.legislation.gov.au/Details/C2021A00021>

⁴³³ Australia - News media bargaining code, 2021

<https://www.accc.gov.au/system/files/Final%20legislation%20as%20passed%20by%20both%20houses.pdf>

⁴³⁴ Australian Communications and Media Authority – News media bargaining code <https://www.acma.gov.au/news-media-bargaining-code>

байна. Мөн Австралийн томоохон мэдээллийн бизнесүүд сэтгүүл зүй болон бүс нутгийн мэдээнд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээ амласан.

Зохицуулах эрх бүхий байгууллагууд:

Австралийн Харилцаа холбоо, мэдээллийн газар нь тус улс дахь харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн үйлчилгээг зохицуулдаг бие даасан байгууллага юм. Тус газар нь 5 жилийн хугацаагаар Австралийн амбан захирагчийн томилох дарга, дэд дарга, орон тооны 3 гишүүн, сайдын томилох орон тооны бус 3 гишүүн буюу нийт 8 гишүүний бүрэлдэхүүнтэй. Тус газар нь долоо хоног тутмын хуралдаанаар шийдвэр гаргана. Энэ байгууллагын үйл ажиллагааг 2005 оны Австралийн Харилцаа холбоо, мэдээллийн газрын тухай хуулийн дагуу болон салбарын бусад хууль тогтоомжоор зохицуулна.⁴³⁵

Австралийн Харилцаа холбоо, мэдээллийн газар 1992 онд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулийн дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, радиогийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрт хяналт тавихтай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний олон талт байдлыг хангана.⁴³⁶ Мөн 1992 онд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулиар арилжааны телевиз, радио болон тэдгээртэй хамаарал бүхий сонины эзэмшлийг хязгаарласан.⁴³⁷

Хэвлэл мэдээллийн эзэмшилтэй холбоотой дараах дүрэм бий:

- Нэг тусгай зөвшөөрлийн бүсэд арилжааны телевизийн нэгээс дээш тусгай зөвшөөрөлтэй буюу арилжааны телевизийн өөр тусгай зөвшөөрөлтэй компанид нэгэн зэрэг захирлаар ажиллахыг хориглосон.
- Нэг тусгай зөвшөөрлийн бүсэд арилжааны радио өргөн нэвтрүүлгийн 2-оос дээш тусгай зөвшөөрөл эзэмшихийг хориглосон.
- Арилжааны өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл болон өгөгдөл дамжуулах дамжуулагчийн тусгай зөвшөөрөл нэгэн зэрэг эзэмшихийг хориглосон.
- Нэг тусгай зөвшөөрлийн бүсэд арилжааны өргөн нэвтрүүлгийн нэгээс дээш тусгай зөвшөөрөл эзэмших буюу тийм компанийг эзэмшихийг хориглосон.
- Нэг тусгай зөвшөөрлийн бүсэд 2-оос дээш арилжааны радио нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмших болон өөр арилжааны радиогийн тусгай зөвшөөрөлтэй компани удирдахыг хориглосон.
- Арилжааны өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл болон өгөгдөл дамжуулах дамжуулагчийн тусгай зөвшөөрөлтэй компани буюу түүнийг эзэмшдэг компанийг удирдахыг хориглосон.
- Эдгээр хязгаараас хэтэрсэн 2 ба түүнээс дээш компанийг удирдаж болохгүй.

Гэхдээ Австралийн Харилцаа холбоо, мэдээллийн газраас арилжааны телевизийн өргөн нэвтрүүлгийн ганц тусгай зөвшөөрөлтэй бүсэд тэрхүү тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хоёр дахь үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрч болно. Арилжааны телевизийн өргөн нэвтрүүлгийн 2 тусгай зөвшөөрөлтэй бүсэд тусгай зөвшөөрөл эзэмшигчид гурав дахь арилжааны телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг үзүүлэхийг зөвшөөрч болно. Энэхүү хязгаарлалтын дүрэм нь Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулийн 38С хэсэг болон 40 дэх хэсэгт заасан өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлүүдэд хамаарахгүй.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хууль нь арилжааны өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийг гадаадаас эзэмшдэг буюу тусгай зөвшөөрлийг эзэмшдэг компаниудын гадаадын захирлуудыг хязгаарладаггүй. Австралийн хэвлэл мэдээллийн хөрөнгийг гадаадаас эзэмших асуудлыг 1975 оны Гадаадын худалдан авалтын тухай хууль болон

⁴³⁵ Australian Communications and Media Authority Act 2005 <https://www.legislation.gov.au/Details/C2021C00233>

⁴³⁶ Australia - Broadcasting Services Act 1992 <https://www.legislation.gov.au/Details/C2018C00375>

⁴³⁷ Australia - Media control rules <https://www.acma.gov.au/media-control-rules>

Австралийн Гадаадын хөрөнгө оруулалтын бодлогоор зохицуулдаг. Хэвлэл мэдээллийн хөрөнгийн гадаадын эзэмшигчдийн бүртгэлд Австралийн хэвлэл мэдээллийн компанид 2.5% ба түүнээс дээш хувийн ашиг сонирхол бүхий гадаадын хүмүүсийн талаарх мэдээлэл байдаг.⁴³⁸

Хэвлэл мэдээллийн олон талт байдлыг хангахтай холбоотой дараах дүрэм бий:

- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуульд зааснаар хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа гэдэгт тусгай зөвшөөрөлтэй арилжааны өргөн нэвтрүүлгийн телевиз, радио болон тэрхүү телевиз, радиогийн бүс дэх хамаарал бүхий сонины үйл ажиллагаа хамаарна.
- Хэвлэл мэдээллийн бүлэг гэдгийг Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуульд 2 буюу түүнээс дээш хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулж байгаа бүлэг гэж тодорхойлсон.
- Бүртгэх боломжтой хэвлэл мэдээллийн бүлэг буюу хэвлэл мэдээллийн 2 буюу түүнээс дээш үйл ажиллагаа явуулж буй бүлэг гэдэгт:
 - Эдгээр хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа бүрийг хянах албан тушаалтай этгээд
 - Эдгээр хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа бүрийг дүрэм, журмын хүрээнд нийцэж буй эсэхийг хянадаг этгээд
 - Радиогийн анхны тусгай зөвшөөрлийн талбайд хамрах хүн амын 50-аас дээш хувь нь багтаж байгаа арилжааны телевизийн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй бүлэг
 - Радиогийн анхны тусгай зөвшөөрлийн хамрах талбай нь арилжааны радио өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөлтэй бүлгийн талбайтай ижил буюу дотор байгаа бүлэг
 - Тухайн бүлэг сонинтой бөгөөд тэр нь радиогийн анхны тусгай зөвшөөрлийн талбайтай холбоотой.

Хэвлэл мэдээллийн олон талт байдлын схемийн хувьд, бүртгэгдэх боломжтой хэвлэл мэдээллийн бүлэг нэг оноотой байна. Хэвлэл мэдээллийн бүлэгт хамааралгүй хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа бас нэг оноотой байна.

Хэвлэл мэдээллийн бүлгийн эрх бүхий этгээд нь хэвлэл мэдээллийн бүлгийн үйл ажиллагаа бүрийг хянадаг этгээд юм. Хэрэв хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны эрх бүхий этгээд өөрчлөгдвөл энэ тухай Австралийн Харилцаа холбоо, мэдээллийн газарт мэдэгдэх ёстой бөгөөд тус газраас Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулийн 61AU хэсгийн дагуу хэвлэл мэдээллийн бүлгийн эзэмшил, хяналтын бүртгэлийг хөтөлнө. Эзэмшил, хяналтын өөрчлөлт нь тухайн бүс нутгийн арилжааны радио дахь орон нутгийн оролцоог хангах, орон нутгийн агуулгыг түгээхтэй холбоотой шаардлага тавихад хүргэж болно.

Дараах нөхцөлийг хэвлэл мэдээллийн олон талт байдлыг алдагдуулсан нөхцөл гэж үзнэ:

- Нийслэл дэх арилжааны радио өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл нь радиогийн тусгай зөвшөөрлийн талбайд 5-аас бага оноотой байх нөхцөл;
- Бүс нутаг дахь арилжааны радио өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл нь тусгай зөвшөөрлийн талбайд 4-өөс бага оноотой байх нөхцөл.

Хэвлэл мэдээллийн олон талт байдлыг алдагдуулах нөхцөл бүхий хэлцлийг хориглох бөгөөд үүнийг “4/5 дүрэм” гэж нэрлэдэг. Эдгээр дүрмийг зөрчсөн нь эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

⁴³⁸ Australia - Register of Foreign Owners of Media Assets <https://www.acma.gov.au/register-foreign-owners-media-assets>

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулийн 59 дэх хэсэгт заасны дагуу хэрэв сонины борлуулалтын 50-иас багагүй хувь нь холбогдох байгууллагын арилжааны телевизийн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн бүсэд байгаа гэж үзвэл Австралийн Харилцаа холбоо, мэдээллийн газар сониныг бүртгэлд оруулна. Радиогийн тусгай зөвшөөрлийн талбайд 50%-иас багагүй хэсэг нь борлуулагддаг сонин, тухайн тусгай зөвшөөрлийн талбайн хүн амын 2%-иас багагүй хэсэгт борлуулагддаг сониныг нэгэн адил бүртгэнэ. Сонин гэдэгт англи хэл дээр 7 хоногт 4-өөс доошгүй удаа хэвлэгддэг сониныг ойлгох бөгөөд түүний 50%-иас ихгүй хэсгийг борлуулдаг бол хамаарахгүй. Дээрх бүртгэлийн шаардлагыг хангахгүй сониныг бүртгэхгүй буюу өмнөх бүртгэлээс хасна.⁴³⁹

Хариуцлагын тогтолцоо:

Австралийн Хэвлэлийн зөвлөл 1976 онд байгуулагдсан бөгөөд хэвлэл мэдээллийн практикт өндөр стандарт тогтоох, хэвлэл мэдээллээр дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, олон нийтийн мэдээлэлтэй байх эрхийг дэмжих чиг үүрэгтэй. Тус зөвлөл нь олон нийтийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэр дэвшүүлсэн төлөөлөл, хоёр хараат бус сэтгүүлч бүхий 22 гишүүнтэй. Австралийн Хэвлэлийн зөвлөл Австралийн сонин, сэтгүүл, цахим хэвлэлд нийтлэгдсэн зар сурталчилгаанаас бусад материалын талаарх гомдлыг хүлээн авах, хариу өгөх чиг үүрэг бүхий үндсэн байгууллага юм. Ингэхдээ тус үйл ажиллагааны стандарт буюу ерөнхий зарчим, тусгай стандарт, бэлгийн цөөнхийн талаар мэдээлэх, сонгуулийг мэдээлэх, хүчирхийллийг мэдээлэх гэх мэт удирдамжийг зөрчсөн эсэхийг хянана.⁴⁴⁰ Тус зөвлөлд 2019-2020 онд 1076 гомдол ирсэн бөгөөд түүний 80%-ийг хүлээн авсан буюу хянан хэлэлцэх шатанд шилжүүлсэн бөгөөд 20 гомдолд албан ёсны шийдвэр гаргасан.⁴⁴¹ Энэ нь гомдлоосоо татгалзах, гомдолд дурдсан тал шийдвэр гаргахаас өмнө арга хэмжээ авах (уучлал гуйх, залруулга хийх, материалыг бүхэлд нь устгах, нийтлэлд өөрчлөлт оруулах) зэрэгтэй холбоотой. Австралийн Хэвлэлийн зөвлөлийн хувьд нөхөн төлбөр гаргуулах, торгох, бусад санхүүгийн шийтгэл оногдуулах эрхгүй бөгөөд тус зөвлөлөөс гаргах шийдвэр нь албан ёсоор зэмлэх, буруутгах, уучлал гуйхыг даалгах (гэхдээ заавал биш), нийтлэгдсэн материалыг буцаан татах, тодорхой үүрэг хүлээлгэх, залруулга хийлгэх зэрэг хэвлэн нийтлэгчийн зүгээс засч, залруулж болох бусад арга хэмжээ авахаар хязгаарлагдана.

3.3.3. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын туршлага

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (цаашид “ИБУИНХУ” гэх) “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд сүүлийн 5 жилд буюу 2017-2021 онд 33-40 дүгээр байрын хооронд байгаа хэвлэлийн эрх чөлөөний “сэтгэл хангалуун” үзүүлэлттэй улс юм.⁴⁴²

Хэвлэл мэдээллийн хууль тогтоомж:

ИБУИНХУ-ын хувьд Европын холбооны гишүүнчлэлээс гарах хүртэл Европын Хүний эрхийн конвенцийн 8 болон 10 дугаар зүйл тус улс дахь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний баталгаа байв.⁴⁴³ Хэвлэл мэдээллийн салбарыг хариуцсан засгийн газрын байгууллага нь Цахим, соёл, хэвлэл мэдээлэл, спортын газар юм. ИБУИНХУ дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хууль тогтоомж, бодлого нь арилжааны

⁴³⁹ Australia – Associated newspaper register <https://www.acma.gov.au/associated-newspaper-register>

⁴⁴⁰ Australian Press Council <https://www.presscouncil.org.au/>

⁴⁴¹ Australian Press Council. Annual Report 2019–2020. 30 June 2020 https://www.presscouncil.org.au/wp-content/uploads/2021/11/AnnualReport_2019-2020-Final_web.pdf

⁴⁴² Reporters Without Borders: United Kingdom <https://rsf.org/en/united-kingdom>

⁴⁴³ Julie Firmstone. United Kingdom - Media legislation. European Journalism Centre (EJC). 2019 <https://medialandscapes.org/country/united-kingdom/policies/media-legislation>

хэвлэл мэдээллийн хэрэгсэл (хэвлэл, өргөн нэвтрүүлэг) болон олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хоёр салбартай холбоотой.

1990-ээд оноос хойш ИБУИНХУ-д арилжааны хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хөндлөнгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшихээс сэргийлсэн зохицуулалтыг сулруулж, дүрэм журмыг зөөлрүүлэх ерөнхий хандлага ажиглагдаж байна. Тодруулбал, 2003 оны Харилцаа холбооны тухай хуулиар Европын холбооны бус компаниудад ИБУИНХУ-ын хэвлэл мэдээллийн эзэмшлийг нээж, улмаар Харилцаа холбооны зохицуулагч (Ofcom) байгуулагдсан.⁴⁴⁴ Уг хуульд томоохон сонины бүлгүүдийг өргөн нэвтрүүлгийн 3 дугаар сувгийн тусгай зөвшөөрлийг эзэмшихээс сэргийлсэн хөндлөнгийн эзэмшлийн дүрмийг тусгасан; Төрийн нарийн бичгийн дарга хэвлэл мэдээллийн байгууллагууд нэгдэх үйл явцад хөндлөнгөөс оролцож, нэгдэх нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй эсэхийг тодорхойлох боломжийг олгодог “Хэвлэл мэдээллийн нийтийн ашиг сонирхлын тест”-ийг нэвтрүүлсэн; мөн Харилцаа холбооны газраас тухайн хүн эсвэл компани тусгай зөвшөөрөл эзэмших шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохыг шаарддаг өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн хязгаарлалтыг нэвтрүүлсэн.⁴⁴⁵ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх зах зээлийн харилцаа нээлттэй болж, зохицуулалтыг сулруулснаар өмчийн төвлөрөл бий болж, ашиг олоход хөтлөгдсөн мэдээний талбар бий болж, мэдээний чанар муудсан гэж зарим шүүмжлэгч үзэж байна.

ИБУИНХУ-ын олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага Би Би Си (BBC)-гийн удирдлага, санхүүжилтыг Хааны баталсан дүрмээр тогтоодог. ИБУИНХУ-ын засгийн газраас Би Би Сигийн дүрмийг хянан үзэх замаар түүний олон нийтийн өргөн нэвтрүүлгийн санхүүжилтийн загварт тогтмол үнэлгээ хийдэг. Хааны баталсан дүрэм бүр 10 жилийн хугацаатай бөгөөд одоогийн дүрэм нь 2017.01.01-нд батлагдаж, 2027.12.31-ний өдөр хүртэл үйлчилнэ.⁴⁴⁶ Энэхүү шинэ дүрэмд Би Би Сиг удирдах арга барилд томоохон өөрчлөлтүүдийг оруулсан болно. Дүрмийг хянан үзэх явцад гарсан гол маргаан нь ямар ч платформ дээр эсвэл ямар ч төхөөрөмжөөр дамжуулан телевизийн нэвтрүүлэг үзэх, хадгалж авахыг хүссэн өрхийн төлсөн телевизийн тусгай зөвшөөрлийн хураамжаар Би Би Сиг үргэлжлүүлэн санхүүжүүлэх эсэх тухай байв. Тусгай зөвшөөрлийн хураамж нь Би Би Сигийн хөтөлбөр, үйлчилгээг санхүүжүүлдэг бөгөөд түүний тодорхой хэсэг нь ИБУИНХУ-ын хүн амд өргөн зурвасын сүлжээг нэвтрүүлэх, Уэльс хэл дээрх S4C суваг болон орон нутгийн телевизийн сувгуудыг санхүүжүүлэх зардалд хувь нэмэр оруулдаг. Тусгай зөвшөөрлийн хураамж нь Би Би Сиг зар сурталчилгаанаас ангид, хувь нийлүүлэгч болон улс төрийн ашиг сонирхлоос ангид байх боломжийг олгодог. Шинэчлэгдсэн дүрэмд тусгай зөвшөөрлийн хураамж 2028 он хүртэл үргэлжлэх боловч урт хугацаанд “тогтворгүй болох магадлалтай” гэж заасан. Тусгай зөвшөөрлийн хураамжийг захиалгын загвараар солих төлөвлөгөө байхгүй ч Би Би Сид өөрийн контентоо зөвхөн захиалгаар ашиглах боломжтой болгох эсэхийг судлах боломжийг олгоно. Дүрмийн хугацаа 10 жил байсныг 11 жил болгон өөрчилж, улс төрийн аливаа мөчлөгөөс хамааралгүй болно.

2017 оны Дижитал эдийн засгийн тухай хууль нь дижитал эдийн засагт дэлхийд тэргүүлэгч болох ИБУИНХУ-ын Засгийн газрын зорилгыг дэмжихэд чиглэсэн олон арга хэмжээг багтаасан.⁴⁴⁷ Энэхүү хууль нь хэрэглэгчдийг чадавхжуулах, илүү сайн холболтоор хангах зорилготой бөгөөд ингэснээр хүн бүр хаана ч амьдарч байсан өргөн зурвасын сүлжээнд нэвтрэх боломжтой болох; дижитал ирээдүйд тохирох илүү сайн дэд бүтцийг бий болгох; дижитал технологи ашиглан төрийн үйлчилгээг сайжруулах; иргэдийг цахим шуудангийн

⁴⁴⁴ UK – Ofcom <https://www.ofcom.org.uk/home>

⁴⁴⁵ UK - Communications Act 2003 <https://www.legislation.gov.uk/ukpga/2003/21/contents>

⁴⁴⁶ UK - The Royal Charter for BBC <https://www.bbc.com/aboutthebbc/governance/charter>

⁴⁴⁷ UK - Digital Economy Act 2017 <https://www.legislation.gov.uk/ukpga/2017/30/contents>

залилан, төвөг учруулсан дуудлагаас хамгаалж, хүүхдүүдийг онлайн садар самуунаас хамгаалахад чиглэсэн. Уг хуульд “Бүх нийтийн үйлчилгээний үүрэг” багтсан бөгөөд энэ нь хүмүүст хаана ажиллаж, амьдарч байгаагаас үл хамааран хурдан интернетийн холболтыг (хамгийн багадаа 10 Мб/с) шаардах хууль ёсны эрхийг олгох юм.

Хариуцлагын тогтолцоо:

ИБУИНХУ-д 2011 онд хэвлэлийнхний ёс зүй, гэмт үйлдлийн талаарх дуулиантай холбоотойгоор буюу “News of the World” сонины ёс зүйгүй үйлдлийн талаарх мэдээлэл цуглуулах, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг шүүгч Левесон ахлан ажиллаж парламентад тайлангаа танилцуулсан бөгөөд Төлөөлөгчдийн танхимын шийдвэрээр 2012 оны 11 дүгээр сард тайланг нийтэлсэн. Энэхүү тайланд хэвлэлийн бие даасан өөрийн зохицуулалтын талаар зөвлөмж өгсөн.⁴⁴⁸ Үүний дараа 2014 оны 11 дүгээр сарын 03-нд “Хэвлэл мэдээллийн зохицуулах байгууллагыг хүлээн зөвшөөрөх зөвлөл”-ийг (Press Recognition Panel) Хааны баталсан дүрмээр байгуулсан.⁴⁴⁹

Одоо хэвлэлийн сайн дурын зохицуулалтыг хоёр байгууллага хариуцаж байна. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын гол байгууллага болох 1995 онд байгуулагдсан Хэвлэлийн гомдол шийдвэрлэх комиссыг 2014 онд татан буулгаж, оронд нь “Хэвлэлийн стандартын бие даасан байгууллага” (IPSO) байгуулагдсан.⁴⁵⁰ Хэвлэлийн стандартын бие даасан байгууллага нь нийтлэг сонин, сэтгүүлийн дийлэнхийг буюу 3000 гаруй редакцийг төлөөлж байна. Харин 2015 онд шинээр байгуулагдсан “Хэвлэлийн бие даасан хяналт” (IMPRESS) нь одоогоор нийгэмлэгт түшиглэсэн хэвлэл мэдээллийн жижиг хэрэгслүүд болон цахим орчинд түшиглэсэн шинэ тоглогчдыг буюу 111 хэвлэн нийтлэгч, 191 хэвлэлийг зохицуулж байна.⁴⁵¹

“Хэвлэл мэдээллийн зохицуулах байгууллагыг хүлээн зөвшөөрөх зөвлөл”-өөс 2016.11.25-нд “Хэвлэлийн бие даасан хяналт” (IMPRESS)-ыг зохицуулах байгууллагаар зөвшөөрсөн.⁴⁵² Гэхдээ үндэсний хэмжээний олон сонин “Хэвлэлийн бие даасан хяналт”-д нэгдэхээс татгалзаж байгаа бөгөөд түүнийг хэвлэлийн эрх чөлөөнд заналхийлж байна гэж үзсээр байна. “Guardian” болон “Financial Times” дээрх хоёр зохицуулах байгууллагын алинд ч нэгдэхээс татгалзсан бөгөөд өөрсдийгөө зохицуулж байна. Үүний зэрэгцээ, дижитал мэдээллийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл өсөхийн хэрээр цахим орчинд тохирсон хариуцлагатай байдлыг хангах арга хэрэгсэл шаардлагатай болж байна.

3.3.4. Бүгд Найрамдах Солонгос Улсын туршлага

Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх) “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд 2018-2021 онд 41-43 дугаар байрын хооронд байгаа хэвлэлийн эрх чөлөөний “сэтгэл хангалуун” үзүүлэлттэй улс юм.⁴⁵³

Хэвлэл мэдээллийн хууль тогтоомж:

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг БНСУ-ын 1987 оны Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд баталгаажуулсан. Үг хэлэх эрх болон хэвлэлийн эрх чөлөөнд цензур тавих, зөвшөөрөл олгохыг хориглосон.⁴⁵⁴ БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх 2004 оны

⁴⁴⁸ UK - Leveson Inquiry - Report into the culture, practices and ethics of the press. 29 November 2012

<https://www.gov.uk/government/publications/leveson-inquiry-report-into-the-culture-practices-and-ethics-of-the-press>

⁴⁴⁹ UK – Press Recognition Panel (PRP) <https://pressrecognitionpanel.org.uk/the-royal-charter/>

⁴⁵⁰ UK – Independent Press Standards Organisation (IPSO) <https://www.ipso.co.uk/>

⁴⁵¹ UK- The Independent Monitor for the Press (IMPRESS) <https://www.impress.press/>

⁴⁵² UK - PRP Board Recognises IMPRESS <https://pressrecognitionpanel.org.uk/impress-2/>

⁴⁵³ Reporters Without Borders: South Korea <https://rsf.org/en/south-korea>

⁴⁵⁴ Constitution of the Republic of Korea https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1

шийдвэртээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд бүх төрлийн хэлбэр, сувгаар харилцах, үзэл бодлоо илэрхийлэх хамаарна гэж шийдвэрлэсэн.⁴⁵⁵ Гэхдээ бусад этгээдийн нэр хүндэд халдсан, эрхийг зөрчсөн зэрэг илэрхийллийн агуулгаас хамааран энэ эрхийг хязгаарлаж болно.

Одоогийн эрх баригч намын зүгээс 2005 онд батлагдсан Хэвлэлийн арбитрын тухай хууль буюу “Хэвлэлийн Арбитр болон хэвлэлийн мэдээгээр учруулсан хохиролд авах арга хэмжээний тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна.⁴⁵⁶ Энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээллийн ажилтнуудын илт хайхрамжгүй байдал, санаатай буруу үйлдлээс шалтгаалж худал, зохиомол мэдээ тараасан тохиолдолд бодит хохирлын өртгөөс тав дахин их хэмжээний торгууль ногдуулах хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна. Сөрөг хүчний намууд болон хэвлэл мэдээлэлтэй холбоотой байгууллагууд уг нэмэлт өөрчлөлтийн төслийг үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд ноцтой халдана гэж үзэж эсэргүүцэж байна. Эрх баригч болон сөрөг хүчний намууд Хэвлэлийн арбитрын тухай хуулийн асуудлаар тусдаа зөвлөлдөх байгууллагаар дамжуулан хэлэлцэхээр тохиролцсон ч эрх баригч нам Үндэсний ассамблейн гишүүдийн дунд олонх буюу 300-аас 180 суудалтай учраас санал болгож буй нэмэлт өөрчлөлтийг батлах магадлал өндөр байна.

Үүнтэй холбоотойгоор 2021.09.16-ны өдөр хүний эрхийн байгууллагууд “Article 19”, “Human Rights Watch”, “Нээлттэй интернетийн холбоо” болон “Солонгосын дэвшилтэт сүлжээ” байгууллага хамтран БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Инд хандаж захидал хүргүүлсэн.⁴⁵⁷ Тус захидалд БНСУ-ын 1990 онд соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд заасны дагуу илэрхийллийн эрх чөлөөг хязгаарлахын тулд 1/ хуульд заасан байх, 2/ хууль ёсны зорилготой байх, 3/ тэрхүү зорилгод чиглэсэн зайлшгүй шаардлагатай бөгөөд тохиромжтой арга хэмжээ авах нөхцөлийг сануулж, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 2018 оны тогтоолд “худал мэдээллийг хориглох нь өөрөө хүний эрхийн олон улсын эрх зүйгээр тодорхойлсон хууль ёсны зорилгод нийцэхгүй” гэдгийг тодотгож, олон улсын эрх зүйн шаардлага, НҮБ-ын шинжээчдийн боловсруулсан стандарт, хувийн нууц, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах зуучлагчийн хариуцлагын талаарх Манилагийн зарчмуудад нийцүүлэн хуулийн төслийг хэрхэн шинэчлэх талаар оролцогч талууд, хэвлэл мэдээллийн компаниуд, интернетийн зуучлагчид, иргэний нийгмийн бүлгүүдтэй нягт зөвлөлдөх, хуулийн төслийн 2(17-3), 30-2, 2(17-2), 17-2-ыг хасах зөвлөмж өгсөн.⁴⁵⁸

⁴⁵⁵ South Korea - Constitutional Court decision, 29 January 2004, 2001Hun-Ma894

<https://english.court.go.kr/site/eng/decisions/casesearch/caseSearchPop.do>

⁴⁵⁶ South Korea - Act on Press Arbitration and Remedies for Damage Caused by Press Reports - 2005

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=24492&lang=ENG

⁴⁵⁷ Joint Letter to South Korean President Moon Jae-in on Press Arbitration Law. September 16, 2021

https://www.hrw.org/sites/default/files/media_2021/09/210916%20ENG%20%28PRES%29%20Press%20Arbitration%20Law%20Letter.pdf

⁴⁵⁸ -UN Human Rights Council, Report of the Special Rapporteur on the promotion and protection of freedom of opinion and expression, April 13, 2021, UN Doc. A/HRC/47/35, para. 38, 40

-UN Human Rights Council, Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression,” April 6, 2018, UN Doc. A/HRC/38/35, paras. 66-67

-UN Human Rights Council, “Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression,” March 30, 2017, UN Doc. A/HRC/35/22, para. 49

- The United Nations Special Rapporteur on freedom of opinion and expression, the Organization for Security and Co-operation in Europe (OSCE) Representative on Freedom of the Media, the Organization of American States (OAS) Special Rapporteur on Freedom of Expression and the African Commission on Human and Peoples’ Rights (ACHPR) Special Rapporteur on Freedom of Expression and Access to Information, “Joint Declaration on Freedom of Expression and Fake News, Disinformation and Propaganda,” March 3, 2017

-Manila Principles on Intermediary Liability, March 24, 2015

https://www.eff.org/files/2015/10/31/manila_principles_1.0.pdf

2009 онд батлагдсан “Сониныг дэмжиж тухай” хууль буюу Сонины хуулийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын сайд сонинуудыг зохицуулдаг.⁴⁵⁹ Сонины тухай хуулиар сонины бизнес эрхлэгчдийн бизнесийг бүртгэх журамтай бөгөөд гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд БНСУ-д сонин хэвлэхийг хориглодог. Цаасан болон цахим сонин хэвлэн нийтлэх, түгээхийн тулд бизнес нь холбогдох орон нутгийн засаг захиргаанд бүртгүүлэх ёстой. Мөн гадаадын сонины бизнес эрхлэгчид БНСУ-ын орон нутагт газар, салбараа байгуулж бүртгүүлэх шаардлагатай. Сонины тухай хуульд гадаадын засгийн газар, компани, байгууллага, гүйцэтгэх захирал нь гадаадын иргэн байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон гадаадын иргэн, гадаадын этгээдийн эзэмшиж буй хувьцаа нь босго хэмжээнээс хэтэрсэн компани, байгууллага аливаа сонин хэвлэхийг хориглодог. Мөн Сонины тухай хуульд гадаадын иргэд цахим сонин гаргахыг хориглосон.⁴⁶⁰

Өргөн нэвтрүүлгийн харилцааг 1987 онд батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар, интернет протоколоор дамжуулж буй өргөн нэвтрүүлгийг 2008 онд батлагдсан Интернет мультимедиа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тухай хуулиар зохицуулдаг.⁴⁶¹ Энэ хоёр хуулийн хэрэгжилтийг Харилцаа холбооны хороо (КСС) болон Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны яам (MSIT) хариуцдаг. Эдгээр хуулиар өргөн нэвтрүүлгийн операторын тусгай зөвшөөрөл, үнэлгээний системийг зохицуулдаг. Өргөн нэвтрүүлгийн операторууд Харилцаа холбооны хорооноос тусгай зөвшөөрөл авах буюу Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны яамд бүртгүүлэх, зөвшөөрөл авах ёстой. Солонгосын өргөн нэвтрүүлгийн телевизүүд хөтөлбөрөө цацахаас өмнө үзэгчдэд хор хөнөөл учруулж болзошгүй таван зүйлд (сэдэв, хүчирхийлэл, бэлгийн харьцаа, даган дууриах эрсдэл, хэл яриа) үндэслэн хөтөлбөртөө өөрсдөө үнэлгээ өгч, тэмдэглэгээ тавих шаардлагатай бөгөөд хөтөлбөрийн туршид тэмдэглэгээг харуулах ёстой. Харилцаа холбооны хороо нь Өргөн нэвтрүүлгийн стандартыг гаргадаг бөгөөд түүний хэрэгжилтэд хяналт тавьдаг. Мөн Харилцаа холбооны хороо нь өргөн нэвтрүүлгийн зар сурталчилгааны стандартыг гаргадаг. Эфирт цацагдсан контентыг хянан үзээд тухайн контент нь дээрх стандарт буюу журамд нийцээгүй тохиолдолд холбогдох өргөн нэвтрүүлгийн компани, хөтөлбөрийн нийлүүлэгч, продакшны компаниудад шийтгэл оногдуулж болно.

Сэтгүүлчдэд эх сурвалжаа хамгаалахын тулд дуугүй байх эрхийг шууд олгосон хуулиудыг цуцалсан. Одоогоор сэтгүүлчдэд эх сурвалжаа хамгаалахыг шууд зөвшөөрсөн хууль тогтоомж байхгүй бөгөөд эх сурвалжийн хамгаалалт нь Үндсэн хуулиар олгогдсон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд хамаарах эсэх нь тодорхойгүй байдалтай байна.

Хариуцлагын тогтолцоо:

Хэвлэлийн Арбитр болон хэвлэлийн мэдээгээр учруулсан хохиролд авах арга хэмжээний тухай хуулийн дагуу хохирсон тал хэвлэл мэдээллийн компанийн эсрэг залруулга хийлгэх, няцаалт хийлгэх, нэмэлт мэдээлэл гаргуулахаар гомдол гаргах боломжтой. Залруулга хийлгэх хүсэлтийг компанийн нийтэлсэн үнэн, бодит бус мэдээлэлд холбогдуулан гаргана. Мэдээллийн үнэн зөв эсэхээс үл хамааран няцаалт хийж болно. Нэмэлт мэдээлэл гаргуулах хүсэлтийг гэмт хэрэгт сэжиглэгдсэн, яллагдагчаар татагдсан бөгөөд хожим нь гэм буруугүйд тооцогдсон буюу ялаас чөлөөлөгдсөн этгээдийн гаргаж болно.

⁴⁵⁹ South Korea — Act on the Promotion of Newspapers https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53924&lang=ENG

⁴⁶⁰ South Korea — The Media and Entertainment Law Review: South Korea. Hyun Ho Eun, Jung-Chull Lee and Dukjoong Na. 08 December 2021 <https://thelawreviews.co.uk/title/the-media-and-entertainment-law-review/south-korea>

⁴⁶¹ South Korea - Broadcasting Act https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=54774&lang=ENG; Internet Multimedia Broadcast Services Act https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46591&lang=ENG

Эдгээр гомдлыг хэвлэл мэдээллийн компанид шууд гаргах, Хэвлэлийн Арбитрын комиссоор дамжуулан гаргах, эсвэл шүүхээр дамжуулан гаргах боломжтой. Хэрэв мэдээ, сурвалжлага нь худал буюу тухайн этгээдийн нэр хүндэд бодит хохирол учруулсан бөгөөд олон нийтийн ашиг сонирхлыг хангахтай холбоогүй бол хохирсон талын зүгээс тухайн мэдээг устгуулах, арилгуулахаар хүсэлт гаргаж болно. Хэвлэлийн Арбитрын комисс нь хэвлэлийн мэдээ, мэдээлэлтэй холбоотой маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх төрөлжсөн байгууллага юм. Арбитрын хэлтэс нь шүүгч, өмгөөлөгч, хэвлэл мэдээллийн ажилтан аснаас бүрдэнэ. Гомдол гаргагч тал болон хэвлэл мэдээллийн компани хоорондын амжилттай эвлэрлийн гэрээ нь хуулийн дагуу хууль ёсны хүчин төгөлдөр байна.

Хэрэв хэвлэл мэдээллийн компани хууль бус үйлдэл хийвэл хохирсон тал эдийн засгийн хохирол, сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэх боломжтой бөгөөд үүнийгээ нотлох шаардлагатай. Хэвлэлийн Арбитрын тухай хуулиас ялгаатай нь эдгээр нэхэмжлэлийг хувь сэтгүүлч, сурвалжлагчдын эсрэг гаргаж болно.

Солонгост хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллээс болж нэр хүндэд нь хохирол учирсан тал тухайн мэдээлэл үнэн эсэхээс үл хамааран тухайн хэвлэн нийтлэгч болон хувь сэтгүүлч, сурвалжлагчийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгүүлж болно. Нийтлэгч болон хувь хүн сэтгүүлч, сурвалжлагчийн хувьд мэдээлэл үнэн зөв бөгөөд нийтийн ашиг сонирхолд үйлчилсэн гэдгийг нотолж чадвал эрүүгийн хариуцлага хүлээхгүй байж болно. Харин худал мэдээний хувьд эрүүгийн хариуцлага хүлээх эрсдэлтэй. Гэхдээ гомдол гаргасан тал хохирсон гэдгээ нотлох ёстой. Мөн тухайн мэдээлэл худал байсан ч түүнийг хэвлэн нийтлэгч үнэн гэж итгэсэн буюу үнэн гэж итгэхүйц хангалттай үндэслэл байсан бөгөөд тухайн мэдээ нь олон нийтийн тусын тулд байсан бол хэвлэн нийтлэгч эрүүгийн хариуцлага хүлээхгүй.⁴⁶² Гэхдээ энэ талаар хэвлэн нийтлэгч өөрөө нотлох үүрэгтэй. Үндсэн хуулийн шүүх болон Дээд шүүхийн зүгээс дээр дурдсан эрүүгийн хуулийн хамгаалалт нь олон нийтийн зүтгэлтэнд хамаарал багатай гэж үзсэн.⁴⁶³ Энэ нь олон нийтийн зүтгэлтэнтэй холбоотой асуудлаар бэлтгэсэн мэдээг олон нийтийн сайн сайхны төлөө бэлтгэсэн мэдээ гэж үзэх боломжтой болохыг харуулж байна.

3.3.5. Америкийн Нэгдсэн Улсын туршлага

Америкийн Нэгдсэн Улс (цаашид “АНУ” гэх) “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн тайланд сүүлийн 5 жилд буюу 2017-2021 онд 43-48 дугаар байрын хооронд байгаа хэвлэлийн эрх чөлөөний “сэтгэл хангалуун” үзүүлэлттэй улс юм.⁴⁶⁴

Хэвлэл мэдээллийн хууль тогтоомж:

АНУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр нэмэлт болон түүнийг тайлбарласан тус улсын Дээд шүүхээс гаргасан олон шийдвэрүүд нь хууль зүйн тогтолцооны үндэс суурь бөгөөд бусад улс оронд байдаг олон төрлийн хэвлэл мэдээллийн зохицуулалт, тухайлбал үзэн ядсан үг хэллэг, сонгуулийн кампанит ажилтай холбоотой зохицуулалтыг хязгаарладаг.⁴⁶⁵ Өргөн нэвтрүүлгийн хувьд 1934 оны Харилцаа холбооны тухай хууль, 1996 оны Холбоо харилцааны тухай хууль гэсэн хоёр хууль тогтоомжийг голлон авч үздэг. 1934 оны Харилцаа холбооны тухай хууль нь өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын "итгэмжлэлийн загвар" гэж нэрлэгддэг бөгөөд ихэвчлэн арилжааны аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл

⁴⁶² South Korea - Supreme Court decision, 23 August 1996, 94 Do 3191 <https://www.scourt.go.kr/scourt/index.html>

⁴⁶³ South Korea - Constitutional Court decision, 24 June 1999, 97 Heon-Ma 265

<https://english.court.go.kr/site/eng/decisions/casesearch/caseSearchPop.do>;

Supreme Court decision, 27 February 2004, 2001 Da 53387

⁴⁶⁴ Reporters Without Borders: United States <https://rsf.org/en/united-states>

⁴⁶⁵ Daniel C. Hallin. USA Media legislation. European Journalism Centre (EJC). 2019

<https://medialandscapes.org/country/united-states/policies/media-legislation>

олгодог боловч “олон нийтийн тав тухтай байдал, хэрэгцээнд” нийцүүлэн агаарын долгионыг ашиглахыг шаарддаг бөгөөд тусгай зөвшөөрлийг үе үе шинэчлэх шаардлага тавьдаг.⁴⁶⁶ Энэ бүтэц нь зарчмын хувьд хэвээр байгаа боловч 1980-аад оноос эхлэн зохицуулалтыг сулруулснаар тусгай зөвшөөрлийг сунгах үйл явц үндсэндээ албан ёсны шинжтэй болсон. Кабелийн телевизийг тусгайлан зохицуулсан хуулиуд бий бөгөөд хамгийн сүүлийнх нь 1992 оны Кабелийн телевизийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, өрсөлдөөний тухай хууль юм.⁴⁶⁷

Гүтгэлэг, доромжлолын хууль тогтоомж, түүнчлэн хувийн нууцын тухай хуулиудыг үндсэндээ муж улсын түвшинд тодорхойлдог боловч Холбооны шүүхээр хянуулдаг. 30 орчим муж улс сэтгүүлчдэд эх сурвалж болон бусад нууц мэдээллийг тодорхой хэмжээгээр хамгаалах “бамбай хууль” баталсан. Харин холбооны түвшинд ийм бамбай хууль байхгүй.

1966 онд батлагдаж 1967 оноос хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь иргэдэд Холбооны засгийн газраас гаргаж буй мэдээлэлд хандах эрхийг олгож, мэдээлэл хүсэх журмыг тогтоодог.⁴⁶⁸ Энэ хуулийг сэтгүүлчид, ялангуяа эрэн сурвалжлах нийтлэл бэлтгэхэд өргөн ашигладаг. Жишээлбэл, 2021 онд АНУ-ын Тагнуулын төв газраас мэдээлэл авахаар 2895 хүсэлт гаргасан байх бөгөөд энгийн хүсэлтэд ажлын 7 хоногт, цогц мэдээлэл авах хүсэлтэд ажлын 282 өдөрт тус тус мэдээлэл өгч байна.⁴⁶⁹ Муж улсуудад ч үр ашигтай байдал, заалтаараа ялгаатай ч ийм мэдээллийн эрх чөлөөний тухай хууль байдаг. Гэхдээ Мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд дор дурдсан 9 төрлийн мэдээллийг хамруулаагүй:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор нууцалсан мэдээлэл
2. Зөвхөн байгууллагын хүний нөөцийн дотоод дүрэм, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл
3. Холбооны өөр хуулиар задруулахыг хориглосон мэдээлэл
4. Худалдааны нууц, аж ахуй, санхүүгийн нууцалсан буюу давуу тусгайлан хамгаалсан мэдээлэл
5. Агентлаг доторх буюу тэдгээрийн хоорондын давуу эрхтэй харилцаа холбоо /өмгөөлөгчийн ажилтай холбоотой холбоо, өмгөөлөгч-үйлчлүүлэгчийн нууц/
6. Хэрэв задруулсан тохиолдолд өөр хүний хувийн нууцад халдах мэдээлэл
7. Хууль сахиулах үйл ажиллагааны зорилгоор эмхэтгэсэн мэдээлэл
8. Санхүүгийн байгууллагуудын хяналтад хамаарах мэдээлэл
9. Байгалийн нөөцийн геологийн мэдээлэл.

Хариуцлагын тогтолцоо:

АНУ-д хэвлэлийн зөвлөл байдаггүй. Холбооны Харилцаа холбооны комиссын хувьд өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хариуцаж байгаа ч өнөө үед тусгай зөвшөөрлийг сунгах үйл явц нь тусгай зөвшөөрлийн төлөөх томоохон өрсөлдөөн байхаа больсон.⁴⁷⁰ Хууль зүйн яамны Монополийн эсрэг газар зах зээлийн төвлөрөлтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцдаг.⁴⁷¹ Тус газар ихэвчлэн хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэгдэх, нийлэх асуудлыг хянадаг бөгөөд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Мэргэжлийн Сэтгүүлчдийн Нийгэмлэг (SPJ) нь 9000 орчим гишүүнтэй бөгөөд сэтгүүл зүйн мэргэжлийн ур чадварыг сурталчлах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах зэрэг үйл ажиллагаа

⁴⁶⁶ USA - Communications Act of 1934 <https://www.fcc.gov/Reports/1934new.pdf>

⁴⁶⁷ USA – Cable Television Consumer Protection and Competition Act of 1992 https://transition.fcc.gov/Bureaus/OSEC/library/legislative_histories/1439.pdf

⁴⁶⁸ USA – The Freedom of Information Act <https://www.congress.gov/114/bills/s337/BILLS-114s337enr.xml>;

⁴⁶⁹ USA - The government's central website for FOIA <https://www.foia.gov/>

⁴⁷⁰ USA – Federal Communication Commission <https://www.fcc.gov/>

⁴⁷¹ USA – The Antitrust Division of the Justice Department <https://www.justice.gov/atr>

явуулдаг. Америкийн Мэдээллийн редакторуудын нийгэмлэг (ASNE) нь 1922 онд Америкийн сонины редакторуудын нийгэмлэг нэртэйгээр байгуулагдсан бөгөөд тус нийгэмлэг мэргэжлийн ёс зүй, соёлыг төлөвшүүлэхэд олон жил гол үүрэг гүйцэтгэсэн. Мөн Америкийн сэтгүүлийн редакторуудын нийгэмлэг (ASME) байдаг. Бусад холбоод нь эрэн сурвалжлах сурвалжлагч эсвэл эрүүл мэндийн сэтгүүлч гэх мэт тусгай мэргэшсэн сэтгүүлчдийг төлөөлж, Латин сэтгүүлч, хар арьст сэтгүүлчид зэрэг бүлгүүдийг төлөөлдөг.

АНУ-ын Дээд шүүхээс гаргасан жишиг шийдвэрүүд:

- АНУ-ын Дээд шүүх 1964 онд шийдвэрлэсэн “Нью-Йорк Таймс сонины эсрэг Салливан” хэрэгт Үндсэн хуулийн 1 дүгээр нэмэлтийг хэрэглэжээ. Тус сонин Алабама мужийн Монтгомери хотын хууль сахиулах албаны ажилтнууд иргэний эрхийн төлөө тэмцэгчдийн эсрэг хүч хэрэглэж байгааг эсэргүүцсэн агуулгатай төлбөртэй сурталчилгааг нийтэлснээр асуудал манджээ. Уг сурталчилгаанд Монтгомери хотын цагдаагийн газрын комиссар Л.Б.Салливаны нэрийг дурдаагүй ч гэсэн сурталчилгаанд орсон үг хэллэг нь түүний нэр төрийг гутаасан гэсэн үндэслэлээр шүүхэд ханджээ. Анхан шатны шүүх энэ хэргийг Салливаны талд шийдвэрлэж, түүнд 500,000 доллар төлөхийг даалгасан шийдвэр гаргажээ. Харин АНУ-ын Дээд шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүйд тооцсон байна. Дээд шүүхийн шүүгч Уильям Бреннан “Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудлаар нээлттэй, ширүүн маргаан, мэтгэлцээн өрнөх нь зүйн хэрэг” гэж тайлбарласнаас гадна худал мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудлаар эрүүл мэтгэлцээн өрнөх нөхцөлийг хангах ач холбогдолтой учраас 1 дүгээр нэмэлтээр худал мэдээллийг ч гэсэн хамгаалах ёстой. Түүнчлэн төрийн албан тушаалтнууд тухайн гүтгэлгийн мэдээллийг “санаатайгаар тараасан гэдгийг нотолсны үндсэн дээр шүүхэд гомдол мэдүүлэх ёстой” гэж тайлбарласан байна. Дээд шүүх дараагийн хэргүүдийг шийдвэрлэхдээ ч гэсэн гүтгэлгийг санаатай тараасан гэдгийг нотлохыг шаарддаг болжээ. Харин хувь хүмүүстэй холбоотой (төрийн албан тушаалтан буюу нийгмийн зүтгэлтэн хамаарахгүй) гүтгэлгийн хэргийг тухайн мужийн шүүх тодорхой стандарт тогтоон шийдвэрлэж болно гэж тайлбарлажээ. Гүтгэлгийн чанартай худал мэдээлэл нь хувь хүний нэр төрийг гутаасан гэдгийг нотолсон тохиолдолд хохирогчид нөхөн төлбөр олгох ёстой гэдгийг ч шүүх хүлээн зөвшөөрсөн юм. Мөн Дээд шүүх хэвлэн нийтлэгчдийг гүтгэлгийн хэрэгт тоомжиргүй хандаж байгааг нотлохыг гомдол гаргагчаас шаардах журам гаргасан нь сэтгүүлчдэд чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломж олгосон байна.⁴⁷²
- АНУ-ын Дээд шүүх 1971 онд Пентагоны баримт гэж нэрлэгдсэн хэрэгт холбогдуулан “Нью-Йорк Таймс сонины эсрэг АНУ-ын засгийн газар” гэх хэргийг шийдвэрлэсэн. Учир нь Нью-Йорк Таймс сонин Америкийн арми Вьетнамын дайнд хэрхэн оролцсон талаар нууц баримтуудыг нийтэлсний дараа Ерөнхийлөгч Ричард М.Никсоны засаг захиргаа шүүхэд хандан нууц баримтуудыг нийтлэхийг хориглох хүсэлт тавьжээ. Гэхдээ Дээд шүүх засгийн газрын эсрэг шийдвэр гаргасан. Дээд шүүх “Шүүхэд хандан мэдээллийн агуулгыг хянах хүсэлт тавих нь Үндсэн хуульт ёсонд харшилна” гэж онцолсон бөгөөд засгийн газар “мэдээллийн агуулгыг хянах үндэслэлээ хангалттай нотолж чадаагүй учраас энэ хүсэлтийг хүлээн авах боломжгүй” гэж тайлбарласан. Засгийн газар үндэсний аюулгүй байдалд аюул учруулна гэсэн үндэслэлээр мэдээллийн агуулгыг урьдчилан хянах хүсэлт гаргасан тохиолдолд ялах магадлал багатай гэдгийг Пентагоны баримт гэж нэрлэгдсэн энэхүү хэргийг Дээд шүүх хэрхэн шийдвэрлэснээс харж болно. Энэ хэргээс хойш Дээд шүүх үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл нийтлэхийг хориглох тухай хүсэлтийг хэлэлцэж байгаагүй бөгөөд 9 дүгээр сарын 11-ний халдлагаас хойш ч

⁴⁷² New York Times Company v. Sullivan, 376 U.S. 254 (1964) <https://supreme.justia.com/cases/federal/us/376/254/>

гэсэн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих тухай шийдвэр гаргаагүй.⁴⁷³

- 1974 онд АНУ-ын Дээд шүүх “Герцийн эсрэг Роберт Уэлч”-ийн хэргийг шийдвэрлэсэн. Шүүгч Льюис Пауэлл “тухайн үг хэллэг хохирол учруулсан гэж үзэж байгаа бол шүүгч нар энэ хэргийг шийдвэрлэнэ гэж найдах хэрэггүй. Харин хохирогч өөрөө эсрэг үндэслэл дэвшүүлж, маргах боломжтой” гэж тайлбарлажээ.⁴⁷⁴
- 1978 онд АНУ-ын Дээд шүүх “Цуркерийн эсрэг Стэнфорд сонин”-ы хэргийг шийдвэрлэснээр цагдаагийн албан хаагчид их сургуулийн оюутны сонины байр луу нэвтэрч, цагдаа нар болон жагсагчдын хооронд болсон мөргөлдөөнийг харуулсан гэрэл зургуудыг хурааж авах эрхгүй гэсэн шийдвэр гаргажээ. Тухайн үед жагсагчид Стэнфордын их сургуулийн эмнэлгийн байрыг эзэлсэн байсан. Оюутнууд Үндсэн хуулийн 1 дүгээр нэмэлтийн дагуу хууль сахиулах байгууллагын ажилтнууд хэвлэлийн байгууллагын байранд нэвтрэх эрхгүй гэж маргаж байлаа. Харин шүүгч Байрон Уайт Үндсэн хуулийн 1 дүгээр нэмэлтийн дагуу мэдээллийн байгууллагад онцгой статус олгохгүй боловч 4 дүгээр нэмэлтэд “аливаа эзэмшлийг үндэслэлгүйгээр нэгжих, эд зүйлсийг хураан авахыг хориглосон” учраас оюутны сонины байр ч хамгаалагдах ёстой гэж тайлбарлажээ. Шүүгч Поттер Стьюарт “Цагдаа нар сонины байрыг нэгжсэн нь хэвлэлийн эрх чөлөөнд халдсаны нотолгоо. Сонины байранд эвдрэл учруулсан нь эрх чөлөөнд халдсаны илэрхий нотолгоо. Хамгийн ноцтой нь цагдаа нар урьдчилан мэдэгдэлгүйгээр сонины байранд нэгжлэг явуулсан нь нууц эх сурвалжаас авсан мэдээллийг задлах, тухайн мэдээллийн эх сурвалжийг илчлэх эрсдэлтэй байсан” гэж тайлбарласан.⁴⁷⁵
- 1988 онд Дээд шүүх Ларри Флинтийн эзэмшдэг Хаслер сэтгүүлийн эсрэг сэтгэл зүйн хямралд оруулсан гэсэн үндэслэлээр гомдол гаргасан Реверенд Жерри Фалуэллийн гомдлыг хүлээн авахаас татгалзжээ. Тус сэтгүүлд Реверенд Жерри Фалуэллийг согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ угаалгын өрөөнд эхтэйгээ бэлгийн харилцаанд орж байгааг харуулсан шог зураг нийтэлсэн нь шуугиан тарьсан. Харин тус сэтгүүлийн захиргаа энэ бол шог зураг учраас болсон явдалтай адилтгаж нухацтай тусгаж авах шаардлагагүй гэсэн тайлбар өгчээ. Харин Фалуэлл Флинтийг гүтгэсэн, хувийн нууцад халдсан, сэтгэл зүйн хямралд оруулсан зэрэг үндэслэлээр гомдол гаргасан. Хэдийгээр Фалуэлл эхний хоёр үндэслэлд ялагдсан ч тангарагтний шүүх гуравдахь үндэслэлд түүний талд шийдвэр гаргажээ. Түүнийг давж заалдах шатны шүүх хүлээн авсан. Гэхдээ давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг Дээд шүүх хүчингүй болгосон. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Уильм Ренквист Америкчууд улс төрийн талаар ёж, ширүүн үг хэллэг хэрэглэдэг уламжлалтай гэдгийг онцлоод бүдүүлэг, зохисгүй үг хэллэгийг хязгаарлаж, стандарт тогтоох тухай Фалуэллийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан байна. “Бүдүүлэг, зохисгүй үг хэллэг гэдэг ойлголтыг улс төр, нийгмийн хүрээнд хэрэглэх нь шүүгч нар субьектив шийдвэр гаргах эрсдэл дагуулна. Учир нь шүүгч нар өөрсдөө хувь хүмүүс учраас өөрт таалагддаггүй буюу өөрийн үзэл бодолд нийцээгүй үг хэллэгийг буруутгаж, субьектив шийдвэр гаргах эрсдэлтэй” гэж Ренквист тайлбарласан байна. Мөн нийгмийн зүтгэлтэн хүн ийм төрлийн дайралтыг тэсвэрлэх чадвартай байх нь Үндсэн хуулийн 1 дүгээр нэмэлтийн дагуу хамгаалагдсан хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах ач холбогдолтой гэж Ренквист онцолсон байна.⁴⁷⁶

⁴⁷³ New York Times Company v. United States, 403 U.S. 713 (1971)

<https://supreme.justia.com/cases/federal/us/403/713/>

⁴⁷⁴ Gertz v. Robert Welch, Inc., 418 U.S. 323 (1974) <https://supreme.justia.com/cases/federal/us/418/323/>

⁴⁷⁵ Zurcher v. Stanford Daily, 436 U.S. 547 (1978) <https://supreme.justia.com/cases/federal/us/436/547/>

⁴⁷⁶ Hustler Magazine, Inc. v. Falwell, 485 U.S. 46 (1988) <https://supreme.justia.com/cases/federal/us/485/46/>

3.3.6. Хуучин социалист улсуудын туршлага (Латви, Литва, Чех)

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 1960 оны Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол ажилчид, хоршоолсон ардууд (малчид, тариаланчид), хөдөлмөрч сэхээтний социалист улс бөгөөд түүний үндэс нь ажилчин анги, хоршоолсон ардын холбоо мөн” гэж заасан бөгөөд өдгөө Монгол Улсын хувьд хуучин социалист орны нэг болсон. Иймд энэ хэсэгт хуучин социалист улсуудын туршлагыг авч үзэв.

Хүснэгт 28. Хуучин социалист зарим улсын хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлт

Улсын нэр	Хэвлэлийн эрх чөлөөний үзүүлэлт-2021			Социалист улс байсан үе	Гишүүнчлэл
	Эзлэх байр	Оноо	Нөхцөл байдал		
Латви	22	19.26	Сэтгэл хангалуун нөхцөл байдал	1940-1990/91	2004 оноос Европын холбооны гишүүн
Литва	28	20.15	Сэтгэл хангалуун нөхцөл байдал	1944-1990/91	2004 оноос Европын холбооны гишүүн
Чех	40	23.38	Сэтгэл хангалуун нөхцөл байдал	1969-1990	2004 оноос Европын холбооны гишүүн

Бүгд Найрамдах Латви Улс:

Латвийн хувьд 2004 оноос эхлэн Европын холбооны гишүүн болсон бөгөөд парламентын бүгд найрамдах улс юм. Латви улсын хувьд 19-20 дугаар зуунд хэвлэл мэдээллийг хатуу цагдан хяналтаар зохицуулж байсан. Өнөөгийн хувьд Латвид хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг 1990 оноос хойш батлагдсан хэд хэдэн хуулиар зохицуулж байна. Үг хэлэх эрх чөлөөг Латвид Үдсэн хуулиар баталгаажуулсан. Латвийн Үндсэн хууль 1922 онд батлагдсан бөгөөд түүнийг 1991 онд сэргээсэн. Тус Үндсэн хуулийн 100 дугаар зүйлд “хүн бүр үг хэлэх эрх чөлөөтэй байх бөгөөд үүнд мэдээлэл чөлөөтэй олж авах, эзэмших, түгээх эрх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх багтана. Цензур тогтоохыг хориглоно” гэж заасан.⁴⁷⁷

Латвийн 1990.12.20-ны өдөр батлагдсан Хэвлэл ба нийтийн хэвлэл мэдээллийн тухай хууль 1991 онд хүчин төгөлдөр болсон. Тус хуулиар хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулж, хэвлэл болон бусад нийтийн хэвлэл мэдээлэлд цензур тогтоох, түүнийг монополизлохыг хориглодог. Мөн нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн бүртгэх, ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоохыг хуульд заасан. Түүнчлэн нийтлэх ёсгүй мэдээллийн төрлүүд, худал мэдээг залруулах, эх нууц эх сурвалжийг хамгаалах, сэтгүүлчийн эрх, үүрэг гэх мэт асуудлыг зохицуулсан.⁴⁷⁸

Латвийн 1998 онд батлагдсан Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь төрийн байгууллагуудын мэдэлд байгаа эсвэл ил болгох ёстой мэдээллийг хүмүүст хүртээмжтэй байлгах боломжийг олгодог. Хуульд тэдгээр мэдээллийг хувь хүмүүс олж авч ашиглах нэгдсэн журмыг тогтоосон.⁴⁷⁹

Латвийн 2010 онд батлагдсан Цахим хэвлэл мэдээллийн тухай хууль нь Латви улсын харьяанд байгаа цахим хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа, түүний дүрмийн талаар зохицуулдаг. Түүнчлэн төрийн үйлчилгээний хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн үйлчилгээний чиг үүрэг гэсэн хэсгүүдийг багтаасан.⁴⁸⁰

Дээр дурдсан хуулиудаас гадна Зар сурталчилгааны тухай хууль, Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль, Төрийн хэлний тухай хууль, Мэдээллийн нийгмийн үйлчилгээний тухай хууль тус тус хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд хамаарч байна. Үүнтэй

⁴⁷⁷ Latvia – Constitution, 1991 https://www.constituteproject.org/constitution/Latvia_2016.pdf?lang=en

⁴⁷⁸ Latvia - Law on the Press and other Mass Media, 1991 <https://likumi.lv/ta/en/en/id/64879-on-the-press-and-other-mass-media>

⁴⁷⁹ Latvia - Freedom of Information Law, 1998 <https://likumi.lv/ta/en/en/id/50601-freedom-of-information-law>

⁴⁸⁰ Latvia - Electronic Mass Media Law, 2010 <https://likumi.lv/ta/en/en/id/214039-electronic-mass-media-law>

холбоотойгоор сэтгүүлч, түүний эх сурвалжийг хамгаалах, үг хэлэх эрх чөлөөний зарчмыг бэхжүүлэх зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан нээлттэй захидалд 120 гаруй сэтгүүлч гарын үсэг зурсан. Энэ хэрэг Европын Хүний эрхийн шүүхэд шилжсэн бөгөөд шүүхээс сэтгүүлчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн гэж үзсэн ("Nagla v. Latvia" гэх хэрэг).

2015 оны хавар Соёлын яаманд Хэвлэл мэдээллийн бодлогын хэлтэс шинээр байгуулагдсан. Энэхүү хэлтсээр дамжуулан тус яам нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжихийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн бодлого боловсруулж, түүний уялдааг хангадаг. Латвийн хэвлэл мэдээллийн бодлогын гол зорилго нь хүчирхэг, олон ургалч, мэргэжлийн, ил тод, тууштай, тогтвортой хэвлэл мэдээллийн орчин юм. Засгийн газрын 2016.11.08-ны өдрийн хуралдаанаараа баталсан Хэвлэл мэдээллийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хэвлэл мэдээллийн орчныг сайжруулах чиглэлээр тодорхой зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү үндсэн чиглэлд дараах таван үндсэн зарчим, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон:

- Хэвлэл мэдээллийн олон ургалч байдал;
- Хэвлэл мэдээллийн чанар, хариуцлагатай байдал;
- Хэвлэл мэдээллийн орчин дахь мэргэшсэн байдал;
- Хэвлэл мэдээллийн боловсрол;
- Хэвлэл мэдээллийн орчны уян хатан байдал.

Энэхүү төлөвлөгөөнд Хэвлэл ба нийтийн хэвлэл мэдээллийн тухай хууль, Цахим хэвлэл мэдээллийн тухай хуулийг орлох шинэ хэвлэл мэдээллийн хуулийн төслийг боловсруулахаар тусгасан. Ингэхдээ эдгээр хуулийг сайжруулах, Европын холбооны бодлого, удирдамжид нийцүүлэх зорилго дэвшүүлсэн. Энэхүү төлөвлөгөөнд хэвлэл мэдээллийн салбар өөрийгөө зохицуулах буюу сэтгүүлчийн талаарх хувь хүний гомдлыг мэргэжлийн болон ёс зүйн стандартын дагуу хүлээн авч шийдвэрлэх Хэвлэл мэдээллийн омбудсман байгуулах явдлыг дэмжих талаар тусгасан.⁴⁸¹

Бүгд Найрамдах Литва Улс:

Литвын хувьд 2004 оноос эхлэн Европын холбооны гишүүн болсон бөгөөд парламентын бүгд найрамдах улс юм. Литвын хувьд Балтийн бүс нутагтаа хамгийн том хэвлэл мэдээллийн зах зээлтэй улс юм. Литвын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд нийтийн хэвлэл мэдээлэлд цензур тогтоох, түүнийг монопольчлохыг хориглодог.⁴⁸²

Литвын 1996 онд батлагдсан "Олон нийтийг мэдээллээр хангах тухай хууль"-д нийтийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтлэх, түгээх журам, нийтийн мэдээллийг боловсруулагч, түгээгч, түүнд оролцогч, сэтгүүлч, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг энэ хуулиар тогтоосон.⁴⁸³ Энэ хуулиар өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн тусгай зөвшөөрөл олгох, өмчлөлийн хязгаарлалт, хэвлэл мэдээллийн агуулга, хөтөлбөрийн найруулга, хэл, сурталчилгааны хязгаарлалт, ёс зүйд тавигдах шаардлагыг тогтоосон. Тус хуулийн 8 дугаар зүйлд мэдээллийн эх сурвалжийн нууцлалын талаар заасан.

Тодруулбал, олон нийтэд мэдээлэл бэлтгэгч, түгээгч, тэдгээрийн оролцогч, сэтгүүлч мэдээллийн эх сурвалжийн нууцыг хадгалах, задруулахгүй байх эрхтэй. Харин хүний үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хамгаалах, шударга ёсыг хэрэгжүүлэх зорилгоор болон нийтийн ашиг сонирхлын үүднээс мэдээллийн эх сурвалжийг задруулах шаардлагатай бол

⁴⁸¹ Latvia – Accountability systems <https://medialandscapes.org/country/latvia/policies/accountability-systems>

⁴⁸² Lithuania – Public Information Policy <https://lrkm.lrv.lt/en/activities/public-information-policy>

⁴⁸³ Lithuania – Law on the Provision of Information to the Public (LPIP) <https://e-seimas.lrs.lt/portal/legalAct/lt/TAD/2865241206f511e687e0fbad81d55a7c?jfwid=1clcwosx33>

энэ талаар шүүх үндэслэл бүхий шийдвэр гаргаж мэдээллийн эх сурвалжийг задруулах үүрэг хүлээлгэж болно. Мэдээллийн эх сурвалжийг задруулах зорилгоор үйлдвэрлэгч, олон нийтэд мэдээлэл түгээгч, тэдгээрийн оролцогч, сэтгүүлчийн албан өрөө, байр, арын өрөөнд, түүнчлэн тээврийн хэрэгсэлд нэгжлэг хийх, хураах ажиллагааг Бүгд Найрамдах Литва Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу явуулна. Ингэхдээ сэтгүүлч, үйлдвэрлэгчдийн байгууллагын төлөөлөгчдийн хурлаар томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл гэрчийн оролцоотойгоор дээрх байр, тээврийн хэрэгслийн өмчлөгч, хэрэглэгчийн эд хөрөнгөнд нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг явуулна.

Тус хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар хүн бүр төрийн болон хотын байгууллага, агентлаг, албан тушаалтны үйл ажиллагааг олон нийтэд шүүмжлэх эрхтэй. Тийнхүү шүүмжилсний төлөө хяхан хавчихыг хориглоно. Тус хуулийн хэрэгжилтийг Соёлын яам хариуцна. Тус хуулийн 5 дугаар бүлэг буюу 45-50 дугаар зүйлд төрийн зохицуулах болон хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулах байгууллагын талаар зохицуулсан.

Бүгд Найрамдах Чех Улс:

Бүгд найрамдах Чех улсын хувьд 2004 оноос эхлэн Европын холбооны гишүүн болсон бөгөөд парламентын бүгд найрамдах улс юм. Тус улсад төрийн гүйцэтгэх үүргийн талаарх неолиберал хандлагын дагуу 1990-ээд оны үед хэвлэл мэдээллийн зохицуулалтын үндсэн хэлбэр бий болж, улмаар Европын холбооны тогтолцоотой уялдуулсан хэвлэл мэдээллийн зохицуулалтын хүрээ нь 1990 оноос хойш томоохон өөрчлөлтөд ороогүй байна. Харин 2016 оны 11 дүгээр сард парламентаас баталсан Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуульд улстөрчдийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хувь эзэмшихийг шууд хориглосон нэмэлт өөрчлөлт орсон нь анхаарал татаж байна.⁴⁸⁴

Чехийн 2000 онд батлагдсан Тогтмол хэвлэлийг хэвлэн нийтлэхтэй холбоотой эрх, үүргийн тухай хууль буюу Хэвлэлийн хуулиар тогтмол хэвлэн нийтлэгч нь түүний нийтэлсэн мэдээллийн үнэн зөвийг хариуцна. Тухайн тогтмол хэвлэл болон цахим хэвлэлд гарсан мэдээлэл, нийтлэлийн улмаас гэм хор учирсан гэж үзэж буй хувь хүн тухайн хэвлэлд хандаж хариу тайлбар авахыг шаардах эрхтэй. Мөн тус хуулийн 16 дугаар зүйлд зааснаар сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа хамгаалах эрхтэй. Гэхдээ энэ эрх нь эрүүгийн хэрэгт холбогдсон эх сурвалжийн хувьд хамаарахгүй. Соёлын яаманд бүртгүүлээгүй тогтмол хэвлэлийг торгох зохицуулалттай. Хэвлэл мэдээллийн гол зохицуулах байгууллага нь Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн зөвлөл, Телевизийн зөвлөл, Радиогийн зөвлөл, Зар сурталчилгааны зөвлөл юм.⁴⁸⁵

⁴⁸⁴ Czech Republic - Law on Conflict of Interest, 2016
https://publicofficialsfinancialdisclosure.worldbank.org/sites/fdl/files/assets/law-library-files/Czech%20Republic_Conflict%20of%20Interest%20Act_159_2006_EN.pdf

⁴⁸⁵ Czech Republic - Act No. 46/2000 Coll. on the Periodical Press (Tiskový zákon)
<https://www.zakonyprolidi.cz/cs/2000-46>

ДҮГНЭЛТ

1/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний талаарх олон улсын жишиг ба дотоодын хууль тогтоомжийн нөхцөл байдал

1.1. Олон улсын нөхцөл байдал:

Дэлхийн 160 улсад гүтгэлгийг гэмт хэрэгт тооцон ял шийтгэл эдлүүлсэн хэвээр байгаа, төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын 4/5 нь редакцийн хараат байдалтай, иргэдийн 2/3 нь найдваргүй эх сурвалж бүхий мэдээ цацсан, нийтэлсэн гэх шалтгаанаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үл итгэх байдалтай, сэтгүүлчдийн 2/3 нь аюулгүй байдлын баталгаагүй нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэж байгаа бөгөөд улс төрийн орчин, эрх зүйн тогтолцооноос үл хамааран дэлхийн олон улсад дан ганц сэтгүүлчдийн үйл ажиллагаанд нөлөөлж, хорих цагдах гэхээс илүүтэйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн бие даасан байдалд нөлөөлөх илүү нарийн зохион байгуулалттай үйл ажиллагаа өрнөж байна.

Ингэхдээ засгийн газрын оролцоотойгоор хэвлэл мэдээллийн өмчлөлд зохисгүй өөрчлөлт, зохицуулалт хийх, санхүүгийн дарамт үзүүлэх, шударга сэтгүүлчдийг олон нийтэд илтэд буруушаах, тэднийг хууль бусаар тагнах, хэвлэл мэдээллийн сайтуудыг хакдах зэргээр дээрх үйл ажиллагаа илэрч байна. Мөн засгийн газрууд гэрээ, зохицуулалтын хувьд нэг талд давуу байдал олгосон таатай шийдвэр гаргах, төрийн мэдээллийг давуу эрхтэйгээр авах боломж олгох зэрэг аргыг ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд зохих хэлбэрээр дэмжлэг үзүүлэх, нөлөөгөө тогтоох замаар хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд шууд бус хэлбэрээр оролцож байна. Улмаар хэвлэл мэдээллийг олон нийтэд гэхээсээ илүү эрх мэдэлтэй бүлэг, хүмүүст үйлчилдэг болгох эрсдэл улам нэмэгдэж байна. Үүнээс гадна эдийн засгийн хямралын нөлөөгөөр хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл төвлөрлийг бий болгож, улмаар ашиг сонирхлын зөрчлөөр олон талт, хараат бус сэтгүүл зүйд заналхийлж байна. Цахим орчин дахь мэдээллийн эмх замбараагүй байдал буюу суртал ухуулга, сурталчилгаа, цуурхал зэрэг нь арилжааны, улс төрийн мөн редакцийн агуулгын хоорондын төөрөгдлийг нэмэгдүүлж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгааг тогтворгүй болгож байна. Улмаар хуурамч мэдээллийн тархалтыг хязгаарлах нэрийн дор бие даасан, шүүмжлэгч сэтгүүл зүйд хатуу дарамт, цензур бий болгох аюултай хуулиудыг батлах оролдлого гарсаар байна.

Сэтгүүл зүйн уламжлалт бизнесийн загварууд үр дүнгүй болж, хэвлэл мэдээллийн олон ургалч байдалд улам сөргөөр нөлөөлж байгаа нь редакцуудыг гаднын оролцогчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд, удирдлагуудын дарамт шахалтад илүү өртөмтгий болгож байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл чөлөөт байдалтай мэт боловч түүний хараат бус байдал алдагдсан үед хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшилдээ оруулах явдал аюул заналхийлэл болсон хэвээр байна. Хэвлэл мэдээлэл дэх төрийн шууд болон шууд бус цагдан хяналт нь хувь хүний үзэл бодлын эрх чөлөөнд нөлөөлөхөөс гадна өргөн утгаараа нийгэм, улс орон, дэлхий даяар үзүүлэх олон сөрөг нөлөөллийг бий болгох эрсдэлтэй байна.

1.2. Дотоодын нөхцөл байдал буюу Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилт

Сүүлийн 10 жилийн хугацаанд хэвлэл мэдээлэлд олон нийтийн итгэх итгэл буурсаар байна. Иргэдийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төр, эдийн засгаас ихээхэн хараат гэж дүгнэж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төр, эдийн засгийн хувьд хараат байх нь тэдний үйл ажиллагааны талаарх үнэлгээнд нэгэн адил нөлөөлж байна. Олон хэрэглэгчтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл төр засгийн талаар хараат бусаар мэдээлж сурвалжлах байдал хангалтгүй байна. Сэтгүүл зүйн үйл ажиллагааг үндэс, угсаа, шашин шүтлэг,

хүйсийн шалгуур дээр үндэслэн хориглохгүй хэдий ч түүнд шууд бус байдлаар саад хийх байдал ажиглагдаж байна. Голлох хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн эмзэг бүлгийнхэн, энгийн иргэдийн дуу хоолойг бүрэн дүүрэн, өргөн хүрээнд илэрхийлж чадахгүй байна.

Төрийн эрх мэдэлтнүүд, улс төрийн гол тоглогчдын зүгээс хуурамч мэдээлэл буюу үзэл суртлын томоохон хэмжээний хөдөлгөөн зохион байгуулах, дэмжих байдал гарч байна. Сэтгүүлчдийн бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлгийг хориглохын тулд мөнгө, бэлэг сэлт, бусад эд зүйлс өгөхөөр амлаж байсан тохиолдол ойролцоогоор 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байна. Сэтгүүлчид мөнгө авч нийтлэл нэвтрүүлэг бэлтгэдэг, эсвэл бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгээ түгээхээ больдог, шантаажилдаг гэх зэрэг ойлголтыг олон нийтэд төрүүлж, хэвлэл мэдээллийн салбарын нэр хүндийг унагах, сэтгүүлчдэд итгэх итгэлийг бууруулж байна. Гэхдээ иргэдийн хувьд редакцтай хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэсэн хэвээр байна.

2/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчин

Дээр дурдсан нөхцөл байдал нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн баталгаа хангалтгүй байгаатай холбоотой байна.

Улсын Их Хурлаас 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйл буюу “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.” гэсэн зохицуулалт хэрэгжихгүй байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хувьд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн хэдий ч түүний үзэл баримтлал, зохицуулалтыг бусад хууль тогтоомжид баталгаажуулах, дэлгэрүүлэх явдал хангалтгүй байна. Энэ нь 40 гаруй хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг зүй бусаар хөндсөн буюу хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг олон улсын хэм хэмжээнд зааснаас буруугаар, хэтрүүлэн хязгаарлах хэлбэрээр илэрч байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах механизм бий болгоогүй байна.

Мөн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “...Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэж, 3.2-т “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” гэж тус тус заасан. Гэвч редакцийн агуулгад төрөөс нөлөөлөх буюу түүнийг өөрчлөх боломж олгосон хууль тогтоомж хэд хэд байна. Засгийн газраас хэвлэл мэдээллийн зарим байгууллагуудтай “хамтран ажиллах” гэрээ байгуулж байгаа нь төрийн цензурыг тогтоох эрсдэлтэйгээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн эрх ашигт нийцсэн мэдээ, мэдээлэл бэлтгэх үүргээ умартахад хүргэх үр дагавартай байна. Чөлөөт хэвлэл мэдээлэл нь олон нийтийн үнэнийг мэдэх зарчимд үйлчилдэг, тэнцвэртэй, хараат бус байх ёстой бөгөөд аль нэг талын дагнасан зар сурталчилгаа, тэнцвэргүй мэдээ, мэдээлэл түгээх нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх биш юм.

Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас бусад дотоодын хууль тогтоомжид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөвшөөрөгдсөн хязгаарлалт (бусдын эрхийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах), тэрхүү хязгаарлалтыг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлагыг (1/ хуульд заасан байх, 2/ хууль ёсны зорилготой байх, 3/ тэрхүү зорилгод нийцсэн зайлшгүй шаардлагатай бөгөөд тохиромжтой арга хэмжээ авах) зөрчиж хэвлэлийн эрх чөлөөг боомилох зорилготой зохицуулалт тусгаж, тэдгээр зохицуулалтыг хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эсрэг урвуулан ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Үүнтэй холбоотойгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барих, хэлэлцэн батлах бодлогыг тухай бүр тодорхойлж ирсэн байх бөгөөд энэ хүрээнд боловсруулсан, хэлэлцүүлсэн хуулийн төслүүдэд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид, хөндлөнгийн судлаачид дүн шинжилгээ хийж, тодорхой зөвлөмжийг тухай бүр өгчээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, батлах талаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны дунд нэгэнт хүлээлт бий болсон байх бөгөөд гагцхүү өмнө боловсруулсан, хэлэлцүүлсэн хуулийн төслүүд дэх мэргэжлийн дүн шинжилгээ, зөвлөмжийг зайлшгүй анхаарч, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг цогц хууль тогтоомжоор баталгаажуулах нь чухал байна.

Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр хууль тогтоомжийг өөрчлөх, сайжруулах чиглэлээр бодит үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь Монгол Улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бэхжүүлэх сонирхол хууль тогтоогчид, улс төрийн намууд, мөн хэвлэл мэдээллийн салбарын зарим хөрөнгө оруулагчдад байгаа эсэх асуудлыг хөндөхөд хүргэж байна.

3/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж буй хүчин зүйлс

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн баталгаа хангалтгүй байгаа нь дараах үр дагаварт хүргэж байна:

3.1. Улс төрийн нөхцөл байдал:

Өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын удирдлагууд болон олон нийтийн радио, телевизийн удирдлагууд улс төрийн эрх мэдэлтнүүднээс ихээхэн хараат байдалтай байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 8.3, 8.4-т зааснаар Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох бөгөөд Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Гэвч тус хорооны гишүүд бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх явдал түгээмэл байна. Энэ нь тус хорооны дарга, гишүүнийг томилох эсэх эрх хэмжээ зөвхөн Ерөнхий сайдад байгаатай холбоотой байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхийг хууль тогтоомжийн шинэчлэлт, өөрчлөлтийн хүрээнд нэмэгдүүлсэн хэдий ч тус хорооны хараат бус байдлыг хангах талаар анхаарахгүй орхисон.

Дээрх байдал Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлж байна. Цахим орчинд зохицуулалт хийх журмуудын зохицуулалт нь зөвхөн төрийн эрх бүхий байгууллагын дүгнэлт, саналд тулгуурлан цахим орчин дахь агуулгыг хязгаарлах, устгахад чиглэсэн. Тэрхүү дүгнэлт, саналд хөндлөнгийн этгээд буюу шинжээчийн дүгнэлт гаргуулах нөхцөл тусгагдаагүй. Энэ нь цахим орчин дахь мэдээллийн төөрөгдөл, үзэн ядалтыг дэвэргэсэн агуулгаас хамгаалах нэрийн дор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг зохисгүйгээр хязгаарлах эрсдэлийг бий болгож байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос дээрх журмуудын дагуу шийдвэрлэж буй гомдлын агуулга, шийдвэрийн талаар тухай бүр ил тод мэдээлдэггүй, зөвхөн тоон мэдээг сүүлд товч дурдаж байгаа нь дээрх эрсдэл бодитой болохыг харуулж байна. Түүнчлэн, цахим орчин дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлээр Харилцаа холбооны зохицуулах хорооноос олон нийтийн цахим сүлжээний томоохон компаниудад шаардлага тавих бус, Фэйсбүүкийн өөрийн зохицуулалт, үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай ажиллаж байна.

Мөн мэдээллийн вэб сайт үүсгэн байгуулахад саад тотгор байхгүй ч түүнийг ажиллуулахын тулд Харилцаа холбооны зохицуулах хорооны хууль бус хяналттай тулгарч байна.

Тодруулбал, Захиргааны ерөнхий хуулийн 67.2, 67.3-т заасан шаардлагыг хангаагүй буюу захиргааны хэм хэмжээний актад тооцогдохгүй “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-аар дамжуулан цахим хуудасны агуулгад хяналт тавьж, хандалтыг хаах зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Улмаар 2011 онд гаргасан “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий шаардлага”-ын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооноос Ерөнхий сайдын эрх ашигт нийцүүлэн гаргасан шийдвэрийг шүүхээс хүчингүй болгосон ч Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүд шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх хэмжээнд хүртэл Ерөнхий сайдаас бүрэн хамааралтай, хараат байна.

Олон нийтийн радио, телевизийн удирдах байгууллага буюу Үндэсний зөвлөлийн гишүүд ашиг сонирхлын зөрчилтэй байх явдал үргэлжилсээр байна. Монголын Үндэсний олон нийтийн телевизээр сонгуулийн үеэр эрх баригч улс төрийн намаас нэр дэвшигчийн үйл ажиллагаа болон тэдгээрийн талаарх байр суурийг харуулсан мэдээллийн цагийг илүү оногдуулж, тэдэнд хэт давуу байдал бий болгож байна. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлөөс түүний редакцийн хараат бус байдлыг хангахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай бөгөөд олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангаж буй эсэхэд иргэд хяналт тавьж байх нь улам чухал болж байна.

Тухайн хэвлэл мэдээллийн байгууллага өөрөө Төрийн ордонд ажиллаж Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх сэтгүүлчийг түүний ур чадвар, мэргэшсэн байдлыг харгалзан сонгох нөхцөлтэй байсан бол сүүлд Улсын Их Хурал өөрөө сэтгүүлчдэд тавигдах шаардлагыг тогтоож, төрийн ордонд ажиллах сэтгүүлчийг “сонгон шалгаруулах”, түүнд “тусгай зөвшөөрөл олгох” байдлаар холбогдох журам баталж, хэрэгжүүлж байна.

3.2. Эдийн засгийн нөхцөл байдал:

Эздийн зүгээс хэвлэл мэдээллийн байгууллага үүсгэн байгуулах, худалдан авахдаа редакцийн хараат бус байдлыг хангах бус улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоо хамгаалах зорилготой байна. Бизнес, улс төрийн нягт холбоо нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчдийн хараат бус байдалд шууд сөргөөр нөлөөлж, улмаар олон нийтийн гэхээс илүү эзэн, санхүүжүүлэгчийн ашиг сонирхолд үйлчлэх, уншигч, сонсогч, үзэгчийн хэрэгцээ, эрэлтийг зар сурталчилгаа өгөгч, хандивлагчдын эрх ашгаас дээгүүр тавихад хүндрэлтэй болох явдал гарч байна. Энэ нь “бичихийг хориглосон сэдвийн хар жагсаалт”-тай болох, хэвлэл мэдээллийн салбар дахь хаалтын гэрээ, бизнес улс төрийн ашиг сонирхлын хамаарлаас үүдэлтэй редакцийн цензур, сэтгүүлчийн өөрийн цензур хэвшмэл зүйл болох, сэтгүүлчийн бэлтгэсэн нийтлэл, нэвтрүүлгийг нийтлэхийг хориглохын тулд мөнгө, бэлэг сэлт, бусад эд зүйлс амлах, сэтгүүлчдэд байнгын ажил олгогчоос өөр байгууллагаас агуулгад нөлөөлөх зорилгоор мөнгө төлөх зэргээр илэрч байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах нь төрийн үүрэг болохын хувьд түүнд чиглэсэн эдийн засгийн дэмжлэг хангалтгүй байна. Тухайлбал, борлуулсан сониныг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг хүчингүй болгосон, мэргэжлийн сонин, сэтгүүлийн захиалгыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдох орлогоос хасах зохицуулалтыг хүчингүй болгосон. Төрийн мэдээлэл сурталчилгааны төсвийг хэрхэн хуваарилж байгааг хянах механизм байхгүй. Мэдээлэл сурталчилгаанд зориулсан төрийн байгууллагын төсвийг хэрхэн зарцуулах ямар нэгэн дүрэм, журам, зохицуулалт байхгүй. Энэ нь Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз дэх төрийн дэмжлэг нь түүнийг эдийн засгийн хувьд төрөөс хараат байх эрсдэлтэй болгосон.

Энэ нөхцөл байдал нь олон ургалч байдлыг хангахад чиглэсэн буюу хэвлэл мэдээллийн эзэмшлийн төвлөрлөөс сэргийлсэн зохицуулалт үр дүнгүй байгааг харуулж байна. Хэвлэл

мэдээллийн эзэмшлийг ил тод байлгах, эзэмшлийн хэт төвлөрлөөс сэргийлэх талаар холбогдох бодлогын баримт бичиг бий боловч хэвлэл мэдээллийн төвлөрлийг тусгайлан зохицуулдаг хууль тогтоомж байхгүй бөгөөд энэ салбар дахь төвлөрлийн тухай албан ёсны ямар нэгэн тодорхойлолт байхгүй. Хэвлэл мэдээллийн хэт төвлөрлөөс хамгаалах, эзэмшлийн төвлөрлийг хэмжих зохицуулалт, хэмжүүр, шалгуур байхгүй. Энэ нь хэвлэл мэдээллийн олон ургалч байдлыг эрсдэлд учруулж, иргэдийн олон талт мэдээлэл хүлээн авах эрхийг хязгаарлах эрсдэлтэй байна.

Ийм нөхцөл байдал нь хэвлэл мэдээллийн ба маркетингийн компанийн ялгааг бүдгэрүүлж, сэтгүүлчдийг хэвлэл мэдээллийн эздийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой цензурт автуулахаас сэргийлж, тийнхүү эдийн засгийн цензур тогтоосон тохиолдолд хариуцлага хүлээлгэх нөхцөлийг хууль тогтоомжид орхигдуулсан байна. Мөн телевиз, радианоос бусад буюу сонин, сэтгүүл, мэдээллийн сайтын хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээд нь хараат бус, бие даасан, мэргэжлийн редакцтай байх, тэдгээрийн ашиг сонирхлын зөрчил нь сэтгүүлчдийг өөрийн цензурт автахаас сэргийлэх тусгайлсан зохицуулалт дутагдаж байна.

3.3. Эрх зүйн зохицуулалт:

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх ба нэр төртэй холбоотой иргэний хэргийн шинжтэй асуудлыг эрүүгийн журмаар хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, удаан хугацаагаар шалгаж байгаа нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зохисгүйгээр хязгаарлах нөхцөл болж байна.

Монгол Улсын олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйл, Үндсэн хуульд баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг бусад хууль тогтоомжоор баталгаажуулах, тэдгээрийг хэрэгжүүлэх байдал хангалтгүй байгааг НҮБ-ын Хүний эрхийн хороо, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжид тодорхой дурдсаар байна. Монгол Улсын хувьд эдгээр зөвлөмжийг хүлээн авсан ч дүр үзүүлэн хэрэгжүүлэх буюу огт хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд заасан “гүтгэх” зөрчлийг тус хуулиас хассан өдөртөө Эрүүгийн хуульд “худал мэдээлэл тараах” гэмт хэрэг болгосон.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийн зохицуулалт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг дайчлахтай холбоотой бусад хууль тогтоомж нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хуулиар хязгаарлах “зайлшгүй шаардлагатай байх”, “зохист хэмжээндээ байх” нөхцөлийг зөрчсөн буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд өөрт нь аюул учруулсан, хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчдийн үйл хэргийг няцаах, үгүйсгэх, тэднийг чимээгүй болгоход ашиглах үр дагавартай байна. Тодруулбал, худал мэдээлэл тараах гэмт хэргийн үндсэн шинж болох “илт худал мэдээлэл”-ийг хууль тогтоомжид тайлбарлаагүй, хохирогчийн зүгээс тийнхүү худал мэдээлэл тараахаас сэргийлэх, худал мэдээллийг залруулах хангалттай арга хэмжээ авсан эсэхийг харгалздаггүй, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу шийдвэрлэж болох иргэний гэм хорын асуудлыг эрүүжүүлсэн байна.

Сэтгүүлчийн аюулгүй байдал алдагдсан жишээ, баримттай харьцуулахад Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэсэн 1 тохиолдол хангалтгүй байна. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн талаарх шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байж чадахгүй байна. Энэ нь сэтгүүлчийн эсрэг хүчирхийлэл болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдсан гэмт хэргийг мөрдөн шалгах,

яллах, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах, тэднийг мэргэшүүлэх шаардлага байгаа болохыг харуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэснийг зөрчиж төрийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар биш Засгийн газрын тогтоолоор тогтоож байна. Энэ нь төрийн мэдээлэл дээд зэргээр ил тод байх, нууцалбал зохих мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашгийн шалгуурт үндэслэн хуулиар тогтоосны үндсэн дээр нууцлах олон улсын хэм хэмжээ болон Үндсэн хуулийн зарчимтай нийцэхгүй байна. Төрийн болон албаны нууцын хуулийг огт хөндөөгүй, улмаар “төрийн нууц”, “албаны нууц” нэрийн дор олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлыг үл хайхран мэдээллийг нууцлах, мэдээлэл өгөхгүй байх, төрийн байгууллага, албан тушаалтны алдаа, дутагдлыг нуух, хаацайлах өнөөгийн байдлыг залруулахад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн зохицуулалт үр дүнгүй байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн тухай хуульд мэдээллийг ил болгох буюу задруулахтай холбоотой хохирлын үнэлгээ, нийтийн ашиг сонирхлын эрэмбийн талаар зохицуулаагүй.

Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакцийн мэдээллийн эх сурвалжийг албадан ил болгох эрхийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх бусад этгээдийн хувьд дээрх мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхийг хуулиар баталгаажуулаагүй. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлалыг баталгаажуулах шийдлийг оновчгүй тусгасан байна. Энэ нь сэтгүүлчид, редакторын эх сурвалжийг хамгаалах механизмыг хуульд бүрэн тусгах шаардлагатай болохыг харуулж байна.

Өргөн нэвтрүүлгийн телевиз, радианоос бусад буюу сонин, сэтгүүл, мэдээллийн сайтын хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээд нь хараат бус, бие даасан, мэргэжлийн редакцтай байх, тэдгээрийн ашиг сонирхлын зөрчил нь сэтгүүлчдийг өөрийн цензурт автахас сэргийлэх тусгайлсан зохицуулалт байхгүй. Редакцийн хараат бус байдалд халдсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид орхигдуулсан.

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14.3 дугаар зүйлд зааснаар “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт олон ургалч үзэл санаа, редакцийн хараат бус байдлыг баталгаажуулахад дангаараа хангалтгүй байна.

3.4. Нийгэм-соёлын нөхцөл байдал:

Хэвлэл мэдээлэл нь улс төрийн, эдийн засгийн, шашны, цэргийн эрх мэдэлтнүүд, цагдаа ба шүүхийн тогтолцоо, зохион байгуулалттай гэмт хэрэг, зэвсэгт бүлэглэлийн талаарх мэдээллийг ил болгодог хэдий ч тийнхүү ил болгох нь ихээхэн дарамт, саад бэрхшээл, эрсдэлтэй төдийгүй ихээхэн хичээл зүтгэл шаардаж байна. Энэ нь дээрх мэдээллийг чөлөөтэй ил болгох нөхцөл бүрдээгүй гэж үзэхэд хүргэж байна. Нийгэм-соёлын хөндүүр сэдвүүдийг ихэнх хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн зүгээс хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчихгүйгээр мэдээлж байна.

Монгол Улсад хүйн хэвлэл мэдээллийг дэмжсэн төрийн бодлого, эрх зүйн дэмжлэг байхгүй бөгөөд Засгийн газраас энэ чиглэлд таатай орчин бүрдүүлэх, тэдэнд санхүүгийн болоод бусад төрлийн туслалцаа үзүүлэх талаар анхаардаггүй, хүйн хэвлэл мэдээлэлд нөөцөлсөн зурвас, долгион байхгүй. Орон нутгийн болон хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих төрийн тусгай сан, санхүүгийн нөөц байдаггүй. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (community media)-ийн бодлого, зохицуулалтыг аль ч түвшинд хүлээн зөвшөөрөөгүй байна. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.3.1, 7.3.4-т иргэн болон шашны байгууллагад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон нь хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хязгаарласан зохицуулалт болсон.

3.5. Сэтгүүлчийн аюулгүй байдал:

Гурван сэтгүүлч тутмын хоёр нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт өртөж байсан бөгөөд хамгийн түгээмэл хэлбэр нь утсаар заналхийлэх, эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг айлгаж, дарамтлах зэргээр илэрч байна. Сүрдүүлэг, дарамт, заналхийлэл, доромжлол гэх мэт зүйлд 25 хүртэлх насны залуу сэтгүүлчид илүү өртөж байгаа бол эрхлэгч, редакцийн бусад гишүүдийг болон гэр бүлийн гишүүдийг нь айлгаж, дарамтлах байдал эмэгтэй сэтгүүлчдэд илүү тохиолдож байна. Сэтгүүлчийн эсрэг тухайн зөрчлийг ноцтой биш, ямар нэг байдлаар их хэмжээний хохирол амсаагүй гэж үзсэн үед зохих байгууллагуудад мэдэгддэггүй байна. Ихэнх тохиолдолд тухайн сэтгүүлчийн гэр бүлийн хүн, эсвэл ойр дотнын хүн нь түүнийг эрсдэлээс хамгаалж байна.

Сэтгүүлчийн ажлын багаж хэрэгсэлд халдах явдал ойролцоогоор 5 сэтгүүлч тутмын гуравт нь тохиолдож байгаа бөгөөд залуу сэтгүүлчид илүүтэй өртөж байна. Сэтгүүлч, зураглаачийн зүгээс ажлын багаж хэрэгсэл нь их хэмжээгээр гэмтээгүй, дахин ашиглах боломжтой хэвээр байгаа бол цагдаагийн байгууллагад гомдол гаргах нь ховор байна. Тэдэнд хандлаа ч үр дүнгүй гэж үзэж байна. 10 сэтгүүлч тутмын 8-ыг ажил хэргийн шалтгаанаар утсаар тагнаж, чагнадаг байж болзошгүй байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 19.11 дүгээр зүйлийн зохицуулалтаар зөвхөн төрийн нууцыг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд бус иргэн, сэтгүүлчийн хувьд энэ гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болох эрсдэлтэй болсон байна.

Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол 2 сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байна. Сэтгүүлчийн бичсэн мэдээ, нийтлэл гарсны дараа нэр дурдсан байгууллага болон эрх мэдэл бүхий албан тушаалтан ямар эх сурвалжаас мэдээлэл авсан тухай асуудаг, сэтгүүлчийн эсрэг шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүхээс сэтгүүлчийг тухайн мэдээллийн баримтаа нотлохыг шаарддаг нь нууц эх сурвалжийн хамгаалалт байхгүйг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

1/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн бүрэлдэхүүн болохыг зөвшөөрч баталгаажуулах

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд хуулийн зорилгыг “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино” гэж хэвээр хадгалах, тус хуулийг дагалдуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг зохисгүйгээр хязгаарлаж буй дараах хууль тогтоомжийг өөрчлөх:

- Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль дахь “худал мэдээлэл”, “илт худал мэдээлэл” гэх зохицуулалт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй”, “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэсэн зарчимтай шууд харшилж байгааг хүлээн зөвшөөрч, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1-т заасан “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээх”, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1-т заасан “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараах” гэмт хэргийг тус тус хуулиас хасах.
- Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар гомдол гаргасан тохиолдолд түүнийг шалгаж, шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс тухайн нийтлэл, мэдээлэлд дурдсан агуулгатай холбоотой урьдчилж бэлтгэсэн бодит, бүрэн мэдээлэл байсан эсэх, тийнхүү мэдээлэл байхад зориуд тухайн нийтлэл, мэдээллийг нийтэлсэн эсэхийг заавал харгалздаг байх.
- Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг зөрчсөн гэмт хэрэг, зөрчилд хүлээлгэх хариуцлагыг тусгайлан оруулах.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд “сэтгүүлчдийн заавал гишүүнчлэлтэй байгууллага бий болгох, түүнд сэтгүүлчдийг заавал гишүүн болгох” зохицуулалт оруулахгүй байх.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журамтай адилтган тусгайлан тус хуульд өөрт нь заах замаар хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль зүйн баталгааг хөндөхөөс сэргийлэх.
- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг гомдол гаргаж буй тал тухайн асуудлын талаар зөвхөн өөрөө нотлох, төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс тийнхүү гомдол гаргах эрхгүй байх талаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд тусгах.
- Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2020 оны А/200, А/169 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам”-д заасан эрх бүхий байгууллагын дүгнэлт, саналд хөндлөнгийн этгээд буюу шинжээчийн дүгнэлт гаргуулж байх талаар өөрчлөлт оруулах. Энэ хүрээнд Харилцаа холбооны

зохицуулах хорооноос дээрх журмуудын дагуу шийдвэрлэж буй гомдлын агуулга, шийдвэрийн талаар тухай бүр цахим хуудсаараа дамжуулан ил тод мэдээлж байх.

2/ Хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг хангах

Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэгэнт заасан агуулгын хязгаарлалтыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, бусад хуульд дахин заах шаардлагагүй бөгөөд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний бие даасан байдлыг алдагдуулах, ойлгомжгүй байдлыг бий болгох, улс төрийн зорилгоор хэрэглэгдэх үр дагавартай тул дараах хууль тогтоомжийг өөрчлөх:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйл /Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг/-ийг хасах.
- Гамшгаас хамгаалах тухай хуулийн “10.4.13.олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх;” гэснийг хасах.
- Цагдаагийн албаны тухай 59.1.2-т “Шуурхай мэдээлэл нийтэд түгээх шаардлага гарсан тохиолдолд өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглах” гэснийг хасах.
- Монгол Улсын хууль, тогтоомжид төрийн мэдээллийг заавал дамжуулах үүргийг оногдуулсан хуулиудыг нягтлан зайлшгүйгээс бусад шаардлагагүй зохицуулалтыг хүчингүй болгох.
- “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 9.13-т “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” гэснийг хасах.
- “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 14.1-т “Хэвлэл мэдээллийн байгууллага цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын онцгой комисс болон бусад эрх бүхий байгууллагаас өгсөн сэрэмжлүүлэг, мэдээллийг олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүйгээр мэдээлнэ”, 14.2-т “Цар тахлын талаарх цаг үеийн болон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой үнэн, бодит мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд хүргэнэ” гэснийг хасах. Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Түр хороо байгуулах тухай” 29 дүгээр тогтоолын 4-т “Түр хороо, Ажлын шуурхай хэсгийг үнэн зөв, бодит мэдээллээр тухай бүр хангаж, мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх, нийтэд буруу ташаа, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх, тараасан бол холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай” гэж заасныг хасах.

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.3-т “контентийн үйлчилгээ эрхлэх” гэснийг хасах.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлахад баримтлах шалгуур” буюу 1/ тухайн мэдээлэл нь хуульд заасан хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой байх, 2/ тухайн мэдээллийг ил болгох, задруулах нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд ноцтой хохирол учрахыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоосон байх, 3/ тэрхүү учрах ноцтой хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос илүү чухал байх гурван нөхцөлийг нэгэн зэрэг хангасан тохиолдолд мэдээллийг нийтэд мэдээлэхгүй байх, төрийн болон албаны нууцад хамааруулах талаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль ба Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмж тусгаж, дагаж мөрдүүлэх.
- Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг Засгийн газрын тогтоолоор биш, зөвхөн хуулиар тогтоох тухай холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, ил болгохтой холбоотой асуудлыг шийдэхэд иргэний нийгэм, тэр дундаа хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийн оролцоог хангах талаар холбогдох хууль, журамд тусгах.
- Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд заасан “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэргийн үйлдсэн этгээд нь төрийн нууцыг итгэмжлэн хариуцсан этгээд, эсхүл албан тушаал, албан үүргийн хувьд мэдсэн этгээд байхаар өөрчлөн найруулах, эсхүл хүчингүй болгох.
- Эрүүгийн хуулийн 14.2 дугаар зүйлд заасан “Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах”, 14.3 дугаар зүйлд заасан “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэрэгт оногдуулах ялыг хүндрүүлэх. Мөн энэ төрлийн гэмт хэргийг шалган шийдвэрлэх албан хаагчдыг бэлтгэх буюу харьяалал тогтоох.
- Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах буюу сэтгүүлчээс нууц эх сурвалжийнх нь талаар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулахгүй байх зохицуулалтыг процессын хуулиуд буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах. Ингэхдээ, сэтгүүлч нууц эх сурвалжаа хамгаалах эрхтэй байх нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхолд хамаатай бөгөөд тэрхүү эрхийг хөндөхийн тулд шүүхээс зохих үнэлгээ заавал хийж, олон нийтийн бусад ашиг сонирхлыг хангахад сэтгүүлчийн эх сурвалжийг илчлэх нь шууд хамааралтай, зайлшгүй шаардлагатай болох нь нотлогдсоноос бусад үед сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах эрхийг хөндөхгүй байх.
- Олон нийтийн эрх ашгийн төлөө асуудал дэвшүүлсэн нийтлэл, бүтээл бичсэн, сэтгүүл зүйн бусад үйл ажиллагаа явуулсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг хуулийн маргааныг тусгайлсан журмаар буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангахад чиглэсэн журмын дагуу шийдвэрлэх зохицуулалтыг процессын хуулиудад тусгах.
- Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд “Шүгэл үлээгч нь өөрийн хувийн мэдээллийг ил болгохгүйгээр өөрийн өмнөөс хуульчаар, эсхүл сэтгүүлчээр

дамжуулан шүгэл үлээж болно. Энэ тохиолдолд шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг хуульчийн, эсхүл сэтгүүлчийн мэдээллээр орлуулна. Сэтгүүлчээс шүгэл үлээгчийн талаар тодруулах зорилгоор гэрчээр болон бусад байдлаар байцаах, мэдүүлэг, тайлбар авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг шаардахыг хориглоно.” гэж тусгах.

- Редактор нь хэвлэл мэдээллийн үндсэн зарчим, зорилгын хүрээнд редакцийн ажлыг удирдаж, редакцийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, нийтлэгч, өмчлөгч, компанийн бусад удирдлага нь редакцийн асуудлаар редакторт заавар өгөх, редакцийн шийдвэрийг хүчингүй болгох эрхгүй, мөн урьдчилан хэвлэл, бичвэр, зураг үзүүлэхийг шаардах, нэвтрүүлгийн материалыг олон нийтэд нээлттэй болгохоос өмнө сонсгох, үзүүлэхийг шаардах эрхгүй байх зохицуулалтыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд тусгах.

3/ Төрөөс хэвлэл мэдээллийн олон талт байдлыг дэмжих

- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан “Хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх”, 19 дүгээр зүйлд заасан “Эзэмшлийн ил тод байдлыг хангах” зохицуулалтыг дэлгэрэнгүй, тодорхой болгох, тэдгээрт хэвлэл мэдээллийн хэт төвлөрлөөс хамгаалах, эзэмшлийн төвлөрлийг хэмжих зохицуулалт, хэмжүүр, шалгуурыг тусгах.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд ашиг сонирхлын зөрчлийг ил тод болгох, давхар эзэмшлийн хязгаарлалтын талаар тусгах. Энэ хүрээнд хэвлэл мэдээллийн компани, бүлгүүдэд ямар нэгэн телевиз, радио, сонины хувьцааны 1/3-ээс дээш хувийг эзэмшихийг хориглох.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд хүйн хэвлэл мэдээллийг хүлээн зөвшөөрч, тусгах.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд сэтгүүлчдэд тусгай зөвшөөрөл олгохгүй байх нөхцөлийг баталгаажуулах.
- Орон нутгийн хэмжээнд цаг үеийн мэдээ, мэдээлэл хүргэдэг буюу жижиг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зориулсан төрийн тэтгэлгээр дамжуулан бичвэрт суурилсан цаг үеийн мэдээ, мэдээллийн хэрэгслийг дэмжих замаар олон нийтэд чиглэсэн өргөн хүрээтэй сэтгүүл зүйн агуулга буюу олон талт байдлыг дэмжих.
- Борлуулсан сониныг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, мэргэжлийн сонин, сэтгүүлийн захиалгыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдох орлогоос хасах зохицуулалтыг холбогдох хуульд тусгах.
- Төрийн мэдээлэл сурталчилгааны төсвийг хэрхэн хуваарилж байгааг хянах механизм бий болгох, мэдээлэл, сурталчилгаанд зориулсан төрийн байгууллагын төсвийг хэрхэн зарцуулах талаар тусгайлан зохицуулах.
- Олон нийтийн радио телевизийн тухай хуульд түүний удирдах дээд байгууллагын гишүүдийг томилох үйл явцыг ил тод болгох, улс төрийн шууд нөлөөн дор хэрэгжихээс сэргийлэх, төрөөс санхүүжих үйл явц нь олон нийтийн радио, телевизийн хараат бус байдлыг хөндөхгүй байх агуулга бүхий зохицуулалтыг тодотгон өөрчлөх.

4/ Бие даасан, хараат бус зохицуулах байгууллагыг бэхжүүлэх

- Харилцаа холбооны тухай хуулийн 8.3-т “Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно.” гэснийг өөрчилж, Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийг сонгох буюу томилоход хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл болон өргөн нэвтрүүлгийн чиглэлийн холбоод, мэргэжилтнүүдийн оролцоог заавал хангах, Ерөнхий сайд томилох бус, Улсын Их Хурлаас холбогдох зохицуулалтын дагуу зөвхөн батламжлах зохицуулалтыг тусгах.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх. Энэ хүрээнд хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчсөн эсэх талаар тус зөвлөлийн ёс зүйн хороодоос гаргасан тогтоолыг мөрдөн байцаах, яллах, шүүхийн үйл ажиллагаанд шинжээчийн дүгнэлттэй адилтган үзэх зохицуулалтыг эрүү, зөрчлийн процессын хууль тогтоомжид тусгах. Түүнчлэн мөрдөх байгууллага, шүүхээс “худал мэдээлэл”, “илт худал мэдээлэл”-тэй холбоотой асуудал нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчилтэй холбоотой эсэхийг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөр урьдчилж дүгнүүлэх чиглэлээр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд тусгах.

4. НОМ ЗҮЙ

A/ Монгол хэл дээр

1. Нэг сэдэвт бүтээл (хугацааны дарааллаар)

1. Б.Чимид. “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө”. Б.Чимид сан. Үндсэн хуулийн үзэл баримтлал (хоёр дахь хэвлэл). Улаанбаатар. 2017 он
2. ЮНЕСКО. Мэдээлэл, харилцааны хөгжлийн хөтөлбөр. Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ. 2016 он
3. Б.Галаарид. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил. Улаанбаатар. 2018 он
4. Х.Наранжаргал. Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй. Улаанбаатар. 2021 он
5. Д.Нарантуяа. Редакцийн зурвас. Улаанбаатар. 2021 он

2. Тайлан, илтгэл, гарын авлага, ярилцлага (үсгийн дарааллаар)

6. Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн. “Хөл хорио ба эх орондоо ирэх эрх” судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Улаанбаатар. 2021 он.
7. М.Батчимэг: “Хэвлэлийнх гэдэг хэний эрх чөлөө болохыг ярих цаг болжээ”. “Зууны мэдээ” сонин. 2013.01.29
8. М.Батчимэг. “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар редакцийн хараат бус байдлыг хангах нь” илтгэл. Хэвлэлийн хүрээлэн. “Чөлөөт сэтгүүл зүйн эрх зүйн орчин” хэвлэл мэдээллийн удирдах ажилтны үндэсний хоёрдугаар чуулганы илтгэлийн эмхэтгэл. Улаанбаатар. 2013.10.04.
9. Бие даасан боловсрол, хөгжлийн төв ТББ. “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургалтын гарын авлага”. Улаанбаатар. 2018 он.
10. Л.Галбаатар. Халдашгүй байх эрхэд халдах зөвшөөрлийн тогтолцоо. “Нээлттэй нийгэм форум”-ын “Бодлогын асуудал” цуврал. №31, 2020 оны 6 дугаар сар
11. Глоб интернэшнл төв. “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан – 2012-2020”. Улаанбаатар. 2013-2021 он
12. Глоб интернэшнл төв. “2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн хоёрдахь шатны дүн”. 2005.05.09.
13. Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар. “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ”. Улаанбаатар. 2019 он.
14. Глоб Интернэшнл төв, Монголын хуульчдын холбоо, Хэвлэл мэдээллийн зөвлөл. “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн мониторингийн тайлан”. Улаанбаатар. 2019 он.
15. Глоб интернэшнл төв. “УИХ-ын 2020 оны сонгуулийн үеэр телевизийн сурталчилгаанд хийсэн мониторингийн дүгнэлт”. 2021.04.12
16. Глоб интернэшнл төв. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд сурталчилгааны телевизийн мониторингийн үр дүн”. 2021.05.31, 2021.06.04
17. Глоб интернэшнл төв. “Коронавируст халдвар буюу ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ иргэний болон улс төрийн эрхэд нөлөөлөх нь” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021.10
18. Жендэрийн үндэсний хороо. “Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй” редакцад зориулсан удирдамж. Улаанбаатар. 2021 он.
19. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл”. Улаанбаатар. 2021 он.
20. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс. “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс”. Нэгдүгээр боть. Улаанбаатар. 2021 он.
21. “Максима Медиа” ХХК. “2020 оны телевиз үзэлтийн судалгааны тайлан”. Улаанбаатар. 2021 он.
22. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан

23. Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз. “Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт /2019 оны 12-р сар/”. 2019 он
24. Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”. 2015 он
25. Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим: Сэтгүүлчдийн гарын авлага”. Улаанбаатар. 2017 он.
26. Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл. “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” товхимол. Улаанбаатар. 2020 он
27. Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын шийдвэрүүд, 2017-2021
28. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн 2018.07.31-ний өдрийн мэдэгдэл; 2022.01.25-ны өдрийн мэдэгдэл
29. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Бээжин дэх Төлөөлөгчийн газар. “Хүйн хэвлэл мэдээлэл: сайн туршлагын гарын авлага”. 2013
30. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд Монгол Улсын иргэний нийгмийн байгууллагаас илгээсэн тайлан. 2019.10.03
31. Нээлттэй нийгэм форум. “Олон нийтийн радио телевизийн тухай хуульд өгөх санал, шүүмж”. “Хуулийн шүүмж” №31. 2021
32. Б.Пүрэвсүрэн. “Гудамжны хууль”. Улаанбаатар. 2021
33. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага, хот, хөдөөгөөр, /1997-2020/; Сүм хийд 2020
34. Тусгай зөвшөөрөлтэй телевиз, радио, сувгийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээлэл. Эзэмшлийн мэдээлэл 2020 он УБ телевиз суваг. 2021.02.25
35. Үндэсний аудитын газар. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан. Улаанбаатар. 2021 он.
36. Үндэсний аудитын газар. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан. Улаанбаатар. 2020.
37. Үндэсний статистикийн хороо. “Ардчилсан засаглал судалгаа”-ны 2009-2020 оны үр дүн. Улаанбаатар. 2020 он.
38. Фридрих-Эбэртийн сан. “Азийн хэвлэл мэдээллийн барометр – Монгол Улс: Монголын хэвлэл мэдээллийн байдалд монгол мэргэжилтнүүдийн өгсөн үнэлгээ”. Улаанбаатар. 2012 он.
39. Хараат бус судалгааны хүрээлэн. “Залуучуудын санал бодлын судалгаа”. 2020
40. Харилцаа холбооны зохицуулах хороо. “Интернэт ангиллын зөвшөөрөл эзэмшигчид”
41. Харилцаа холбооны зохицуулах хороо. Орон нутгийн үзэгчдийн телевиз үзэлтийн судалгаа. Улаанбаатар. 2013.
42. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны товч тайлан. 2021.04.15
43. Харилцаа холбооны зохицуулах хороо. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн тайлан”. Улаанбаатар. 2021 он.
44. Харилцаа холбооны зохицуулах хороо. “Сайт ангиллын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчид”.
45. Харилцаа холбооны зохицуулах хороо. “Тусгай зөвшөөрөлтэй телевиз, радио, сувгийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээлэл”. 2021.02.25
46. Харилцаа холбооны зохицуулах хороо. “Цахим орчны зохицуулалтын зөвлөмж” илтгэл. 2021.09.29
47. Хууль зүйн яамны 2013 оны үйл ажиллагааны товч тайлан, Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны үйл ажиллагааны тайлан
48. Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг. “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик”. Нээлттэй Нийгэм Форум. Улаанбаатар. 2021 он.

49. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Хэвлэлийн эрх чөлөөний хуультай холбоотой судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан. Улаанбаатар. 2008 он.
50. Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан. Улаанбаатар. 2017.
51. Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлтэй үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэх болон тэдгээр хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”. Улаанбаатар. 2019 он.
52. Хэвлэлийн Хүрээлэн. “Хэвлэл мэдээллийн хариуцлага ба сэтгүүл зүйн хэм хэмжээ” үндэсний хэмжээний санал асуулга болон контент анализийн судалгаа. Улаанбаатар. 2011 он
53. Хэвлэлийн хүрээлэн. Хэвлэл мэдээллийн эзэмшлийн мониторингийн тайлан. 2016
54. Хэвлэлийн Хүрээлэн. Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг. Улаанбаатар. 2016 он
55. Хэвлэлийн хүрээлэн. “Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцийн бодлого, сэтгүүлзүйн практик” санал асуулга, контент анализын судалгааны тайлан. Улаанбаатар. 2017 он
56. Хэвлэлийн хүрээлэн, ХБНГУ-ын Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. “Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан”. Улаанбаатар. 2019.09.
57. Хэвлэлийн хүрээлэн. “Монголын хэвлэл мэдээлэл – өнөөдөр” мониторингийн тайлан. Улаанбаатар. 2021 он.
58. Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв. “Фэйсбүүк дэх сонгуулийн сурталчилгааны мониторинг”. 2020.12.13

3. Эрх зүйн акт (хугацааны дарааллаар)

59. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966
60. Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992 он, №1
61. Онц байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1996 он, №2
62. Гүйцэтгэх ажлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1998 он, №3
63. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1998 он, №10
64. Татан буугдсан “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонины өмчийг хувьчлах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1999 он, №5
65. Хөдөлмөрийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1999 он, №25
66. Харилцаа холбооны тухай хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2001 он, №43
67. Эрүүгийн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002 он, №5
68. Зар сурталчилгааны тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002 он, №23
69. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2005 он, №8
70. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2011, №1
71. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2011 он, №3, №5
72. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2013 он, №24
73. Захиргааны ерөнхий хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2015 он, №28
74. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2006 он, №38
75. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2006 он, №40, 2015 он, №29
76. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2016 он, №7

77. Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2017 он, №7
78. Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2017 он, №8
79. Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2017 он, №24
80. Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2019 он, №22
81. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2019 он, №23
82. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2019 он, №42
83. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2019 он, №49
84. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2020 он №06
85. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2020 он №06
86. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2020 он, №08
87. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2020 он, №17
88. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2020 он, №22
89. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2021 он, №02
90. Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2021 он, №31
91. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2022 он
92. Монгол Улсын Их Хурлын 1999 оны “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоол
93. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
94. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 44 дүгээр тогтоолын хавсралт “Хууль санаачлагчид нь буцаах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”
95. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”
96. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
97. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”
98. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”
99. БНМАУ-ын Ардын их хурлын 1991.02.28-ны өдрийн хуралдааны протокол. Дугаар 17.
100. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдааны протокол. 1998.01.20, дугаар 16
101. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны протокол. 1998.08.28, дугаар 32
102. Засгийн газрын 2011 оны 126 дугаар тогтоолын хавсралт “Өрх бүрт шуудан” хөтөлбөр
103. Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралт “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”

104. Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
105. Засгийн газрын 2021 оны “Түр хороо байгуулах тухай” 29 дүгээр тогтоол
106. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 91 дүгээр тушаалын хавсралт “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”
107. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 2021.11.11
108. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011.02.24-ний өдрийн 8 дугаар тогтоолын хавсралт “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”
109. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 64 дүгээр тогтоолын хавсралт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”
110. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 дугаар тогтоолын хавсралт “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”
111. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 25 дугаар тогтоол
112. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 57 дугаар тогтоолын хавсралт “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”,
113. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 73 дугаар тогтоолын хавсралт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам”
114. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/1270 дугаар тушаалын хавсралт “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам”
115. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/55 дугаар тушаалын 11 дүгээр хавсралт “Хуулийн этгээдийн хэлбэрийн индекс”

Б/ Гадаад хэл дээр (үсгийн дарааллаар)

116. Access Info. Legal Analysis of the Austrian Freedom of Information Act. 19 April 2021.
117. Access now. Keep it on report. March 2021
118. Alan Soon and Rishad Patel. “Mongolia: Codifying and funding the media ecosystem”. January, 2022
119. Alexandra Arkin. Norway's policies on media ownership and transparency, and media pluralism make it "faultless" for press freedom. April 19, 2018
120. Amnesty International. Afghanistan: Implement Access to Information Law. Feb 05, 2020
121. Article 19. “International standards: Regulation of media workers”. 2012
122. Article 19. Global: Exercise your right to information. September 28, 2021
123. Article 19. Open Development. Access to Information and the Sustainable Development Goals. July 2017.
124. Australia - Broadcasting Services Act 1992
125. Australia - Media control rules
126. Australia - News media bargaining code, 2021
127. Australia - Treasury Laws Amendment (News Media and Digital Platforms Mandatory Bargaining Code) Act 2021
128. Australian Communications and Media Authority Act 2005
129. Centre for Law and Democracy. “Mongolia: Note on the Law on Freedom of the Media”. April 2014.
130. Centre for Law and Democracy. Background Paper: Freedom of Expression and International Law. November 2021
131. Council of Europe Committee of Ministers, Recommendation Rec (2000)23 of the Committee of Ministers to member states on the independence and functions of regulatory authorities for the broadcasting sector (Adopted by the Committee of Ministers on 20 December 2000 at the 735th meeting of the Ministers' Deputies)

132. Council of Europe. Information Disorder: Toward an interdisciplinary framework for research and policy making. October, 2017
133. Czech Republic - Law on Conflict of Interest, 2016
134. Czech Republic - Act No. 46/2000 Coll. on the Periodical Press (Tiskový zákon)
135. Daniel C. Hallin. USA Media legislation. European Journalism Centre (EJC). 2019
136. DataReportal.com; Kemp, S. Digital 2021: Global Overview Report. Kepios. 27 January, 2021
137. Dragomir, M. and Söderström, A. The state of the media: A global analysis of the editorial independence of state media and an introduction of a new state media typology. Center for Media, Data, and Society. 2021
138. European Convention on Human Rights. 1950
139. European Court of Human Rights. Factsheet – Protection of journalistic sources. December 2021
140. Gertz v. Robert Welch, Inc., 418 U.S. 323 (1974)
141. Global Right to Information Rating: Mongolia. 2019-08
142. Guardian News & Media Limited. “How Facebook let fake engagement distort global politics: a whistleblower’s account” 12 April 2021.
143. Guardian. Kazakhstan authorities raise death toll from unrest to 225. Jan 16, 2022
144. Helge Østbye. Norway - Media Landscapes Expert Analyses of the State of Media. European Journalism Centre (EJC). 2019
145. Hustler Magazine, Inc. v. Falwell, 485 U.S. 46 (1988)
146. International Center for Journalists. Trust me, I’m a journalist, Sharon Mashovi, Jan 4 2022
147. International Covenant on Civil and Political Rights. Adopted and opened for signature, ratification and accession by General Assembly resolution 2200A (XXI) of 16 December 1966 entry into force 23 March 1976, in accordance with Article 49.
148. International Federation of Journalists. Jordan: Al-Rai newspaper journalists protest over unpaid salaries, press releases, 14 Feb 2022
149. Joint Declaration by the UN Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, the OSCE Representative on Freedom of the Media and the OAS Special Rapporteur on Freedom of Expression. 6 December 2004
150. Joint Declaration on Diversity in Broadcasting, The UN Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, the OSCE Representative on Freedom of the Media, the OAS Special Rapporteur on Freedom of Expression and the ACHPR (African Commission on Human and Peoples’ Rights) Special Rapporteur on Freedom of Expression and Access to Information, 7-8 December, 2007
151. Joint Declaration on Freedom of Expression and responses to conflict situations, 6 May 2014
152. Joint Declaration on Media Independence and Diversity in the Digital Age. The United Nations (UN) Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, the Organization for Security and Co-operation in Europe (OSCE) Representative on Freedom of the Media, the Organization of American States (OAS) Special Rapporteur on Freedom of Expression and the African Commission on Human and Peoples’ Rights (ACHPR) Special Rapporteur on Freedom of Expression and Access to Information, 4 May 2016 and 3 March 2017
153. Joint Letter to South Korean President Moon Jae-in on Press Arbitration Law. September 16, 2021
154. Jon Wessel-Aas. Protection of journalistic sources in Norwegian law. 2020
155. Journalists’ Safety Indicators: International Level Based on the UNESCO’s Media Development Indicators, 25 July 2013
156. Julian Dierkes, Marissa Smith, and Shannon Tiezzi. Khurelsukh Cruises to Victory in Mongolian Presidential Race. June 10, 2021
157. Julie Firmstone. United Kingdom - Media legislation. European Journalism Centre (EJC). 2019
158. Latvia – Constitution, 1991
159. Latvia - Law on the Press and other Mass Media, 1991
160. Latvia - Freedom of Information Law, 1998

161. Latvia - Electronic Mass Media Law, 2010
162. Lithuania – Law on the Provision of Information to the Public (LPIP)
163. Mark Kolakowski. Facebook (FB) Papers. October 28, 2021
164. Meta Ad Library Report: Mongolia – Spending by advertiser. Aug 4, 2020 - Feb 3, 2022
165. Michael Karanicolas. Travel Guide to the Digital World: Surveillance and International Standards. London. 2014.
166. Milan F. Živković. Alternative models for independent media funding: Who will pay for journalism? 2016
167. New York Times Company v. Sullivan, 376 U.S. 254 (1964)
168. New York Times Company v. United States, 403 U.S. 713 (1971)
169. Norway - Act relating to mediation and procedure in civil disputes (The Dispute Act) – 2005.
170. Norway - Lov om økonomisk støtte til mediene (mediestøtteloven)
171. Norway - Lov om redaksjonell uavhengighet og ansvar i redaktørstyrte journalistiske medier (medieansvarsloven)
172. Norway - The Criminal Procedure Act of 22 May 1981 No. 25
173. Norway – The Penal Code. 2005
174. Ole Kristian Aabø-Evensen, Private mergers and acquisitions in Norway: Overview. 2017
175. Organization for Security and Co-operation in Europe (OSCE). The Representative on Freedom of the Media. “Law of Mongolia on Freedom of Media”. Reviewed by Eve Salomon, Director of Salomon Whittle Ltd. February 2015.
176. Organization for Security and Co-operation in Europe .The Media Self-Regulation Guidebook. Miklós Haraszti. 2008.
177. OSCE media freedom representative concerned about blocking of news website in Mongolia. Vienna. 10 July 2014
178. Recommendation CM/Rec(2018) of the Committee of Ministers to member States on media pluralism and transparency of media ownership (Adopted by the Committee of Ministers on 7 March 2018 at the 1309th meeting of the Ministers' Deputies)
179. Reporters Without Borders. 2020 World Press Freedom Index: “Entering a decisive decade for journalism, exacerbated by coronavirus”
180. Reporters Without Borders. RSF 2020 Index: Asia-Pacific – hyper-control and national-populist excesses.
181. Reporters Without Borders. RSF refers violence against reporters covering protests in Kazakhstan to UN, 2022.01.12
182. Reporters Without Borders. The World Press Freedom Index
183. Reporters Without Borders. Violations of press freedom barometer. The figures in 2022
184. Samantha Bradshaw, Philip N. Howard. The Global Disinformation Order: 2019 Global Inventory of Organised Social Media Manipulation. 2019
185. Sarah Repucci. Freedom and the Media, Media Freedom downward spiral. 2019
186. South Korea - Act on Press Arbitration and Remedies for Damage Caused by Press Reports - 2005
187. South Korea – Act on the Promotion of Newspapers
188. South Korea - Broadcasting Act
189. South Korea - Constitutional Court decision, 24 June 1999, 97 Heon-Ma 265;
190. South Korea - Constitutional Court decision, 29 January 2004, 2001Hun-Ma894
191. South Korea - Internet Multimedia Broadcast Services Act
192. South Korea - Supreme Court decision, 23 August 1996, 94 Do 3191
193. South Korea – The Media and Entertainment Law Review: South Korea. Hyun Ho Eun, Jung-Chull Lee and Dukjoong Na. 08 December 2021
194. The Constitution of the Kingdom of Norway. 1814
195. The Office of the High Commissioner for Human Rights. COVID-19 Guidance. 13 May 2020
196. The RTI rating. Analyses of the quality of the World’s access to information laws. Global Right to information Rating map.
197. UK - Communications Act 2003
198. UK - Digital Economy Act 2017

199. UK – Independent Press Standards Organisation (IPSO)
200. UK - Leveson Inquiry - Report into the culture, practices and ethics of the press. 29 November 2012
201. UK – Press Recognition Panel (PRP)
202. UK - The Royal Charter for BBC
203. UK- The Independent Monitor for the Press (IMPRESS)
204. UN General Assembly Resolution (A/RES/68/163) on Safety of Journalists and the Issue of Impunity (2013)
205. UN Human Rights Committee (HRC), General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression, 12 September 2011, CCPR/C/GC/34
206. UN Human Rights Council Resolution (A/HRC/45/L.42/Rev.1) on the Safety of Journalists (2020)
207. UN Human Rights Council, “Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression,” March 30, 2017, UN Doc. A/HRC/35/22, para. 49
208. UN Human Rights Council, Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression,” April 6, 2018, UN Doc. A/HRC/38/35, paras. 66-67
209. UN Human Rights Council, Report of the Special Rapporteur on the promotion and protection of freedom of opinion and expression, April 13, 2021, UN Doc. A/HRC/47/35, para. 38, 40
210. UN Treaty Body Database. Ratification, Reporting & Documentation for Mongolia
211. UNESCO Director-General's Report on the Safety of Journalists and the Danger of Impunity
212. UNESCO observatory of killed journalists
213. UNESCO. Independent regulation of broadcasting: A Review of International Policies and Experiences. 2016
214. UNESCO. Freedom of Expression and Media Development, Journalism is a public good. World Trends in Global Report 2021/2022
215. UNESCO. Media Development Indicators: A framework for assessing media development Endorsed by the Intergovernmental Council of the International Programme for the Development of Communication (IPDC) at its 26th session (26-28 March 2008)
216. UNESCO. Reporting Facts: Free from Fear or Favour. 2021
217. UPR of Mongolia - Second Cycle - Thematic list of recommendations - A/HRC/30/6/Add.1
218. USA – Cable Television Consumer Protection and Competition Act of 1992
219. USA - Communications Act of 1934
220. USA – Federal Communication Commission
221. USA – The Freedom of Information Act;
222. Zurcher v. Stanford Daily, 436 U.S. 547 (1978)
- 223.